



# ШУДАРГААР ШҮҮЛГЭХ ЭРХ

*гарын авлага*



[www.amnesty.org](http://www.amnesty.org)





Монголын Эмнести Интернэшнл байгууллага шүүх эрх мэдлийг шинэчлэх болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, улмаар нийгэмд шударга ёсыг тогтооход хувь нэмэр болно гэж үзсэний үндсэн дээр Нээлттэй Нийгэм Форумын санхүүгийн дэмжлэгтэйгээр “Шударгаар шүүлгэх эрх” гарын авлагыг монгол хэлнээ хөрвүүлж хуульчид, хүний эрхийн ажилтнуудад хүргүүлж байна.

Хүн бүр хэрэг маргаанаа шударгаар шүүлгэх эрхтэй. Энэ эрх нь Монгол улсын нэгдэн орж, соёрхон баталсан олон улсын хүний эрхийн гэрээ конвенцид төдийгүй түүнд нийцүүлэн гаргасан дотоодын хууль тогтоомжид тусгалаа олж баталгаажсан байдаг. Тус гарын авлага нь хуулинд тусгагдсан баталгааг амьдралд хэрэгжүүлэхэд тус дөхөм болно гэж найдаж байна.

Олон улсын хэмжээнд нэгэнтээ тогтсон шударга шүүхийн жишиг стандарт нь Монголын шүүх, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаанд шингэж хүнлэг энэрэнгүй иргэний нийгэм батжих болтугай.



**ЭМНЕСТИ  
ИНТЕРНЭШНЛ**



**НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ  
ФОРУМ**

# ШУДАРГААР ШҮҮЛГЭХ ЭРХ

© Эмнести Интернэшнлийн Хэвлэл

Бүх эрхийг хуулиар хамгаалсан. Энэ хэвлэл нь зохиогчийн эрхтэй. Нөлөөллийн ажил, кампанит ажил, сургалтын зорилгоор хөлс төлөхгүйгээр дахин хэвлэж олшруулах боломжтой боловч худалдахыг зөвшөөрөхгүй. Дээрхи зорилгоор хэрэглэх нөхцөлд зохиогчийн эрхийг эзэмшигчид мэдэгдэхийг хүсч байна. Бусад нөхцөл шалтгаанаар хэвлэх олшруулах, бусад хэвлэлд ашиглах, орчуулах, тохируулах нөхцөлд хэвлэгчээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авах ба төлбөр төлж болзошгүй.

Эмнести Интернэшнл хүний үндсэн эрхийг хамгаалах, дэмжих, туслах үйл зэрэг үйл ажиллагааг олон улсын хэмжээнд явуулдаг бие даасан, сайн дурын хөдөлгөөн бөгөөд дараахь үндсэн зорилгод тулгуурлаж кампанит ажил явуулдаг. Үүнд:

- Үзэл санааны хоригдол хэмээгдэх өөрийн үзэл, арьс өнгө, хүйс, яс үндэс, угсаа гарал, хэл, сүсэг бишрэлээсээ болж баривчлагдсан тэгэхдээ хүч хэрэглээгүй, хүчирхийллийг дэмжээгүй ямар ч улсын иргэдийг чөлөөлөх
- Улс төрийн хоригдлуудын хэргийг цаг тухайд нь шударгаар шийдвэрлэхэд туслах
- Цаазаар авах ял, эрүүдэн шүүлт тулгах болон бусад хүнлэг бусаар харьцах ёсыг арилгах, халах
- Хууль бус аллага, сураггүй алга болгох явдлыг эцэс болгох зэргийг дурьдаж болно.

Эмнести Интернэшнл нь аль нэг засгийн газар, улс төрийн бүлэглэл, шашны үзлээс тусгаар бие даасан байгууллага. Өөрөөр хэлбэл аливаа Засгийн газар, улс төрийн бүлэглэлийн байр суурийг эсэргүүцэх буюу дэмждэггүй бөгөөд Засгийн газар, сөрөг хүчнүүдийн үзэл суртал, хувь хүний үзэл бодлоос үл шалтгаалан тухайн тохиолдолд зөвхөн хүний эрхийг хамгаалах асуудлыг л авч үздэг.

Эмнести Интернэшнл хүний халдашгүй байх эрхийг хамгаалан Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал ба олон улсын баримт бичгүүдэд заасан хэм хэмжээг олон улсын гэрээ хэлэлцээрүүд, хүний эрхийн боловсролын хөтөлбөрт баталгаажуулахыг дэмжин ажилладаг.

Эмнести Интернэшнл нь улс орнуудыг хүний эрхийг хангаж буй байдлаар нь зэрэглэл тогтоон ангилдаггүй, тухайн тохиолдолд хүний эрхийг ноцтойгоор зөрчихийг эцэс болгохын тулд анхаарлаа төвлөрүүлдэг.

Эмнести Интернэшнл нь өөрийн удирдлага бүхий, ардчилсан байгууллага юм. Даяарх гишүүд дэмжигчдийнхээ хандиваар санхүүждэг. Байгууллагын бие даасан байдлыг хангах бүх хандив тусламж нь олон улсын зөвлөлөөс хуульчлан тогтоосон журмын дагуу нарийн чанд зарцуулагддаг.

Эмнести Интернэшнл нь дэлхийн 150 гаруй улс оронд 3 сая гаруй гишүүд, дэмжигчидтэй. Байгууллагынхаа шударга, бодитой үйл ажиллагаа явуулах явдлыг хангахын тулд гишүүд өөрийн болон бусад оронд ажилладаг.

Эмнести Интернэшнл нь дэлхий даяарх хүний эрхийн зөрчлийн талаарх бодит байдлыг хурдан шуурхай олж илрүүлэхийг хичээн ажилладаг.

ISBN: 0- 86210 -277-4

Индекс: POL30/02/98

Эх хэл: Англи

Хэвлэсэн: Эмнести

Интернэшнлийн Олон Улсын

Нарийн Бичгийн Дарга Нарын

Газар, Нэгдсэн Вант Улс

Хаяг:

Peter Benenson House

1 Easton Street

London WC1X 8DJ

United Kingdom

[www.amnesty.org](http://www.amnesty.org)

## Гарчиг

Өмнөх үг .....	1
Танилцуулга .....	2
Олон улсын хэм хэмжээ, байгууллагууд .....	5
Энэ гарын авлагад тусгасан хэм хэмжээ .....	6
Ишлэл .....	14
Хураангуйлал .....	17

## А. Шүүх хурлаас өмнөх шатанд эдлэх эрх

### Бүлэг 1. Халдашгүй байх эрх ..... 21

#### 1.1 Халдашгүй байх эрх

- 1.2 Ямар тохиолдолд баривчлах, албадан саатуулах нь хууль ёсны байх вэ?
  - 1.2.1 Европын Конвенц
- 1.3 Ямар тохиолдолд баривчлах, албадан саатуулах нь хууль бус байх вэ?
- 1.4 Хуулийн дагуу ямар этгээд хүний эрх чөлөөг хязгаарлах эрхтэй вэ?
- 1.5 Шүүх хурал болохоос өмнө суллагдах

### Бүлэг 2. Албадан саатуулагдсан хүмүүс мэдээлэл авах эрх ..... 26

- 2.1 Албадан саатуулагдсан болон баривчлагдсан шалтгаанаа нэн даруй мэдэх эрх
- 2.2 Өөрийн эрхүүдийн талаар мэдээлэл авах эрх
  - 2.2.1 Албадан саатуулагдсан этгээд хууль зүйн туслалцаа авах эрхтэй гэдгийг мэдэгдэх
- 2.3 Ямар ял тулгаж байгаа талаар нэн даруй мэдээлэл авах эрх
- 2.4 Албадан саатуулагдсан этгээдийн ойлгож чадах хэл дээр мэдээллийг хэлж өгөх
- 2.5 Гадаадын иргэд

### Бүлэг 3. Шүүх хурлаас өмнө эрх зүйн зөвлөгөө авах эрх..... 31

- 3.1 Өмгөөлөгчийн туслалцаа авах эрх
  - 3.1.1 Шүүх хурлаас өмнөх шатанд өмгөөлөгч авах эрх
- 3.2 Өмгөөлөгч сонгох эрх
- 3.3 Үнэ төлбөргүй өмгөөлөгч авах эрх
  - 3.3.1 Туршлагатай болон нэр хүндтэй өмгөөлөгч авах эрх
- 3.4 Албадан саатуулагдсан этгээд өмгөөлөгч авах эрх
  - 3.4.1 Албадан саатуулагдсан этгээд хэдийд өмгөөлөгч авах эрхтэй вэ?
- 3.5 Албадан саатуулагдсан этгээд өөрийн өмгөөлөгчтэйгээ зөвлөлдөх цаг нөхцлөөр хангагдах эрх
- 3.6 Өмгөөлөгчтэйгээ аминчлан, чөлөөтэй уулзах эрх

### Бүлэг 4. Хоригдож буй этгээд гадаад ертөнцтэй холбоотой байх ..... 36

- 4.1 Эргэлт хүлээн авах ба уулзалт хийх эрх
  - 4.1.1 Ямар нэгэн холбоо тогтоох эрхгүй албадан саатуулагдах
- 4.2 Албадан саатуулагдсан тухайгаа болон хоригдож буй газрынхаа талаар гэр бүлийнхэндээ мэдэгдэх
- 4.3 Гэр бүлийнхэнтэйгээ харилцах эрх
- 4.4 Гадаадын иргэд гадаад ертөнцтэй холбогдох эрх
- 4.5 Эмчид хандах эрх
  - 4.5.1 Эмчийн тусламж авах эрх хэдийд үүсэх вэ?

<b>Бүлэг 5. Аль болох богино хугацаанд хэргийг хянан шийдвэрлүүлэх эрх .....</b>	<b>40</b>
5.1 Аль болох богино хугацаанд хэргийг хянан шийдвэрлүүлэх эрх	
5.1.1 Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч эрх бүхий албан тушаалтан	
5.2 “Нэн даруй” гэдэг нь ямар утгатай вэ?	
<b>Бүлэг 6. Албадан саатуулагдсан хууль зүйн үндэслэлийн эсрэг гомдол гаргах.....</b>	<b>43</b>
6.1 Албадан саатуулагдсан хууль зүйн үндэслэлийн эсрэг гомдол гаргах	
6.2 Хорих хууль зүйн үндэслэл	
6.3 Үргэлжлүүлэн хянах	
6.4 Заавал хангах эрх	
6.5 Хууль бусаар баривчлагдсан ба хоригдсоны төлөө нөхөн төлбөр авах эрх	
<b>Бүлэг 7. Боломжит хугацаанд хэргээ шийдвэрлүүлэх эсхүл суллагдах эрх.....</b>	<b>47</b>
7.1 Боломжит хугацаанд хэргээ шийдвэрлүүлэх эсвэл шүүх хурлаас өмнө суллагдах эрх	
7.2 Боломжит хугацаа гэж юу вэ?	
7.2.1 Оргон зугагах эрсдэл	
7.2.2 Засаг төрийн байгууллага зохих анхаарал тавьж байгаа эсэх	
<b>Бүлэг 8. Өмгөөлөлд бэлтгэх боломжтой цаг хугацаа, нөхцлөөр хангагдах эрх.....</b>	<b>49</b>
8.1 Өмгөөлөлд бэлтгэх боломжит хугацаа болон нөхцлөөр хангагдах эрх	
8.2 Боломжтой цаг хугацаа гэж юу вэ?	
8.3 Мэдээлэл авах	
8.4 Тулгаж буй яллагааны талаархи мэдээллийг авах эрх.	
8.4.1 Яллагааны тухай мэдээллийг хэзээ өгөх вэ?	
8.4.2 Хэл	
8.5 Мэргэжлийн хүмүүст хандах эрх	
<b>Бүлэг 9. Байцаагдах үед эдлэх эрх .....</b>	<b>53</b>
9.1 Байцаагдаж буй этгээдүүдийг хамгаалах	
9.2 Хүч хэрэглэн мэдүүлэг авахыг хориглох	
9.3 Үг хэлэхгүй байх эрх	
9.4 Орчуулагч авах эрх	
9.5 Тэмдэглэл хөтлөх	
9.6 Байцаалтын журам ба хэрэгжилтийн явцтай танилцах	
<b>Бүлэг 10. Эрүү шүүлтэнд өртөхгүй байж хүнлэг нөхцөлд хоригдох эрх .....</b>	<b>57</b>
10.1 Хүнлэг нөхцөлд хоригдох эрх	
10.1.1 Хууль ёсны албадан саатуулагдах газарт хоригдох эрх	
10.1.2 Хоригдох үеийн тайлан бүртгэл	
10.1.3 Эрүүл мэндийн туслалцааг цаг тухайд нь авах эрх	
10.2 Урьдчилан хорих газарт байгаа хүмүүст нэмэлт хамгаалалт олгох	
10.3 Албадан саатуулагдсан эмэгтэйчүүд	
10.4 Эрүү шүүлт тулгах болон хүнлэг бус харьцаж шийтгэхийг хориглоно	
10.4.1 Удаан хугацаагаар ганцаарчлан хорих	
10.4.2 Хүч хэрэглэх	
10.4.3 Байцаалтын үед хүчээр дарамтлах	
10.4.4 Албадлага хэрэглэх	
10.4.5 Биед нэгжлэг хийх	
10.4.6 Химийн болон шинжлэх ухааны туршилт хийх	

10.4.7 Сахилгын арга хэмжээгээр дарамтлах

10.4.8 Эрүү шүүлт болон хүнлэг бус харьцаанаас үүссэн хохирлыг  
нөхөн төлүүлэх эрх

## **Б. Шүүх хэргийг хянан шийдвэрлэх үед**

<b>Бүлэг 11. Хууль болон шүүхийн өмнө эрх тэгш байх .....</b>	<b>69</b>
11.1 Хуулийн өмнө эрх тэгш байх	
11.2 Шүүхийн өмнө эрх тэгш байх	
11.2.1 Шүүхэд эрх чөлөөтэй хандах эрх	
11.2.2 Шүүх нь хэнийг ч ялгаварлан гадуурхах ёсгүй	
<b>Бүлэг 12. Хуулийн дагуу байгуулагдсан бие даасан, хараат бус болон шударга шүүхээр шүүгдэх эрх.....</b>	<b>72</b>
12.1 Хараат бус, бие даасан, шударга шүүхээр шүүгдэх эрх	
12.2 Хуулийн дагуу байгуулагдсан шүүхээр шүүгдэх эрх	
12.3 Эрх мэдэл бүхий шүүхээр шүүгдэх эрх	
12.4 Бие даасан шүүхээр шүүгдэх эрх	
12.4.1 Эрх мэдэл хуваарилах	
12.4.2 Шүүгчийг томилох ба түүний ажиллах нөхцөл	
12.4.3 Хэрэг хуваарилалт	
12.5 Шударга шүүхээр шүүгдэх эрх	
12.5.1 Шүүхийн хараат бус байдал	
<b>Бүлэг 13. Шударгаар шүүгдэх эрх .....</b>	<b>80</b>
13.1 Шударгаар шүүгдэх эрх	
13.2 Эрх тэгш байх	
<b>Бүлэг 14. Нээлттэй шүүгдэх эрх .....</b>	<b>82</b>
14.1 Нээлттэй шүүгдэх эрх	
14.2 Нээлттэй шүүх хурал явуулах журам	
14.3 Нээлттэй шүүхийг хуралдуулахгүй байх онцгой тохиолдол	
14.4 Ил тод шүүгдэх эрхийг зөрчих	
<b>Бүлэг 15. Гэм буруу нь нотлогдоогүй тохиолдолд гэм буруугүйд тооцох .....</b>	<b>85</b>
15.1 Гэм буруу нь нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох	
15.2 Нотлох үүрэг	
15.3 Гэм буруугүй байдлыг нотлох процесс	
15.4 Гэм буруугүйд тооцогдсоны дараа	
<b>Бүлэг 16. Сэжигтэн өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх .....</b>	<b>88</b>
16.1 Гэмт хэрэгт холбогдолгүй болохоо нотлох, өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх	
16.2 Мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх	
16.3 Хүч хэрэглэж мэдүүлэг гаргуулах	
<b>Бүлэг 17. Эрүү шүүлт тулгаж буюу бусад хориотой арга хэрэглэж цуглуулсан нотлох баримт нотлох чадвараа алдах нь .....</b>	<b>90</b>
17.1 Эрүү шүүлт тулгаж буюу хүнлэг бус аргаар цуглуулсан нотлох баримт нотлох чадвараа алдах нь.	
17.2 Хүч хэрэглэн цуглуулсан нотлох баримт нотлох чадвараа алдах нь	
17.2.1 Америкийн Конвенцийн 8.3 дугаар заалт	

<b>Бүлэг 18. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тухайн гэмт хэрэгт зөвхөн нэг удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэх ...</b>	<b>92</b>
18.1 Тухайн хэргийг үйлдэх үед гэмт хэрэгт тооцоогүй бол эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийн хориглоно	
18.2 Нэг хэрэгт хоёр удаа ялиноогдуулахыг хориглох	
18.2.1 Америкийн конвенцийн дагуу нэг хэрэгт хоёр удаа ял тулгахыг хориглосон	
18.3 Олон улсын тусгай шүүх	
<b>Бүлэг 19. Хүндэтгэн үзэх шалтгаангүй тохиолдолд цаг алдалгүй хэргийг шүүхээр хянан шийдвэрлүүлэх эрх .....</b>	<b>95</b>
19.1 Хүндэтгэн үзэх шалтгаангүй тохиолдолд цаг алдалгүй хэргийг шүүхээр хянан шийдвэрлүүлэх эрх.	
19.2 Боломжит хугацаа гэж юу вэ?	
19.2.1 Хэргийн нөхцөл байдал	
19.2.2 Шүүгдэгчийн хандлага	
19.2.3 Эрх бүхий албан тушаалтны хандлага	
<b>Бүлэг 20. Өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлөгчийн туслалцаа авах эрх .....</b>	<b>98</b>
20.1 Өөрийгөө өмгөөлөх эрх	
20.2 Өөрөө өөрийгөө өмгөөлөх	
20.3 Өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрх	
20.3.1 Албадан саатуулагдсан этгээд өмгөөлөгч авах эрхтэй болохыг мэдэгдэх	
20.3.2 Өмгөөлөгч сонгох эрх	
20.3.3 Өмгөөлөгч томилуулах, үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрх	
20.4 Өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах эрх	
20.5 Дадлага туршлагатай, нэр хүндтэй өмгөөлөгч авах эрх	
20.6 Өмгөөлөгчийг айлган сүрдүүлэхийг хориглох	
<b>Бүлэг 21. Шүүх хуралд оролцох, давж заалдах эрх .....</b>	<b>104</b>
21.1 Шүүх хуралд оролцох эрх	
21.2 Шүүгдэгчгүйгээр шүүх хурал явуулах	
21.3 Давж заалдах шатны шүүх хуралд оролцох эрх	
<b>Бүлэг 22. Гэрчийг дуудах ба байцаах мэдээлэл авах эрх .....</b>	<b>107</b>
22.1 Гэрч	
22.2 Яллагдагчийн эсрэг мэдүүлэг өгсөн гэрчүүдийг байцаах эрх	
22.2.1 Далд гэрч	
22.2.2 Яллах талын гэрчүүдийг байцаахад тавих хязгаарлалт	
22.3 Өмгөөлөх талын гэрчийг дуудан байцаах эрх	
22.4 Хохирогч ба гэрч нарын эрх	
<b>Бүлэг 23. Орчуулагч авах болон орчуулга хийлгэх эрх.....</b>	<b>113</b>
23.1 Орчуулга ба тайлбар	
23.2 Туршлагатай орчуулагч авах эрх	
23.3 Бичиг баримтыг орчуулуулах эрх	
<b>Бүлэг 24. Шүүхийн шийдвэр .....</b>	<b>115</b>
24.1 Шүүхийн шийдвэрийг нийтийн өмнө нээлттэй байлгах эрх	
24.2 Шүүхийн шийдвэрийн үндэслэлийг мэдэх эрх	
24.3 Боломжтой хугацаанд шүүгдэх эрх	



<b>Бүлэг 25. Шийтгэл .....</b>	<b>117</b>
25.1 Ялыг хэзээ оногдуулах вэ?	
25.2 Ямар ялыг оногдуулж болох вэ?	
25.3 Ял нь олон улсын хэм хэмжээг зөрчих ёсгүй	
25.4 Бие махбодийн шийтгэл	
25.5 Хорих нөхцөл байдал	
25.6 Хоморголон шийтгэхийг хориглох	

<b>Бүлэг 26. Давж заалдах эрх .....</b>	<b>121</b>
26.1 Давж заалдах эрх	
26.2 Дээд шатны шүүхийн хяналт	
26.3 Бүрэн хянах	
26.4 Давж заалдах шатанд шударгаар шүүлгэх баталгаа	

## **С. Онцгой Хэргүүд**

<b>Бүлэг 27. Хүүхэд .....</b>	<b>125</b>
27.1 Шүүхээр хэргээ шударгаар шийдвэрлүүлэх хүүхдийн эрх.	
27.2 Хүүхдийн тухай тодорхойлолт.	
27.3 Хуулиуд зөрчилдөх нөхцөлд хүүхдэд хэрхэн хандах үндсэн зарчмууд	
27.3.1 Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг таслан шийдвэрлэх тогтолцоо тусдаа байх	
27.3.2 Хялбаршуулсан шүүн таслах ажиллагаа	
27.3.3 Насанд хүрээгүй хүүхдийн хэргийг шуурхай шийдвэрлэх	
27.3.4 Нууцлал	
27.4 Баривчилах болон урьдчилан хорих	
27.5 Шүүх ажиллагаа	
27.6 Шүүхийн Шийдвэр	
27.7 Ял	
27.7.1 Хориглосон ялын төрөл	
27.8 Хоригдол хүүхдүүд	

<b>Бүлэг 28. Цаазаар авах ял .....</b>	<b>133</b>
28.1 Цаазаар авах ялыг халах.	
28.2 Ялыг хөнгөрүүлж буй заалтаас бусад заалтыг буцаан хэрэглэхгүй байх	
28.3 Цаазаар авах ял ногдуулах хэргийн тоог цөөрүүлэх хүрээ	
28.4 Цаазаар авах ялыг ногдуулж болохгүй хүмүүс	
28.4.1 Насанд хүрээгүй хүмүүс	
28.4.2 Өндөр настан	
28.4.3 Сэтгэцийн эмгэгтэй хүмүүс	
28.4.4 Жирэмсэн болон нярай эмэгтэйчүүд	
28.5 Шударгаар шүүгдэх баталгаагаар хангагдах эрх	
28.5.1 Үр нөлөөтэй зөвөлгөө авах эрх	
28.5.2 Өмгөөлүүлэхэд бэлтгэх боломжит цаг хугацаа, нөхцлөөр хангагдах эрх	
28.5.3 Хэргээ цаг алдалгүй шийдвэрлүүлэх эрх	
28.5.4 Давж заалдах эрх	
28.6 Ял хэлтрүүлэх буюу ялыг хөнгөрүүлж өгөх хүсэлт гаргах эрх	
28.7 Цаазаар авах ялыг гүйцэтгэж болохгүй үе	
28.8 Ял оногдуулах ба цаазаар авах ялыг гүйцэтгэх хоорондох хугацаа	
28.9 Цаазаар авах ялтай хоригдолын шоронгийн нөхцөл	

<b>Бүлэг 29. Тусгай ба онцгой цэргийн шүүх .....</b>	<b>141</b>
29.1 Тусгай ба онцгой шүүх	

- 29.2 Төрөлжсөн шүүх
- 29.3 Бүхий л төрлийн шүүхээр шударгаар шийдвэрлүүлэх эрх
- 29.4 Хуулиар тогтоосон шүүх эрх мэдэл
- 29.5 Хараат бус, бие даасан шүүх
- 29.6 Цэргийн шүүх
  - 29.6.1 Шударга, бие даасан хараат бус шүүх
  - 29.6.2 Цэргийн албан хаагчдыг цэргийн шүүхээр шүүх
  - 29.6.3 Энгийн иргэдийг цэргийн шүүхээр шүүх

**Бүлэг 30. Шүүхийн алдаанаас үүссэн хохиролыг нөхөн төлүүлэх эрх ..... 145**

- 30.1 Шүүхийн алдаанаас үүссэн хохиролыг нөхөн төлүүлэх эрх
- 30.2 Шүүхийн алдаа

**Бүлэг 31. Онцгой нөхцөл байдал үүссэн үед шударгаар шүүгдэх эрх ..... 146**

- 31.1 Хуулийг хэсэгчлэн хүчингүй болгох
- 31.2 Шаардлага ба уялдаа
  - 31.2.1 Онцгой нөхцөл мөн үүссэн үү?
- 31.3 Хязгаарлаж болохгүй эрхүүд
  - 31.3.1 Америк хоорондын тогтолцооны дагуух шүүхийн баталгаа
- 31.4 Шударга шүүхээр шүүгдэх эрхийг хязгаарлахыг хориглосон хэм хэмжээ
  - 31.4.1 Хүний эрхийн Олон Улсын гэрээ
  - 31.4.2 Гэрээний бус хэм хэмжээ
  - 31.4.3 Хүмүүнлэгийн эрх зүй
- 31.5 Олон улсын үүргээ биелүүлэх

**Бүлэг 32. Зэвсэгт мөргөлдөөний үед шүүх шударга байх ... 153**

- 32.1 Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй
  - 32.1.1 Олон улсын зэвсэгт мөргөлдөөн
  - 32.1.2 Олон улсын бус зэвсэгт мөргөлдөөн
  - 32.1.3 Ялгварлан гадуурхагдахгүй байх
  - 32.1.4 Хамгаалалтанд байх хугацаа
  - 32.1.5 Шүүхээр хэргээ шударгаа шүүлгэх эрх
- 32.2 Шүүх хурлаас өмнө
  - 32.2.1 Мэдэгдэл хийх
  - 32.2.2 Гэм буруутай нь нотлоогүй тохиолдолд гэм буруугүйд тооцох
  - 32.2.3 Өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх
- 32.3 Урьдчилан хоригдох үед эдлэх эрх
  - 32.3.1 Эмэгтэйчүүдийг урьдчилан хорих
  - 32.3.2 Хүүхдүүд урьдчилан хоригдох
- 32.4 Шүүхэд эдлэх эрх
  - 32.4.1 Шударга, хараат бус шүүх
  - 32.4.2 Боломжит хугацаанд хэргээ шийдвэрлүүлэх эрх
  - 32.4.3 Өмгөөлүүлэх эрх
  - 32.4.4 Нэг хэрэгт хоёр удаа ял шийтгүүлэхээс хамгаалах
  - 32.4.5 Хууль болон ялыг буцаан хэрэглэхээс хамгаалах
- 32.5 Цаазаар авах ялгүй хэргүүдэд ял шийтгэх
  - 32.5.1 Хоморголон шийтгэхийг хориглох
- 32.6 Цаазаар авах ял оногдуулах хэргүүд

**Хавсралт 1 ..... 167**

**Хавсралт 2 ..... 175**

## Өмнөх үг

Дэвид Вайсброд,

Миннесотагийн их сургуулийн Хуулийн Профессор

Аливаа этгээдийг үйлдсэн гэмт хэрэгт нь шийтгэх болоод гэмт хэргийн сэжигтнээр тагахад тухайн хувь хүн эрх чөлөөгөө гэлтгүй бусад эрхүүдээ алдах эрсдэлтэй байдаг. Шударгаар шүүгдэх эрх нь хувь хүнийг шударга бусаар яллахгүй байхаас хамгаалсан үндсэн эрх юм. Энэ нь Эмнести Интернэшнлийн санааг ихэд зовоодог тухайлбал эрүүдэн шүүгдэхээс ангид байх, амьд явах, улс төрийн эрх буюу үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх гэх мэт эрхүүдийг хангахад зайлшгүй хамгаалалт болж өгдөг.

Шүүн таслах ажиллагааг ажиглах нь хүний эрхийг хамгаалах олон улсын үйл ажиллагааны маш чухал хэсэг юм. Шүүх ажиллагааг ажиглах эрх нь шударга, бас нээлттэй шүүхийг бий болгоно. Нээлттэй шүүхээр шүүгдэх эрхийг олон улсын болон бүс нутгийн нилээд хэдэн хүний эрхийн гэрээ, баримт бичгүүдэд үндсэн суурь эрх хэмээн бэхжүүлж байдаг.

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд “Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, бие даасан шүүхээр адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй”, Гэмт хэрэгт буруутгагдаж буй хэн боловч өмгөөлүүлэх бүх боломжоор хангагдсан нээлттэй шүүх хурлаар гэм буруутайг нь хуулийн дагуу тогтоох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрхтэй” гэсэн байдаг.

Нээлттэй шүүхээр шүүлгэх эрх нь шударга шүүхийг баталгаажуулах үндсэн цөм төдийгүй эрүүдэн шүүх, хүчирхийлэл доромжлолыг буруушаахад тусалдаг. Мөн нээлттэй шүүх нь шүүх үйл явцын шударга байдлыг бататгахад тус дөхөм болно. Олон нийтийн хяналт нь шүүгч болон яллагчийг өөрсдийн үүргээ хүсэл сонирхлын дагуу бус, мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэхэд нөлөөлдөг. Нээлттэй шүүх нь гэрчийг үнэнийг хэлэхэд хүргэж, нотолгоог үнэн зөвөөр бүрдүүлэхэд тусладаг. Мөн яллагдсан хүмүүсийн эрхийн цаана нээлттэй шүүхтэй байх олон нийтийн сонирхол байдаг. Олон нийт шүүх үйл явц хэрхэн явагдаж буйг, шийдвэрүүд хуулийн тогтолцоонд хэр нийцэж буйг мэдэх эрхтэй.

Эмнести Интернэшнл болон хүний эрхийн бусад байгууллага олон жилийн туршид улс төрийн шүүх ажиллагаанд нилээдгүй тооны ажиглагчдаа илгээсэн билээ. Олон улсын шүүх ажиллагааны ажиглагчдыг (Олон улсын засгийн газар хоорондын болон засгийн газрын бус байгууллагуудаас) шүүх хуралд байлгаснаар олон улсын хууль зүйн хэм хэмжээг барьж байна гэсэн үг юм. Энэхүү практик нь олон улсын байгууллага, нийгэмлэгүүдэд аль хэдийн танил болсон арга юм.

Шүүх хурлыг шууд ажиглах, бичмэл протокол буюу тэмдэглэлийг нь үндэслэн үнэлэх зэргээр шүүх таслах ажиллагаа шударга байгааг тодорхойлох олон арга, хэмжүүр байдаг.

Үнэлгээ нь тодорхой хэргийг хэрхэн шийдвэрлэсэн практик нь тухайн шүүх үйл ажиллагаа явуулсан орны хуульд хэрхэн нийцэж байгаа эсэх, эдгээр хууль болон хэргийг шүүсэн практик нь тухайн улсын нэгдэж орсон болон гэрээний бус хэм хэмжээ болон олон улсын хэм хэмжээнд хэрхэн тааруулан нийцүүлсэн эсэхэд үнэлэлт дүгнэлт өгдөг.

Энэ гарын авлагад Хүний эрхийн гэрээний болон гэрээний бус хэм хэмжээнүүдэд нийцсэн шударгаар шүүлгэх эрхийн хэм хэмжээг тусгасан тул хуульч, шүүгч болон бусад хүнд тухайлбал Эмнести Интернэшнлийн ажилтнууд, хүний эрхийн хамгаалагчдад шударга шүүхийг баталгаажуулах, шударгаар шүүлгэх эрхийг хамгаалахад нь тус болно.

## Танилцуулга

### “Хаа нэг газар дахь шударга бус явдал бусад газрын шударга байдалд заналхийлдэг”

Мартин Лютер Кинг

Хүн бүрийн эрхийг хүндлэх нь шударга байдлын үндэс юм. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд “хүн төрөлхтний бүх гишүүдийн заяамал нэр төр болон тэдний адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс мөн” хэмээсэн байдаг.

Хувь хүн эрүүгийн хариуцлагад татагдаж шүүхийн өмнө зогсохдоо тухайн этгээд бүхэл бүтэн төрийн аппараттай сөрөн нүүр тулдаг. Гэмт хэрэгт буруутгагдсан хувь хүнд хэрхэн хандаж байгаа нь тухайн улс хүний эрхийг хэр их хүндэлдэгийн бодит баталгаа мөн. Төр нь хүний эрхийг хэр хүндэтгэж байгааг эрүүгийн шүүх таслах ажиллагаагаар сорьдог. Хэрэв буруутгагдсан этгээд нь үзэл санааны хоригдол, эрх баригчид тухайн хүнээс илүү эрхтэй гэж үзэх үед энэ сорилт бүр ч илүү хатуу тусдаг.

Төр засаг гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шүүх үүрэгтэй. Гэвч хүмүүсийг шударга бусаар шүүсэн үед шударга ёс үйлчлэх боломжгүй. Хууль сахиулагчид хүмүүст эрүү шүүлт тулган, зүй бусаар хандаж, гэм буруугүй хүмүүст хилс хэрэг хүлээлгэж, шүүх ажиллагаа илт шударга бус эсвэл шударга бус хэмээн ойлгогдох үед шүүх тогтолцоо өөрийн шударга байх боломжоо алддаг.

Цагдаагийн хэсэг, байцаалтын өрөө, албадан саатуулах төв, шүүхийн танхим, хорих ангид хүний эрх үгүйсгэгдэх нь Төр засаг үүрэг, хариуцлагаа биелүүлж чадахгүй байна гэсэн үг юм.

Сэжигтэнээр татагдсан мөчөөс эхлэн, баривчлагдах, саатуулагдах, мөрдөн байцаалт, шүүх ажиллагаа болон давж заалдах зэрэг байцаан шийтгэх ажиллагааны бүхий л шатанд хүний эрх зөрчигдөх өндөр эрсдэлтэй нүүрлэнэ. Энэ үе шатуудад хүний эрхийг хамгаалахын тулд олон улсын хамтын нийгэмлэг шударга шүүхийн хэм хэмжээг боловсруулсан.

Шүүхээр шударгаар шүүгдэх нь хүний үндсэн эрх юм. Энэ нь 50 жилийн тэртээ дэлхий даяархи төр засгийн байгуулсан, одоо ч олон улсын хүний эрхийн тогтолцоонд тулгын чулуу болсоор байгаа Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд бүх нийтээрээ хүлээн зөвшөөрөгдсөн суурь зарчим юм. 1948 оноос хойш Хүний Эрхийг Түгээмэл Тунхаглалд хүлээн зөвшөөрөгдсөн шударга шүүхээр шүүгдэх эрх нь олон улсын заншлын эрх зүйн нэг хэсэг болохынхоо хувьд бүхий улс орнуудад хуулийн нэгэн адил үйлчилж байна.

Шүүхээр шударгаар шүүгдэх эрхийг улам баталгаажуулж 1966 онд НҮБ-ын Ерөнхий Ассемблей Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон Улсын Пактанд тусгажээ. Мөн энэ эрх нь НҮБ, бүс нутгийн төр засгийн байгууллагаас батлан гаргасан олон улсын болон бүс нутгийн хэд хэдэн гэрээ хэлэлцээр, гэрээний бус хэм хэмжээнүүдэд тусгалаа олсон байна. Эдгээр хүний эрхийн хэм хэмжээ нь дэлхий дээрх бүх хуулийн тогтолцоонд хамаарч, хуулийн үйл ажиллагааны олон талд байдалд харгалзан үзэхүйц бөгөөд бүхий л тогтолцооны зайлшгүй тавигдах наад захын баталгаа байхаар боловсруулагдсан.

Шударга шүүхийн талаарх олон улсын хүний эрхийн хэм хэмжээ нь төр засаг гэмт хэрэгт яллагдаж буй этгээдэд хэрхэн хандах үнэлгээний шалгуурыг тогтоосон улс гүрнүүдийн хамтын гэрээний үндэс юм.

## Шударга шүүхийн төлөө Эмнести Интернэшнл

Эмнести Интернэшнл нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, бусад олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд заасан хүний эрх, тухайлбал шударга шүүхээр шүүгдэх эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дэлхий нийтийн сайн дурын хөдөлгөөн юм. Иймээс улс төрийн хоригдлуудын болон цаазаар авах ял оногдуулж болзошгүй шүүх ажиллагаанд хөндлөнгийн ажиглалт байнга хийдэг.

Эмнести Интернэшнлийн дүрмийн 1 дүгээр хэсэгт бусад байгууллагуудыг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн улс төрийн хоригдлуудыг шударга шүүхээр шүүлгэхийн төлөө ажиллахыг уриалсан байдаг. Энэхүү зорилтын хүрээнд дэлхийн улс орнуудад шүүх ажиллагааны ажиглагчдаа илгээх, тодорхой зарим орнуудад шударга шүүх ажиллагаанд гарч буй асуудлуудын тухай тайлан илтгэл бэлтгэх, гишүүнчлэлээ улам өргөжүүлэх, улс төрийн хоригдлуудыг шударга шүүхээр шүүлгэх зэрэг ажлуудыг хийж байна. Үүнээс гадна Эмнести Интернэшнл нь шударга бус шүүхээр шүүгдсэн үзэл санааны хоригдлуудын төлөө, цаазаар авах ялыг халах ажиллагаа өрнүүлсээр байна. Эмнести Интернэшнл шударга бусаар шүүгдсэн үзэл санааны хоригдол болон цаазаар авах ялаар шийтгэгдсэн хүмүүсийн талаар тодорхой асуудлуудыг гаргаж тавьсан билээ. Шударга шүүх ажиллагааны талаар асуудал хөндсөн хэд хэдэн хэргийг НҮБ-ын Дур Зоргоор Баривчлах асуудлаархи ажлын хэсэг, шүүхээс гадуур дур зоргоор гүйцэтгэл явуулах талаархи НҮБ-ын Тусгай Илтгэгчид хүргүүлээд байна.

Эмнести Интернэшнл нь Эрүү Шүүлт Тулгахаас Урьдчилан Сэргийлэх 12 зүйлт хөтөлбөр, Сураггүй Алга Болгохын Эсрэг Хөтөлбөр, мөн Шүүхээс гадуур Цаазаар Авах Ялыг гүйцэтгэхээс урьдчилан сэргийлэх 14 зүйлт хөтөлбөрүүдийг боловсруулсан. Эдгээр хөтөлбөр нь Эмнести Интернэшнлийн олон жилийн турш дэлхийн улс орнуудад хуримтлуулсан туршлага дээр үндэслэгдсэн юм. Мөн энэ нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хувь хүнийг хамгаалахтай холбоотой эрхүүдийг нэгтгэсэн бөгөөд бүх төр засаг батлах шаардлагатай гэж үзэж буй хэм хэмжээнүүдийн талаарх Эмнести Интернэшнлийн байр суурийг харуулж байгаа юм.

## Гарын авлагын зорилго

Уг гарын авлага нь шударга ёсны хэм хэмжээнд шүүх тогтолцоо эсвэл эрүүгийн шүүх хэр нийцэж байгаад ажиглалт, хяналт тавих этгээдэд холбогдох хүний эрхийн хэм хэмжээг таниулах зорилготой. Мөн энэ номыг шүүх ажиллагааны ажиглагчид, бусад аливаа нэг хэргийн шударга байдал, шударга шүүхийн олон улсын хэм хэмжээг тухайн орны эрүүгийн шүүх тогтолцоо хэрхэн хүндэтгэн дагаж буйг үнэлж, дүгнэх гэсэн хүн бүрт зориулав.

Эрүүгийн шүүн таслах ажиллагааны шударга байдлыг үнэлэх нь ярвигтай бас олон талтай, цогц байдлаар авч үзэх ёстой асуудал юм. Энэ үнэлгээ нь ихэнхидээ шүүх ажиллагаа дотоодын хууль тогтоомжийн дагуу явагдаж буй эсэх, үндэсний хуулиуд нь олон улсын хэм хэмжээтэй нийцдэг эсэх, хуулийг хэрэгжүүлж буй арга барил нь шударга ёсны зарчимд тулгуурладаг эсэхэд голлон анхаардаг. Заримдаа шүүн таслах ажиллагаа нь аль нэг талаараа дутагдалтай, ихэнхидээ олон улсын хэм хэмжээнд олон талаараа нийцдэггүй.

Шүүх ажиллагааны талаархи олон улсын хэм хэмжээ нь олон янзын арга хэрэгсэлтэй бөгөөд байнга хувьсан өөрчлөгдөж байна. Энэхүү гарын авлага нь эрүүгийн шүүх ажиллагааны шатан дахь хүний эрхийн бүс нутгийн болон олон улсын хэм хэмжээг дэлгэн харуулжээ. Зарим хэм хэмжээ баривчилгааны бүх хэлбэр (захиргааны баривчилгаа), эрүүгийн бус (иргэний) хэрэг зэрэг бүх төрлийн шүүх ажиллагаанд хамаарах боловч уг гарын авлагад зөвхөн эрүүгийн шүүх

ажиллагаанд холбогдох хэм хэмжээг авч үзсэн болно. Практикт аль хэм хэмжээ шаардлагатай байдгийг тодорхой болгохын тулд бүс нутгийн болон НҮБ-ын эрх бүхий байгууллагуудын тухайн хэм хэмжээний талаархи тайлбарыг номондоо оруулав.

Энэ бол шударгаар шүүлгэх эрхийн тухай Эмнести Интернэшнлийн анхны ном бөгөөд бид ямар нэгэн санал хүсэлт, зөвлөгөөг талархан хүлээн авах болно. Санал хүсэлтээ дараах хаягаар илгээгээрэй.

The Legal and International Organizations Program, Amnesty International, International Secretariat, 1 Easton Street, London WC1X 8DJ, United Kingdom

### **Гарын авлагын бүтэц**

Энэ гарын авлага Танилцуулга, Үндсэн хэсэг ба Хавсралт гэсэн 3 гол хэсгээс бүрдэнэ.

Тайлбар хэсэгт агуулгын дэлгэрэнгүй хүснэгт, Холбогдох олон улсын болон бүс нутгийн хэм хэмжээнүүдийн талаарх товч тайлбар, энэ гарын авлагад дурьдсан хэм хэмжээ, байгууллагуудын жагсаалт, нэршлийн хэрэглээ болон байгууллагууд, хэргүүдийг ишлэхэд хэрэглэсэн товчлолуудын жагсаалт зэргийг оруулав.

Гарын авлагын Үндсэн хэсэг нь 3 хэсгээс бүрдэнэ. А хэсэгт, саатуулагдагсдын эрх зэрэг шүүх ажиллагааны өмнөх шатанд эдлэх эрхийн тухай оруулав. Б хэсэгт шүүх хурал, давж заалдах, ял оногдуулах болон ял гүйцэтгэх зэрэг шүүх ажиллагааны үе дэх эрхийн тухай, харин В хэсэгт цаазаар авах ялтай хэргүүд, насанд хүрээгүй хүүхэд, онц байдал зарласан үе болон зэвсэгт мөргөлдөөний үед шударгаар шүүлгэх эрхийн тухай өгүүлэв.

Хавсралт нь 2 хэсгээс бүрдэнэ.

### **Хэм хэмжээнүүдийн эх сурвалжийг хаанаас авч болох вэ?**

НҮБ-ын гэрээний болон гэрээний бус хэм хэмжээ: Номын дэлгүүр, өөрийн орон дахь НҮБ-ын Мэдээллийн Алба, эсвэл дараах хаягаар захидал бичнэ үү:

Office of the UN High Commissioner for Human Rights, United Nations, New York, NY10017, USA

Эсвэл Office of UN High Commissioner for Human Rights, United Nations Office at Geneva, 8-14 avenue de la Paix, 1211 Geneva 10, Switzerland; <http://www.unhchr.ch>

Интернэтээс мэдээлэл хайх зааварчилгааг <http://www.derechos.org/human-rights/manual.htm> эсвэл [manual@desaparecidos.org](mailto:manual@desaparecidos.org) цахим шуудангаас авна уу.

Бүс нутгийн хэмжээг:

Organization of African Unity, POB 3243, Addis Ababa, Ethiopia

Organization of American States, Instituto Interamericano de Derechos Humanos, Aparado Postal 10081-1000, San-Jose, Costa Rica; <http://www.oas.org>

Council of Europe, F-67075, Strasbourg cedex, France <http://stars.coe.fr>

## Олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, байгууллагууд

Энэ бүлэгт шударга шүүхтэй холбоо бүхий олон улсын хүний эрхийн төрөл бүрийн хэм хэмжээ, энэ жишиг хэмжээг хэрхэн тайлбарлах удирдамж, чиглэлээр хангадаг зарим байгууллагуудын талаар тайлбарлах болно.

1. Хүний эрхийн хэм хэмжээ
  - 1.1 Гэрээнүүд
  - 1.2 Гэрээний бус хэм хэмжээ
2. Олон улсын гэрээний хэм хэмжээ
  - 2.1 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
  - 2.2 НҮБ-ын хүний эрхийн бусад гэрээ, конвенцууд
  - 2.3 Зэвсэгт мөргөлдөөний үеэр хэрэглэх хууль
3. Олон улсын гэрээний бус хэм хэмжээ
4. Бүс нутгийн жишиг хэмжээ
  - 4.1 Африк
  - 4.2 Америк
5. НҮБ-ын төрөлжсөн механизм
6. Олон улсын эрүүгийн шүүх

### 1. Хүний эрхийн хэм хэмжээ

Уг гарын авлагад дурьдагдаж буй хэм хэмжээ нь эрх зүйн янз бүрийн өөр хүчин чадалтай. Зарим нь зөвхөн тухайн гэрээг дагаж мөрдөхөө хүлээн зөвшөөрсөн улс орнуудад л хүчин төгөлдөр үйлчилдэг. Бусад /гэрээний бус/ нь улс орнуудын мөрдвөл зохих хэм хэмжээний олон улсын хамтын нийгэмлэгийн зөвшилцлийг илэрхийлдэг. Энэ нь хамтдаа шударга бус шүүх ажиллагаанаас хамгаалах олон улсын эрх зүйн суурь юм. Олон улсын эрх зүйн эдгээр баримт бичиг нь хорьдугаар зууны 2-р хагасаас эхлэн дэлхийн бүхий л үндэстэн хүн бүрийн ололт амжилтын нийтлэг хэм хэмжээ болтлоо хөгжижээ.

Хүний эрхийн байгууллагынхаа хувьд Эмнести Интернэшнл нь улс орнуудад хамаарах хамгаалах үүрэгтэй хэм хэмжээг ишлэл болгодог. Ерөнхийдөө энэ гарын авлага улс орнуудын хамгаалах үүрэгтэй эрхүүдийг тусгасан гэрээнүүдийн холбогдох хэсэгт анхаарлаа хандуулна. Зарим улс орнууд гэрээнд нэгдэн орохоор хүлээн зөвшөөрөөгүй байдгаас тухайн гэрээг хэрэглэх боломжгүй байдаг бол зарим тохиолдолд тухайн асуудалд гэрээний бус хэм хэмжээнд илүү тодорхой заагдсан байх нь бий. Ямар ч тохиолдолд Эмнести Интернэшнл байгууллага нь олон улсаар хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг дагаж мөрдөж ажиллахыг нь дэмжих, дэлгэрүүлэх чиглэлээр ажилладаг.

#### 1.1 Гэрээ

Конвенц, Пакт, Протокол, Дүрэм гэх мэтээр нэршсэн хэм хэмжээнүүд нь нэгдэж орохоор хүлээн зөвшөөрсөн орнуудад л хуулийн адил хүчин төгөлдөр байдаг юм. Иргэний болон Улс Төрийн Эрхийн Олон Улсын Пакт, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц зэрэг зарим гэрээ нь дэлхий даяарх улс орнууд нэгдэн ороход нээлттэй байдаг. Бусад гэрээний хувьд тодорхой бүс нутгийг хамарсан байдаг бөгөөд зөвхөн тухайн бүс нутгийн улс орнуудад л даган мөрдөнө<sup>1</sup>.

Улс орнууд гэрээг хоёр янзаар хүлээн зөвшөөрч, нэгдэн ордог. Тэд гарын үсэг зурах, соёрхон батламжлах гэсэн хоёр үе шатыг дамжих эсвэл зөвхөн нэгдэн орох гэсэн нэг алхамыг хэрэгжүүлж болно. Тухайн улс гэрээнд гарын үсэг зурна

#### Ишлэл

<sup>1</sup> Үүнд Хүний ба улс түмний эрхийн Африкийн Дүрэм, Хүний эрхийн тухай Америкийн Конвенц болон Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын Конвенц

гэдэг нь дараа тухайн гэрээг соёрхон батлана гэдгээ албан ёсоор мэдэгдэж буй хэрэг юм.

Хэрэв гэрээнд нэгдэн орсон л бол тухайн гэрээний зорилго, зорилттой зөрчилдөх аливаа үйл ажиллагаанд оролцож болохгүй. Гэрээг соёрхон батлаж эсвэл нэгдэн орсон л бол тухайн улс нь гэрээнд оролцогч тал болно. Аливаа гэрээнд оролцогч тал нь тухайн гэрээнд тусгагдсан бүх заалтыг даган мөрдөж, гэрээний дагуу хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх ёстой байдаг.

Протокол нь өөр нэгэн гэрээнд нэмэлт болгон хавсаргасан гэрээ юм. Энэ нь ерөнхийдөө эх гэрээнд онцгой, нэмэлт заалт оруулах, хамрах хүрээг тэлэх, гомдолын механизмыг бий болгодог. Протокол нь тухайн улс түүнийг соёрхон батлах юм уу, нэгдсэн орсон үед хуулийн нэгэн адил хүчин чадалтай.

Олон улсын гэрээнүүдийн заалтыг тайлбарлах зааврыг Хүний эрхийн шүүх, Гэрээний хяналтын байгууллагын шийдвэр, тогтоол, зөвлөмжөөр өгдөг.

Гэрээний заалтыг зөрчиж буй талаарх гомдлыг мөрдөн шалгах, хэрэгжилтэнд хяналт тавих зорилгоор гэрээний хүрээнд эсвэл НҮБ болон бүс нутгийн байгууллага ийм байгууллагуудыг бий болгодог.

НҮБ-ын Дур зоргоороо баривчлах асуудлаарх ажлын хэсэг, НҮБ-ын Хүний эрхийн Комиссын тусгай илтгэгч гэх мэт засгийн газар хоорондын байгууллагуудын гаргасан тайлбар нь мөн хүчин төгөлдөр эрх бүхий удирдамж байна.<sup>2</sup>

## 1.2 Гэрээний бус хэм хэмжээ

Гэрээний бус хэм хэмжээнд шударга шүүн таслах ажиллагаатай холбоотой хүний эрхийн нилээд хэдэн хэм хэмжээ тусгалаа олсон. Гэрээний бус хэм хэмжээ нь ихэнхидээ Тунхаглал, Зарчим, Дүрэм гэх мэтээр нэрлэгддэг. Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон бүх хүнийг хамгаалах зарчим, Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм зэрэг нь шударга шүүх ажиллагааг баталгаажуулж тусгасан гэрээний бус хэм хэмжээний жишээ юм. Хэдийгээр эдгээр нь гэрээ шиг хуулийн хүчин чадалгүй боловч олон жилийн турш засгийн газруудаар хэлэлцэгдэж, НҮБ-ын Ерөнхий Ассамблей зэрэг улс төрийн байгууллагуудад ихэвчлэн зөвшилцөлөөр батлагддаг тул дагуулах хүчтэй байдаг. Эдгээр улс төрийн хүчнээс шалтгаалан гэрээний бус хэм хэмжээ нь гэрээний адил хүчин төгөлдөр хэмээн тооцогддог. Гэрээний бус хэм хэмжээ нь заримдаа олон улсын заншлын эрх зүйн дагуу бүх улсуудад хуулийн адил хүчин төгөлдөр үйлчлэхээр аль хэдийн тогтсон зарчмуудыг дахин баталгаажуулдаг.

## 2. Олон улсын гэрээний хэм хэмжээ

Оролцогч тал нь заавал хэрэгжүүлэхээр үүрэг хүлээсэн доорхи олон улсын гэрээнүүд нь шударга шүүх ажиллагааг баталгаажуулсан заалтуудтай тул энэхүү гарын авлагад тусгагдсан болно.

### 2.1 Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт нь 1966 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгээр батлагдсан бөгөөд 1976 оноос хүчин төгөлдөр болсон юм. 1998 оны 10 дугаар сарын байдлаар 140 орон тус гэрээнд нэгдэн ороод байна. ИУТЭОУП нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд дурдагдсан иргэний болон улс төрийн эрхийг дэлгэрүүлж, гүнзгийрүүлэн, соёрхон баталсан буюу нэгдэн орсон

#### Ишлэл

<sup>2</sup> Шүүхийн шийдвэр, хууль зүйн ухааны эрдэмтэд болон Олон Улаан Загалмайн нийгэмлэг зэрэг төрийн бус байгууллагуудын тайлбар зэрэг болно.



улс орондоо хүчин төгөлдөр хэрэгжих гэрээ болгон төрөлжүүлжээ. ИУТЭОУП нь хүний үндсэн эрхүүд тухайлбал Эмнести Интернэшнл байгууллагын дэмжин ажилладаг амьд явах эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, чөлөөтэй хуран чуулах, эвлэлдэн нэгдэх эрх, хуулиас гадуур дур зоргоороо баривчилагдахаас ангид байх, эрүү шүүлт, хэрцгий хүнлэг бус харьцаанаас ангид байх мөн шударга шүүхээр шүүлгэх гэх зэрэг эрхүүдийг хамгаалдаг.

ИУТЭОУП нь хянах эрх бүхий 18 шинжээчтэй Хүний эрхийн хороотой. Тус Хүний Эрхийн Хорооноос гаргасан ерөнхий зөвлөмж нь ИУТЭОУП-ыг тайлбарлахад мөрдөх ёстой удирдамж болдог. Тэдгээрийн заримыг энэ гарын авлагын Хавсралт 1 хэсэгт оруулав.

Тус Хүний эрхийн комисс нь ИУТЭОУП болон түүний хоёр нэмэлт протоколын биелэлтийг хянадаг. Гэрээнд Оролцогч талууд нь ИУТЭОУП-ын 40-р зүйлд заасны дагуу тогтоосон хугацаанд тус Хүний эрхийн хороонд хэрэгжилтийнхээ талаархи илтгэл, мөн шаардлагатай үед тусгай илтгэл өргөн барих ёстой.

Уг Хүний эрхийн хороо нь нэг улс нөгөө улсын талаар гаргаж буй гомдлыг авч үзнэ. Ингэхдээ ИУТЭОУП-ын 41 дүгээр зүйлийн дагуу оролцогч талууд Хорооны гомдлыг хянан шалгах чадамжийг албан ёсоор хүлээн зөвшөөрч буйгаа мэдэгдсэн үед Хүний Эрхийн Хороо нэг орны нөгөөгийнхөө эсрэг гаргасан гомдлыг хянаж болно. /Пактад оролцогч улсууд НҮБ-ын болоод Бүс нутгийн хүний эрхийн нилээд хэдэн гэрээнд тусгагдсан гомдол гаргах эрхээ тун ховорхон хэрэглэдэг./

**Иргэний болон улс төрийн эрхийн тухай 1-р нэмэлт протокол 1976** оноос хүчин төгөлдөр болсон бөгөөд ИУТЭОУП-аар хамгаалагдсан эрхийг тус Протоколд нэгдэж орсон улс зөрчиж буй талаарх хувь хүн эсвэл түүний нэрийн өмнөөс гарсан гомдол, нэхэмжлэлийг хянах эрхийг Тус Хороонд олгожээ. 1998 оны 10 дугаар сарын байдлаар 92 орон тус протоколд нэгдэж ороод байна.

Энэхүү гарын авлагад тус Нэмэлт Протоколын дагуу Хороо хувь хүний гомдлыг хэрхэн авч үзсэн талаар тусгасан болно.

**Цаазаар авах ялыг халах зорилго бүхий Иргэний болон улс төрийн эрхийн тухайн олон улсын пактын 2-р нэмэлт протокол/** ИУТЭОУП-ын 2-р нэмэлт протокол/-ыг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1989 онд батлаж, 1991 оноос хүчин төгөлдөр болсон. Энэ Протоколд оролцогч улс нь энхийн цагт нэг ч хүн цаазаар авахуулах ёсгүй гэдгийг хүлээн зөвшөөрч, цаазаар авах ялыг халах бүхий л шаардлагатай арга хэмжээг авна. 1998 оны 10 дугаар сарын байдлаар 33 улс нэгдсэн байна.

## 2.2 НҮБ-ын хүний эрхийн бусад гэрээ

**Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах тухай Конвенц /Эрүү шүүлтийн эсрэг конвенц/** нь 1984 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн зөвшилцлөөр батлагдсан бөгөөд 1987 онд хүчин төгөлдөр болсон. 1998 оны 10 дугаар сар гэхэд 109 орон уг гэрээнд нэгдэн ороод байна. Конвенцид оролцогч улс өөрийн орны шүүх эрх мэдлийн хүрээнд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, эрүү шүүлттэй холбоотой аливаа гомдлыг мөрдөн шалгаж, эрүү шүүлт тулгагчийг шүүхийн өмнө аваачихын хамт эрүүдэн шүүгдсэн хэнд ч шүүх ажиллагааны явцад шударгаар хандах, эрүү шүүлт тулган авсан баримтыг нотлох баримтад тооцохгүй байх, мөн хохирогчдод нөхөн олговор олгох ёстой. Эрүү шүүлтийн эсрэг хороо Конвенцийн биелэлт хэр байгаа талаарх оролцогч орнуудын илтгэлийг авч үзэх, асуулга явуулах, шийдвэр гаргах, хийхийг нь хүлээн зөвшөөрсөн үед хувь хүний хэргийг шалгах гэм мэтчилэнгээр Конвенцийн биелэлтийг хянах үүрэгтэй.

### Ишлэл

3 Конвенцийн хэлэлцүүлгийн тухай нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл: Эмнести Интернэшнл, Хүүхдийн Эрхийн Конвенц, индекс: IOR 51/09/94 1994 оны 10 дугаар сар

**Хүүхдийн эрхийн тухай конвенц** нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар 1989 онд батлагдаж, 1990 онд хүчин төгөлдөр болсон.<sup>3</sup> 1998 оны 10 дугаар сар гэхэд АНУ, Сомали 2-оос бусад бүх НҮБ-ын гишүүн орнууд буюу 191 орон уг конвенцид нэгдэн оржээ. Хүүхдийн эрхийн конвенцид эрүүгийн хуулийг зөрчсөн гэж шийтгэгдэж буй хүүхдэд шударга шүүхээр шүүлгэх баталгааг тусгасан байдаг. Тус конвенц нь конвенцид оролцогч улсууд конвенцийн дагуу хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж буйг хянадаг. Хүүхдийн эрхийн Хороог байгуулсан. Оролцогч улсууд нь тус хороонд тогтмол илтгэл тайлангаа явуулж байх үүрэгтэй.

**Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц** /Эмэгтэйчүүдийн конвенц/ нь 1979 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар 1979 онд батлагдаж, 1981 оноос хүчин төгөлдөр болсон. 1998 оны 10 дугаар сарын байдлаар 162 орон тус конвенцид нэгдэн оржээ. Энэхүү конвенц нь эмэгтэйчүүдийн эсрэг бүхий л ялгаварлан гадуурхах хэлбэрээс эмэгтэйчүүдийг үр дүнтэй хамгаалах зорилготой.

Тус конвенцийн 2 болон 15 дугаар зүйл нь эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдийн нэгэн адил хуулийн өмнө тэгш эрхтэй хэмээн заасан байдаг. Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах хороо нь тус конвенцийн 17-р заалтын дагуу конвенцийн хэрэгжилтийг хянах, оролцогч улс орнуудаас ирүүлж буй илтгэлтэй танилцах, судалгаа явуулах зэрэг үүрэгтэйгээр байгуулагдсан.

**Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийг** /Арьс өнгөний эсрэг конвенц/ НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1965 онд баталж, 1969 онд хүчин төгөлдөр болжээ. 1998 оны 10 сарын байдлаар 151 орон тус конвенцид нэгдэж орсон байна. Конвенцид оролцогч улсууд нь арьс өнгөөр ялгаварлах явдлыг буруушааж, шүүх засаглал гээд бүхий л боломжтой аргаар устгах үүрэгтэй. Арьс өнгөөр ялгаварлах хэлбэрийг устгах хороо нь тус конвенцийн хэрэгжилтийг хянана.

### 2.3 Зэвсэгт мөргөлдөөнийг зохицуулах хуулиуд

Зэвсэгт мөргөлдөөний үед болон дотоодын зөрчилдөөн, иргэний дайн гэх мэт дайсагналцлаас иргэд, хүн амыг хамгаалах талаарх 1949 оны **Женевийн 4 конвенц** нь шударга шүүх ажиллагааны талаарх заалтуудыг мөн багтаасан байдаг. 1998 оны 2 дугаар сарын байдлаар 188 улс уг гэрээнүүдэд нэгдэн оржээ. Уг конвенцийн **1 дугаар Нэмэлт Протоколоор** (150 улс) олон улсын зэвсэгт мөргөлдөөний үед энгийн иргэдийг хамгаалах цар хүрээг тэлсэн бөгөөд 142 орон нэгдэж орсон **2 дугаар Нэмэлт Протоколд** дотоодын зэвсэгт мөргөлдөөний үед энгийн иргэдийг хамгаалдаг.

## 3. Олон улсын гэрээний бус хэм хэмжээ

Шударга шүүхтэй холбоотой олон улсын гэрээний бус зарим хэм хэмжээг доор тайлбарлав. Энэ гарын авлагад дурьдсан гэрээний бус бүх хэм хэмжээ нь Хэм Хэмжээ болон Байгууллагууд хэсэгт мөн тусгагдсан болно.

**Хүний эрхийн түгээмэл тунхаглал /ХЭТТ/** нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар 1948 онд батлагдсан бөгөөд бүхий л улс орнуудын үйл ажиллагааг зохицуулах ёстой дэлхий даяар хүлээн зөвшөөрөгдсөн зарчмуудын цогц юм. Уг тунхаглалын 10, 11-р зүйлүүдэд шударга шүүхийн тухай тусгасан. ХЭТТ-д тусгагдсан шударга шүүхээр шүүлгэх эрх нь олон улсын заншлын эрх зүй, ихэнх улс орнуудын эрх зүйн ерөнхий зарчмын нэг хэсэг болохынхоо хувьд маш өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд бүхий л оронд хүчин төгөлдөр үйлчилдэг. ХЭТТ нь олон улсын болоод бүс нутгийн гэрээ, хэм хэмжээнүүдийн эх сурвалж болдог.

#### Ишлэл

4. Жишээ нь: Арабын Улсуудын Холбоо Хүний эрхийн тухай Арабын Дүрмийг баталсан (хараахан хүчин төгөлдөр болоогүй): Хүний эрхийн тухай Арабын Дүрэм 1994 оны 9 дүгээр сарын 15-нд батлагдсан. Хүний Эрхийн Эрх зүйн Сэтгүүл 18 (1997), хуудас 151 (Англи орчуулга)  
Хүний эрхийн тухай Арабын Дүрмийн тайлбарыг Мона Ришмави, “Хүний эрхийн тухай Арабын Дүрэм: Тайлбар” Интеррайтс Буллэтн 10, 1996 он хуудас 8;

Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмууд нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар 1988 онд батлагдсан бөгөөд саатууулагдагч болон хоригдогч нартай хэрхэн харьцах талаархи олон улсын хэм хэмжээг агуулсан юм.

## 4. Бүс нутгийн гэрээний хэм хэмжээ

Бүс нутгийн засгийн газар хоорондын байгууллагууд нь хүний эрхийг хамгаалах хүрээнд бүс нутгийн гэрээ болон тунхаглал батлан гаргадаг. Эдгээр хэм хэмжээ нь ерөнхийдөө тухайн бүсийн байгууллагад гишүүнчлэлтэй улс орнуудад хамаарна. Энэ гарын авлагад Африкийн Холбоо, Америкийн улсуудын байгууллага, Европын Зөвлөл зэрэг бүс нутгийн хэмжээний байгууллагуудыг дурьдлаа. Эдгээрээс гадна энэхүү тайланд дурдагдаагүй хүний эрх, шударга шүүхээр шүүлгэх эрхийг хамгаалсан олон арван бүс нутгийн гэрээ, хэм хэмжээ бий<sup>4</sup>.

### 4.1 Африк

**Хүний ба Улс Түмний Эрхийн тухай Африкийн Дүрэм** (Африкийн Дүрэм) – ийг 1981 онд Африкийн Холбоо батлаж 1986 оноос хүчин төгөлдөр болсон. 1998 оны 10 дугаар сарын байдлаар Эритрейгээс бусад Африкийн Холбооны гишүүн 52 орон дээрх Дүрэмд орсон байна<sup>5</sup>.

Энэхүү тунхаглалын өөрт тулгарсан аливаа асуудлыг мэдэгдэх эрхийн хүрээнд шударга, бие даасан шүүхийн асуудал хөндөгдөж байгаа юм.

**Хүний ба Улс Түмний Эрхийн Төлөөх Африкийн Комисс**(Африкийн Комисс) нь Африкийн Дүрмийн хэрэгжилтийг хянадаг. Энэ нь 11 гишүүнээс бүрдэх бөгөөд оролцогч талууд нэр дэвшүүлэн Төр Засгийн Тэргүүнүүдийн Африкийн Холбооны Ассамблейгаас сонгодог. Уг комисс нь бүсийн нутгийн хэмжээнд хүний эрхийн тухай ойлголтыг түгээн дэлгэрүүлэх, таниулах, хамгаалах болон аливаа нэг улс дүрмийн заалтыг зөрчсөн гэх улс хоорондын нэхэмжлэлийг хүлээн авч хянах эрхтэй. Комисс нь зөвхөн гишүүн улсууд төдийгүй тэдгээрийн иргэд хоорондын харилцааг хянах, шүүн таслах бүрэн эрхтэй.

Африкийн Комисс мөн дараах бүрэн эрхтэй: “хүний болон ард түмний эрх, үндсэн эрх чөлөөнд холбогдох эрх зүйн асуудлыг шийдэхэд чиглэсэн зарчмууд болон дүрмийг боловсруулж, батлах эрхтэй бөгөөд тэдгээрийг үндэслэн Африкийн засгийн газрууд өөрсдийн хууль тогтоомжийг гаргана” (45(1)(b) зүйл

1992 онд Комисс Африкийн Дүрэм дэх шударга шүүхээр шүүлгэх баталгааны цар хүрээг өргөжүүлж, хүчирхэгжүүлсэн **Шударга Шүүхээр Шүүлгэх болон Шүүхэд Хандах Эрхийн талаарх Тогтоолыг** гаргажээ.

1998 оны 2 дугаар сард болсон чуулга уулзалтын үр дүнд Африкийн холбооны байгууллагын сайд нарын зөвлөл Африкийн дүрэйн нэмэлт болгон Хүний ба Улс Түмний Эрхийн төлөөх Африкийн Шүүхийн тухай нэмэлт протоколыг баталсан юм. Африкийн хүний эрхийн шүүх байгуулагдвал Африкийн зөвлөлийн хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд чухал түлхэц болж өгөх юм. Мөн Африкийн Дүрэм, Африкийн Комисс болон Африкийн холбооны гишүүн улс орнуудын хүсэлтээр заавар, зөвлөмж өгөх боломжтой болно. 1998 оны 10 дугаар сарын байдлаар 30 улс уг протоколд гарын үсэг зурж, нэг улс соёрхон батлаад байна. 15 улс уг протоколыг соёрхон баталсан тохиолдолд Африкийн шүүх байгуулагдаж үйл ажиллагаагаа эхлүүлэх болно.

#### Ишлэл

5. Дүрмийн хэлэлцүүлгийн тухай нэмэлт мэдээлэл: Эмнести Интернэшнл, Хүний ба улс түмний эрхийн тухай Африкийн Дүрмийн шинэчлэлийн асуудлаарх Эмнести Интернэшнлийн судалгаа, Эмнести Интернэшнл индекс: IOR 63/03/93, 1993 он.

## 4.2 Америк

**Хүний эрх, үүргийн тухай Америкийн Тунхаглал** (Америкийн Тунхаглал) нь 1948 онд болсон Америкийн Улсуудын 9 дүгээр Хурлаас Америкийн улсуудын байгууллагын тунхаглалтай хамт батлагдан гарсан юм. Энэ нь Америкийн улсуудын хүний эрхийг хамгаалах тогтолцооны үндэс суурь болсон ба Америкийн Улсуудын Байгууллагын Дүрмийн гишүүн улс орнууд уг баримт бичигт заагдсан эрхүүдийг хангах үүрэгтэй. Тунхаглалын 26 дугаар зүйлд эрх зүйн зохих процедурыг хангах эрхийг тусгажээ.

**Хүний Эрхийн Тухай Америкийн конвенц** (Америкийн конвенц), Коста Рикагийн Сан Хосен Пакт нь 1969 онд батлагдаж, 1978 оны 7 дугаар сараас хүчин төгөлдөр болсон. Уг конвенц нь Америкийн Улсуудын Байгууллагын гишүүн орнууд нэгдэн ороход нээлттэй бөгөөд 1998 оны 7 дугаар сарын байдлаар нийт 35 гишүүн орноос 25 нь дээрх конвенцид нэгдэн орсон байна. Уг конвенцийн 8-р зүйлд шударга шүүхээр шүүлгэх эрхийн тухай орсон байдаг. Уг конвенцоор Америк Дундын Хүний Эрхийн Комисс болон Америк Дундын Хүний Эрхийн Шүүхэд гишүүн улс орнуудыг конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсхийг шалгах бүрэн эрхийг олгодог. Энэхүү конвенцийг соёрхон баталснаар Комиссын бүрэн эрхийг шууд хүлээн зөвшөөрч байна гэсэн үг юм. Гэвч Конвенцийн 62-р зүйлийн дагуу оролцогч улс орнууд Шүүхийн шүүх эрх мэдлийг хүлээн зөвшөөрч байгаагаа мэдэгдэх ёстой. 1998 оны 7 дугаар сарын байдлаар 17 улс орон шүүхийн эрх мэдлийг хүлээн зөвшөөрчээ.

**Америкийн Хүний Эрхийн Конвенцийн Цаазаар Авах Ялыг Халах Нэмэлт Протоколыг** 1990 онд Америкийн Улсуудын Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас батлан гаргажээ. Уг протоколд нэгдэн орсон улсууд энхийн цагт өөрийн улс нутаг дэвсгэрт цаазаар авах ялыг бүр мөсөн хориглох үүрэг хүлээдэг. 1998 оны 7 дугаар сарын байдлаар 4 улс уг протоколыг соёрхон баталж, 3 улс гарын үсэг зураад байв.

**Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэгт хэрэгт ял, шийтгэл оноох тухай Америкийн Улсуудын Конвенц** (Эрүүдэн шүүхийн тухай Америк Улсуудын Конвенц) нь 1985 оны хуралдаанаас батлагдан гарсан бөгөөд 1987 оны 2 дугаар сараас хүчин төгөлдөр болсон. Уг конвенцид нэгдэн орсон улс орнууд дээрх конвенцийг дотоодын хууль тогтоомжтой нийцүүлэх талаар авсан арга хэмжээнийхээ тайланг Америк дундын хүний эрхийн комисст өгөх үүрэгтэй. 1998 оны 7-р сарын байдлаар 13 улс уг конвенцид нэгдэн ороод байна.

**Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах, түүнээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулах тухай Америк дундын конвенц** (Белем До Пара-гийн конвенц) нь 1994 оны 6 дугаар сард Ерөнхий Ассамблейгаар батлагдаж, 1995 онд хүчин төгөлдөр болсон. 1998 оны 7-р сарын байдлаар энэхүү конвенц нь хамгийн их дэмжигдэж, соёрхон батлагдсан конвенц болсон ба 27 улс нэгджээ.

**Хүчээр сураггүй алга бологсдын тухай Америкийн улсуудын Конвенц** (Сураггүй алга бологсдын тухай Америкийн Улсуудын Конвенц)-ыг 1994 онд Америкийн Улсуудын Байгууллага баталж, 1996 оноос хүчин төгөлдөр үйлчлэх болсон. Энэ нь бүс нутаг дахь “сураггүй алга болох явдал”-аас урьдчилан сэргийлэх, хэргийг шийдвэрлэх, бүр мөсөн таслан зогсооход чиглэж байгаа юм. Зөвхөн тухайн бүс нутгийн байгууллагын гишүүн орнууд нэгдэх боломжтой байдаг дийлэнх бүс нутгийн гэрээнүүдээс ялгаатай нь уг Конвенцид бүх улс орнууд нэгдэн ороход нээлттэй байдаг. 1998 оны 7 дугаар сарын байдлаар 5 орон соёрхон баталж, 8 орон гарын үсэг зуржээ.

**Америк Дундын Хүний Эрхийн Комисс** (Америк Дундын Комисс) нь хүний эрхийг хамгаалалт, биелэлтийг дэмжих, эдгээр асуудал дээр АУБ-ын

гишүүн орнуудад зөвлөх үүрэгтэйгээр байгуулагджээ. Мөн Комисс нь гишүүн орнуудын маргаан, хүсэлт дээр тулгуурлан хэргийн газарт очих, тусгай судалгаа бэлтгэх, хүний эрхийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх зөвлөмжийг газрын газруудад өгөх, мөн засгийн газруудаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайлан илтгэлийг хүлээн авах зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

Хувь хүмүүс, бүлэг эсвэл төрийн бус байгууллагуудаас Америкийн Тунхаглалд тусгагдсан эрхүүд зөрчигдсэн тухай, харин засгийн газруудаас Америкийн Конвенцэд дурьдсан эрх зөрчигдсэн тухай нэхэмжлэлийг хүлээн авч, шийдвэрлэдэг. Яаралтай үед Комисс хүмүүсийг гэм хороос хамгаалахын тулд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах хүсэлт гаргаж болно. Түүнчлэн, Комисс онцгой болон маш яаралтай тохиолдолд, хүмүүст учирч болзошгүй хэзээ ч нөхөгдөшгүй хохирлыг зайлуулах шаардлагатай бол Шүүх асуудалд тохирох түр арга хэмжээ авахыг хүсч болно.

**Америк Дундын Хүний Эрхийн Шүүх** (Америк Дундын Шүүх) нь АУБ-ын гишүүн орнуудаас сонгогдсон 7 шүүгч бүхий олон улсын шүүх бөгөөд Коста Рикад төв нь байрладаг. Шүүхийн зорилго нь Америкийн Конвенцийг тайлбарлах, хэрэглэх явдал юм. Америк Дундын Комисс эсвэл шүүхийн шүүх эрх мэдлийн хүлээн зөвшөөрсөн тохиолдолд оролцогч орнуудын өргөн барьсан хэргийг шүүн хэлэлцүүлнэ. Шүүхийн шийдвэр нь оролцогч талуудад хүчин төгөлдөр хэрэгжинэ. Яаралтай тохиолдолд, учирч болзошгүй хохирлоос сэргийлэх үүднээс Шүүх түр арга хэмжээ авахыг тушааж болно. Америк Дундын Шүүх маш өргөн хүрээтэй зөвлөх үүрэг гүйцэтгэх бөгөөд Америкийн Хүний Эрхийн Конвенцийн зүйл заалтын тайлбарт зөвлөмж санал өгдөг. 1998 оны 7 дугаар сарыг хүртэл тэдний хэвлэсэн 15 зөвлөмж санал нь Америк дундын тогтолцооны эрх зүйн судалгааны чухал хэсэг болж байна.

### 4.3 Европ

**Европын Хүний Эрхийн Конвенц** (Европын Конвенц) нь 1953 онд хүчин төгөлдөр болсон. Энэхүү конвенцийг соёрхон баталсан эсвэл нэгдэн орсон улс л Европын зөвлөлд орох эрхтэй болдог. 1998 оны 9 дүгээр сарын байдлаар Европын Зөвлөлийн гишүүн 40 улс энэхүү конвенцид нэгдэн оржээ. Конвенцийн 3, 5, 6, 7-р зүйлд шударга шүүхээр шүүлгэх эрхийн тухай заалт орсон байдаг.

**Уг Конвенцийн Цаазаар Авах Ялыг Халах тухай 6 дугаар Нэмэлт Протокол** нь (Европын Конвенцийн 6 дугаар Протокол) 1985 онд хүчин төгөлдөр болсон. Уг протоколоор энхийн цагт цаазаар авах ял хэрэглэхийг хориглодог. 1998 оны 9 дүгээр сарын байдлаар 28 орон уг протоколд нэгдэн орсон.

**Дээрх конвенцийн 7 дугаар протокол** нь 1988 онд хүчин төгөлдөр болсон. Уг протоколд гадаадын иргэдийг хамгаалах мөн дээд шүүхээр эрүүгийн ял шийтгэлээ дахин хянуулах эрх зэрэг эрхүүдийг тусгасан байдаг. Мөн нэг хэргээр нэгээс дээшгүй удаа шүүлгэж ял сонгохгүй байх эрхийг хамгаалсан байдаг. Уг протоколд шүүхийн алдаанаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг тусгажээ. 1998 оны 9 дүгээр сарын байдлаар нийт 26 орон нэгдээд байна.

**Европын Хүний Эрхийн Комисс** нь Европын Конвенцийн хэрэгжилтийг хянадаг. Хэрэв хоёр тал хоёулаа Конвенцид нэгдсэн улс орнууд бол Комисс Конвенцийг зөрчсөн тухай улс хоорондын нэхэмжлэлийг хүлээн авч шалгадаг. Хэрэв Конвенц зөрчсөн гэгдэх улм нь Комиссын нэхэмжлэл хүлээн авах эрхийг хүлээн зөвшөөрсөн улс орон байвал Комисс хувь хүн, бүлэг, төрийн бус байгууллагуудын гаргасан нэхэмжлэлийг мөн шалгаж болно.

**Европын хүний эрхийн шүүх** буюу Европын шүүх нь Европын конвенцид нэгдсэн эсэхээс үл хамааран нийт Европын зөвлөлийн гишүүн орнуудын тоотой тэнцэхүйц хэмжээний шүүгчидтэй. Европын шүүхээс гаргасан шийдвэрийг дээрх

конвенцид нэгдэн орсон улс орнууд заавал биелүүлэх шинж чанартай байдаг. Европын Конвенцид нэгдсэн улс орнууд болон Европын Комисс нь Европын Шүүхэд хэрэг үүсгэх эрхтэй бөгөөд Европын шүүх Конвенцийн тайлбар, хэрэглээтэй холбоотой хэргүүдийг шүүх эрх мэдэлтэй юм.

11 дүгээр протоколоор уг 2 байгууллага 1998 оны 11 дүгээр сарын 1-нд нэгдэн **Европын Хүний Эрхийн Шүүх** болсон. Иргэд болон хувь хүмүүс уг шүүхэд шууд нэхэмжлэл, гомдол гаргах эрхтэй. Европын зөвлөлд гишүүнчлэлтэй 40 орон бүгдээрээ 11 дүгээр протоколд нэгдэн орсон байна.

Европын сайд нарын зөвлөл 1973 онд **Европын Шоронгийн Дүрмийг** батласан бөгөөд 1987 онд нэмэлт өөрчлөлт оруулан дахин шинэчлэжээ. Дээрх энэ нь заавал даган мөрдөх шинж чанартай биш хэдий ч хоригдогсодтой харьцах наад захын жишиг дүрэм болж өгдөг байна. Уг дүрмээр эрүү шүүлт, хүнлэг бус харьцааг хориглож, яллагдсан болон шүүн таслагдаагүй хоригдлуудыг тусад нь хорих хэрэгтэй хэмээн үзэж хоригдлуудын өөр өөр ангиллуудын зарчмыг гаргажээ.

Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Байгууллага нь Европын зөвлөлд гишүүнчлэлтэй бүх улсуудаас гадна Төв Азийн улсууд, Канад, АНУ гишүүнчилдэг маш өргөн хүрээг хамардаг байгууллага юм. Тус байгууллагаас 1990 оны Копенгаген, 1991 оны Москвад болсон дээд хэмжээний уулзалтаараа Европын Конвенцийн заалт болон НҮБ-ын хэм хэмжээг өргөн хүрээнд дахин баталгаажуулсан шударга шүүхийн хамгаалалтыг багтаасан маш нарийн тодорхой, улс төрийн хувьд заавал дагах хүний эрхийн амлалтыг баталжээ.

## 5. НҮБ-ын хүний эрхийг хангах механизм

НҮБ-ын гэрээ, конвенцуудын хэрэгжилтийг хянадаг байгууллагаас гадна НҮБ-ын Хүний Эрхийн Комиссоос томилогдсон мэргэжилтнүүд ( ажлын хэсэг болон тусгай илтгэгчид) хүний эрхийн хэм хэмжээний хэрэглээний талаар зааварчилгаа өгдөг. Үүнийг НҮБ-ын хүний эрхийг хангах механизм гэдэг.

Эдгээр механизм нь ерөнхийдөө аливаа улс хүний эрхийн конвенцид нэгдэн орсон эсэхээс үл хамааран дэлхийн улс орнууд дахь хүний эрхийн зөрчлийн аливаа нэг хэлбэрийн тухай нэхэмжлэлийг мөрдөн шалгах эрхтэй. Мөн тухайн улсын зөвшөөрлөөр газар дээр нь биеллэн очиж мөрдөн шалгадаг. Хүний эрхийг зөрчсөн тохиолдол бүрийг хянан хэлэлцэж, судалгаа явуулах бөгөөд судалгаанаас гарсан үр дүн, санал зөвлөмжөө тухайн улсын засгийн газарт тайлан хэлбэрээр өгөн, жилд нэг удаа НҮБ-ын Хүний эрхийн Комисст ажлын үр дүнгээ тайлагнадаг. Дээрх механизмуудын зарим нь шударга шүүхтэй холбоотой асуудлуудтай шууд холбоотой хэргийг хариуцан ажилладаг.

**Дур зоргоороо баривчлах асуудлаарх ажлын хэсэг** 1991 оноос үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд дур зоргоороо хорьсон буюу олон улсын хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдлийг шалгах эрх бүхий байгууллага юм. Үүнд шүүх хурлын өмнөх болон дараах үе хоёулаа хамаарна.

**Хүчээр сураггүй алга бологсдыг хариуцсан ажлын хэсэг** 1980 онд байгуулагдсан. Уг ажлын хэсэг нь ор сураггүй алга болсон хүмүүстэй холбоотой хэргийг судлан, сураггүй алга бологсдын хувь заяа, хаана байгааг тодруулж, хэргийг мөрдөн байцаах зорилгоор алга бологсдын ар гэр, засгийн газрын хооронд гүүр болон ажилладаг. Мөн улс орнууд “Албан хүчээр сураггүй алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай Тунхаглал”-аар хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэхэд хяналт тавьдаг.

**Хууль бусаар, дур мэдэн, олноор цаазаар авах асуудлаархи НҮБ-ын тусгай Илтгэгч** 1982 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба ихэвчлэн хүний амьд явах эрхийг бүдүүлгээр зөрчсөн үйлдэл, тэр дундаа шударга бус шүүхээс үүдэн цаазаар авах ял ноогдуулсныг зогсоох чиглэлээр ажилладаг. Мөн уг тусгай илтгэгч нь эмэгтэйчүүд хүүхдүүд, шашин, үндэстэн ястан, хэлний цөөнхийн зэрэг нийгмийн тодорхой бүлгүүдийн хэрэгт онцгой анхаарал хандуулан ажиллах үүрэгтэй.

**Эрүү шүүлтийн асуудлаарх тусгай илтгэгч** нь 1985 оноос үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Уг илтгэгч нь эрүүдэн шүүхтэй холбоотой асуудлуудыг шалгах, эрүүдэн шүүхийг хориглосон олон улсын төдийгүй дотоодын хууль тогтоомжуудын биелэлтийг хянах чиглэлээр ажилладаг.

**Шүүгчийн хараат бус байдлын асуудлаарх Тусгай илтгэгч** нь 1994 оноос шүүгчийн хараат бус байдалд халдсан аливаа үйлдлийг илрүүлэх, шүүгчийн хараат бус байдлыг хэрхэн хамгаалах талаар зөвлөмж заавар өгөх зорилго бүхий үйл ажиллагаагаа явуулж ирсэн.

## **6.Олон Улсын эрүүгийн шүүх**

Хуучин Югослав болон Руандагийн асуудал эрхэлсэн Олон улсын эрүүгийн шүүхийг Югослав болон Руандад болсон хямрал мөргөлдөөний үеэр хүний эрхийг ноцтойгоор зөрчиж, төрлөөр устгах болон хүн төрөлхтний эсрэг бусад гэмт хэрэг үйлдсэн гэмт этгээдүүдийг шүүх зорилгоор НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс байгуулсан юм. Эдгээр Шүүхийн Дүрэм (Югославын Дүрэм, Руандагийн Дүрэм) болон тэдгээрийн тунхагласан Нотлох Баримт ба Шүүх Ажиллагааны Дэг (Югославын Дэг, Руандагийн Дэг) нь олон улсын эрх зүйн чухал хэм хэмжээ юм. Эдгээр шүүх нь орчин үеийн шударга шүүхийн төлөөлөл болдог бөгөөд сэжигтний өмгөөлөгч авах эрх, дуугүй байх эрхүүдийг ханган ажилласанаараа шүүх ажиллагаанд ахиц дэвшил гаргасан. Дээрх шүүхээс цаазаар авах ял хэрэглэхийг зөвшөөрдөггүй.

Эдгээр хэм хэмжээний ихэнхи нь Ромд болсон дипломат бага хурлын үр дүнд 1998 оны 7 дугаар сарын 17-нд батлагдсан Олон улсын Эрүүгийн Шүүхийн Дүрэмд тусгагджээ. Энэхүү тогтоол нь тухайн үед 120 гишүүн дэмжиж, 7 нь татгалзаж, 21 нь түтгэлзэн, 60 орон соёрхон баталснаар хүчин төгөлдөр болсон. Уг Дүрэм нь цаазаар авах ялыг бүр мөсөн хориглоод зогсохгүй шударга шүүхийг хангах олон заалтыг багтаасан юм.

## Ишлэл

Энэхүү гарын авлага нь дараах хүний эрхийн хэм хэмжээ болон баримт бичгүүдээс ишлэл авсан болно. Хаалтанд бичсэн товчилсон хэлбэрийг ихэнхидээ хэрэглэсэн болно.

Хүний ба улс түмний эрхийн тухай Африкийн Дүрэм (Африкийн Дүрэм)

Конвенц)

Хүний ба улс түмний эрхийн төлөөх Африкийн комисс (Африкийн Комисс)

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (Эмэгтэйчүүдийн Эрхийн Конвенц)

Шударга Шүүхээр Шүүлгэх болон Шүүхэд Хандах Эрхийн талаарх Тогтоол (Африкийн Комиссын Тогтоол)

Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм хэрэг үйлдэгчдийг шийтгэн цээрлүүлэх тухай Конвенц

Хүний ба улс түмний эрхийн Африкийн шүүх (Африкийн Шүүх)

Хүүхдийн эрхийн тухай конвенц

Хүүхдийн эрхийн тунхаглал

Хүний Эрхийн Тухай Америкийн конвенц (Америкийн Конвенц)

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай тунхаглал

Хүний эрх тухай Америкийн тунхаглал (Америкийн Тунхаглал)

Оршин суугаа орныхоо иргэн биш гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүсийн эрхийн тухай тунхаглал

Шүүхийн байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчмууд

Бүх этгээдийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах тухай Тунхаглал (Эрүүдэн Шүүхийн Эсрэг Тунхаглал)

Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм

Албан хүчээр сураггүй болгохоос бүх хүмүүсийг хамгаалах тухай тунхаглал

Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн зарчмууд

Европын хүний эрхийн Комисс

Бээжингийн тунхаглал ба үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр

Европын Хүний үндсэн эрх чөлөө болон хүний эрхийг хамгаалах конвенц

Аливаа хэлбэрээр саатулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмууд цогц

Хүний эрхийн Европын шүүх

Европын шоронгийн дүрэм

Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль

1949 оны 8 дугаар сарын 12-ны Женевийн конвенц

Эрүүдэн шүүхийн эсрэг Хороо

Дайтаж байгаа армийн шархадсан ба өвчтэй цэргийг асран хамгаалах тухай Женевийн конвенц (Женевийн 1 дүгээр Конвенц )

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц (Эрүүдэн Шүүхийн Эсрэг

Тэнгисийн зэвсэгт хүчний шархдагсад, өвчтөн, Дайнд олзлогдсон харьцах тухай Женевийн конвенц



Яллагчдын үүргийн удирдах зарчмууд	Цаазаар авах ялаар шийтгүүлсэн хүмүүсийн эрхийн хамгаалалтыг баталгаажуулах арга хэмжээнүүд
Хүний эрхийн комисс	
Америкийн улсуудын хүний эрхийн комисс	Цаазаар авах ялыг халах тухай Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын Нэмэлт протокол -2
Америк улсуудын хүний эрхийн шүүх	Шүүгч болон хуульчдын хараат бус байдлын тухай тусгай мэдүүлэг
Хүчирхийлэгдэн сураггүй алга бологсдыг хамгаалах Америкийн улсуудын конвенц	Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм
Эрүүдэн шүүхийн эсрэг Америкийн улсуудын конвенц	Олон улсын эрүүгийн шүүхийн дүрэм
Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүхий л хэлбэрийг устгах олон улсын конвенц	Хуучин Югославын олон улсын эрүүгийн шүүхийн дүрэм
Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт	Руандагийн олон улсын эрүүгийн шүүх ажиллагааны тогтоол
Хоригдлуудыг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг гутаан доромжлохоос хамгаалах талаархи эмчийн ёс суртахууны тухай үндсэн зарчим	Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай НҮБ-ын удирдамж
Олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдсэдийг хамгаалах тухай 1949 оны 8 сарын 12-ны Женевийн конвенцийн нэмэлт протокол-1	Насанд хүрээгүй хүмүүсийн эрх зөрчигдөхөөс хамгаалах НҮБ-ын дүрэм
Олон улсын бус зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдсэдийг хамгаалах тухай 1949 оны 8 сарын 12-ны Женевийн конвенцийн нэмэлт протокол-2	Насанд хүрээгүйчүүдийн талаарх байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг дүрэм
Цаазаар авах ялыг халахтай холбоотой хүний үндсэн эрхийг хамгаалах конвенцийн 6-р протокол	Хүний эрхийн түгээмэл тунхаглал
Хүний үндсэн эрхийг хамгаалах конвенцийн 7-р протокол	Консулын харилцааны тухай Венийн конвенц
Ялын дээд хэмжээ болох цаазаар авах ялыг халах Америкийн конвенцийн протокол	Дур зоргоор хорихын эсрэг ажлын хэсэг
Хүний эрхийг хамгаалах Африкийн комиссийн сөрөг мэдүүлгийг шүүн таслах болон шударга шүүх ажиллагаан дахь эрхийн тогтоол	Хүчирхийлэн, сураггүй алга болгохын эсрэг ажлын хэсэг

### Ишлэл

1. Үндсэн Зарчим , үг хэллэгийн хэрэглээ
- 2 Хүний Эрх ба Урьдчилан Хорих, НҮБ-ын Хүний Эрхийн Төв, 1994 он, UN баримт бичиг: E.94.XIV.6. “Баривчилгаа” гэдэг нь гэмт хэрэгт яллагдаж буй хүнийг эрх мэдэл бүхий газраас баривчлан саатуулах ажиллагаа юм.
- 3 Еклийн хэрэг, Хүний Эрхийн Европын Шүүх, Цуврал 51-А, 1982 оны 7 дугаар сарын 15
- 4 Эрүү шүүлтгийн эсрэг Конвенц, Зүйл I(1)
- 5 Эрүү шүүлтгийн эсрэг Тунхаглал, Зүйл 1(2)
- 6 Хүний эрхийн Европын Шүүх, Срамскийн хэрэг, цуврал 84-А 17, 39-р тал, 1984 оны 10 дугаар сарын 22, Ван Леувэн болон Де Мейерэ нарын хэрэг, цуврал 43-А 24, 55-р тал, 1981 оны 7 дугаар сарын 23

## Шударга шүүхтэй холбогдох нэр томъёо

**Шударга шүүхтэй холбоо бүхий нэр томъёо нь олон улсын хэм хэмжээнүүдэд янз бүрээр тодорхойлогддог. Дараах тодорхойлолтууд нь Эмнести Интернэшнлийн гарын авлагад хэрэглэгдэх нэр томъёог ойлгомжтой болгох зорилготой. Эдгээр тодорхойлолтууд нь ОУ-ын стандарт үндэсний хуулиуд шиг өргөн хэрэглэгддэггүй юм.**

### Албадан саатуулах, хорих

Албадан саатуулах хэмээх нэр томъёо нь хувь хүн гэмт хэрэгт холбогдсон гэх шалтгаанаар эрх чөлөөгөө хасуулсан үед хэрэглэгдэнэ. Хорих гэдэг нь шүүхээр гэм буруутайг нь тогтоосны дараа эрх чөлөөг нь хасахыг хэлнэ. Эрх чөлөөг хасах гэдэг нь шүүх ажиллагааны өмнө болон шүүх ажиллагааны үед эрүүгийн шүүх ажиллагааны нөхцлөөс хамааран эрх чөлөөг нь хорино гэсэн үг юм<sup>1</sup>.

### Баривчлах

Баривчлах нь эрүүгийн хариуцлагад хувь хүнийг татах, хувь хүнийг баривчилан саатуулах зорилготойгоор засгийн газрын эрх мэдлийн дор хувь хүний эрх чөлөөг хасах үйл ажиллагаа юм.<sup>2</sup>

### Эрүүгийн хариуцлага

Хувь хүнд гэмт хэрэг үйлдсэн гэж албан ёсны сануулгыг хууль сахиулах эрх мэдэлтнүүдээс өгөхийг хэлнэ.<sup>3</sup>

### Эрүү шүүлт

Эрүүдэн шүүх гэж төрийн албан тушаалтан буюу албан үүрэг гүйцэтгэж буй этгээд өөрөө, эсвэл түүний өдөөн хатгаснаар буюу ил далд зөвшөөрлөөр буюу хэн нэгэн этгээдийг өөрөөс нь буюу гуравдах этгээдээс мэдээлэл авах, хэрэг хүлээлгэх, үйлдсэн буюу үйлдсэн гэж сэжиглэгдэж буй хэрэгт нь шийтгэх, айлган сүрдүүлэх, албадах, аливаа үндэслэлээр ялгаварлан гадуурхах шалтгаанаар бие махбод, сэтгэл санааны хувьд хүчтэй өвтгөх шаналгах аливаа үйлдлийг хэлнэ.<sup>4</sup> Энэхүү тодорхойлолтонд гагцхүү хуулийн цээрлэлийн үр дүнд түүнтэй салшгүй холбоотойгоор эсвэл түүнээс тохиолдлоор үүдсэн өвдөлт шаналлыг хамааруулахгүй.<sup>5</sup>

### Шүүх ба трибунал

Шударга ёс сахиулах байгууллагуудыг шүүх болон трибунал гэдэг. Эдгээр нь хууль дээдлэх ёсны зарчимд тулгуурлан зохих шалгуурт нийцүүлэн хуулийн дагуу байгуулагдана. Трибунал нь шүүхээс өргөн хүрээтэй ойлголт бөгөөд хүний эрхийг хангах байгууллагуудын тогтолцоонд оруулдаггүй.<sup>6</sup>

## Хураангуйлал

### Нэмэлт протокол 1

1949 оны 8 сарын 12-ны Женевийн конвенцийн Олон Улсын Зэвсэгт Мөргөлдөөний хохирогчдыг хамгаалах тухай нэмэлт протокол

### Нэмэлт Протокол 2

1949 оны 8 сарын 2-ны Женевийн Конвенцийн Олон Улсын Зэвсэгт Бус Мөргөлдөөний хохирогчдыг хамгаалах тухай протокол

Африкийн Тунхаг

Хүний эрхийн Африкийн Тунхаг

Африкийн Комисс

Хүний эрхийн Африкийн Комисс

Африкийн Комиссын Тогтоол

Хүний эрхийн Африкийн комиссын Шударга Шүүхийн эрхийн тухай тогтоол

Африкийн Шүүх

Хүний Эрхийн Африкийн Шүүх

Америкийн Конвенц

Хүний эрхийн Америкийн Конвенц

Америкийн тунхаг

Хүний эрх үүргийн тухай Америкийн тунхаг

Цогц зарчим

Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмууд

Арьсны үзлийн эсрэг конвенц

Арьс үндэсээр ялгаварлан үзэх бүх хэлбэрийг устгах тухай Олон улсын конвенц

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц

Цаазаар авах ялын хамгаалалт

Цаазаар авах ялаар шийтгэгдсэн хүмүүсийг хамгаалах

Эрүүдэн шүүхийн эсрэг тунхаг

Эрүүдэн шүүх, хүнлэг бусаар нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг тунхаг

Сураггүй алга бологсдын тухай тунхаг

Хүчирхийлэгдэн сураггүй алга бологсдыг хамгаалах тунхаг

Европын комисс

Хүний эрхийн Европын комисс

Европын Конвенц

Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай конвенц

Европын шүүх

Хүний эрхийн Европын шүүх

Женевийн 4 Конвенц

Дайны үед иргэдийг хамгаалахтай холбогдсон Женевийн Конвенц

Женевийн конвенц

1949 оны 8 сарын 12-ны Женевийн конвенц

ИУТЭОУП

Улс төр болон иргэний эрхийн Олон улсын Пакт

ОУЭШ-ийн дүрэм

Олон улсын эрүүгийн шүүхийн дүрэм

Америк дундын Комисс

Хүний эрхийн Америк дундын Комисс

Америк дундын сураггүй алга бологсдын тухай конвенц

Хүчирхийлэгдэн сураггүй алга бологсдын тухай Америк дундын конвенц

Эрүүдэн шүүхийн эсрэг Америкийн улсуудын конвенци

Эрүүдэн шүүх шийтгэл, түүнээс урьдчилан сэргийлэх Америкийн

улсуудын конвенци	тухай тогтоол
Америк дундын шүүх	Хоригдолтой харьцах харьцааны наад захын жишиг дүрэм
Хүний эрхийн Америк дундын шүүх	Бээжингийн дүрэм
Эмчийн ёс зүйн дүрэм	Насанд хүрээгүй хүмүүсийн талаархи байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг дүрэм НҮБ-ын дүрэм
Хоригдлуудыг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг гутаан доромжлохоос хамгаалах эмчийн ёс суртахууны үндсэн зарчим	Токиогийн дүрэм
Европын конвенцийн 7-р протокол	Женевийн конвенц 3
Хүний эрх үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенцийн 7-р протокол	Дайны олзлогсодтой харьцах тухай Женевийн конвенц
Риядын удирдамж	Эмэгтэйчүүдийн конвенц
Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх удирдамж	Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүхий л хэлбэрийг халах тухай конвенц
Руандагийн олон улсын эрүүгийн шүүх ажиллагааны дүрэм	Югославын тогтоол
Руандагийн тогтоол	Хуучин Югославын олон улсын эрүүгийн шүүхийн хууль эрх зүйн акт
Руандагийн ОУ-ын эрүүгийн шүүхийн	



ШУДАРГААР  
ШҮҮЛГЭХ ЭРХ

---

## А ХЭСЭГ

# ШҮҮХ ХУРЛААС ӨМНӨХ ШАТАНД ЭДЛЭХ ЭРХ

---

- |          |  |
|----------|--|
| Бүлэг 1  | Халдашгүй байх эрх   |
| Бүлэг 2  | Албадан саатуулагдсан хүмүүс мэдээлэл авах эрх                     |
| Бүлэг 3  | Шүүх хурлаас өмнө эрх зүйн зөвлөгөө авах эрх                       |
| Бүлэг 4  | Хоригдож буй этгээдүүд гадаад ертөнцтэй холбоотой байх             |
| Бүлэг 5  | Аль болох богино хугацаанд хэргийг хянан шийдвэрлүүлэх эрх         |
| Бүлэг 6  | Албадан саатуулагдсан хууль зүйн үндэслэлийн эсрэг гомдол гаргах   |
| Бүлэг 7  | Боломжит хугацаанд хэргийг хянан шийдвэрлүүлэх эсвэл суллагдах эрх |
| Бүлэг 8  | Өмгөөлөлд бэлтгэх боломжтой цаг хугацаа, нөхцлөөр хангагдах эрх    |
| Бүлэг 9  | Байцаагдах үед эдлэх эрх   |
| Бүлэг 10 | Эрүү шүүлтэнд өртөхгүй байж, хүнлэг нөхцөлд хоригдох эрх           |



## БҮЛЭГ 1

### Халдашгүй байх эрх

Хүн бүр халдашгүй байх эрхтэй. Хуулийн дагуу арга хэмжээ авах болсон үед баривчилж, цагдан хорьдог. Үүнийг хэн ч дур мэдэн хийж үл болох бөгөөд зөвхөн эрх бүхий этгээд л гүйцэтгэнэ. Эрүүгийн хэрэгт шалгагдаж буй этгээдүүд шүүх хурал хүртэл хоригдон саатуулагдахгүй байж болно.

#### 1.1 Халдашгүй байх эрх

#### 1.2 Ямар тохиолдолд баривчлах, албадан саатуулах нь хууль ёсных байх вэ?

##### 1.2.1. Европын конвенц

#### 1.3 Ямар тохиолдолд баривчлах, албадан саатуулах нь хууль бус байх вэ?

#### 1.4 Хуулийн дагуу ямар этгээд хүний эрх чөлөөг хязгаарлах эрхтэй вэ?

#### 1.5 Шүүх хурал болохоос өмнө суллагдах

### 1.1 Халдашгүй байх эрх

Хүн бүр эрх чөлөөтэй байх эрхтэй.\* Энэ бол хүний үндсэн эрх юм.

Төрөөс тогтоосон тодорхой нөхцлүүдийн дагуу хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж болдог. Олон улсын хүний эрхийн хэм хэмжээ нь хувь хүнийг хууль бусаар, дур мэдэн баривчилж эрх чөлөөг нь хязгаарлахгүй байх болон албадан саатуулагдсан үед гарч болох бусад хэлбэрийн зөрчил гарахаас давхар хамгаалж байдаг. Эдгээр олон улсын баримт бичгийн зарим нь эрүүгийн хэрэгт холбогдсон эсэхээс үл хамааран бүх хүн, эрүүгийн хариуцлага хүлээсэн бусад этгээд болон гадаадын иргэн, хүүхэд гэх мэт тодорхой хэсэг хүмүүсийн эрх чөлөөг хязгаарласан тохиолдолд хэрэглэгдэнэ. Түүнчлэн энэ шударга шүүх ажиллагааны талаархи гарын авлагад захиргааны журмаар хоригдон саатуулагдан эрх, эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүсийн эрхийг багтаасан хүний эрхийн талаархи нилээд хэм хэмжээг тусгасан бөгөөд ялангуяа эрүүгийн хэрэгт ял шийтгэгдсэн хүмүүст хэрэглэгдэх эрхүүдэд илүү анхаарал хандуулсан болно.<sup>1</sup>

Эрх чөлөөтэй байх эрхийн зайлшгүй үр дагавар нь дур мэдэн, хууль бусаар баривчилж, цагдан хорихоос хамгаалагдах явдал юм. Хүний эрх чөлөөтэй байх эрхийг хамгаалахын тулд олон улсын баримт бичгүүдэд тухайлбал, Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 9 дүгээр зүйлд “Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу албадан саатуулах эрхгүй” гэж тунхагласан байдаг. Энэхүү үндсэн баталгааг тухайн хүн эрүүгийн хэрэгт холбогдсон эсвэл оюуны хомсдолтой ч бай, дүрвэж яваа болон цагаачиллын хяналтанд байсан ч хүн бүхэнд олгох ёстой.<sup>2</sup>

Олон улсын хэм хэмжээ нь зөвхөн дур зоргоор баривчилж, цагдан хорихгүй байхыг баталгаажуулах төдийгүй хуулиар тогтоосон журам, үндэслэлийн дагуу гүйцэтгэх ёстой гэдгийг тодорхойлдог.

#### Холбогдох хэм хэмжээ

##### ХЭТТ 3 дугаар зүйл

Хүн бүр амьд явах эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй

##### ИУТЭОУП-ын 9 дүгээр зүйлийн 9.1

Хүн бүр эрх чөлөөтэй байх болон халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчилж буюу цагдан хорьж болохгүй. Хуулиар тогтоосон үндэслэл журмаас бусад аль тохиолдолд хэнийг ч хорьж болохгүй.

\*Хүний Эрхийн Түгээмэл Тунханлалын 3 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйл, Африкийн Дүрмийн 6 дугаар зүйл, Америкийн Тунхаглалын 1 дүгээр зүйл, Америкийн Конвенцийн 7 дугаар зүйл болон Европын Конвенцийн 5 дугаар зүйл

#### Ишлэл

1. Захиргааны журмаар баривчлах тухай нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл Харьцуулсан болон Олон Улсын Эрх зүй: Урьдчилан сэргийлэх зорилгоор албадан саатуулах нь, С.Франковски, Д. Шелтон, Мартинус Нижхофф, 1992 он
2. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар тал – 8

Африкийн Комиссоос 12 жилийн турш “Төрийн тэргүүний тааллаар” ямар ч үндэслэлгүйгээр шийтгэл оногдуулах эсвэл шүүх хурал хийхгүйгээр улс төрийн шалтгаанаар иргэдийг баривчилж, цагдан хорьж саатуулж байсан нь Африкийн дүрмийн 6 дугаар зүйлд тусгасан эрх чөлөөтэй байх эрхийг зөрчсөн байна гэдгийг хүлээн зөвшөөрсөн.<sup>3</sup>

Америк дундын Комисс гэрийн хорионд байлгах, улсын дотор цөлөх, хүчээр газар заан суурьшуулж байгаа зэрэг тодорхой нөхцөл байдлууд нь Америкийн Конвенцийн 7 дугаар зүйлд баталгаажсан хүний эрх чөлөөтэй байх эрхийг зөрчиж байна гэж үзсэн.<sup>4</sup>

Мөн Америк дундын Шүүхээс Америкийн Конвенцийн 8 дугаар зүйлийн 8.2-т тусгагдсан нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцох зарчмаар хүний эрх чөлөөний аливаа хязгаарлалт нь зайлшгүй шаардлагатай үед л хязгаарлах ёстой гэж тогтоосон.<sup>5</sup>

## 1.2 Ямар тохиолдолд баривчлах, албадан саатуулах нь хууль ёсных байх вэ?

Хүний эрх чөлөөг гагцхүү хуулиар тогтоосон журмын дагуу, тодорхой үндэслэлтэйгээр хязгаарлах ёстой.\*

Энэхүү журмууд нь зөвхөн дотоодын эрх зүй төдийгүй олон улсын хэм хэмжээнд нийцсэн байх ёстой.

Европын Шүүхээс Европын Конвенцийн 5 дугаар зүйлийн 5.1-д “хуулиар тогтоосон журмын дагуу” гэсэн хэллэг нь дотоодын эрх зүйд хамааралтай ч, дотоодын хууль өөрөө “Европын Конвенцид заасан болон агуулагдсан зарчимд нийцсэн байх ёстой” гэж тогтоосон.<sup>6</sup>

\* Иргэний болон улс төрийн олон улсын пакт 9(1) дүгээр зүйл, Африкийн Дүрмийн 6 дугаар зүйл, Америкийн Тунхаглалын 55 дугаар зүйл, Америкийн Конвенцийн 7(2) болон 7(3) дугаар зүйл болон Европын Конвенцийн 5(1) дугаар зүйл

### Ишлэл

3. Крисчна Ачутан (Алек Бандааг төлөөлж), Ортон болон Вера Чирвагийн нэрийн өмнөөс Эмнести Интернэшнл ба Малави, (64/92, 68/92, 78/92 тус тус), Африкийн Комиссын жил бүрийн 8 дах Илтгэл, 1994-1995 он. Хүний болон Улс Түмний Эрхийн тухай Африкийн Комисс /RPT/8th

4. Америк Дундын Комисс, Аргентина дах Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл, 1980 он, Америкийн Улсуудын Байгууллага /Ser.L/V/II.49, баримт бичиг 19, тал - 189,193,291; Америк Дундын Комисс, Чили дах Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл, 1985 он, Америкийн Улсуудын Байгууллага /Ser.L/V/II.66, баримт бичиг 17, тал - 134,139 Америк Дундын Комисс, Никарагуа дах Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл, 1981 он, Америкийн Улсуудын Байгууллага /Ser.L/V/II.53, баримт бичиг 19, тал - 65;

5. Суарез Росерогийн хэрэг, Эквадор, 1992 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн ял  
6. Кенмаче ба Франц (№3), (45/1993/440/519), 1994 оны 11 дүгээр сарын 24

### Холбогдох хэм хэмжээ

#### Европын Конвенцийн 5 дугаар зүйл

Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хуульд заасан дараах үндэслэл журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хязгаарлахыг хориглоно. Үүнд:

а/ эрх бүхий шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор хэн нэгэн этгээдийг хууль ёсоор хорих

б/ хуулинд заасан хариуцлагыг биелүүлэх тушаал эсхүл шүүхийн хууль ёсны шийдвэрийн дагуу тухайн этгээдийг хорих, асвэл хууль ёсны баривчилгаа явуулах

в/ тухайн этгээдийг гэмт хэргээ үйлдээд зугатахаар завдсан гэх тодорхой үндэслэл байгаа үед болоод эрх бүхий хуулийн байгууллагын өмнө зайлшгүй байлгах зорилгоор хийсэн баривчлах ажиллагаа болон саатуулалт

г/ эрх бүхий хуулийн байгууллагын өмнө авчрах зорилгоор хуулийн дагуу саатуулсан болон насанд хүрээгүй гэмт хэрэгтнийг сургалтын удирдлагад хянан харгалзуулахаар авсан саатуулалт

д/ тухайн этгээдийг халдварт өвчин тараахаас урьдчилан сэргийлэх, сэтгэцийн өөрчлөлттэй, согтуу, мансууруулах бодис хэрэглэсэн болон, тэнэмэл хүмүүсийг хууль ёсоор саатуулах

е/ тухайн улс руу зөвшөөрөлгүйгээр нэвтрэхээс сэргийлэх, эсвэл тухайн улсаас хөөгдөн гаргаж байгаа, эсхүл шилжүүлэгдэж байгаа этгээдийн эсрэг авсан хууль ёсны саатуулалт эсхүл баривчилгаа



### 1.2.1 Европын конвенц

Европын Конвенцийн 5 дугаар зүйлд хүний эрх чөлөөг хязгаарлаж болох зөвшөөрөгдсөн нөхцлүүдийг зааж өгсөн байдаг. Баривчилгааг зөвтгөх нэг нөхцөл болох хэн нэгнийг захиргааны байгууллагын өмнө аваачихын тулд “гэмт хэрэг үйлдсэн гэх үндэслэл бүхий сэжиг” байх ёстой гэжээ.

Европын шүүх “тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн байж болох талаархи гэрчийн үнэн зөв, баталгаатай мэдээлэл болон үйлдэл” байгаа тохиолдолд “үндэслэл бүхий сэжиг”-гэй хэмээн хуулийн дагуу баривчилж болно гэж үзсэн.

### 1.3 Ямар тохиолдолд баривчлах, албадан саатуулах нь хууль бус байх вэ?

Хэнийг ч дур мэдэн баривчилж, цагдан хорих ёсгүй.\*

Хуулийн дагуух баривчилгаа болон цагдан хорих явдал нь олон улсын хэм хэмжээний дагуу байсан ч дур мэдсэн байж болно. Жишээлбэл, хуулийн дагуу тухайн хүнийг баривчилсан шалтгаан тодорхойгүй болон хэтэрхий өргөн хүрээтэй эсвэл үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний зэрэг бусад суурь хэм хэмжээний зөрчил байсан зэрэг тохиолдолд дур мэдэн баривчилсан хэрэг болно. Нэмж хэлэхэд тухайн этгээд анхнаасаа хуулийн дагуу баривчлагдсан боловч шүүх эрх мэдлийн байгууллагын захирамжийн дагуу суллагдсаны дараа дур мэдэн баривчлагдсан болно.

Хүний Эрхийн Хорооноос ИУТЭОУП-ын 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан “дур мэдэн” хэмээх нэр томъёог зөвхөн хууль бус хорьж саатуулахыг хэлээд зогсохгүй хүч хэтрүүлсэн, шударга бус болон хойшлуулшгүй эсхүл таамаглах аргагүй гэсэн нөхцлүүдийг агуулсан илүү өргөн агуулгатай гэж тайлбарласан байна.

Африкийн комисс “Малави дахь нэгэн байгууллагын албан хаагчдыг хорлон сүйтгэх ажиллагаанд байгууллагын факс, хувилах машин зэргийг ашигласан гэж сэжиглэн олноор нь саатуулсныг Африкийн дүрмийн 6 дугаар зүйлийг зөрчсөн, дур мэдсэн байна. Түүнчилэн ялын хугацаа дууссанаас хойш цагдан хорьсон нь дур мэдэн баривчлах явдлыг хориглох тухай Африкийн дүрмийн 6 дугаар зүйлийг зөрчсөн хэрэг болно” гэж үзсэн байна.

Хуулийн дагуух баривчилгааг шалгахдаа Европын Шүүх дотоодын материаллаг болон процессийн хуульд нийцсэн эсэх болон саатуулан баривчилах нь дур мэдсэн байсан эсэхийг хянан шалгадаг.

Америк Дундын Комисс хуулиас гадуурхи баривчилгаа /үүнд удирдлагын заавраар, эсвэл хагас цэрэгжсэн бүлэг, аюулаас хамгаалах хүчний зөвшөөрлөөр гүйцэтгэсэн баривчилгаа/, хууль зөрчсөн баривчилгаа, хуулийн дагуу боловч эрх хэмжээгээ хэтрүүлэн баривчлан хорьж саатуулах гурван хэлбэрийг тогтоожээ.

### 1.4 Хуулийн дагуу ямар этгээд хүний эрх чөлөөг хязгаарлах эрхтэй вэ?

Баривчлах, хорих, албадан саатуулах ажиллагааг зөвхөн бүрэн эрх олгогдсон албан тушаалтан тодорхой зорилгоор гүйцэтгэдэг.\*\* Иймээс ч зарим улсын

\*Хүний Эрхийн Түгээмэл Тунхашалын 9 дүгээр зүйл, Иргэний болон улс төрийн олон улсын пакт 9(1) дүгээр зүйл, Африкийн Дүрмийн 6 дугаар зүйл, Америкийн Тунхаглалын 55 дугаар зүйл, Америкийн Конвенцийн 7(2)болон 7(3) дугаар зүйл болон Европын Конвенцийн 5(1) дугаар зүйл

\*\* Үндсэн Зарчим – 2 дугаар зарчим

## Эмнести Интернэшнл: Шударгаар шүүлгэх эрх

нийтлэг практикт аюулаас хамгаалах хүчнийхэн баривчлах, цагдан хорихыг хориглосон бөгөөд хуулийн дагуу дээрх үйлдлийг хийх эрх хэмжээгүй байдаг.

Хүмүүсийг баривчилж, хорьж саатуулахдаа тэдний хэргийг мөрдөн байцааж байгаа эрх бүхий албан тушаалтнууд нь зөвхөн хуулийн дагуу олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд ажиллах ёстой. Гэхдээ тэдний үйл ажиллагааг буюу энэхүү эрх хэмжээг ашиглахыг хуулийн байгууллагууд болон бусад албан тушаалтнууд давхар хянадаг.\*

Аливаа улс хуульдаа ямар албан тушаалтан хүний эрх чөлөөг хязгаарлах эрхтэй болохыг тодорхой тусгаж өгөх хэрэгтэй. Үүндээ мөн тушаал хэрэгжүүлэх тодорхой сүлжээ бүхий хатуу хяналттай байх, бүх хууль хэрэгжүүлэгч албан тушаалтнууд хийсэн үйлдэлдээ ялангуяа баривчлах, хорих, албадан саатуулах, ял оногдуулах зэрэгтээ хариуцлага хүлээх нөхцлүүдийг тусгах хэрэгтэй.\*\*

### 1.5 Шүүх хурал болохоос өмнө суллагдах

Эрүүгийн хэрэгт шалгагдаж буй этгээд шүүх хурал хүртэл ерөнхий зарчмаар цагдан хоригдож, саатуулагдахгүй байж болно. Эрх чөлөөтэй байх эрх, гэм буруугүйд тооцогдох эрхийн дагуу (Нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцох журмын 15-р зүйлийг харах) эрүүгийн хэрэгт холбогдсон хэмээн сэжиглэгдэж байгаа хэнийг ч шүүх хурал болохоос өмнө цагдан хорьж үл болно гэж заасан байдаг.\*\*\* Гэхдээ Олон улсын хэм хэмжээнд зайлшгүй шаардлагатай үед тухайлбал гэмт хэрэгтэн оргож зугтах магадлалтай, гэрчид саад учруулах буюу нийгэмд илэрхий хор уршиг учруулж болзошгүй тохиолдолд урьдчилан хорьж, саатуулах тухай тодорхой тусгасан байдаг.

Хүний Эрхийн Хорооноос шүүх хурлыг хүлээх хугацаанд урьдчилан хорих төвд аль болох богино хугацаанд хорино гэж тодорхойлсон байна.<sup>14</sup>

Хүний эрхийн хороо урьдчилан хорих төв нь зөвхөн хуулийн дагуу хорих ёстойгоос гадна үндэслэл бүхий, шаардлагатай нөхцлүүдэд л хорих ёстой гэдгийг заасан байдаг. ИУТЭОУП-оор зөвхөн хуулиар тогтоосон үндэслэл журмын дагуу тухайн хүнийг шүүн таслах ажиллагаанд оролцуулахын тулд хорьж саатуулах арга хэмжээ авахыг зөвшөөрсөн байдаг. Гэхдээ “зайлшгүй” гэдгийг нарийн тодорхойлон тайлбарласан. Энэ нь гэмт хэрэгт сэжиглэгдэж буй тухайн этгээдийг мөрдөн байцаалтын болон яллах үед цагдан хорихыг зөвтгөх хангалттай үндэслэл болохгүй. Хэдий тийм боловч өөр улс руу зорчин гарах, гэрчийн аюулгүй байдлыг хангах болон бусад нотлох баримтыг хөндлөнгийн халдагаас хамгаалах, өөр гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой байдаг. Хүний эрхийн хорооноос мөн тухайн

#### Холбогдох хэм хэмжээ

##### Саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчим

###### Зарчим 2

Баривчлах, саатуулах, түүнчлэн хорих ажиллагааг хуулийн заалтад чанд нийцүүлж эрх бүхий албан тушаалтан буюу хуулиар эрх олгосон этгээд явуулах ёстой

###### Зарчим 9

Бусдыг баривчилж, саатуулж, эсвэл хэрэгт мөрдөн байцаалт явуулж байгаа албан тушаалтан, буюу байгууллага зөвхөн хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд энэ бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон гомдлыг шүүхийн болон хуульд заасан байгууллагад гаргаж болно.

#### Ишлэл

14. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 8, догол мөр 3
15. Ван Алфен ба Голланд (305/1988), 1990 оны 7 дугаар сар, Report of the HRC Vol II. (A/45/40)

этгээдийг нийгэмд илт хор учруулахаар, үүнээс өөр арга хэмжээ авах боломжгүй бол хорьж саатуулах арга хэмжээ авч болно гэж үзсэн.<sup>15</sup>

Европын шүүх шүүх хурлаас өмнө баривчилж саатуулах ажиллагааг үргэлжлүүлэхийг зөвхөн олон нийтийн эрх ашиг нь хувь хүний эрх чөлөөнөөс илүү чухал гэж үзэх баттай нотлогоотой нөхцөлд зөвтгөж болно гэж үзсэн байна.<sup>16</sup>

Хэрвээ тухайн хүнийг урьдчилан хорих төвд саатуулсан бол эрх бүхий этгээд цаашид хорих шаардлагатай эсэхийг байнга хянаж байх ёстой.\*

**5 дугаар бүлгийн аль болох түргэн хугацаанд шүүгч болон бусад хуулийн байгууллагын албан тушаалтнаар хэргийг хянан шийдвэрлүүлэх, 6 дугаар бүлгийн саатуулагдсан хууль зүйн үндэслэлийн эсрэг гомдол гаргах эрх, 7 дугаар боломжтой хугацаанд хэргийг хянан шийдвэрлүүлэх эсвэл цагдан хоригдохоос чөлөөлүүлэх эрхийг дэлгэрүүлэн үзнэ үү.**

### Холбогдох хэм хэмжээ

#### ИУТЭОУП-ын 9.3 дугаар зүйл

Шүүхийн өмнөх шатанд байгаа хүнийг заавал цагдан хорьж байх нийтлэг журам байх албагүй бөгөөд шүүх хуралд оролцох, шүүн таслах ажиллагааны аль ч шатанд байлцах, шаардлагатай тохиолдолд, шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд байх баталгаа гаргаж өгсөн бол этгээдийг суллаж болно.

#### Токиогийн дүрмийн 6-р дүрэм

6,1 Тодорхой хэргийг мөрдөн шалгах хийгээд нийгэм, хохирогчийг хамгаалах зорилгоор шүүхийн өмнөх шатанд хорьж саатуулах явдлыг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны онцгой арга хэмжээ болгож хэрэглэх ёстой.

6,2 Шүүхийн өмнөх шатанд хорьж саатуулахыг орлох бусад арга хэмжээг боломжийн хирээр аль болох эхэлж хэрэглэнэ.

#### Үндсэн зарчмууд 39-р зарчим

Хуульд заасан онцгой тохиолдлоос бусад тохиолдолд шүүх буюу бусад байгууллага шүүн таслах ажиллагааны эрх ашгийн үүднээс өөр шийдвэр гаргаагүй бол эрүүгийн гэмт хэрэгт ялагдан саатуулагдсан этгээд шүүх хуралдааны хугацаанд хуульд заасан нөхцлөөр чөлөөлөгдөж болно. Тэр байгууллага нь уг этгээдийг саатуулах шаардлага байгаа эсэхэд хараа хяналт тавих ёстой.

\* Үндсэн Зарчим- 39 дүгээр зарчим

### Ишлэл

16. Ван Де Тан ба Испани (26/1994/473/554) 1993 оны 7 дугаар сарын 13, хэрэг 55

## Бүлэг 2

### Албадан саатуулагдсан хүмүүс мэдээлэл авах эрх

Баривчлагдсан, түр албадан саатуулагдсан хүн бүрт баривчлагдсан, саатуулагдсан шалтгаан болон өмгөөлөгч авах зэрэг эрхийг нь сануулах ёстой. Тэдэнд ямар ял тулгаж байгааг нэн даруй мэдэгдэх ёстой. Энэхүү мэдээлэл нь баривчилгаа болон түр саатуулах ажиллагааг хуулийн дагуу явуулахад хяналт тавьж, ял оногдуулсан тохиолдолд өөрийгөө хамгаалах боломжийг олгодог.

#### 2.1 Баривчилсан болон түр саатуулсан шалтгааныг нэн даруй мэдэгдэх эрх

#### 2.2 Эрхийг нь сануулах

##### 2.2.1 Өмгөөлөгч авах эрхийг мэдэгдэх

#### 2.3 Оноогдох ялыг нэн даруй мэдэх эрх

#### 2.4 Мэдэх хэлээр нь мэдэгдэх

#### 2.5 Гадаадын иргэд

### 2.1 Баривчилсан болон түр саатуулсан шалтгааныг нэн даруй мэдэгдэх эрх

Хүн бүрт баривчлагдах, албадан саатуулагдах үед нь тэдний эрхийг хязгаарлах болсон шалтгааныг нэн даруй мэдэгдэх ёстой.\*

Баривчлах болон түр саатуулах шалтгааныг мэдэгдэх үндсэн зорилго нь хоригдож байгаа хүн өөрийгөө хуулийн дагуу шийтгэгдэж байгааг мэдэх боломжийг олгоход оршдог. /Албадан саатуулагдсан хууль зүйн үндэслэлийн эсрэг гомдол гаргах сэдвийг 6-р бүлгээс дэлгэрүүлэн үзнэ үү/ Иймээс шалтгааныг мэдэгдэх нь тодорхой байх ёстой. Үүнд баривчлах болон түр саатуулах болсон хууль зүйн болон бодит үндэслэлийг маш тодорхой агуулсан байх шаардлагатай.

Жишээлбэл, Хүний Эрхийн Хорооноос “тухайн хүнийг түүний эсрэг гомдолын үндэслэлийг тайлбарлалгүйгээр аюулгүй байдлыг хангах ын тулд шууд баривчлах болсон гэж мэдэгдэх нь хангалтгүй”.<sup>1</sup>

\*Иргэний болон улс төрийн олон улсын пакт 9(2) дүгээр зүйлт, Африкийн Комиссын Тогтоолын 2(Б) хэсэг, Үндсэн Зарчим - 10 дугаар зарчим болон Америкийн Конвенцийн 7(4) дугаар зүйл болон Европын Конвенцийн 5(2) дугаар зүйл, Үндсэн зарчим - 11(2) дугаар зарчим тус тус харна уу

#### Холбогдох хэм хэмжээ

#### ИУТЭОУП-ын зүйл 9,2

Баривчлагдсан шалтгааныг хүн бүрт баривчлах үед нь мэдэгдэхийн зэрэгцээ буруутгаж байгаа аливаа үндэслэлийг даруй мэдэгдэнэ.

#### Үндсэн зарчмууд 10

Баривчлагдсан хүн бүрт түүнийг баривчлах болсон шалтгааныг баривчлах үед мэдээлж аливаа сонгосон ялыг түүнд даруй мэдэгдэх ёстой.

#### 11.2-р зарчим

Саатуулах тухай аливаа тогтоол түүнчлэн саатуулсан шалтгааны тухай аливаа тодорхой мэдээллийг саатуулагдсан этгээдэд, хэрэв өмгөөлөгч байгаа бол түүнд нэн дариу мэдэгдэнэ.

#### Ишлэл

1. Дресчер Уругвайн хэрэг (43/1979), 1983 оны 7 дугаар сарын 21

Үүнтэй адилаар, Хүний Эрхийн Хороо “үндэсний аюулгүй байдлыг хамгаалах” зорилгоор Суданд олон хүмүүсийг баривчилсан явдалд санаа зовиож буйгаа илэрхийлээд, “үндэсний аюулгүй байдлын талаархи ойлголтыг хуулиар тодорхойлж, цагдаа, аюулаас хамгаалах алба тухайн хүнийг баривчилахдаа шалтгааныг нь бичгээр үйлдэн үзүүлж олон нийтийн болон шүүхийн хяналт дор явуулах шаардлагатай” гэж зөвлөжээ.<sup>2</sup>

Түүнчлэн нэгэн этгээдийг баривчлах үедээ зөвхөн хүн амины хэргээр сэжиглэн баривчилж байгаагаа мэдэгдсэн нь ИУТЭОУП-ын 9 дүгээр зүйлийн 9.2-ыг зөрчсөн гэж Хүний Эрхийн Хороо үзсэн. Хэдэн долоон хоногийн турш түүнийг баривчлах болсон шалтгаан болон гэмт хэргийн баримт, ямар хүн хохирогч болсон тухай дэлгэрэнгүй мэдэгдээгүй байжээ.<sup>3</sup>

Европын шүүхээс Европын Конвенцийн 5 дугаар зүйлийн 5.2-ыг “баривчлагдсан хүнд мэргэжлийн нарийн үг хэллэг хэрэглэхгүйгээр энгийн үгээр баривчлах болсон хууль зүйн болон бодит үндэслэлийг ойлгомжтой тайлбарлаж өгөх ёстой бөгөөд ингэснээр тухайн хүн шүүхэд гомдол гаргах боломжтой болно”. Ингэхдээ баривчлах үедээ бүгдийг дэлгэрэнгүй мэдэгдэх шаардлагагүй гэж үзсэн байна. Энэ хэрэгт баривчилах үедээ хүн бүрт баривчлагдах болсон шалтгааныг хуулийн заалтаар нь хэлж өгсөн байжээ. Хэдэн цагийн дараа тэднийг байцааж буй цагдаа хориглогдсон байгууллагад ажиллаж байгаатай нь холбоотойгоор тэднийг сэжиглэж байгаагаа хэлсэн байна. Шүүх энэ тохиолдолд тэд ямар шалтгаанаар баривчлагдсан тухай хангалттай мэдээлэл авч чадаагүй хэмээн гомдол гаргах үндэслэлгүй гэж үзсэн байна.<sup>4</sup>

ИУТЭОУП-ын 9 дүгээр зүйлийн 9.2, Үндсэн зарчмуудын 10 дугаар зарчим, Африкийн комиссын тогтоолын 2.б-д ямар шалтгаанаар баривчилж байгааг **баривчлах үед** мэдэгдэх ёстой тухай заажээ.

Нэгэн Хүний эрхийн байгууллагын хуульчийг баривчилсан шалтгааныг мэдэгдэлгүйгээр 50 цаг хорьсон нь ИУТЭОУП-ын 9.2-р зүйлийг зөрчсөн болохыг Хүний Эрхийн Хороо олж илрүүлсэн байна.<sup>5</sup>

Гэхдээ баривчлагдаж байгаа хүн шалтгаанаа хангалттай ухамсарлаж байвал тухайн нөхцөл байдлыг харгалзан зарим үед заавал мэдэгдэхгүй байж болно.

Машинаас нь мансууруулах бодис илрүүлсэн нэгэн хүнийг баривчлаад, маргааш өглөө нь хэлмэрчээр дамжуулан баривчилсан шалтгааныг мэдэгдсэн тохиолдолд тухайн этгээд баривчлах шалтгааныг хангалттай ойлгоогүй гэж маргах нь огт үндэслэлгүй хэмээн Хүний Эрхийн Хороо үзжээ.<sup>6</sup>

Европын комиссын 5 дугаар зүйлийн 5.2-т зүйлд баривчлах шалтгааныг “нэн даруй” мэдэгдэхийг шаардсан байдаг. Энэ “яаралтай, нэн даруй” гэх нэр томъёоны агуулга нь ерөнхийдөө хатуу ойлгогдохоор боловч орчуулагч, хэлмэрч олох шаардлагатай болсон үед хойшлогдохоос өөр аргагүй болно.

Европын шүүх баривчлагдаж байгаа хүнд яагаад баривчлагдаж байгааг ойлгуулах зорилготой “баривчлах болон байцаах хоёрын хооронд гарч байгаа хугацаа” нь 5.2 дугаар зүйлд тогтоосон нэн даруй хугацаанд хамаарахгүй гэж тогтоосон байна.<sup>7</sup>

## Ишлэл

2. Судан: Хүний Эрхийн Төлөв Байдлын Судалгааг Дүгнэх нь, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП /С/79/Нэмэлт 85, 1997 оны 11 дүгээр сарын 19
3. Келли ба Ямайка (253/1987) 1991 оны 4 дүгээр сарын 8, Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл (А/46/40) 1991 он
4. Фокс, Кампбелл болон Хартлей (18/1989/178/234-236) 1990 оны 8 дугаар сарын 30
5. Порторрейл ба Бүгд Найрамдах Доминикан Улс (188/1984)
6. Гриффин ба Испани (493/1992) 1995 оны 4 дүгээр сарын 4, НҮБ-ын баримт бичиг ИУТЭОУП /с/57/1, 1996 оны 8 дугаар сарын 23.
7. Фокс, Кампбелл болон Хартлей (18/1989/178/234-236) 1990 оны 8 дугаар сарын 30

\*Үндсэн Зарчим - 13 ба 14 дүгээр зарчим, Югославын Дүрмийн 42 дугаар дүрэм, Руандагийн Дүрмийн 42 дугаар дүрэм

Хуульчдын Гүйцэтгэх Үүргийн Үндсэн Зарчмын 5 дугаар зарчим, Үндсэн зарчим – 17(1) дугаар зарчим

\*\*\*\* Иргэний болон улс төрийн олон улсын пакт 9(2) ба 14(3) (а) дүгээр зүйл, Америкийн Конвенцийн 7(4) ба 8(2)(б) болон Европын Конвенцийн 5(2) ба 6(3)(а) дугаар зүйл, Зарчмуудын цогц -10 дугаар зарчим, Африкийн Комиссын Тогтоол 2(Б) хэсэг, Югославын Дүрмийн 20(2) ба 21(4)(а) дугаар зүйл, Руандагийн 20(2) ба 21(4)(а) дугаар дүрэм

## Ишлэл

8. Югослав болон Руандагийн Дүрэм нь Прокуророор байцаагдаж буй сэжигтэнд хорионд байгаа эсэхийг үл харгалзан өөрөө өмгөөлөгч эсвэл үнэ төлбөргүй хуулийн туслалцаа авах эрх, үнэ төлбөргүй орчуулга тайлбар авах эрх эсвэл дуугүй байх эрхийг мэдэгдэхийг шаарддаг.
9. Холбооны Бүгд Найрамдах Герман (8098/77)1978 оны 12 дугаар сарын 13

## 2.2 Эрхийг нь сануулах

Аливаа хүн эрхээ эдлэхийн тулд түүнийгээ сайтар мэдэж байх ёстой. Баривчлагдаж байгаа болон түр саатуулагдаж байгаа хүмүүст өөрсдийн эрхийг нь сануулах, түүнийгээ хэрхэн хэрэгжүүлэхийг тайлбарлаж өгөх ёстой.\*<sup>8</sup>

### 2.2.1 Өмгөөлөгч авах эрхийг мэдэгдэх

Баривчлагдсан болон албадан саатуулагдсан хүн бүрийн мэдэх ёстой нэг чухал эрх нь тэд өмгөөлөгч, хуульчийн туслалцаа авах эрхтэй гэдгээ ойлгох явдал юм. Шүүх хурлаас өмнө өмгөөлөгч авах эрхийг **3-р бүлгээс үзнэ үү**. Баривчлагдсан, түр саатуулагдсан, ял тулгагдаж байгаа хүн бүрт өмгөөлөгч, хууль зүйн тусламж авах эрхийг мэдэгдэх ёстой.\*\*

Хуульчдын Гүйцэтгэх Үүргийн Үндсэн Зарчмуудын 5 дугаар зарчмын дагуу “баривчлах, түр саатуулагдах, эрүүгийн хэрэгт яллах үед нэн даруй энэхүү мэдээллээр хангана гэж заасан. Зан үйлийн зарчмын 17.1 зарчим нь баривчилсны дараа яаралтай мэдээллээр хангах ёстой гэсэн байдаг. Югославын дүрэм, Руандагийн дүрмээр прокурорт байцаагдаж байгаа аливаа сэжигтнийг тухайн хүн баривчлагдсан эсэхээс үл хамааран өмгөөлөгч авах тухай мэдэгдлийг хүргэнэ гэж заажээ.

## 2.3 Оноогдох ялыг нэн даруй мэдэх эрх

Баривчлагдсан болон саатуулагдсан хүн бүр тэдэнд ямар ял тулгасан талаар нэн даруй мэдээлэл авах эрхтэй.\*\*\*

Европын Комиссоос Европын Конвенцийн 5 дугаар зүйлийн 5.2-т баривчлагдаж буй бүх хүнд “баривчлах тухай шийдвэрийн үндэслэл болж байгаа үйлдэл болон нотлох баримтыг хангалттай мэдэгдэх ёстой бөгөөд ингэснээр тулгаж байгаа хэргийг хүлээн зөвшөөрөх эсхүл үгүйсгэх боломжийг сэжигтэнд олгох ёстой” гэж шийдвэрлэсэн.<sup>9</sup>

Оногдуулах ялын тухай мэдээллийг нэн даруй хүргэх шаардлага нь үндсэн 2 зорилгыг агуулдаг. Баривчлагдаж байгаа хүн бүр тэднийг хуулийн дагуу баривчилж байгаа талаархи мэдээллийг авах нь ИУТЭОУП-ын 9 дүгээр зүйлийн 9.2-т заасан болон бүс нутгийн гэрээний заалтууд дахь аюулгүй байдлыг хангах зорилготой юм. Түүнчлэн эрүүгийн хэргээр шүүгдэж байгаа этгээд аюулгүй байдлаа хангаж эхэлсэн, хангасан эсэхээс үл хамааран энэхүү эрхээ эдлэхийг зөвшөөрдөг. ИУТЭОУП-ын 14.3, Америкийн конвенцийн 8.2.б, Европын конвенцийн 6.3 дугаар зүйлүүдэд энэ тухай нарийвчилан зохицуулсан байдаг. Баривчилсны дараа нэн даруй мэдээлэл өгөх нь аюулгүй байдлыг хангахын тулд олгох мэдээлэлтэй адил тодорхой байхыг шаарддаггүй. 8-р бүлгийн Өмгөөлөлд бэлтгэх тохиромжтой цаг хугацаа, нөхцлөөр хангагдах эрх 8.4. Тулгагдаж буй ялын тухай мэдээлэл авах эрхийг үзнэ үү.

## Холбогдох хэм хэмжээ

### Үндсэн зарчмууд -13

Аливаа этгээдэд эрхийг нь болон түүнийг хэрэгжүүлэх журмын талаар баривчлах үед, эсвэл саатуулах буюу хорихын өмнө эсхүл дараа нь нэн даруй уг баривчлах, саатуулах, хорих ажиллагааг хариуцах байгууллага мэдэгдэж, тайлбарлан ойлгуулах ёстой.

### Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчим – 5

Засгийн газар нь эрх бүхий байгууллагууд баривчлах, буюу хорих, эсхүл эрүүгийн гэмт хэрэгт яллах үедээ хүн бүрт өөрийн сонголтоор хуульчийн

## 2.4 Албадан саатуулагдсан этгээдийн ойлгож чадах хэл дээр мэдээллийг хэлж өгөх

Мэдээллийг бүрэн ойлгуулахын тулд тухайн хүний мэдэх хэлээр мэдэгдэх ёстой. 23 бүлгийн “орчуулагч хэлмэрч авах эрх”-ийг үзнэ үү.

Эрх бүхий байгууллагын хэрэглэж буй хэлийг хангалттай ойлгодоггүй болон ярьдаггүй баривчлагдсан, цагдан хоригдсон, яллагдсан хэн бүхэн эдлэх эрх, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх, баривчлагдсан цагдан хоригдсон шалтгаан болон оногдуулах ялын талаар өөрийн ойлгодог хэлээр мэдээлэл авах эрхтэй. Мөн тэд баривчилсан шалтгаан, баривчлах болон цагдан хорих байр руу шилжүүлэх хугацаа, шүүхэд эсвэл бусад эрх бүхий байгууллагад шилжүүлэх огноо, түүнийг хэн баривчилсан, цагдан хорьсон, хаана саатуулсан тухай бичгээр үйлдсэн мэдэгдлийг авах эрхтэй.\* Түүнчлэн тэд баривчилсны дараах шатанд хэлмэрч авах эрхтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд үнэ төлбөргүй байна.\*\*

Тухайн хүний ойлгодог хэлээр баривчилсан шалтгааныг мэдэгдэхийг шаарддаг ганц гэрээ нь Европын конвенц юм.\*\*\* Гэхдээ Хүний Эрхийн Хороо үүнийг улам тодруулж, Африкийн комиссийн шийдвэрийн 2.б-д болон Үндсэн Зарчмуудын 14 дүгээр зарчимд энэ тухай тусгайлан зохицуулсан байдаг.

### Холбогдох хэм хэмжээ

#### Үндсэн зарчим – 14

Баривчлах, саатуулах буюу хорих ажиллагааг хариуцсан байгууллага, албан тушаалтны хэлээр сайн ярьдаггүй буюу ойлгодоггүй, этгээд энэхүү зарчмуудын 10, 11 /2 дахь хэсэг/, 12 /1 дэх хэсэг/ 13 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн мэдэх хэл дээр аль болох түргэн авах, тэрчлэн түүний баривчлагдсаны дараа хэргийг хянан шийдвэрлэхтэй холбогдуулан орчуулагчийн туслалцааг шаардлагатай бол үнэ төлбөргүй авах эрхтэй.

#### Консулын харилцааны тухай Венийн конвенцийн 36-р зүйл

Консулын тойрогт томилогч улсын аль нэг иргэнийг баривчилсан, хорьсон буюу шүүх хурал хүртэл цагдан хорьсон эсхүл ямар нэг өөр хэлбэрээр албадан саатуулсныг уг иргэн шаардвал хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага томилогч улсын консулын байгууллагад мэдэгдэнэ. Тэдгээр байгууллага баривчлагдсан, гянданд хоригдсон, цагдан хоригдсон буюу албадан саатуулагдсан хүнээс уг консулын байгууллагад мэдэгдэх гэсэн бүх мэдээг саадгүй уламжилна. Тэдгээр байгууллага энэ дэд хэсэгт дурдсан эрхийг уг хүнд нэн даруй мэдэгдэнэ.

Хэрэв гэрээнд оролцогчид түүний заалтыг хэрэглэн гуравдахь улсад буюу түүний оролцсон бүлэг улсад эсхүл нийт улсад эрх олгохыг зорьж байгаа бөгөөд гурав дахь улс үүнийг зөвшөөрвөл тэрхүү гэрээний заалтаас түүний эрх үүснэ. Гэрээнд өөрөөр заагаагүй бол сөрөг нотолгоо гарах хүртэл тус улсын зөвшөөрөл хэвээр байна гэж үзнэ.

#### Зан үйлийн зарчим - 16,2

Хэрэв саатуулагдсан болон хоригдож буй этгээд гадаадын иргэн бол иргэн нь болох улсын буюу олон улсын эрх зүйн дагуу ийм мэдээлэл авах эрх бүхий өөр улсын дипломат төлөөлөгчийн газар болон консулын газартай, хэрэв уг этгээд нь дүрвэгч, буюу ямар нэгэн байдлаар засгийн газар хоорондын байгууллагын хамгаалалтанд байдаг этгээд бол олон улсын эрх бүхий байгууллагын төлөөлөгчидтэй зохих хэрэгсэлээр холбоо барих эрхтэй болохыг нэн даруй мэдэгдэх ёстой.

\* Үндсэн Зарчим - 14 дүгээр зарчим

\*\* Үндсэн Зарчим - 14 дүгээр зарчим, Югославын Дүрмийн 21(4)(а) дугаар зүйл, Руандагийн 20(4)(а)дугаар дүрэм

\*\*\*Европын Конвенцийн 5(2) дугаар зүйл

## 2.5 Гадаадын иргэд

Гадаад иргэн баривчлагдсан, цагдан хоригдсон тохиолдолд дээрхээс гадна тухайн орны элчин сайд, консулын газарт нэн даруй мэдэгдэж, холбоо тогтоож өгөх ёстой. Хэрэв дүрвэгч, харьяалалгүй хүн эсвэл засгийн газар хоорондын байгууллагаар хамгаалагдах этгээд байвал зохих олон улсын байгууллагад мэдэгдэж, холбож өгнө.\*

Консулын харилцааны тухай Венийн конвенц нь тухайн хүний баривчлагдсан, саатуулагдсан, хоригдсон этгээдэд энэхүү эрхийг хойшлуулалгүйгээр мэдэгдэхийг шаарддаг. Харин Үндсэн зарчмуудад энэхүү мэдээллээр нэн даруй хангана гэж заасан байдаг.

\*Консулын Харилцааны тухай  
Венийн Конвенцийн 36 дугаар  
Зүйл ба Зарчмуудын цогц –  
16(2) дүгээр зарчим

### Ишлэл

10. Хүний Эрхийн Хороо  
Ерөнхий Тайлбар 13, догол  
мөр 8



## Бүлэг 3

### Шүүх хурлаас өмнө эрх зүйн

#### зөвлөгөө авах эрх

Эрүүгийн хэрэгт сэжиглэгдсэн хорионд байгаа хүн бүр эрхээ эдлэх, өөрсдийгөө хамгаалах тусламж авах, сонголт хийх, хуульчийн зөвлөлгөө авах эрхтэй. Хэрвээ тухайн хүн өмгөөлөгч хөлслөх боломжгүй бол хуулийн байгууллагаас шаардлага хангах хуулийн зөвлөхийг томилж өгнө. Мөн хуульчтай уулзах зохих цаг хугацаагаар хангагдсан байна. Өмгөөлөгчтэйгээ уулзах холбоог шуурхай тогтоох ёстой.

#### 3.1 Өмгөөлөгчийн туслалцаа авах эрх

##### 3.1.1 Шүүх хурлаас өмнөх шатанд өмгөөлөгч авах эрх

#### 3.2 Өмгөөлөгч сонгох эрх

#### 3.3 Үнэ төлбөргүй өмгөөлөгч авах эрх

##### 3.3.1 Туршлагатай болон нэр хүндтэй өмгөөлөгч авах эрх

#### 3.4 Албадан саатуулагдсан этгээд өмгөөлөгч авах эрх

##### 3.4.1 Албадан саатуулагдсан этгээд хэдийд өмгөөлөгч авах эрхтэй вэ?

#### 3.5 Албадан саатуулагдсан этгээд өөрийн өмгөөлөгчтэйгээ зөвлөлдөх цаг нөхцлөөр хангагдах эрх

#### 3.6 Өмгөөлөгчтэйгээ аминчлан, чөлөөтэй уулзах эрх

### 3.1 Хуульчийн тусламж авах эрх

Эрүүгийн хэрэг болон өөр хэргээр баривчилагдаж, хоригдсон, хоригдоогүй хүн бүр хуулийн зөвлөгөө авах эрхтэй.\* **20.3-р бүлэгт байгаа өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрхийг үзнэ үү.**

#### 3.1.1 Шүүх хурлаас өмнөх шатанд өмгөөлөгч авах эрх

Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 1-р зүйлд эрүүгийн байцаан шийтгэх бүх шатанд байцаалтын явцад ч өмгөөлөгчтэй байх эрхийг заасан байдаг. /хоригдож байгаа бүх хүнд хамааруулсан энэ тухай заалтыг Үндсэн зарчмуудын цогцын 17-р зүйлээс үзнэ үү./

#### Холбогдох хэм хэмжээ

##### Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 1-р зүйл

Хүн бүр эрхээ хамгаалуулахын тулд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүх шатанд өмгөөлөгчдөд хандах эрхтэй.

##### Цогц зарчим 17-р зүйл

Саатуулагдсан этгээд өмгөөлөгчөөс хууль зүйн зөвлөгөө авах эрхтэй. Уг этгээд баривчлагдсаны дараа өөрийн эрхийн тухай эрх бүхий мэдэгдэх бөгөөд түүнийг эрхээ хэрэгжүүлэх тааламжтай боломжийг олгоно.

##### Европын шоронгийн дүрмийн 93-р журам

Шүүхээр ял шийтгүүлээгүй этгээд хоригдсон даруйдаа өмгөөлөгчөө сонгох, эсхүл үнэ төлбөргүй өмгөөлөгчөөр хангагдах эрхтэй байх бөгөөд тухайн өмгөөлөгч нь түүнийг хамгаалах зорилгоор айлчилж очих, мэдээллээ алдахгүйгээр уулзах боломжтой байх ёстой.

\* Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 1 дугаар зарчим, Үндсэн Зарчим– 17(1) дугаар зарчим, Европын Шоронгийн Дүрмийн 93 дугаар дүрэм, Югославын Дүрмийн 21(4)(г) дугаар зүйл, Руандагийн 20(4)(г) дугаар дүрэм. Мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 55(2)(в) дугаар зүйлийг үзнэ үү.

Шүүн таслах ажиллагаанаас өмнө хуулийн зөвлөлгөө авах эрхийн талаар ИУТЭОУП, Америкын конвенц, Африкийн дүрэм, Европын конвенцид оруулсан байдаг. Гэхдээ Хүний эрхийн хороо, Америк хоорондын комисс, Европын шүүх шударгаар шүүлгэх эрх эдлэн гэдэг нь хорих, байцаах, мөрдөн байцаах шатанд өмгөөлөгчтэй байхыг шаарддаг.

ИУТЭОУП, Америкын конвенц, Африкийн дүрэм, Европын конвенцид зааснаар хувь хүний шүүн таслах ажиллагаанаас өмнө хуулийн зөвлөлгөө авах эрх нь тодорхойгүй байдаг. Гэхдээ Хүний эрхийн хороо, Америк хоорондын комисс, Европын шүүхэд шударгаар шүүлгэх эрх эдлэх гэдэгт хорих, байцаах, мөрдөн байцаах шатанд өмгөөлөгчтэй байхыг шаарддаг.

Хүний Эрхийн Хороо “бүх баривчлагдсан хүн нэн дариу өмгөөлөгч авах ёстой” гэж тогтоосон байна.<sup>1</sup>

Америк Дундын Комисс хэрэгтэн болж байгаа хэн боловч баривчлагдмагцаа өмгөөлөгч авах эрхтэй. Мөрдөн байцаалтын явцад болон саатуулагдсан этгээдийн өмгөөлөгч авах эрхийг хязгаарлаж болно гэсэн хуулийн хориглолт нь өмгөөллийн эрхийг ноцтой зөрчиж байгаа хэрэг гэж үзсэн байна.<sup>2</sup>

Үүнтэй адилаар Европын Шүүх “хэрэгтэн цагдаагийн газар мөрдөн байцаах анхны шатнаас өмгөөлөгчийн зөвлөгөө авах нь шударгаар шүүлгэхийн үндэс” гэжээ. Шүүх түр саатуулах байранд 48 цаг байлгахдаа өмгөөлөгчөөс зөвлөгөө авах эрхийг нь хязгаарласан хэргийг шалгажээ. Энэ нь тэр хүнд ял тулгах уу, үгүй юу гэдэгт нь нөлөөлөхөөс гадна баривчлагдахдаа мэдүүлэг өгөхгүй байх хэрэгтэй, хэлсэн үг нь шүүх дээр түүний эсрэг хэрэглэгдэж болзошгүй гэдгийг сануулахыг заасан үндэсний хуультай зөрчилдсөн байжээ. Европын шүүх баривчилсны дараа 48 цаг өмгөөлөгчөөс зөвлөгөө авах эрхийг боогдуулсан нь Европын конвенцийн 6-р зүйлийг зөрчсөн гэж дүгнэсэн байна.<sup>3</sup>

Югославын дүрэм, Руандагийн Дүрэм болон ОУЭШ-ийн дүрэмд сэжигтэн прокурорт байцаагдахдаа өмгөөлөгчтэй байх эрхийг хангаж өгдөг.\*

### 3.2 Өмгөөлөгчөө сонгох эрх

Хуульч сонгох эрх гэдэг нь хэрэгтэн өөрийн сонголтоор өмгөөлөгчөө сонгох эрхтэй гэсэн үг юм.\*\* 20.3-р бүлгийн өмгөөлөгчөөр хамгаалуулах эрхийг үзнэ үү.

### 3.3 Үнэ төлбөргүй өмгөөлөгч авах эрх

Хэрвээ баривчлагдсан, ял тулгагдсан, албадан саатуулагдсан хүн өөрийн сонгосон өмгөөлөгч байхгүй бол шүүх болон бусад байгууллагаас томилсон өмгөөлөгчийг авах эрхтэй. Хэрвээ тухайн хүн өмгөөлөгч хөлслөх боломжгүй бол үнэ төлбөргүй өмгөөлөгч авах эрхтэй.\*\*\*

Шударга шүүхийн үүднээс хэрэг хэр ноцтой болох, ямар ял тулгахаас хамаарч өмгөөлөгчийг томилно. /20.3.3-р бүлэгт байгаа өмгөөлөгч томилуулж авах, үнэ хөлсгүй хуулийн туслах авах эрхийн талаар дэлгэрүүлэн үзнэ үү./

Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 3-р зарчимд засгийн газраас ядуу болон, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хуулийн зөвлөгөө авах мөнгө санхүүгээр хангахыг шаардсан байдаг.

\*Югославын Дүрмийн 42 дугаар зүйл болон Руандагийн 42 дугаар дүрэм. Мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 55(2)(в) дугаар зүйл

\*\*Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 1 болон 5 дугаар зарчим, Европын Шоронгийн Дүрмийн 93 дугаар дүрэм мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 55(2)(в) дугаар зүйл

\*\*\* Үндсэн Зарчим - 17(2) дугаар зарчим, Хуульчдын Гүйцэтгэх Үүргийн Үндсэн Зарчмын 6 дугаар зарчим, Югославын Дүрмийн 42(А) (з) дугаар зүйл, Руандагийн 20(4)(з) дугаар дүрэм болоод Югославын Дүрмийн 21(4)(г) дугаар зүйл, Руандагийн 20(4) (г) дугаар дүрэм Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 55(2)(в) дугаар зүйлүүд.

#### Ишлэл

1. Гүрж: Хүний Эрхийн Төлөв Байдлын Судалгааг Дүгнэх нь, НУБ-ын баримт бичиг, ИУТЭОУП/С/79/Нэмэлт 74, 1997 оны 4 дүгээр сарын 9, догол мөр 28
2. Америк Дундын Комиссын жил бүрийн илтгэл, 1985-1986, Америкийн Улсуудын Байгууллага Ser.L/V/II.68 баримт бичиг 8, хэвлэл 1, 1986 он, хуудас 154, Эль Салвадор
3. Маррей ба Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (41/1994/488/570), 1996 оны 2 дугаар сарын 8

### 3.3.1 Туршлагатай болон нэр хүндтэй өмгөөлөгч авах эрх

Өмгөөлөгч авах эрх гэдэг нь ямар ч шаардлагад нийцэх зөвлөгөө авах гэсэн үг юм. Бүх улс сэжигтэн болоод, хэрэгтэнд шаардлага хангахуйц өмгөөлөгч томилох ёстой. Баривчлагдсан, түр саатуулагдсан, эрүүгийн хэргээр яллагдаж байгаа хэн боловч үр дүнтэй хуулийн тусламж авахын тулд хэргийн онцлогоос хамаарч туршлагатай, эрх мэдэл бүхий өмгөөлөгч томилуулах эрхтэй.\* **20.5-р бүлэгт байгаа туршлагатай, эрх бүхий, үр дүнтэй өмгөөлөгчөөр хамгаалуулах эрхийг үзнэ үү.**

### 3.4 Албадан саатуулагдсан этгээд өмгөөлөгч авах эрх

Хоригдож байгаа хүн бүр эрүүгийн хэргээр яллагдаж байгаа болоод яллагдаагүй байсан ч өмгөөлөгчтэйгээ уулзах эрхтэй.\*\* Өмгөөлөгчтэйгээ төвөггүй, тогтмол уулзаж байх нь эрүү шүүлт, зүй бусаар харьцах, албадан хэрэг хүлээлгэх, болон бусад зөрчлөөс хамгаалж байдаг.<sup>4</sup>

#### 3.4.1 Албадан саатуулагдсан этгээд хэдийд өмгөөлөгч авах эрхтэй вэ

Хоригдож байгаа хүн өмгөөлөгчтэйгээ уулзах эрхтэй байх нь эрхээ хамгаалах байдлыг хангахад чухал ач холбогдолтой. Иймээс олон улсын хэм хэмжээгээр баривчилсны дараа хойшлуулалгүйгээр өмгөөлөгчтэй нь уулзуулахыг онцгойлсон байдаг.

Хүний эрхийн хороо баривчлагдсан хүн бүр өмгөөлөгчтэйгээ нэн даруй уулзах ёстой гэдгийг онцолсон байна.<sup>5</sup>

Америк дундын комисс Америкын конвенцийн 8.2-р зүйлд байцаагдах эхний мөчөөс эхлэн өмгөөлөгч авах эрхтэй болохыг заасан байдаг.<sup>6</sup>

Хуульчдын Гүйцэтгэх Үүргийн Үндсэн Зарчмын 7-р зарчимд өмгөөлөгчийг нэн даруй авах тухай заасан байна.<sup>6</sup>

#### Холбогдох хэм хэмжээ

##### Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 6, 7-р зүйл Үндсэн зарчмын 17 /2/,18-р зүйл

Хэрэв шүүн таслах ажиллагааны ашиг сонирхолын улмаас шаардагдаж байгаа хийгээд саатуулагдсан этгээд өөрөө сонгож өмгөөлөгч аваагүй, өмгөөлөгчийн үйлчилгээг төлөх чадваргүй бол тэрээр шүүх буюу эрх бүхий байгууллагын олж өгсөн өмгөөлөгчөөр үйлчлүүлэх эрхтэй

##### Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 6 дугаар зарчим

Шүүн таслах ажиллагааны ашиг сонирхол шаардагдах бүх тохиолдолд өмгөөлөгчгүй, өмгөөллийн хөлс төлөх чадваргүй хүн бүр эрх зүйн зөрчлийн шинж чанарт тохирох, үр дүнтэй эрх зүйн тусламж авах үйлчилгээгээр хангагдах эрхтэй

##### Хуульчдын гүйцэтгэх үүргийн 7 дугаар зарчим

Засгийн газар нь баривчлагдсан хүн бүр эрүүгийн гэмт хэрэг үйлдсэнд нь ял сонгосон эсэхээс үл хамааран бүх тохиолдолд баривчлагдсанаас нь хойш 48 цагийн дотор хуульчид хандах явдлыг хангана.

##### Үндсэн зарчмын 18,1 дүгээр зарчим

Саатуулагдсан болон хоригдсон хүн бүр өмгөөлөгчтэйгээ холбоо барьж, зөвлөлдөх эрхтэй.

\*Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчим - 6 дугаар зарчим

\*\*Үндсэн Зарчим – 18(1) дугаар зарчим, Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчим 1 болон 7 дугаар зарчим

#### Ишлэл

4. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 20, догол мөр11, НҮБ-ын Эрүү шүүлтийн талаарх Тусгай Илтгэгч (Хүний Эрхийн Комисс.4/1992/17) 1991 оны 12 дугаар сарын 17
5. Гүрж: Хүний Эрхийн Төлөв Байдлын Судалгааг Дүгнэх нь, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП/С/79/Нэмэлт 74, 1997 оны 4 дүгээр сарын 9, догол мөр28
6. Никарагуан Мискито гаралтай цөөнхийн хүний эрхийн Төлөв байдлын талаарх илтгэл, , Америкийн Улсуудын Байгууллага Ser.L/V/II.62 баримт бичиг 10, 3 дах хэвлэл, 1983 он.
7. Баривчилсан буюу албадан саатуулсан мөчөөс хойш 48 цагийн дотор

\*Үндсэн Зарчим 18(3) дугаар зарчим

\*\* Хуульчдын Гүйцэтгэх Үүргийн Үндсэн Зарчмын 7 дугаар зарчим

\*\*\* Үндсэн Зарчим -15 дугаар зарчим

^ Хуульчдын Гүйцэтгэх Үүргийн Үндсэн Зарчмын 8 дугаар зарчим, Үндсэн Зарчим -18(3) дугаар зарчим, Наад захын Жишиг Дүрмийн 93 дугаар дүрэм, Европын шоронгийн дүрэм-93 дугаар дүрэм, ИУТЭОУП 14(3)(б) зүйл, Америкийн Конвенцийн 8(2) (в) болон 8(2)(г) Африкийн Комиссын Тогтоолын 2(Е) (б) хэсэг, болоод Югославын Дүрмийн 21(4)(б) дугаар зүйл, Руандагийн 20(4)(б) дугаар дүрэм Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 67(1)(б) дугаар зүйлүүд.

^^ Хуульчдын Гүйцэтгэх Үүргийн Үндсэн Зарчмын 8 дугаар зарчим, Үндсэн Зарчим -18(3) дугаар зарчим, Наад захын Жишиг Дүрмийн 93 дугаар дүрэм болоод Европын шоронгийн дүрэм-93 дугаар дүрмүүд

^^^ Хуульчдын Гүйцэтгэх Үүргийн Үндсэн Зарчмын 16 дугаар зарчим

### Ишлэл

8. НҮБ-ын Эрүү Шүүлтийн Талаарх Тусгай Илтгэгч, НҮБ-ын баримт бичиг, Хүний Эрхийн Комисс 4/1990/17, 1989 оны 12 дугаар сарын 17, догол мөр 272. Мөн, НҮБ-ын баримт бичиг, Хүний Эрхийн Комисс 4/1995/34, 1995 оны 1 дүгээр сарын 12, догол мөр 926
9. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 9
10. Крочер болон Моллер ба Швейцарь (8463/78) 1981 оны 7 дугаар сарын 9,
11. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 9

Зөвхөн хуульд заасан онцгой үндэслэл журмыг үндэслэн өмгөөлөгчтэйгээ уулзах эрхийг нь түр түдгэлзүүлж болно.

Хоригдож байгаа хүнд хуульчийн зөвлөгөө авахыг хориглож болох нөхцлүүд нь зөвхөн хууль болон хуулийн дүрэм журмаар аюулгүй байдал, дэг журмыг сахих үүднээс шүүх болон захиргааны байгууллага хориглож болно.\*

Гэхдээ эдгээр хориг нь аль болох богино байна.

НҮБ-ын эрүү шүүлтийн талаар Тусгай Илтгэгч баривчлагдсан хүн бүр баривчлагдсанаас хойш 24 цагийн дотор өмгөөлөгч авах ёстой гэж зөвлөжээ.<sup>8</sup>

Ямар ч хэргээр баривчлагдсан, саатуулагдсан бай 48 цагаас хэтрэхгүй хугацаанд өмгөөлөгч авахыг нь хориглож болохгүй.\*\*

Үндсэн зарчмын 15-р зарчимд “заасан хугацаанаас хойш” ямар ч нөхцөлд хоригдсон хүний хуулийн зөвлөгөө авах эрхийг хорьж болохгүй гэж заасан байдаг.\*\*\*

### 3.5 Албадан саатуулагдсан этгээд өөрийн өмгөөлөгчтэйгээ зөвлөлдөх цаг нөхцлөөр хангагдах эрх

Эрүүгийн хэргээр яллагдаж байгаа бүх хүн өөрийнхөө өмгөөлөгчтэйгээ найдвартай харилцах боломжийг олгосон уулзах тохиромжтой цаг, байраар хангагдах ёстой. /8-р бүлгийг үзнэ үү./ <sup>^9</sup>Үүнийг бүх шатанд хэрэгжүүлэх эрхтэй бөгөөд ялангуяа урьдчилан хорих төвд байгаа хүмүүс энэ эрхээр хангагдах ёстой.

Хоригдож байгаа хүн ямар ч саад, хугацаа хойшлуулах, хяналт цагдалтгүйгээр өмгөөлөгчтэйгээ уулзах таатай орчинг Төр бүрдүүлэх ёстой.^^

Европын конвенцид яллагдагч өмгөөлөгчтэйгээ уулзах, холбоотой байх эрхийг шууд тусгаагүй ч Европын Комисс “хоригдож байгаа хүний эрхээ хамгаалах үндсэн хэлбэр нь хуулийн зөвлөлгөө авах явдал мөн гэж заасан байдаг.<sup>10</sup>

Удирдлагаас хуульчдыг ямар ч хавчлага, заналхийлэл, саад бэрхшээлгүйгээр, зохисгүй харьцаа, хөндлөнгийн оролцоогүйгээр мэргэжлийн түвшинд зөвлөгөө өгч, үйлчлүүлэгчээ төлөөлөх боломжийг бүрдүүлэх ёстой.^^^11

#### Холбогдох хэм хэмжээ

##### ИУТЭОУП -ын 14,3 дугаар зүйл

Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр дараахь наад захын баталгаагаар хангагдах эрхтэй:

3/ өмгөөлүүлэх ажлаа бэлтгэх хүрэлцээтэй хугацаа, бололцоотой байх, сонгож авсан өмгөөлөгчтэйгээ харилцах

##### Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 8-р зүйл

Баривчлагдсан саатуулагдсан, шоронд хоригдсон бүх этгээдүүд, хуульчтай уулзах зохих боломж, хугацаа нөхцөл, түүнтэй садагүй бусдын оролцоогүй, хяналтгүйгээр бүрэн ганцаарчилан харьцах, зөвлөлдөх, ийм зөвлөгөөнийг хууль хэрэгжүүлэх албан тушаалтны дэргэд тэгэхдээ тэд нар сонсох боломжгүйгээр хангуулах ёстой.

### 3.6 Өмгөөлөгчтэйгээ аминчлан, чөлөөтэй уулзах эрх

Эрх баригчид болон хорих байгууллагын удирдлага өмгөөлөгчийн үйлчлүүлэгчтэйгээ найдвартай харилцаатай байх эрхийг хүндэтгэх ёстой. Найдвартай харилцах эрхийг баривчлагдсан, саатуулагдсан, эрүүгийн болон өөр хэргээр яллагдаж байгаа бүх хүнд олгоно.\*<sup>12</sup> **20,4-р бүлгийн өмгөөлөгчтэй найдвартай аюулгүй харилцах эрхийг үзнэ үү.**

Найдвартай харилцах эрхээр хангагдана гэдэг нь хэрэгтэн хуульч хоёр бичгээр болоод амаар ярилцах /үүнд утсаар ярих орно/ үед ямар ч саад, хяналт байх ёсгүй гэсэн үг юм.

Хоригдсон болон саатуулагдсан хүн түүний өмгөөлөгчийн хоорондын харилцаа хэрвээ хэрэгтэн дахин давтан хэрэг үйлдээгүй бол өөрийн эсрэг мэдүүлэг өгөх ёсгүй.\*\*

Аюулгүй байдлыг хангахын тулд олон улсын хэм хэмжээгээр хууль сахиулах албаныхан хоригдсон этгээдийг өмгөөлөгчтэйгээ уулзах үед нь харж болох боловч сонсохуйцаар ойртох эрхгүй гэж заасан байдаг.\*\*\*

#### Холбогдох хэм хэмжээ

**Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 22-р зүйл**  
Засгийн газар нь өмгөөлөгч болон тэдний үйлчлүүлэгчийн ажил мэргэжлийнхээ хүрээнд харилцах аливаа харилцаа, зөвлөгөөний нууц шинж чанартай байхыг нь хүлээн зөвшөөрч хангах ёстой.

#### Үндсэн зарчмын 18.5,18.4-р зүйл

Саатуулагдсан болон хоригдсон этгээд өмгөөлөгчтэйгээ уулзахад нь хууль хэрэгжүүлэгч байгууллагын албан тушаалтан харж болох боловч, харин яриаг нь сонсохооргүй байх нөхцөлд байлгана.

#### Үндсэн зарчмын 18.5,18.4-р зүйл

Саатуулагдсан болон хоригдсон этгээд өмгөөлөгчтэйгээ холбоо барих холбоог нь үйлдсэн буюу үйлдэхээр төлөвлөж буй гэмт хэрэгт холбоогүй л бол саатуулагдсан болон хоригдсон этгээдийн эсрэг гэрчлэх баримт, нотолгооны журмаар ашиглаж болохгүй.

\* Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 8 ба 22 дугаар зарчим, Үндсэн Зарчим – 18 дугаар зарчим, Европын шоронгийн дүрэм-93 дугаар дүрмүүд болон Африкийн Комиссын Тогтоолын 2(E)(1) хэсгийг үзнэ үү.

\*\* Үндсэн Зарчим - 18(5) дугаар зарчим

\*\*\* Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 8 дугаар зарчим, Үндсэн Зарчим -18(4) дугаар зарчим, Наад захын Жишиг Дүрмийн 93 дугаар дүрэм, Европын шоронгийн дүрэм-93 дугаар дүрмүүд

#### Ишлэл

12. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 9

## Бүлэг 4

# Хоригдож буй этгээд гадаад ертөнцтэй харьцах эрх

Хоригдож буй этгээд хүн гэр бүл, хуульч, эмч болон шүүхийн байгууллагын ажилтнуудтай уулзах эрхтэй. Харин гадаадын иргэн бол өөрийн улсын консулын ажилтан юм уу холбогдох олон улсын байгууллагатай харилцах эрхтэй. Гадаад ертөнцтэй харьцах эрхтэй байхын гол ач холбогдол нь “сураггүй алга болох”, эрүү шүүлт тулгагдах, зүй бус, хүнлэг бусаар харьцах зэрэг хүний эрхийн ноцтой зөрчлөөс хамгаалдаг. Энэ бүлэгт төрөл садан гэр бүлтэйгээ уулзах болон эмнэлгийн хараат бус эмчилгээ хийлгэх эрхийн талаар дэлгэрүүлэн үзэх болно. Бид хуульчтай уулзах эрхийн талаар 3-р бүлэгт, шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх эрхийн талаар 5-р бүлэгт үзсэн байгаа.

### 4.1 Эргэлт хүлээн авах ба уулзалт хийх

#### 4.1.1 Ямар нэгэн холбоо тогтоох эрхгүйгээр албадан саатуулагдах

### 4.2 Албадан саатуулагдсан тухайгаа болон хоригдож буй газрынхаа талаар гэр бүлийнхэндээ мэдэгдэх

### 4.3 Эргэлт, уулзалт авах эрх

### 4.4 Гадаадын иргэдийн гадаад ертөнцтэй харьцах эрх

### 4.5 Эмчид хандах эрх

#### 4.5.1 Эмчийн тусламж авах эрх хэдийд үүсэх вэ?

## 4.1 Эргэлт хүлээн авах ба уулзалт хийх

Хуулийн дагуу хоригдож байгаа хүмүүсийн нэг хэсэг эрх чөлөө хязгаарлагдана. Гадагш зорчих, эсвэл нэгдэх зэрэг эрхээ хязгаарлуулна. Нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдож байлаа ч түр саатуулагдсан хүмүүс, мөн хоригдлууд нь хяналт дор байдаг учраас эмзэг байдаг. Олон улсын эрх зүйгээр үүнийг онцгойлон авч үзэж, төрөөс хоригдож байгаа хүмүүсийн өмнө хүлээх үүргийг заасан байдаг. Эрх чөлөөг нь хязгаарласан хүмүүсийг харж хандахдаа гол нь аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах шаардлагатай. Хоригдол эрх чөлөөгөө хязгаарлуулахаас өөр ямар нэг хатуу шийтгэл хүлээх ёсгүй.<sup>1</sup>

Хоригдлуудын бусадтай уулзах харьцах, эргэлт хүлээн авах нь хүний эрхийг зөрчсөн эрүү шүүлт, зүй бусар харьцах, сураггүй алга болгох зэргээс хамгаалах үндсэн хамгаалалт болдог.

Хоригдож байгаа хүмүүс нь гадаад ертөнцтэй зөвхөн зохистой нөхцөл хязгаарлалттай харьцах эрхтэй.\*

### 4.1.1 Ямар нэгэн холбоо тогтоох эрхгүйгээр албадан саатуулагдах

Ямар нэгэн холбоо тогтоох эрхгүйгээр албадан саатуулагдах /гадаад ертөнцтэй харьцах боломжгүй хорио/ эрүү шүүлт, зүй бусаар харьцах, “сураггүй алга болох” нөхцлийг бүрдүүлж өгдөг. Хугацаа сунгаж нууцаар хорих нь хүнлэг бусаар, нэр төрийг гутаан доромжилж харгислаж байгаа нэгэн хэлбэр мөн.<sup>2</sup>

Олон улсын эрх зүйгээр гэхдээ нууц хориог бүх нөхцөлд хориглоогүй байна. Олон улсын жишиг хэмжээ, шинжээчдийн байгууллага хоригдлыг гадаад ертөнцөөс хязгаарлахдаа зөвхөн онцгой нөхцөлд богино хугацаанд хорихыг зөвшөөрсөн байдаг. /Бүлэг 3.4.1, Хоригдож байгаа хүн хэзээ хуульчтай уулзах вэ бүлгийг үзнэ үү./

\* Үндсэн Зарчим -19 дүгээр зарчим

## Ишлэл

1. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 21, догол мөр  
2. Эл гарын авлагад хэрэглэсэн “Ямар нэгэн холбоо тогтоох эрхгүйгээр албадан саатуулах” гэдэгт ялтай болон ял шийтгэл оногдуулаагүйгээс үл хамааран гэр бүл, ойр дотныхон, хуульч болон эмч нартай холбоо тогтоох эрхгүйгээр хоригдож буйг хэлнэ. Шүүх хурлын өмнө болон дараа нь ямар нэгэн холбоо тогтоох эрхгүйгээр албадан саатуулж болно (Бүлэг 5,6 –г унш). Ямар нэгэн холбоо тогтоох эрхгүйгээр албадан саатуулах нь бусад хоригдлуудтай ярилцах, холбоо тогтоохыг хориглодог ганцаарчилсан хорихоос огт өөр ухагдахуун юм.

НҮБ-ын Хүний эрхийн комисс 1997 оны 4 дүгээр сард “урт хугацаагаар тусгаарлан хорих нь эрүү шүүлт тулгах таатай боломж бүрдүүлдэг бөгөөд энэ нь өөрөө харгис, хүнлэг бус, нэр төрийг гутаан доромжилсон хандлага мөн” гэж тогтоожээ.<sup>3</sup>

НҮБ-ын эрүү шүүлтийн талаарх Тусгай Илтгэгч холбоо тогтоох эрхгүйгээр хорихыг бүх нөхцөлд хориглосон. Тэрээр “Эрүү шүүлт ихэнхдээ нууцаар хорьсон үед явагддаг. Нууцаар хорих нь хууль бус бөгөөд ингэж хоригдож буй хүнийг даруй чөлөөлөх ёстой. Баривчлагдсанаас хойш 24 цагийн дотор өмгөөлөгчтэйгээ уулзах эрхийг хуулиар баталгаажуулах шаардлагатай” гэж цохон тэмдэглэсэн.<sup>4</sup>

Хүний эрхийн хороо гаадагш холбогдох эрхгүйгээр хорих нь ИУТЭОУП-ын 7-р зүйл /эрүү шүүлт, зүй бус харьцааг хориглох/, ИУТЭОУП-ын 10-р зүйл /эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүсийн хамгаалалт/ -ийг зөрчиж байна гэж мэдэгдэж байна.<sup>5</sup> Эдгээр нь эрүү шүүлт, зүй бус харьцаанаас хамгаалах төдийгүй “нууцаар хорихоос хамгаалах” зорилготой юм.<sup>6</sup>

Перугийн хуулинд алан хядлага болон түүнтэй адилтгах хэрэгт сэжиглэгдсэн этгээдийг байцаахдаа болгоомжлох үүднээс гадагш холбоо тогтоох эрхгүйгээр хорионд 15 хүртэл хоног саатуулахыг зөвшөөрсөн хэрэгтэй танилцаад Хүний эрхийн хороо “нууцаар хорих нь эрүү шүүлтийн таатай орчин болдог. Иймээс нууцаар хорихоос зайлсхийх ёстой” бөгөөд “нууцаар хорихыг даруй зогсоох арга хэмжээ авах ёстой” гэсэн дүгнэлт гаргасан байна.<sup>7</sup>

Америк Дундын Комисс нууцаар хорих нь хүний эрхийг хүндлэхгүй байгаа хэлбэр мөн бөгөөд “эрүү шүүлт болон бусад зөрчлийг гаргах нөхцлийг бүрдүүлдэг”<sup>8</sup>, үүний зэрэгцээ хоригдогчдын гэр бүлийнхнийг давхар шийтгэж байгаа хэрэг, ийм арга хэмжээг дэлгэрүүлэхийг хүлээн зөвшөөршгүй гэж мэдэгдсэн байна.<sup>9</sup>

36 өдрийн турш нууцаар хорьсон хэрэг гарсан нь Америкийн Конвенцийн эрүү шүүлт, зүй бусаар харьцахаас хамгаалсан 5,2-р зүйлийг зөрчсөн байна гэж Америк хоорондын Шүүх мэдээлжээ.<sup>10</sup>

## Холбогдох хэм хэмжээ

### Үндсэн зарчмын 19–р зүйл

Саатуулагдсан болон хоригдсон этгээд тухайлбал гэр бүлийн гишүүдтэйгээ уулзах, тэдэнтэй захидлаар харилцах түүнчлэн хуулиар буюу хуульд нийцүүлж, тогтоосон гадаад орчинтой харилцах эрхтэй

## Ишлэл

3. Шийдвэр 1997 он/38 хэрэг 20.
4. НҮБ-ын Эрүү Шүүлтийн Талаарх Тусгай Илтгэгч, НҮБ-ын баримт бичиг, Хүний Эрхийн Комисс.4/1995/434, догол мөр926 (г).
5. Алберт Вома Муконг ба Камероон (458/1991), 1994 оны 7 дугаар сарын 21, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП/C/51/D/458/1991; Эл- Мегрейси ба Либийн Араб Ямахирияа (440/1990)1994 оны 3 дугаар сарын 23, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП/C/50/D/440/1990
6. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 20, догол мөр11
7. Перу: Хүний Эрхийн Төлөв Байдлын Урьдчилсан Судалгаа, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП/C/79 Нэмэлт 67, догол мөр18 болон 24, 1996 оны 7 дугаар сарын 25
8. Америк Дундын Комисс, 1971-1981 Арван жилийн үйл ажиллагаа, хуудас 318, Боливийн Хүний эрхийн Төлөв Байдлын талаарх Илтгэлийг үзнэ үү. Америкийн Улсуудын Байгууллага, Ser.L/V/II.53, баримт бичиг 6, 6 дах хэвлэл, 1981он, хуудас 41-42
9. Америк Дундын Комиссын жил бүрийн Илтгэл, 1982-1983, Америкийн Улсуудын Байгууллага, Ser.L/V/II.61, баримт бичиг 22, 1 дэх хэвлэл, 1981он; Америк Дундын Комиссын жил бүрийн Илтгэл, 1983-1984, Америкийн Улсуудын Байгууллага, Ser.L/V/II/63, баримт бичиг 22,
10. Суарез Росерогийн хэрэг, Эквадор, 1992 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн ял

## 4.2 Гэр бүлдээ баривчлагдсан болон хоригдсон, хаана байгаа тухайгаа мэдэгдэх эрх

Баривчлагдсан, албадан саатуулагдсан, хоригдсон хэн боловч гэр бүл, найз нөхөддөө мэдээлэх эрхтэй. Захиргааны байгууллагаас хоригдож байгаа газар, баривчилсан болоод саатуулсан тухай баримтыг багтаан мэдэгдэнэ. /Бүлэг 10.1.1 “Хууль ёсны албадан саатуулагдах газарт хоригдох эрх”-ийг үзнэ үү./ Хэрвээ тухайн хүнийг өөр хорих байр руу шилжүүлбэл гэр бүлийнхэн болоод найз нөхөд нь мэдэгдэх ёстой. \*

Хоригдлуудтай харилцах наад захын жишиг дүрмийн 92-р дүрэмд үүнийг дариу мэдэгдэнэ гэж заасан байдаг бол бусад жишиг хэм хэмжээгээр ч хойшлуулалгүйгээр мэдэгдэнэ гэж тогтоосон байдаг. Гэхдээ шүүх байгууллагын захирамжаар, өөрөөр хэлбэл мөрдөн байцаах онцгой шаардлагын улмаас мэдэгдлийг хойшлуулж болох онцгой нөхцлүүд байдаг. Саатуулах хугацаа нь аль болох цөөн өдөр байна. \*\*

## 4.3 Гэр бүлийнхэнтэйгээ харилцах эрх

Урьдчилан хорих төвд саатуулагдсан хүн бүр гэр бүлийнхэн болоод найз нөхөдтэйгээ харьцах, эргэлт хүлээн авах, уулзах бүрэн бололцоогоор хангагдах ёстой. Ингэхдээ уг байгууллагын хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангахын тулд шүүх байгууллагын захиргааны хяналтанд байх шаардлагатай. \*\*\*

Америк дундын комиссоос төрөл садантайгаа уулзах эрхтэй байх нь “үндсэн шаардлага” бөгөөд энэ нь хоригдогчдын болоод гэр бүлээ хамгаалах эрхийг хамгаалах баталгаа болдог. Эргэлт, уулзалт хүлээн авах нөхцөл, ажиллагаа нь Америкийн Конвенцоор хамгаалагдсан нэр төр, хувийн болоод гэр бүлийн зэрэг эрхийг зөрчих ёсгүй.<sup>11</sup> Ямар ялаар шийтгүүлсэн, эсхүл сэжиглэгдэж байгаагаас үл хамааран эргэлт авах эрх нь бүхий л хоригдолд хамаарах<sup>12</sup> бөгөөд хэт богино хугацаагаар уулзуулах, тогтмол бус эргэлт оруулах нь дур зоргоороо авирласан явдал болно гэж үзсэн байна..<sup>13</sup>

### Холбогдох хэм хэмжээ

#### Үндсэн зарчим 16,1 дүгээр зүйл,

Баривчлагдсаны дараахан буюу саатуулсан, хорьсон нэг газраас нөгөөд шилжүүлсний дараахан, саатуулагдсан буюу хоригдсон этгээд байгаа газрынхаа тухай өөрийн гэр бүлийн гишүүд буюу бусад холбогдох хүмүүст мэдэгдэх хүсэлтийг эрх бүхий байгууллагад нь гаргах эрхтэй.

#### Үндсэн зарчим 16.4 дүгээр зүйл

Энэхүү зарчимд заасан мэдэгдэл бүр нь эрх бүхий байгууллагаар нэн даруй зөвшөөрөгдөж, явуулсан байх ёстой.

#### Үндсэн зарчим 15 дугаар зүйл

Зарчмуудын 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар онцгойлсон боловч саатуулагдсан болон хоригдсон этгээдэд гадаад орчинтой тухайлбал гэр бүл, өмгөөлөгчтэйгээ холбоо тогтоохыг хэдхэн хоногоос хэтрэхгүй хугацаанд татгалзаж болно.

#### Наад захын жишиг дүрэм- 92

Мөрдөнд хоригдсон этгээд нь өөрийнхөө хоригдсон тухайгаа гэр бүлийнхэндээ мэдэгдэх, төрөл садан найз нөхөдтэйгээ харилцах, тэднийг шоронд авчирч уулзах бололцоогоор хангагдсан байх ёстой.

\* Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 16(1) дугаар зарчим, Наад захын Жишиг Дүрмийн 92 дугаар дүрэм, Европын шоронгийн дүрэм-92 дугаар дүрмүүд болон Сураггүй алга бологсдын тухай тунхагын 10(2) зүйл.

\*\* Үндсэн Зарчим -16(1) ба(4) болон 15 дугаар зарчим

\*\*\* Үндсэн Зарчим -19 дүгээр зарчим, Наад захын Жишиг Дүрмийн 92 дугаар дүрэм, Европын шоронгийн дүрэм-92 дугаар дүрмүүд



#### 4.4 Гадаадын иргэд гадаад ертөнцтэй холбогдох эрх

Урьдчилан хорих төвд саатуулагдсан гадаадын иргэд нь өөрийн орны засгийн газрын төлөөлөгчтэй уулзах бүх бололцоогоор хангагдсан байх ёстой. Хэрвээ тухайн хүн дүрвэгч юм уу засгийн газар хоорондын хамгаалалт дор байх ёстой бол эрх мэдэл бүхий олон улсын байгууллагын төлөөлөгчтэй холбоо тогтоож харилцах эрхтэй.\* Энэ харилцааг зөвхөн хоригдлын зөвшөөрлөөр тогтооно.

#### 4.5 Эмчид хандах эрх

Баривчлагдан саатуулагдаж байгаа хоригдол нь шаардлагатай үед эмчид үзүүлэх, эмчилгээ хийлгэх эрхтэй.\*\* Энэ эрхээр хангах нь эрүү шүүлт, зүй бусаар харьцахаас хамгаалах төдийгүй, хүний төрөхөөс нэрлэгдэх нэр төрийг хүндлэх баталгаа болж тухайн байгууллагын үүргийн салшгүй хэсэг болох ёстой.

Хүний эрхийн комисс саатуулагдаж буй хүн бүр тогтмол, нэн даруй, эмчид үзүүлэх бололцоотой байх ёстой гэж үзсэн байдаг.<sup>14</sup>

Хоригдолд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээний тогтсон хэм хэмжээний тухай Бүлэг 10,1,3 “**Эрүүл мэндийн туслалцааг цаг тухайд нь авах эрх**”-д тодорхойлсон байгаа.

Хууль сахиулах албан тушаалтнууд нь өвдсөн юмуу шархадсан хоригдолд шаардлагатай үед эмнэлгийн туслалцаа үзүүлэх үүрэгтэй.\*\*\*

Эмнэлгийн үйлчилгээнд шүдний эмчилгээ, сэтгэцийн оношлогоо зэрэг бусад шаардлагатай эмчилгээг багтаана.<sup>^</sup>

Мэргэжлийн эмчилгээ шаардлагатай болсон хоригдол болон саатуулагдсан хүнийг тусгай юмуу ердийн эмнэлэгт шилжүүлнэ.<sup>^^</sup>

Шаардлагатай эмнэлгийн үйлчилгээ, эмчилгээг үнэ төлбөргүйгээр авах ёстой.\* Хоригдол нь өөрийн өвчний түүхийг үзэх, хоёрдох өвчний саналыг шаардах эрхтэй.\*\*

Хоригдож байгаа этгээд хувийн эмч, шүдний эмчээр эмчлүүлэх хүсэлт тавьсан үед шаардлагатай нөхцөлд зөвшөөрч болно.\*\*\* Хэрвээ энэ хүсэлтийг үл зөвшөөрсөн тохиолдолд шалтгааныг нь мэдэгдэх ёстой. Хувийн эмчид үзүүлсэн зардлыг хорьж байгаа байгууллага хариуцахгүй.

#### 4.5.1 Эмчийн тусламж авах эрх хэдийд үүсэх вэ?

Хорих байранд хоригдлыг хүлээн авахдаа аль болох нэн дуруй эмнэлгийн үзлэгт хамруулах шаардлагатай.<sup>^</sup> Хорих байранд хоригдол ирсэн даруй эмнэлгийн ажилтан хүн бүрийг үзэх ёстой. Цаашид шаардлагатай үед эмнэлгийн үзлэг, эмчилгээг үзүүлнэ.<sup>^^</sup>

#### Холбогдох хэм хэмжээ

**Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хуулийн 6 дугаар зүйл**

Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнууд нь саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийн эрүүл мэндийг бүрэн хамгаалах, тухайлбал шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж үзүүлэх, яаралтай арга хэмжээ авах үүрэгтэй.

\* Консулын Харилцааны тухай Венийн Конвенцийн 36 дугаар Зүйл, Наад захын Жишиг Дүрмийн 38 дугаар дүрэм, Европын шоронгийн дүрэм-44 дугаар дүрмүүд, Үндсэн Зарчим -16(2) дугаар зарчим, Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хуулийн 2 дугаар зүйл болон Оршин суугаа орныхоо иргэн биш гадаад иргэн, харьяалалгүй хүмүүсийн эрхийн тухай Тунхаглалын 10 дугаар зүйл

\*\* Үндсэн Зарчим зарчим 10, Наад захын Жишиг Дүрмийн 24 дугаар дүрэм ба Европын шоронгийн дүрэм-29 дугаар дүрмүүд

\*\*\* Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хуулийн 6 дугаар зүйл

<sup>^</sup> Наад захын Жишиг Дүрмийн 22(3) болон 22(1) дугаар дүрмүүд, Европын шоронгийн дүрэм-26(3) болон 26(1) дугаар дүрмүүд тус тус

<sup>^^</sup> Наад захын Жишиг Дүрмийн 22(2) дугаар дүрэм ба Европын шоронгийн дүрэм-26(2) дугаар дүрмүүд.

#### Ишлэл

11. Илтгэл №38/96, хэрэг 10.506 (Аргентин), 1996 оны 10 дугаар сарын 15
12. Хэрэг 1992, 1997 оны 5 дугаар сарын 27
13. Америк Дундын Комиссын жил бүрийн Илтгэл, 1983-1984, Америкийн Улсуудын Байгууллага, Ser.L/V/II/63, баримт бичиг 10, Уругвай; Куб дах Хүний Эрхийн Төлөв байдлын талаарх 7 дах Илтгэл, 1983, Америкийн Улсуудын Байгууллага, Ser.L/V/II.61, баримт бичиг 29,
14. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 20, догол мөр11

\* Үндсэн Зарчим 24 дүгээр зарчим

\*\* Үндсэн Зарчим 25 болон 26 дугаар зарчмууд

\*\*\* Наад захын Жишиг Дүрмийн 91 дүгээр дүрэм ба Европын шоронгийн дүрэм - 98 дугаар дүрмүүд

^ Үндсэн Зарчим 24 дүгээр зарчим

^^ Наад захын Жишиг Дүрмийн 24 дүгээр дүрэм ба Европын шоронгийн дүрэм – 29 дүгээр дүрмүүд

\* Үндсэн Зарчим 4 дүгээр зарчим

\*\* ИУТЭОУП-ын 9(3) дугаар зүйл, болон Сураггүй алга бологсдын тухай тунхагын 10(1) зүйл, Африкийн Комиссын Тогтоол 2(В) хэсэг, Америкийн Конвенцийн 7(5) дугаар зүйл, Хүчээр сураггүй алга бологсдын тухай Америкийн Улсуудын Конвенцийн 11 дүгээр зүйл, Европын Конвенцийн 5(3) дугаар зүйл, Олон улсын эрүүгийн шүүхийн дүрмийн 59(2) зүйл, Үндсэн Зарчим 11(1) дүгээр зарчим

## Бүлэг 5

### Аль болох богино хугацаанд хэргээ

#### шийдвэрлүүлэх

Эрх чөлөө нь хязгаарлагдаж буй хүн бүрийн эрхийг нь хамгаалахын тулд нэн даруу шүүхэд юмуу шүүх эрх мэдэл бүхий албан тушаалтанд шилжүүлсэн байх хэрэгтэй.

#### 5.1 Аль болох богино хугацаанд шүүгч эсхүл шүүхийн ямар нэгэн албан тушаалтнаар хэргийг хянан шийдвэрлүүлэх эрх

##### 5.1.1 Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч эрх бүхий албан тушаалтан

#### 5.2 “Нэн даруй” гэдэг нь ямар утгатай вэ?

### 5.1 Аль болох богино хугацаанд шүүгч эсхүл шүүхийн ямар нэгэн албан тушаалтнаар хэргийг хянан шийдвэрлүүлэх эрх

Бусдыг хууль бусаар баривчлах, хорихоос сэргийлэх, эрх чөлөөтэй байх эрхийг хамгаалах мөн хүний үндсэн эрхийг хамгаалахын тулд бусдыг бүх төрлийн баривчилгаа, хорих, албадан саатуулахыг шүүх болон хамаарал бүхий удирдах байгууллагын хяналтын дор явуулах ёстой.\*

Баривчлагдсан болон саатуулагдсан хүн бүрийг шүүгчид болон хуулийн дагуу шүүн таслах эрх мэдэл бүхий өөр албан тушаалтанд “нэн даруй” шилжүүлсэн байна.\*\*

9.3-р зүйлд ИУТЭОУП хэргээр баривчлагдсан эсвэл саатуулагдсан хүмүүст эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ, гэвч өөр хэм хэмжээг хэрэглэх нь тэдний болон эрх чөлөөг нь хязгаарлаж байгаа бүх хүмүүсийг авч үздэг байна.

Шүүгч болон өөр албан тушаалтныг хянан үзэх нь:

- Баривчилахад хууль ёсны шалтгаан байгаа эсэхийг тогтоох
- Шүүх хурлаас өмнө хорьж саатуулах шаардлагатай эсэхийг тогтоох
- Хоригдож буй хүний эрүүл мэндийн байдлыг хангах
- Хоригдож буй хүний үндсэн эрх зөрчигдөхөөс сэргийлэх зэрэг юм.

#### Холбогдох хэм хэмжээ

##### Үндсэн зарчим – 24 дүгээр зарчим

Саатуулагдсан болон хоригдсон этгээдийг саатуулах буюу хорих газарт авчирснаас хойш аль болох богино хугацаанд эмнэлгийн зохих шинжилгээнд оруулах, цаашид шаардлага гарсан тухай бүрд түүнд эмнэлгийн үйлчилгээ үзүүлж эмчилнэ. Эмнэлгийн үйлчилгээ, эмчилгээ нь үнэ төлбөргүй байх ёстой.

##### Наад захын жишиг дүрэм - 24

Хоригдол бүрийг бие болоод сэтгэхүйн хувьд эрүүл эсэхийг тогтоох, шаардлагатай арга хэмжээ авахын тулд хүлээн авахдаа болон цаашид шаардлагатай үед эмнэлгийн үзлэгт оруулж, халдварт өвчтэй байж болох хоригдлуудыг тусгаарлах, засан хүмүүжүүлэхэд саад болж болох бие болон сэтгэхүйн гажигийг илрүүлэх, биеийн хөдөлмөр хийх чадварын боломжийг тодорхойлох арга хэмжээ авбал зохино.

Америк Дундын Комисс хорих тухай шүүх албан ёсоор мэдэгдээгүй эсвэл шаардлагатай хугацаанаас хойш мэдэгдсэн бол хоригдож буй хүний эрх ашиг хамгаалагдаагүй хэмээн үзнэ гэжээ. Энэ нь бусад төрлийн зөрчил үүсгэхэд хүргэх бөгөөд, шүүх болоод шүүхийн үйл ажиллагааг үл хүндэтгэсэн хэрэг болох ба хууль бус байдлыг бий болгодог байна.<sup>1</sup>

Дээрх эрхийг эдэлснээр хоригдож буй хүнийг “сураггүй болох” зэрэг хүний эрхийг ноцтой зөрчих хэргээс хамгаалдаг ач холбогдолтой учраас Эмнести Интернэшнлийн “Сураггүй алга болгох явдлыг арилгах 14 зорилтот хөтөлбөртөө бүх хоригдлыг хорих байранд хүргэсний дараа хойшлуулалгүйгээр шүүх байгууллагад шилжүүлэхийг шаардсан байдаг.

### 5.1.1 Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч эрх бүхий албан тушаалтан

Хэрэв баривчлагдаж байгаа хүнийг шүүгчээс өөр албан тушаалтанд шилжүүлж байгаа бол уг ажилтан нь хуулийн дагуу шүүн таслах эрх мэдэл бүхий талуудаас хараат бус байх ёстой. Шүүн таслах эрх эдлэж буй хүн бүр Шүүхийн байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчимд тавигдсан шалгууруудыг хангасан болон хараат бус байх шаардлагатай. /Бүлэг 12.4-г байгаа Бие даасан шүүхээр шүүгдэх эрх бүлгийг үзнэ үү./

Жишээлбэл; хуулийн дагуу шүүн таслах эрх мэдэл бүхий өөр албан тушаалтан нь шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцож болох улсын яллагч юм уу армийн хянагч байвал энэ нь Европын Конвенцийн 5.3-р зүйлийг зөрчинө гэж Европын Шүүх мэдэгджээ.<sup>2</sup>

### 5.2 “Нэн даруй” гэдэг нь ямар утгатай вэ?

Олон улсын хэм хэмжээнүүд нь баривчилсны дараа “нэн даруй” шүүгчид аваачихыг шаардсан байдаг. Эдгээрт ямар хугацаанд аваачихыг нарийн заагаагүй байдаг. Хэрэг болон хэргийн үндэслэлээс хамаарч өөр өөр байна. Хүний Эрхийн Хороо “... 5 өдрөөс цаашгүй хугацаанд” гэж тогтоосон байдаг байна.<sup>3</sup>

Хүний Эрхийн Хорооны гишүүд шүүхэд аваачихгүйгээр 48 цаг хорьж саатуулсан нь үндэслэлгүйгээр удаасан хэрэг гэсэн гомдол хүлээн авч байжээ.<sup>4</sup> Тус Хорооноос нэгэн цаазаар авах ялтай хэрэгт баривчилснаас хойш бүтэн долоо хоногийн дараа хоригдлыг шүүгчид

#### Холбогдох хэм хэмжээ

##### ИУТЭОУП-ын 9.3 зүйл

Баривчлагдсан буюу эрүүгийн хэрэгт буруутгагдсан аль ч хүнийг шүүгч буюу хуулийн дагуу шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд хүн хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх буюу суллагдах эрхтэй.

##### Үндсэн зарчим – 11,1 дүгээр зүйл

Шүүх болон бусад байгууллагад даруй байцаагдах үр нөлөөтэй болмж олголгүйгээр аливаа этгээдийг саатуулж болохгүй. Саатуулагдсан этгээд хуульд зааснаар өөрөө өөрийгөө хамгаалах буюу өмгөөлөгчийн туслалцаа авах эрхтэй.

Энэ үйл явц нь хоригдож буй хүний хорих явцийг хуулийн дагуу үйлдэхийг шаардах, хэрэв баривчилах хорих явц нь тэдний эрхийг зөрчиж байвал суллахыг шаардах эхний боломжийг олгодог байна.

#### Ишлэл

1. Америк Дундын Комисс, Суринэми дэх хүний эрхийн Төлөв байдлын тухай 2 дах илтгэл, Америкийн Улсуудын Байгууллага, Ser.L/V/II.66, баримт бичиг 21, 1 дэх хэвлэл, 1985он
2. Бринкат ба Итали (73/1991/325/397) 1992 оны 11 дүгээр сарын 26; Де Жонг, Балжет болон ван ден Бринк, 1984 оны 5 дугаар сарын 22, цуврал 77-А 23
3. Хүний эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 8, догол мөр2
4. Хүний Эрхийн Төлөв Байдлын Талаарх Тайлан, 1 дүгээр боть, (A/45/40), 1990 он, догол мөр333, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс.
5. МакЛауранс ба Ямайка, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП/С/60/D/702/1996, 1997 оны 9 дүгээр сарын 29.
6. Брoгaн ет ал ба Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, 1988 оны 11 дүгээр сарын 29, 1456 цуврал А-33
7. Эквaдoр дах Хүний Эрхийн Төлөв Байдлын Талаарх Илтгэл, Америкийн Улсуудын Байгууллага, Ser.L/V/II.96, баримт бичиг 10, 1 дэх хэвлэл, 1997 оны 4 дүгээр сарын 24
8. Куб дах Хүний Эрхийн Төлөв байдлын талаарх 7 дах Илтгэл, 1983, Америкийн Улсуудын Байгууллага, Ser.L/V/II.61, баримт бичиг 29,

шилжүүлсэн байсан нь ИУТЭОУП-ын зүйл 9.3-д нийцээгүй байна хэмээн мэдэгджээ.<sup>5</sup>

Европын Шүүх нэгэн хүнийг шүүгчид шилжүүлэлгүй 4 өдөр 6 цаг болсон нь нэн даруй мэдэгдэж байгаа хэрэг биш хэмээн үзсэн байна.<sup>6</sup>

Шүүгч болон шүүх эрх мэдэл бүхий албан тушаалтанд “аль болох богино хугацаанд шилжүүлнэ, хойшлуулж үл болно” гэж Америк Дундын Комисс тогтоосон байдаг.<sup>7</sup> Кубад баривчлагдсан хүнийг түүнд тулгаж байгаа ялыг дуулгах шүүх юмуу шүүгчид шилжүүлэлгүйгээр нэг долоо хоног саатуулахыг хуулиар зөвшөөрсөн байдаг. Комисс энэ нь хугацааг хэтэрхий урт хэмээн үзжээ.<sup>8</sup>

## Бүлэг 6

### Албадан саатуулагдсан хууль зүйн үндэслэлийн эсрэг гомдол гаргах

Эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүн бүр түүнийг хорьсон хууль зүйн үндэслэлийн талаар шүүхээс шаардаж албан ёсны үндэслэлийг гаргуулах эрхтэй. Энэ нь шүүгчид шилжүүлэгдэх эрхээс /Бүлэг 5-ыг үзнэ үү/ өөр юм. Учир нь үүнийг шүүх байгууллагаас бус хоригдож байгаа хүн өөрөө эсвэл тэр хүний нэрийн өмнөөс мэдүүлдэг.

6.1 Албадан саатуулагдсан хууль зүйн үндэслэлийн эсрэг гомдол гаргах

6.2 Хорих хууль зүйн үндэслэл

6.3 Үргэлжлүүлэн хянах

6.4 Заавал хангах эрх

6.5 Хууль бусаар баривчлагдсан болон хорьсны төлөө нөхөн төлбөр авах эрх

#### 6.1 Албадан саатуулагдсан хууль зүйн үндэслэлийн эсрэг гомдол гаргах

Эрх чөлөөгөө хязгаарлуулж буй хүн бүр түүнийг хорьсон хууль ёсны үндэслэлийг шүүхээр хянан хэлэлцүүлэх эрхтэй. Тус эрхийг эдлүүлснээр эрх чөлөө эдлэх эрхийг хамгаалж хууль бусаар баривчлах, хүний эрхийг зөрчих хэргээс сэргийлдэг. Энэ эрхийг зөвхөн эрүүгийн хэргээр шийтгэгдэж байгаа төдий бус эрхээ хязгаарлуулж буй хүн бүр эдлэх ёстой.\*

Хүмүүсийг хорьсон тухай мэдэгддэггүй зарим улсад энэ эрхийг эдлүүлвээс хоригдож байгаа газар, биеийн эрүүл мэндийн байдал, энэ үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа байгууллагыг тодорхойлох хэрэгтэй.\*\*

Нэгэн нэртэй улс төрчийг гэм буруутай эсэхийг нь шүүхээр тогтоолголтгүйгээр 12 жил хорьсныг Африкийн Дүрмийн 7.1- р зүйлийг зөрчсөн гэж Африкийн Комисс мэдэгдсэн байна.<sup>1</sup>

Хэрэг хянан хэлэлцэхийг мэдэгдсэн тохиолдолд хорьж буй байгууллага нь хоригдож байгаа хүнд хойшлуулалгүйгээр холбогдох шүүхийг хэлж өгөх ёстой. Хорих хууль ёсны үндэслэлийг шалгаж байгаа шүүх нь “нэн даруй” болон “хойшлуулалгүйгээр” шийдвэр гаргах шаардлагатай, хэрэв хорих үндэслэл нь хууль бус байвал хоригдлыг суллах захирамж гаргана.

Шийдвэрийг хурдан гаргахын гол шаардлага нь эхний шийдвэрээр хорих явц нь хууль ёсны эсэхийг тодорхойлох бөгөөд үндэсний хууль дүрмээр уг шийдвэрийн эсрэг зарга мэдүүлж болдог.<sup>2</sup>

#### 6.2 Хорих хууль зүйн үндэслэл

Засгийн газар болгон хорих болсон хууль ёсны үндэслэлийг гаргуулах, мөн хууль бус бол чөлөөлж байх процедуртай байх шаардлагатай. Уг үйл ажиллагаа

##### Холбогдох хэм хэмжээ

##### ИУТЭОУП-ын 9.4 дүгээр зүйл

Баривчлагдаж эсхүл цагдан хоригдож эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр ийнхүү хорьж саатуулсан нь хууль ёсны эсэхийг шүүхээр даруй тогтоолгох, хууль бусаар хорьсон бол суллуулах шийдвэр гаргуулах эрхтэй.

\* ИУТЭОУП-ын 9(4) дүгээр зүйл, Үндсэн Зарчим 32 дугаар зарчим, Америкийн Тунхаглалын 25 дугаар зүйл, Америкийн Конвенцийн 7(6) дугаар зүйл, Европын Конвенцийн 5(4) дугаар зүйл, Африкийн Дүрмийн 7(1)(а) –г үзнэ үү.

\*\* Сураггүй алга бологсдын тухай тунхагын 9(1) зүйл.

##### Ишлэл

1. Крисчна Ачутан (Алек Бандаг төлөөлж), Ортон болон Вера Чирвагийн нэрийн өмнөөс Эмнести Интернэшнл ба Малави, (64/92, 68/92, 78/92 тус тус), Африкийн Комиссын жил бүрийн 8 дах илтгэл, 1994-1995 он. Хүний болон Улс Түмний Эрхийн тухай Африкийн Комисс/RPT/8th/
2. Наварра ба Франц (38/1992/383/461), Европын шүүх, 1993 оны 11 дүгээр сарын 23

\* Үндсэн Зарчим 32(2) дугаар зарчим

нь түвэггүй бөгөөд шуурхай, хэрэв хоригдол нь төлбөрийн чадваргүй бол үнэ төлбөргүй байх ёстой.\*

Олон хуулийн тогтолцоонд хорих болсон хуулийн үндэслэлийг гаргуулах, хууль зүйн хамгаалалтын хэрэглэх эрхийг амраго /захиргааны эрх зүйн актыг хууль зүйн үндэслэлтэй, үндсэн хуульд нийцсэн эсэхийг тогтоолгохоор шүүхэд гаргасан нэхэмжлэл/-ээр юмуу writ habeas corpus /хувь хүний халдашгүй байдлыг дур зоргын баривчилгаанаас хамгаалах тухай шүүхийн захирамж/- аар нэхэмжилдэг.

НҮБ-ын Хүний эрхийн комисс болон Цөөнхийн эрхийг хамгаалах, ялгаварлан гадуурхахаас сэргийлэх дэд комиссоос “баривчлагдаж, хоригдож эрхээ хасуулж байгаа хүн бүрийн хорих болсон хуулийн үндэслэлийг цаг алдалгүйгээр тогтоож, хэрвээ хууль бус байвал суллах тушаал гаргах эсэхийг шийдэх, шүүхээр хэргийг шийдүүлэх, дур зоргын баривчилгаанаас хамгаалах зэрэг процедурыг бий болгохыг бүх улсад уриалсан юм.<sup>3</sup>

Хүний Эрхийн Хороо, Европын шүүх хорих хууль ёсны үндэслэлийг тогтоох байгууллага нь шүүх байх ёстой, ингэснээр бодит байдлыг мэргэжлийн түвшинд хараат бус шийдэх баталгаа болж өгнө гэж үзсэн байдаг.

Хүний эрхийн Хорооноос дээд цолтой цэргийн ахлагчаар нь сахилгын арга хэмжээ, тэр дундаа хорьж цагдсан арга хэмжээг хянуулж байгаа нь ИУТЭОУП-ын зүйл 9.4-т заасан шаардлагатай тохирохгүй байгааг тогтоожээ.<sup>4</sup> Мөн нэгэн улсын Дотоод явдлын яам орогнол хүсэгчдийг хорьж саатуулсан хэргийг хянах нь дээрхи шаардлагад нийцэхгүй гэж мэдэгдсэн байна.<sup>5</sup>

Европын шүүхээс “Шийдвэр гаргах эрхгүй зөвлөх хорооны Дотоод хэргийн Ерөнхий нарийн бичгийн даргад өгсөн заавал биелүүлэх ёсгүй зөвлөмжийг Европын Конвенцийн 5.4-р зүйлд зааснаар энэ байгууллага нь “шүүх” биш тул захирамжлах эрхгүй гэж үзсэн байна. Түүнчлэн саатуулагдсан этгээд тус хорооны өмнө хариуцлага хүлээх ёсгүй хэмээн үзсэн.<sup>6</sup>

Африкийн комисс хууль бус хэрэг үйлдсэн хэмээн сэжиглэгдэж байсан хоригдлын үндэсний шүүхэд давж заалдах бололцоог хязгаарласан нь Африкийн Дүрмийн зүйл 7.1-ийг зөрчиж байна гэж шийдвэрлэсэн байна.<sup>7</sup>

Хорих болсон хууль ёсны үндэслэлийг шалгах нь баривчилгааг үндэсний хуулиар тогтоосон процедурын дагуу явуулах баталгаа болж хорих үндэс, шалтгаан нь үндэсний хуулиар зохицуулагдана. Хорих явц нь үндэсний хуулийн байгууллагын процедурын болоод бие даасан журмаар явагдах ёстой. Шүүх хорих явцыг олон улсын хэм хэмжээний дагуу хууль бусаар баривчлаагүй болохыг баталгаажуулах ёстой.

### Холбогдох хэм хэмжээ

#### Үндсэн зарчим 32 дугаар зүйл.

Хүнийг хууль бусаар саатуулсан гэж үзвэл саатуулагдсан этгээд буюу түүний өмгөөлөгч дотоодын хууль тогтоомжинд заасны дагуу өөрийгөө нэн даруй суллуулах зорилгоор шүүх буюу бусад байгууллагад гомдол гарган хэлэлцүүлэх ба хууль бусаар саатуулагдсан бол нэн даруй суллуулах эрхтэй. Энэ зарчимд заасан ажиллагаа хялбар, шуурхай, төлбөрийн чадваргүй этгээдэд үнэ төлбөргүй байх ёстой.

### Ишлэл

3. Комиссын Тогтоол 1992/35 болон Дэд Комиссын Тогтоол 1991/15 тус тус
4. Вуоланне ба Финланд (265/1987), 1989 оны 4 дүгээр сарын 7, Хүний Эрхийн Төлөв Байдлын талаарх Илтгэл, (A/44/40/), 1989 он
5. Торрес ба Финланд (291/1988), 1990 оны 4 дүгээр сарын 2, Хүний Эрхийн Төлөв Байдлын талаарх Илтгэл, (A/44/40/), 1990 он, догол мөр 7.
6. Чахал ба Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (70/1995/576/662), 1996 оны 11 дүгээр сарын 15.
7. Rencontre Africaine pour la defense de droits de l'homme v. Zambia, (71/92), 10th Annual Report of the African Commission, 1996 -1997 Хүний болон Улс Түмний Эрхийн тухай Африкийн Комисс /RPT /10th

### 6.3 Үргэлжлүүлэн хянах

Хоригдож буй хүн бүр хорих болсон хууль ёсны үндэслэлийг тодорхой завсарлагатайгаар шүүх болон бусад захиргааны байгууллагаар хянуулж байх эрхтэй.\*

Хүний Эрхийн Хороо нь урьдчилан хорих төвд үргэлжлүүлэн хорих эсэхийг шийдэх эрх мэдлийг шүүгчид бус яллагчид шилжүүлсэн нь ИУТЭОУП-ын зүйл 9.3-тай нийцэхгүй хэмээн мэдэгджээ.

### 6.4 Заавал хангах эрх

Хорих болсон хууль ёсны үндэслэлийг гаргуулах эрх нь бусад үндсэн эрхийг хамгаалах баталгаа болж өгдөг. Америкийн Конвенц ёсоор аль ч улсыг онцгой нөхцөл байдалд байсан болон уг эрхийг хэрэгжүүлэхгүй байхыг /хэрэгжилтийг сулруулахыг/ үл зөвшөөрсөн байдаг.

Хорих болсон хууль ёсны үндэслэлийг шүүхээр гаргуулах эрх нь ИУТЭОУП болоод Европын хүний эрхийн тухай конвенцийн дагуу саад учирч хэрэгжилтийг сулруулж болох боловч Хүний Эрхийн Комисс, Цөөнхийг ялгаварлан гадуурхахаас сэргийлэн хамгаалах, дэд комиссоос “улсын онц байдал, ямарч нөхцөлд, ямар ч үед тус эрхийг хэрэгжүүлэхийг хамгаалах ёстой” хэмээн уриалжээ.

### 6.5 Хууль бусаар баривчлагдсан ба хоригдсны төлөө нөхөн төлбөр авах эрх

Хууль бусаар баривчлагдаж болон цагдан хоригдож хэлмэгдсэн хүн бүр хохирлоо нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргуулах эрхтэй./ reparation гэдэг үгийг Франц, Испани хэлнээ төлөх сэргээх гэсэн утгаар ИУТЭОУП-д хэрэглэсэн байдаг бол Англи хэлэнд compensation гэдэг нь нөхөн төлбөр, reparation гэдэг нь хохирлыг арилгах сэргээн тогтоох гэсэн утгаар хэрэглэдэг./\*\*

Олон улсын хэм хэмжээ болоод үндэсний хуулийг зөрчиж цагдан хоригдсон, баривчлагдсан хүн бүр нөхөн төлбөр авах эрхтэй. Нөхөн төлбөр олгох үйл ажиллагааг нарийвчлан заагаагүй байна. Үүнийг ихэвчлэн өөрийг нь үндэслэлгүйгээр, буруу хорьсон гэж үзсэн хүн тухайн улсынхаа эсрэг зарга мэдүүлсний дагуу хэрэгжүүлдэг.

Мөн Бүлэг 10.4.8-д байгаа Эрүү шүүлт болон хүнлэг бус харьцаанаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх эрх, Шүүхийн алдаанаас үүссэн хохиролыг нөхөн төлүүлэх эрхийн талаар Бүлэг 30-аас үзнэ үү.

#### Холбогдох хэм хэмжээ

##### ИУТЭОУП-ын 9.5 дугаар зүйл

Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй.

##### Үндсэн зарчим – 35.1 зүгээр зүйл

Энэ зарчмуудад заасан эрхийг төрийн албан тушаалтан зөрчсөнөөс үүссэн хохирлыг дотоодын хууль тогтоомжинд заасан хэм хэмжээг хэрэглэж нөхөн төлөх ёстой.

##### Үндсэн зарчим – 39 дүгээр зарчим

Хуульд заасан онцгой тохиолдлоос бусад тохиолдолд шүүх байгууллага шийдвэр гаргаагүй бол эрүүгийн гэмт хэрэгт яллагдан саатуулагдаж буй этгээдэд хуульд заасан нөхцлөөр чөлөөлж болно. Уг этгээдийг саатуулах шаардлагатай эсэхд тус байгууллага хяналт тавина.

\* Үндсэн Зарчим 32 ба 39 дүгээр зарчмууд

\*\* ИУТЭОУП-ын 9(5) дүгээр зүйл, Европын Конвенцийн 5(5) дугаар зүйл, ХЭТТ-ын

## Бүлэг 7

### Боломжит хугацаанд хэргээ шийдвэрлүүлэх ба суллагдах

Цагдан хоригдож байгаа хүн хэргээ боломжит хугацаанд шүүхээр шийдвэрлүүлээгүй бол шүүх хурлын өмнө хорионоос суллуулах эрхтэй.

**7.1 Боломжит хугацаанд хэргээ шийдвэрлүүлэх эсхүл шүүх хурлаас өмнө суллагдах**

**7.2 Боломжит хугацаа гэж юу вэ?**

**7.2.1 Оргон зугатах эрсдэл**

**7.2.2 Засаг төрийн байгууллага зохих анхаарал тавьж байгаа эсэх**

### 7.1 Боломжит хугацаанд хэргээ шийдвэрлүүлэх эсхүл шүүх хурлын өмнө суллагдах эрх

Эрүүгийн гэмт хэрэгт урьдчилан хоригдож байгаа хүн бүр боломжит хугацаанд хэргээ шүүхээр хэлэлцүүлэх, шүүх хурал хүлээх шатанд суллуулах эрхтэй.\*

Боломжит хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх хуулиар тогтоосон хоёр жишиг хэм хэмжээ байдаг. Гэм буруугүйд тооцох зарчимтай хоёулаа холбоотой байна.

#### Холбогдох хэм хэмжээ

##### Америкийн конвенци- 7.5

Баривчлагдсан хүнийг шүүгч буюу хуулийн дагуу шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд тухайн этгээд шүүх ажиллагаа үргэлжилж буй эсэхэд эргэлзэхгүйгээр хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх эсвэл суллагдах эрхтэй. Хэрэв шүүхэд очих баталгаа гаргаж өгсөн бол тухайн этгээдийг суллаж болно

##### Европын конвенци – 5.3

Энэ хуулийн 1 /с/-д заасан үндэслэлээр баривчлагдсан аливаа этгээд шүүгч буюу эрх бүхий хуулийн албан тушаалтанд даруй шилжүүлэгдэх бөгөөд шүүхийн эрх мэдлийг хуулийн дагуу хэрэгжүүлж буй эрх бүхий албан тушаалтан боломжийн богино хугацаанд тухайн этгээдийг шүүх ажиллагааг явуулах эсвэл суллах ёстой. Шүүхэд очих баталгаа аван тухайн этгээдийг суллаж болно

##### Африкийн комиссын тогтоол – бүлэг 2.с

Баривчлагдсан болон саатуулагдсан этгээдийг нь нэн даруй шүүгч буюу хуулийн дагуу шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх эсвэл суллагдах эрхтэй.

\*ИУТЭОУП-ын 9(3) дүгээр зүйл, Үндсэн Зарчим 38 дугаар зарчим, Америкийн Тунхаглалын 25 дугаар зүйл, Америкийн Конвенцийн 7(5) дугаар зүйл, Европын Конвенцийн 5(3) дугаар зүйл, Африкийн Комиссын Тогтоол догол мөр 2(в) мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 60(4) дугаар зүйлүүд



Нэгдүгээрхи нь цагдан хоригдож байгаа хүнд хамаарах бөгөөд хоригдож байгаа хүний хэргийг боломжит хугацаанд шүүхээр хэлэлцүүлэх эсвэл тус этгээдийг суллахыг шаарддаг. Энэ эрхийг ИУТЭОУП-ын 9.3-р зүйл, Америкийн конвенцийн 7.5 –р зүйл, Европын конвенцийн 5.3 –р зүйлд тодорхойлж хамгаалдаг. Энэ нь цагдан хоригдсон хэн ч бай өөрийн хэргийг давуу эрхтэйгээр Шүүхээр шийдвэрлүүлэхийг шаардах гэм буруугүйд тооцох зарчим болон эрх чөлөөтэй байх эрхэд үндэслэнэ.<sup>1</sup>

Хоёрдугаар жишиг хэм хэмжээ нь эрүүгийн гэмт хэрэгт холбогдон хоригдож байгаа эсхүл хоригдоогүй хүний аль алинд хамаарах бөгөөд бүх эрүүгийн шүүх хурлыг аливаа үндэслэлгүй хугацаа хойшлуулалтаас ангид хийхийг шаарддаг. Гол зорилго нь эрүүгийн хэрэгт холбогдож шүүх хурлаа хүлээж байгаа хүн тодорхой бусаар хугацаа сунгагдсанаас хохирохгүй байх болон нотлох баримт баларч арилаагүй байхад хэргээ шийдүүлэх зэргийг баталгаажуулах юм. Үүнийг ИУТЭОУП-ын зүйл 14.3.в, Америкийн конвенцийн зүйл 8.1, Европын конвенцийн 6.1-ээр хамгаалсан байдаг. **/Бүлэг 19-ээс Хүндэтгэн үзэх шалтгаангүй тохиолдолд цаг алдалгүй хэргийг шүүхээр хянан шийдвэрлүүлэх эрхийн талаар үзнэ үү./**

Боломжит хугацаанд хэргийг шүүх хэлэлцэхгүй бол саатуулах газраас суллана гэдэг нь хариуцлагаас мулталж байна гэсэн үг биш харин шүүх хурал хүртэл сул чөлөөтэй байна гэсэн үг юм. ИУТЭОУП – ын зүйл 9.3, Европын конвенцийн зүйл 5.3, 7.5 зэрэгт шүүх хуралд ирж оролцоно гэсэн баталгаа болгох нөхцөл /батлан даалт болон бусад хамгаалалтын арга хэмжээ/-г тодорхойлсон байдаг.

## 7.2 Боломжит хугацаа гэж юуг хэлэх вэ?

Урьдчилан хорих төвд боломжит хугацааг Хүний эрхийн хороо, бүс нутгийн байгууллагууд тусад нь үнэлж дүгнэсэн. Урьдчилан хорих боломжит хугацааг тодорхойлох хүчин зүйлс нь гэмт хэрэг хэр ноцтой эсэх, оноогдож болох ялын шинж байдал, суллагдвал оргон зугатах эрсдэлтэй эсэх. Дотоодын эрх бүхий байгууллага мөрдөн байцаалтын онцгой болон нарийн төвөгтэй шинж байдлыг авч үзэн байцаан шийтгэх ажиллагаа явуулахад онцгой анхаарлаа хандуулж байгаа эсэх болон тухайн үргэлжлэх хойшлуулалт нь гэм буруутай этгээдийн үйлдэл эсхүл яллагаанаас хамааралтай эсэхийг мөн шалгана.

Хэрэгт холбогдох этгээдийг урьдчилан хорих боломжит хугацаа нь хоригдоогүй байгаа этгээдийн шүүх хурлыг эхлэхээс өмнөх боломжтой гэж үзсэн хугацаа хойшлуулах хугацаанаас богино байна. Хэдий шүүхийн өмнөх хугацаа нь Европын конвенцийн 6.1-р зүйлд зааснаар боломжит хугацаа байж болох ч 5-р зүйлд зааснаар тухайн этгээдийг тэрхүү хугацааны турш урьдчилан хорионд байлгаж болохгүй гэж Европын комисс мэдэгдсэн байна.<sup>2</sup>

Панамд хүн амины хэрэгт сэжиглэгдсэн нэг хүнийг батлан даалтгүйгээр урьдчилан хорих төвд 3 жил хагасын хугацаанд саатуулсан байсан байна. Энэ хэрэгт хүний эрхийн хороо “шүүх батлан даалтаар гаргахаас татгалзах ноцтой хүн амины хэрэгт аль болох богино хугацаанд шүүх ажиллагааг явуулах ёстой” гэж мэдэгдсэн.<sup>3</sup>

Хүний эрхийн хороо шүүхээс хүн амины хэргээр ялагдсан этгээдийг шүүх хурлаас өмнө хавтаст хэрэгт ил тод заасан ямарваа үндэслэлгүйгээр эсхүл хангалттай тайлбаргүйгээр 16 сар хорьсон нь боломжит хугацаанд шүүхээр хэргийг шийдвэрлүүлэх эрхийг зөрчсөн гэж үзжээ.<sup>4</sup>

### Ишлэл

1. Европын Шүүх, Томаси ба Франц, 1992 оны 8 дугаар сарын 27, цуврал 241-А, догол мөр 84; Абдоелла ба Голландын хэрэг, (1/1992/346/419) 1992 оны 11дүгээр сарын 25.
2. Хаасе болон Холбооны Бүгд Найрамдах Герман улсын хэрэг (7412/76), 1977 оны 7 дугаар сарын 12.
3. Дел Цид Комез ба Панамын хэрэг(473/1991), 1995 оны 7 дугаар сарын 19, НҮБ-ын баримт бичиг. ИУТЭОУП/С/57/1, 1996 он, хуудас 46

Уругвайд нэгэн этгээдийг 4-6 сараар /бодит хугацаа нь тодорхой бус байгаа/ тусгаарлан хорьсны дараа үндсэн хуулийг зөрчин хорлон сүйтгэх болон нууц хуйвалдаанд оролцсон гэх хэргээр цэргийн шүүхээр 5-8 сарын дараа шүүж эхэлсэн хэргийг Хүний эрхийн Хороо хянаад “хэргийг боломжит хугацаанд шийдвэрлээгүй” учраас ИУТЭОУП-ын 9.3-р зүйлийг зөрчсөн байна гэж мэдээлсэн байна.<sup>5</sup>

Мөн шүүн таслах хурлын хугацааг товлोलгүйгээр хоёр жил хорьсон хэрэг нь боломжит хугацаанд шүүхээр хэргээ шийдвэрлүүлэхийг заасан Африкийн Хартын 7.1.в дүгээр зүйлийн шаардлагыг зөрчсөн гэж Африкийн Комисс үзсэн байна.<sup>6</sup> Өөр нэг хэрэгт шүүх хуралд оролцуулалгүйгээр 7 жил хорьсон байжээ. Энэ ч бас Африкийн дүрмийн боломжит хугацааны стандартыг зөрчиж байна.<sup>7</sup>

Гэмт этгээдийн үйлдсэн хэрэгт ногдох ялын хэмжээтэй нийцэхгүй хугацаанд тухайн этгээдийн эрх чөлөөг хязгаарлах нь шударга биш гэж Америк дундын шүүх мэдэгджээ. Суарез Розерог гурван жил зургаан сар хорьсон нь “нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцох” зарчмыг зөрчсөн гэж Шүүх үзжээ.<sup>8</sup>

### 7.2.1 Оргон зугатах эрсдэл

Оргон зугатах эрсдэл нь хангалттай үндэслэлтэй бол хэдийгээр энэ нь урьдчилан хорих үндэслэл болох ч урьдчилан хорих хугацаа нь үндэслэлтэй эсэхийг тогтоох хүчин зүйл болохгүй. Эрх бүхий байгууллагын үйл ажиллагааг мөн хянах ёстой.<sup>9</sup>

### 7.2.2 Төрийн байгууллага зохих анхаарал тавьж байгаа эсэх

Урьдчилан хорих хугацаа нь тухайн гэмт хэрэгт холбогдсон хүний тоо болон гэмт хэргийн шинжтэй уялдан гэмт хэрэг нь хэр төвөгтэй байх вэ гэдгээс хамаардаг.

Европын шүүхийн дурдсанаар урьдчилан хоригдож байгаа этгээд эрх бүхий байгууллагын зүгээс явуулж буй байцаан шийтгэх ажиллагаандаа “онцгой анхаарал хандуулах”-ыг шаардах эрхтэй.<sup>10</sup>

Урьдчилан хоригдож буй этгээдийн хэргийг шалгуулах эрх нь эрх бүхий байгууллагын үүргээ зохих хэмжээнд биелүүлэх хүчин чармайлттай тэнцвэртэй байж, үүнд саад болохгүй гэж Европын шүүх үзсэн.<sup>11</sup> Мансууруулах бодис наймаалах хэрэгт гэм буруутай этгээдийг оргон зайлахаас сэргийлж 3-аас дээш жил урьдчилан хорьсон бөгөөд түүний хорионд байх хугацааг сунгасан нь эрх бүхий байгууллагын зүгээс онцгой анхаарал хандуулаагүйтэй хамааралгүй гээд Европын конвенцийн 5.3-р зүйлийг зөрчөөгүй гэж Шүүх үзсэн байна.

#### Ишлэл

4. МакЛауранс ба Ямайка, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП/С/60/D/702/1996, 1997 оны 9 дүгээр сарын 29.

5. Пиетрароиа ба Уругвайн хэрэг (44/1979), 1981 оны 3 дугаар сарын 27, 13.2 болон 17 дугаар догол мөрүүд

6. Аннете Пагноулле (Абдоулае Мезоуг төлөөлөн) ба Камерооны хэрэг, (39/90), Африкийн Комиссын 10 дах Илтгэл, 1996-1997 он, Хүний болон Улс Түмний Эрхийн тухай Африкийн Комисс /RPT/10th

7. Алхассан Абубакар ба Ганын хэрэг (103/93), Африкийн Комиссын 10 дах Илтгэл, 1996-1997 он, Хүний болон Улс Түмний Эрхийн тухай Африкийн Комисс /RPT/10th

8. Суарез Росерогийн хэрэг, Эквадор, 1992 оны 11 дүгээр сарын 12

9. Ялаас зайлсхийн зугатах явдлыг зөвхөн төлөвлөж буй ялын хүнд хөнгөнтэй хамууруулж ойлгож болохгүй хэмээн Европын Шүүх тодорхойлжээ. Яа гчи болон Саргин ба Турк, (6/1994/453/533-534), 1995 оны 6 дугаар сарын 8.

10. Томаси ба Франц, 1992 оны 8 дугаар сарын 27, цуврал 241-А, догол мөр 84; Абдоелла ба Голландын хэрэг, (1/1992/346/419) 1992 оны 11 дүгээр сарын 25.

11. Ван Де Тан ба Испани (26/1994/473/554) 1993 оны 7 дугаар сарын 13, хэрэг 55

## Бүлэг 8

### Өмгөөлөлд бэлтгэх боломж болон хугацаа нөхцлөөр хангагдах эрх

Шударга шүүхийн нэг үндэс нь эрүүгийн хэрэгт холбогдсон бүх хүн өмгөөлөлд бэлтгэх хангалттай хугацаа, бодит бололцоотой байх эрх юм.

- 8.1 Өмгөөлөлд бэлтгэх боломжит хугацаа, нөхцлөөр хангагдах эрх
- 8.2 Боломжит хугацаа гэж юу вэ?
- 8.3 Мэдээлэл авах
- 8.4 Тулгаж буй яллагааны талаарх мэдээллийг авах
  - 8.4.1 Яллагааны тухай мэдээллийг хэзээ өгөх вэ?
  - 8.4.2 Хэл
- 8.5 Мэргэжлийн хүмүүст хандах

#### 8.1 Өмгөөлөлд бэлтгэх боломжит хугацаа, нөхцлөөр хангагдах эрх

Өөрийгөө хамгаалах эрхийг жинхэнэ утгаар хэрэгжүүлэхийн тулд эрүүгийн хэрэгт гэм буруутай гэгдэж буй хүн бүр болон тэдний өмгөөлөгч нар өмгөөлөлд бэлтгэх хангалттай хугацаа, бодит бололцоотой байх ёстой.\* /Бүлэг 20.1- Өөрийгөө өмгөөлөх эрх/

Өмгөөлөлд бэлтгэх хангалттай хугацаа, бодит бололцоотой байх эрх нь ижил тэгш эрхтэй байх үндсэн зарчмын чухал хэсэг болох юм. Шүүх хэргийг шүүх ажиллагааг явуулахдаа хоёр талыг ижил тэгш эрхтэйгээр оролцуулж өмгөөлүүлэх бололцоогоор хангах ёстой. /Бүлэг 13.2-Эрх тэгш байх/

Шүүхээс өмнөх болоод давж заалдах шатыг оруулаад шүүх хэргийг хянан хэлэлцэх бүх шатанд гэм буруутай гэгдэж буй этгээд болон түүний өмгөөлөгч өмгөөлөлд бэлтгэх хангалттай хугацаа, бодит бололцоотой байх эрхтэй.

Гэм буруутай гэгдэж буй этгээд ялангуяа цагдан хоригдож байгаа хүн өөрийн өмгөөлөгчтэйгээ тусдаа уулзахыг энэ эрхээр баталгаажуулна. /Бүлэг 3.4 Албадан саатуулагдсан этгээд өмгөөлөгч авах эрх/

\* ИУТЭОУП-ын 14(3) дүгээр зүйл, Америкийн Конвенцийн 8(2)(с) дугаар зүйл, Европын Конвенцийн 6(3)(b) дугаар зүйл, Африкийн Комиссын Тогтоол догол мөр 2(e)(1), Югославын Дүрмийн 21(4)(b) дугаар дүрэм, Руандагийн Дүрмийн 20(4)(b) дугаар дүрэм мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 60(4) дугаар зүйлүүд

#### Холбогдох хэм эхмжээ

##### Хүний эрхийн түгээмэл тунхаглал – 11.1

1. Гэмт хэрэгт буруутгагдаж буй хэн боловч өмгөөлөх бүх боломжоор хангагдсан нээлттэй шүүх хурлаар гэм буруутайг нь хуулийн дагуу тогтоох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй

##### ИУТЭОУП – зүйл 14.3

3. Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр дараахь наад захын баталгаагаар хангагдах эрхтэй:

(b) өмгөөлүүлэх ажлаа бэлтгэх хүрэлцээтэй хугацаа, бололцоотой байх, сонгож авсан өмгөөлөгчтэйгээ харилцах;

#### Ишлэл

1. Өөрөөгөө хамгаалахад боломжит цаг, нөхцлөөр хангагдах эрх нь эрүүгийн хэрэгт яллагдаж буй хүмүүст хамаарана.

## 8.2 Боломжит хугацаа гэж юу вэ?

Өөрийгөө хамгаалахад бэлтгэх хугацаа нь явуулах ажиллагааны шинж байдал (бэлтгэл арга хэмжээ, анхан шатны эсхүл давж заалдах шатны шүүх эсэх) болон тухайн хэргийн нөхцөл байдлаас хамааралтай байна. Хүчин зүйлүүд нь хэргийн төвөгтэй байдал, гэм буруутай гэгдэж буй этгээдийн өмгөөлөгчтэйгээ уулзах болон нотлох баримттай танилцах болон дотоодын хуульд тогтоосон хугацааны хязгаар зэрэг юм.<sup>2</sup> Боломжит хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх эрх нь өөрийгөө хамгаалахад бэлтгэх хангалттай хугацаатай байх эрхтэй харилцан тэнцүү байж болох юм.

Хэрвээ гэм буруутай гэгдэж буй этгээд өөрийгөө хамгаалахад бэлтгэх хугацаа нь /хуулийн зөвлөгөө авах болон хэргийн баримттай танилцах / хангалтгүй байсан гэж үзвэл өөрийгөө хамгаалахад бэлтгэх хугацаа хангалтгүй байна” гэсэн үндэслэлээр шүүх ажиллагааг хойшлуулахыг үндэсний шүүхээс хүсч болно.<sup>3</sup>

Хүн амины хэргийг шүүх хурлыг хойшлуулж, өмнөх зөвлөхийн оронд шинээр томилогдсон өмгөөлөгчид хэрэгтэнтэй харилцах дөрвөн цагийн хугацаа өгөөд, хэрэгт бэлдүүлэх нь шүүх хуралд бэлтгэхэд хангалттай хугацаа биш юм гэж Хүний Эрхийн Хороо үзэж байна.<sup>4</sup> Тус Хороо мөн нэгэн хэрэгт шүүх хурал эхлэхээс өмнө ердөө 10 минутын өмнө шинэ өмгөөлөгч нь хэрэгтэнтэй уулзаад шүүх хуралд оролцсон төдийгүй эхлэн томилогдсон байсан өмгөөлөгч нь бэлтгэл шатны байцаалтад олон удаа оролцоогүй байсан нь ИУТЭОУП-ын 14,3-р зүйлийг зөрчсөн болохыг тогтоожээ.<sup>5</sup>

## 8.3 Мэдээлэл авах

Өөрийгөө хамгаалах бодит бололцоог бүрдүүлэх нь гэмт этгээд болон түүний өмгөөлөгчийн аль алинд мэдээлэл олж авах эрхийг олгох явдал юм. Мэдээлэлд хэрэгтэн шүүхэд хэргээ үнэн зөвөөр танилцуулах, хэргийг цагаатгах юм уу, ялыг хөнгөрүүлж болох холбогдох бичиг баримт, мэдээлэл, нотолгоо орно.\* Эдгээр мэдээлэл нь хавтаст хэрэгт авагдсан шинжилгээ судалгаа болон прокурорын ашигласан нотлох баримтуудтай танилцах, үүнд тайлбар өгөх боломжийг бий болгодог.<sup>6</sup>

Европын Комисс өөрийгөө хамгаалахад бэлтгэх бодит бололцоотой байх эрх нь яллах баримттай үзэж танилцах эрхтэй байна гэсэн үг хэмээн үзсэн байдаг.<sup>7</sup> Гэхдээ энэхүү эрхэд аюулгүй байдлыг үүднээс үндэслэл бүхий хязгаарлалт тавьж болно.<sup>8</sup> Комисс мөн сэжигтэн биш түүний өмгөөлөгч хавтаст хэрэгтэй танилцах нь уг эрхээ эдэлсэн байна гэж тогтоожээ.

\* Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 21 дугаар зарчим, мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 67(2) дугаар зүйлүүд, болон Югославын Дүрмийн 66 ба 68 дугаар дүрэм, Руандагийн Дүрмийн 66 ба 68 дугаар дүрмүүд

### Ишлэл

2. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 9
3. Доуглас, Жентлес болон Керр ба Ямайкын хэрэг(352/1989), 1993 оны 10 дугаар сарын 19, Хүний Эрхийн Төлөв Байдлын Талаарх Илтгэл 2 дугаар боть(A/49/40), 1994; Савейрс болон Маклейн ба Ямайка, (226/1987 ба 256/1987), 1991 оны 4 дүгээр сарын 11, Хүний Эрхийн Төлөв Байдлын Талаарх Илтгэл (A/46/40), 1991.
4. Смит ба Ямайка (282/1988), 1993 оны 3 дугаар сарын 31, НҮБ баримт бичиг, ИУТЭОУП/С/47/D/282/1988
5. Рейд ба Ямайка (355/1989), 1994 оны 7 дугаар сарын 8, НҮБ баримт бичиг, ИУТЭОУП/С/47/D/355/1989
6. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 9, Фоучерийн Хэрэг, Европын Шүүх 25EH RR 234, хуудас 247
7. Х ба Австри (7138/75), 1977 оны 7 дугаар сарын 5, 9 DR50
8. Хаасе болон Холбооны Бүгд Найрамдах Герман улсын хэрэг (7412/76), 1977 оны 7 дугаар сарын 12

### Холбогдох хэм хэмжээ

#### Хуульчдын Гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмууд – 21

Эрх бүхий байгууллага нь өөрийн мэдэл, хяналтанд байгаа зохих мэдээ, нууц мэдээ, баримт бичгийг үзэх боломжийг өмгөөлөгчөөс өөрийн үйлчлүүлэгчдээ үр дүнтэй тусламж үзүүлэхийн тулд аль болох богино хугацаанд гарган өгөх үүрэгтэй. Энэ боломжоор шаардлага гармагц хангаж өгвөл зохино.

## 8.4 Тулгаж буй яллагааны талаарх мэдээлэл авах

Өмгөөлүүлэхэд бэлтгэхэд хүрэлцэхүйц хугацаа, бодит бололцоотой байх эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нэг чухал мэдээлэл нь хэрэгтэн өөрт оноогдох ялын тухай даруй мэдэх эрх юм.

Эрүүгийн хэргээр шийтгэгдэж байгаа хүн бүр шүүхийн өмнө саатуулагдсан болон саатуулагдаагүй үедээ өөрт тулгаж байгаа аливаа яллагааны талаар аль болох богино хугацаанд мэдэгдэж байх баталгаагаар хангагдсан байх эрхтэй.\*

Мөн Бүлэг 2,3-т Оноогдох ялын талаар аль болох богино хугацаанд мэдэгдэх эрхийн тухай хэсэгт бичсэнийг үзнэ үү. Үүнд саатуулагдсан этгээдэд тулгаж байгаа ялын мэдэгдэх эрхийг ИУТЭОУП-ын 9-р зүйлийн 3-рт баталгаажуулсан нь саатуулагдах болсон хуулийн үндэслэлийн талаар мэдэх эрхтэй нягт холбоотой юм.

Хүний Эрхийн Комиссоос ИУТЭОУП-ын 14-р зүйлийн 3-рт баталгаажуулж байгаа эрх нь тус пактын 9-р зүйлийн 3-рт баривчлагдсан хүмүүсийн эдлэх эрхийг илүү нарийвчилж өгсөн гэж үзсэн байна.<sup>10</sup>

Шударга шүүхээр шийдвэрлүүлэх эрхийг эдлүүлэхэд шүүх хурлын өмнө оноогдох ялыг мэдэгдэхдээ тодорхой буюу ялын шинж чанар, үндэслэлийн талаар мэдэгдэх ёстой.

Хүний Эрхийн Комисс тодорхойлохдоо эрүүгийн хэргээр сэжиглэгдэж байгаа этгээдэд ялын талаар мэдээлэхдээ “тухайн ял нь ямар үндэслэлээр буюу хуулийн ямар зүйл заалтаар шүүгдэх гэж байгааг мэдээлэх ёстой бөгөөд үүнийг бичгээр болон амаар мэдэгдэж болно гэжээ.”<sup>11</sup>

Европын Конвенцийн 6.3-р зүйл нь эрүүгийн хэргээр шийтгэгдэж байгаа этгээдэд ногдуулж байгаа ялын шинж чанар, үндэслэлийн талаар өөрийн нь ойлгох хэлээр аль болох түргэн мэдэгдэх ёстой гэсэн утгатай болохыг Европын Комисс тайлбарлажээ.

### Холбогдох хэм хэмжээ

#### ИУТЭОУП-ын 14.3 /а/

Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр дараахь наад захын баталгаагаар хангагдах эрхтэй:

(а) оногдуулж байгаа ялын шинж чанар, үндэслэлийг ойлгох хэлээр нь даруй, нарийвчлан мэдэгдэх;

#### Америкийн конвенцийн 8.2 /б/

Эрүүгийн хэрэгт сэжиглэгдэж буй аливаа этгээд нь гэм буруутай нь нотлогдтол хуулийн дагуу гэм буруугүйд тооцогдоно. Шүүх ажиллагааны явцад хүн бүр тэгш эрхтэйгээр доор дурдсан эрхээр хангагдана

б/ ямар хэрэгт ял тулгагдаж байгаага мэдэх

#### Европийн Конвенцийн 6,3 / а /

Эрүүгийн хэрэгт сэжиглэгдэж буй аливаа этгээд нь дор дурдсан эрхтэй байна. Үүнд

а/ өөрийн мэдэх, ойлгох хэл дээр ямар хэрэгт яллагдаж байгаага нэн даруй мэдэх

\*ИУТЭОУП –ын 14(3)(а) зүйл, Европын Конвенцийн 6(3)(а)болон Югославын Дүрмийн 21(4)(а) дугаар дүрэм, Руандагийн Дүрмийн 20(4) (а) дугаар дүрмүүд мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 67(1)(а) дугаар зүйлүүд,

### Ишлэл

10. МакЛауранс ба Ямайка, НУБ-ын баримт бичиг, ИУТЭОУП/С/60/D/702/1996, 1997 оны 9 дүгээр сарын 29.  
11. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 8

“Ялын шинж чанар” гэдэг нь тухайн фактын хуулийн шинж чанар, ангилалыг тодорхойлохыг хэлж байгаа бол “үндэслэл” гэдэг нь ялын үндэслэлийг бий болгож байгаа фактыг хэлнэ гэж тайлбарласан байна.<sup>12</sup>

#### 8.4.1 Яллагааны тухай мэдээллийг хэзээ өгөх вэ

ИУТЭОУП-ын 14.3-р зүйл, Европын Конвенцийн 6.3-р зүйлд оногдуулах ялын талаар **нэн даруй** мэдэгдэхийг шаардсан байдаг бол Америкийн Конвенцийн 8.2-р зүйлд **өмнө нь** мэдэгдэх гэж заажээ.

ИУТЭОУП-ын 14.3-р зүйлийг Хүний Эрхийн комисс тайлбарлахдаа эрх бүхий байгууллага оногдуулах ялыг тогтоомогц тэр даруй мэдэгдэх ёстой гэсэн байна. Эрүүгийн хэрэгт сэжиглэгдэж байгаа юмуу тухайн этгээдийг олон нийт гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж байгаа тохиолдолд шүүх эсхүл прокуророос журамласан үе шат бүхий арга хэмжээг авахаар шийдвэл Хорооны саналаар энэхүү эрхийг хэрэгжүүлнэ.<sup>13</sup>

Югославын дүрмийн 20,2 болон Руандагийн дүрмийн 19,2-т хэрэгтэнд оноож байгаа ялын талаар даруй мэдэгдэнэ гэж бас заасан байна.

#### 8.4.2 Хэл

Хэрэгтэнд ялын талаар ойлгодог хэлээр нь мэдэгдэнэ.\* Хэлмэрч болон орчуулагч авах эрхийн талаархи **Бүлэг 23-ыг** үзнэ үү.

#### 8.5 Мэргэжлийн хүмүүст хандах эрх

Өөрийгөө хамгаалах бодит бололцоог бүрдүүлэхийн тулд өмгөөлөлд бэлтгэх явцад тусгай мэдлэг бүхий шинжээчийн саналыг авах эрхтэй.

Америкийн Конвенцийн 8.2.f-р зүйлд өөрийгөө хамгаалахад бэлтгэх бодит бололцоотой байх эрхийг хангах үүднээс шинжээчийг гэрчээр оруулахыг зөвшөөрсөн байдаг. Гэрчийг дуудах болон шалгах эрхийн талаар дэлгэрүүлэн **Бүлэг 22-ыг** үзнэ үү.

\* ИУТЭОУП –ын 14(3)(а) зүйл, Америкийн Конвенцийн 8(2) (b), Европын Конвенцийн 6(3) (а)болон Югославын Дүрмийн 20(2) дугаар дүрэм, Руандагийн Дүрмийн 19(2) дугаар дүрмүүд мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 67(1) дугаар зүйлүүд,

#### Ишлэл

12. Х ба Бельги (7628/76), 9DR 169, 1977 оны 5 дугаар сарын 9; Офнер ба Австри, (524/59) жил бүрийн ном 322, 1960 оны 12 дугаар сарын 19

13. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 8

## Бүлэг 9

### Байцаагдах үед эдлэх эрх

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны мөрдөн байцаалтын шатанд эрүүгийн хэрэгт сэжиглэгдэн холбогдож байгаа этгээдүүд дараахь хүний эрхийн зөрчлүүдэд өртөмтгий байдаг. Үүнд нь эрүүдэн шүүх болон харгис хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон гутаан харьцах явдлууд ордог.

Хууль сахиулах албан тушаалтнуудад байцаагдахаар албадан саатуулагдаж байгаа этгээдүүд тодорхой хэмжээгээр дээрхи эрсдэлд өртөж болзошгүй байдаг. Энэ бүлэг нь мөрдөн байцаалтын үед албадан саатуулагдсан этгээдийн хүний эрхийн талаар өгүүлэх болно.

#### 9.1 Байцаагдаж буй этгээдүүдийг хамгаалах

#### 9.2 Хүч хэрэглэн мэдүүлэг авахыг хориглох

#### 9.3 Үг хэлэхгүй байх эрх

#### 9.4 Орчуулгын туслалцаа авах эрх

#### 9.5 Тэмдэглэл хөтлөх

#### 9.6 Байцаалтын дүрэм журамтай танилцах эрх

### 9.1 Байцаагдаж буй этгээдийн хамгаалалт

Гэмт хэргийн мөрдөн байцаалтын явцад хүмүүсийг хамгаалах хэд хэдэн эрх байдаг. Үүнд: нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцох, эрүүдэн шүүх болон харгис хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон гутаан харьцах явдлыг хориглох, өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эсхүл гэм бурууг албадан хүлээлгэх, мэдүүлэг өгөхгүй байх эрх, зөвлөгөө туслалцаа авах эрх зэрэг орно.

Байцаалтын явцад хамгаалалтын хэд хэдэн нэмэлт хэрэгслүүд бий. Үүний түлхүүрийн нэг нь байцаалтанд хуульч /өмгөөлөгч/-ийг байлгах явдал юм. **(3.1.1 бүлэгт Шүүх хурлаас өмнөх шатанд өмгөөлөгч авах эрх )**

Хуульчид ба шүүгчдийн хараат бус байдлын талаар НҮБ-ын Тусгай комиссар тэмдэглэхдээ: “Сэжигтэн буюу гэмт хэрэгт холбогдож байгаа этгээдийн эрхийг хамгаалахын тулд цагдаад байцаагдах үед өмгөөлөгчийг байлцуулах нь чухал юм. Хуулийн зөвлөх өмгөөлөгчийг байлцуулаагүйгээс тэдний эрх нь зөрчигдөх боломж арай илүү байдаг юм...”<sup>1</sup>

Америкийн Дундын Комисс нь “Тухайн холбогдогч этгээдийг албадан хэрэг хүлээх, эрүү шүүлтээс хамгаалахын тулд байцаалтын үйл ажиллагааг түүний өмгөөлөгчийг байлцуулж явуулах ёстой” гэж үздэг.<sup>2</sup>

Үүний зэрэгцээ Олон улсын стандартад заасны дагуу эрх бүхий албан тушаалтан албадан хоригдож буй этгээдийн байдлыг өөртөө ашигтайгаар урвуулан ашиглах ёсгүй.\*

Албан тушаалтнууд байцаалтын протоколыг хөтлөх болон хадгалах үүрэгтэй.\*\*<sup>3</sup> Эрүү шүүлт тулган авсан мэдүүлгийг хэргээс бусад тохиолдолд нотлох баримтад тооцохгүй.\*\*\*

(17-р бүлэг буюу “Эрүү шүүлт тулгаж буюу бусад хориотой аргуудыг хэрэглэж цуглуулсан нотлох баримт нотлох чадвараа алдах нь “-аас үз.)

\* Үндсэн Зарчим – 21 дүгээр зарчим

\*\* Үндсэн Зарчим – 23 дүгээр зарчим

\*\*\* Эрүү Шүүлтийн Эсрэг Конвенцийн 15 дугаар зүйл, Эрүү Шүүлтийн Эсрэг Тунхаглалын 12 дугаар зүйл

### Ишлэл

1. Тусгай Илтгэгчийн Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад хийсэн айлчлалын илтгэл, НҮБ-ын баримт бичиг, Хүний Эрхийн Комисс.4/1998/39/Нэмэлт 4, догол мөр 47,1998 оны 3 дугаар сарын 5
2. Никарагуан Мискито гаралтай цөөнхийн хүний эрхийн Төлөв байдлын талаарх илтгэл, , Америкийн Улсуудын Байгууллага Ser.L/V/II.62 баримт бичиг 10, 3 дах хэвлэл, 1983 он.
3. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 20, догол мөр 11

ИУТЭОУП-ын 14(3)(ё)дүгээр зүйл, Америкийн Конвенцийн 8(2)(ё) дугаар зүйл, Үндсэн Зарчим – 21(2) дүгээр зарчим, Европын Конвенцийн 6(3) (б) дугаар зүйл, Африкийн Комиссын Тогтоол догол мөр 2(е)(1), Югославын Дүрмийн 21(4)(ё) дугаар дүрэм, Руандагийн Дүрмийн 20(4)(ё) дугаар дүрэм мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 51(1)(а) дугаар зүйлүүд

## 9.2 Хүч хэрэглэн мэдүүлэг авахыг хориглох

Эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон хэнийг ч болов эрүүгийн хэрэг хүлээх, өөрийн эсрэг мэдүүлэг өгөхийг албадаж болохгүй. \*16-р бүлэг буюу “Сэжигтэн өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх” гэдгийг үз.

Эдгээр эрхүүдийг урьдчилсан мөрдөн байцаалтын явц болон анхан шатны шүүн таслах ажиллагаанд хэрэгжүүлнэ. Хүний эрхийн Хороо тэмдэглэхдээ: “Мэдүүлгийг албадан авах, мэдээллийг албан хүчээр гаргуулах, мэдүүлгийг хүчээр албадан авахыг авахыг хориглосон байдаг.

Хүний Эрхийн Хороо “Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14-(3)-(g)-д зааснаар “Хэн нэгнийг өөрийн эсрэг мэдүүлэг өгөхийг албадаж болохгүй”. Өөрөөр хэлбэл энэ заалт нь байцаалт явуулж байгаа албан тушаалтнуудыг сэжигтнээр гэм бурууг нь хүлээлгүүлэх зорилгоор шууд ба шууд бусаар бие болон сэтгэл санааны дарамт учруулж болохгүй.” гэсэн үг юм. Мэдүүлэг авахын тулд байцаагч саатуулагдаж байгаа этгээдтэй Конвенцийн 7-р заалтыг зөрчин харьцаж болохгүй.<sup>4</sup>

Европын шүүх “Хэдийгээр хэн нэгнийг албадан буруутгах ёсгүй ч гэсэн эрүүгийн байцаалтын үйл ажиллагаанд тодорхой хүч хэрэглэн тухайн сэжигтний хүсэлтийг үл харгалзан шээс, цус, амьсгалыг ДНК-ийг шинжилгээний зориулалтаар авах нь үүнд албадан буруутгасан гэдэгт хамаарахгүй.” гэж тодруулсан байна.<sup>5</sup>

Цогц зарчмуудын 21-р зарчим нь Албадан саатуулагдаж байгаа хүмүүс нь хүний эрхийн зөрчилд өртөмтгий байдаг чанарыг тусгаад:

1. ”Хоригдож байгаа эсхүл саатуулагдаж байгаа хүний хоригдож байгаа байдлыг нь өөрийгөө буруутган буруугаа хүлээлгэхэд болон ямар нэгэн этгээдийн эсрэг мэдүүлэг өгүүлэх зорилгоор ашиглахыг хориглосон байх ёстой.
2. “Саатуулагдаж байгаа сэжигтэн нь түүний сэжиглэгдэж байгаа хэрэгт шийдвэр гаргах ба шүүн таслах ажиллагааны чадварт нөлөөлөх, хүчирхийлэл, зүй бус харьцаа болон бусад байцаалтын арга барилын субъект болох ёсгүй.” гэжээ.\*\*

**10.4 бүлэг, Эрүү шүүлт болон зүй бус харьцаанаас ангид байх эрх, 10.4.3 бүлэг Саатуулагдаж байгаа үед биеийн шахалт дарамт үзүүлэх ба 17-р бүлэг Эрүү шүүлт тулгаж болон зүй бус харьцаж олж авсан нотлох баримтуудыг /хасах/ эс тооцох зэрэг бүлгүүдээс үзнэ үү.**

## 9.3. Үг хэлэхгүй байх эрх

Нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцох зарчмын нэг салшгүй хэсэг бол сэжигтний мөрдөн байцаалтын болон шүүн таслах ажиллагааны үед мэдүүлэг өгөхгүй байх эрх мөн. Энэ нь буруугаа албан хүчээр хүлээхгүй байх болон хэн нэгний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг хамгаалах чухал хэсэг мөн. /16-р бүлгийн Сэжигтэн өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхээс үзнэ үү./ Эрүүгийн гэмт хэрэгт холбогдож байгаа этгээдийг байцааж байгаа үед мэдүүлэг өгөхгүй байх эрх нь амаргүй байдаг. Учир нь хууль хяналтын байгууллагын албан тушаалтнууд сэжигтнээс мэдүүлэг авахын тулд бүх хүчин чармайлтаа дайчилдаг. Энэ нь саатуулсан хүний мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй зөрчилддөг.

Мэдүүлэг өгөхгүй байх эрх нь улс орнуудын дотоодын эрх зүйн системд нь тусгагдсан байдаг. Хэдийгээр энэ эрх олон улсын хүний эрхийн

\*\* Үндсэн Зарчим – 21 дүгээр зарчим

### Ишлэл

4. Келли ба Ямайка (253/1987) 1991 оны 4 дүгээр сарын 8, Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл (A/46/40) 1991 он 5. Саундерс ба Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улс (943/1994/490/572), Европын Шүүх, 1996 оны 12 дугаар сарын 17



гэрээ конвенцуудад тодорхой тусгагдан баталгаажуулагдахгүй ч энэ эрхийг Европын конвенц ба Хуучин Югослав, Руанда болон Олон Улсын Шүүхийн дүрэмд орсон гэж ойлгож болох юм.

Европын Шүүх тодорхойлохдоо: “Хэдийгээр Европын Конвенцийн 6-р зүйлд Цагдаагийн асуулганд мэдүүлэг өгөхгүй байх өөрийгөө буруутгахгүй байх эрхүүдийг тусгайлан заагаагүй ч 6-р заалтад заасан шударга үйл ажиллагааны тухай ерөнхийдөө зөвшөөрөгдсөн олон улсын стандартуудад багтана гэдэгт эргэлзэх хэрэггүй юм.” гэжээ.<sup>6</sup> Сэжигтэний мэдүүлэг өгөхгүй байх эрхийг зөрчих хандлагууд шударгаар шүүлгэх үйл ажиллагааг зөрчдөг бөгөөд уг эрхийг зөрчсөн эсэхийг тухайн хэргийн бүх нөхцөл байдлуудыг оролцуулан тогтоох ёстой.

Европын шүүх сэжигтнийг буруутгах зорилгоор дарамт шахалтанд оруулж авсан мэдүүлгийг эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаанд нотлох баримт болгон ашиглах явдлыг өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг зөрчиж байгаа явдал мөн гэж тогтоосон.<sup>7</sup>

Сэжигтэн гаалийн ажилтнуудад баримт гаргаж өгөхгүй байсан өөр нэгэн хэрэгт Европын шүүх үзэхдээ эрүүгийн хэрэгт холбогдож байгаа этгээд мэдүүлэг өгөхгүй байх болон өөрийн эсрэг нотлохгүй байх эрхтэй. Гэтэл энэ гаалийн ажилтнуудын шаардсан бичиг баримт нь сэжигтэнг өөрийг нь буруутгасан нотлох баримт учраас өгөхгүй байсныг хүчээр гаргуулах оролдлого хийжээ гэж үзсэн байна.<sup>8</sup>

Югославын дүрмийн 42-р зүйлийн А заалтанд мэдүүлэг өгөхгүй байх эрхийг тусгайлан заасан байна. Үүнд: “Прокурор нь байцаалт явуулахаас өмнө тухайн хүний ярьдаг, ойлгодог хэл дээр дараахь эрхүүдийг нь хэлж мэдэгдсэн байх ёстой. Үүнд: Мэдүүлэг өгөхгүй байх эрх, тухайн хүний хийж байгаа бүх мэдэгдлүүд нь протоколд бэхжин нотлох баримт болон ашиглагдах боломжтойг мэдэгдсэн байх ёстой. Руандагийн дүрмийн 42.а заалт үүнтэй адил заалт юм. Олон Улсын Шүүхийн /ОУЭШ/ дүрмийн- 55.2.б-ийн заалтад тухайн этгээд нь ОУЭШ-ийн/ прокурорууд эсхүл орон нутгийн үндэсний эрх мэдэл бүхий албан тушаалтнуудад байцаагдаж байгаа тохиолдолд мэдүүлэг өгөхгүй байх эрхээ хэрэгжүүлэх нь түүний гэм буруутай эсэх нь нотлогдоход нь үл хамаарна.

Олон улсын Эрүүгийн Шүүх (ОУЭШ).

#### 9.4. Орчуулагч авах эрх

Эрх бүхий албан тушаалтны хэлийг ойлгохгүй эсхүл уг хэлээр ярьдаггүй хэн боловч баривчлагдсаны дараа эрх зүйн үйл ажиллагаанд туслалцуулах зорилгоор шаардлагатай тохиолдолд үнэ төлбөргүй орчуулагчаар хангагдах ёстой.\*

#### Холбогдох хэм хэмжээ

##### Үндсэн зарчмын 14 дүгээр зүйл

Баривчлах саатуулах буюу хорих үйл ажиллагаа хариуцсан байгууллага, албан тушаалтны хэлээр сайн ярьдаггүй буюу ойлгодоггүй этгээд энэхүү зарчмын 10, 11 /Дахь хэсэг/ 12/1 дэх хэсэг/, 13-д заасан мэдээллийг өөрийн нь мэдэх хэл дээр аль болох түргэн авах, тэрчлэн түүний баривчлагдсаны дараа хэргийг хянан шалгах шийдвэрлэхтэй холбогдуулж орчуулагчийн туслалцааг шаардах бол үнэ төлбөргүй авах эрхтэй

\* Үндсэн Зарчим – 14 дүгээр зарчим

#### Ишлэл

6. Маррей ба Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (41/1994/488/570), 1996 оны 2 дугаар сарын 8, хуудас 20
7. Саундерс ба Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улс (943/1994/490/572), Европын Шүүх, 1996 оны 12 дугаар сарын 17
8. Панке ба Франц, (82/1991/334/407), 1993 оны 2 дугаар сарын 25

\* Европын Шоронгийн Дүрмийн 93 дугаар дүрэм, Югославын Дүрмийн 42 дугаар зүйл, Руандагийн 42 дугаар дүрэм. Мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 55(2)(в) дугаар зүйлийг үзнэ үү.

\*\* Үндсэн Зарчим – 23 дугаар зарчим

\*\*\* Югославын Дүрмийн 43 дугаар зүйл, Руандагийн Дүрмийн 43 дугаар дүрэм.

^ Эрүүдэн Шүүхийн Эсрэг Конвенцийн 11 дүгээр зүйл

Югослав ба Руандагийн дүрэм, Европын шоронгийн дүрэмд саатуулагдаж байгаа гэвч анхан шатны шүүхээр шүүгдээгүй байгаа этгээд нь захиргаа, өөрийн хамгаалагч үүнд тэдний хуулийн зөвлөхүүдтэй хийх уулзалт гэх мэт бүх шаардлагатай уулзалтууд, ярилцагын үеэр орчуулагчаар үнэ төлбөргүй хангагдах эрхтэй.\*

## 9.5. Тэмдэглэл хөтлөх

Албадан саатуулагдсан болон хоригдож байгаа этгээдүүдийн бүх байцаалтууд тэмдэглэлд бичигдэн хадгалагдсан байх ёстой. Тэмдэглэлд байцаалтын хоорондын хугацаа, байцаалтыг явуулж байгаа албан тушаалтны болон байцаагдагч, хамт байлцсан хүмүүсийн овог нэр бичигдсэн байх ёстой. Сэжиглэгдэж байгаа хүн болон түүний /хамгаалагч/ өмгөөлөгч тэмдэглэлтэй танилцах боломжтой байна.\*\* Хүний эрхийн хороо нь “Бүх байцаалтуудын цаг хугацаа ба байцаалт явуулсан газрыг тэмдэглэсэн байх ёстой” гэж цохон тэмдэглэсэн байна. Мөн энэ мэдээллүүд захиргааны болон шүүн таслах ажиллагаанд нээлттэй байх ёстой.<sup>9</sup>

Югослав ба Руандагийн дүрмээр байцаалтын видео болон аудио бичлэгийг авсан байхыг шаарддаг.\*\*\*

## 9.6 Байцаалтын журам ба хэрэгжилтийн явцтай танилцах

Олон улсын сандартын дагуу тухайн улс бүр байцаалт явуулах журам, дүрэм болон байцаалтын арга хэлбэр ба явцтай тогтмол ба системтэйгээр танилцуулсан байх ёстой. ^

### Ишлэл

9. Хүний Эрхийн Хороо  
Ерөнхий Тайлбар 20, догол мөр  
11

## Бүлэг 10

### Эрүү шүүлтэнд өртөхгүй байж хүнлэг нөхцөлд хоригдох эрх

Хүн бүр өөрт нь тулгасан ялыг аливаа эрүү шүүлт, зүй бус харьцаанаас ангид байж, шүүх хуралд бэлтгэх бүрэн бололцоог олгосон нөхцөлд хуульд захирагдах, шударга шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй.

#### 10.1 Хүнлэг нөхцөлд хоригдох эрх

##### 10.1.1 Хууль ёсны албадан саатуулагдах газарт хоригдох эрх

##### 10.1.2 Хоригдох үеийн тайлан бүртгэл

##### 10.1.3 Эрүүл мэндийн туслалцааг цаг тухайд нь авах эрх

#### 10.2 Урьдчилан хорих газарт байгаа хүмүүст нэмэлт хамгаалалт олгох

##### 10.3 Албадан саатуулагдсан эмэгтэйчүүд

#### 10.4 Эрүү шүүлт тулгах болон хүнлэг бус харьцаж шийтгэхийг хориглох

##### 10.4.1 Удаан хугацаагаар ганцаарчлан хорих

##### 10.4.2 Хүч хэрэглэх

##### 10.4.3 Байцаалтын үед хүчээр дарамтлах

##### 10.4.4 Албадлага хэрэглэх

##### 10.4.5 Биед нэгжлэг хийх

##### 10.4.6 Химийн болон шинжлэх ухааны туршилт хийх

##### 10.4.7 Сахилгын арга хэмжээгээр дарамтлах

#### 10.4.8 Эрүү шүүлт болон хүнлэг бус харьцаанаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх эрх

### 10.1 Хүнлэг нөхцөлд хоригдох эрх

Эрх чөлөөгөө хасуулсан хүн бүрийн эдлэх эрхийг олон улсын жишигт нийцүүлэн хамгаалсан байдаг. Эдгээр жишиг нь хүний эрхийн гэрээнүүдийн нийтлэг зарчмуудад тусгагдсан байдаг бол хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм, Европын улсуудын хорих ангийн зарчмууд, эмчилгээ сувилгааны болон хорих төвийн зарчмууд зэрэгт нарийвчлан тусгажээ.

Албадан саатуулагдсан болон хоригдсон хүн бүр өөрийн аюулгүй байдал, халдашгүй эрхээ эдлэх ёстой. /1-р бүлэг Эрх чөлөө эдлэх эрх-ийг үзнэ үү/ Мөн хувь хүний хувьд төрөхөөс заяасан нэр төрөө хүндлүүлэх, эрүү шүүлт тулгах болон хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах харьцаанд өртөгдөхгүй байх, хуулийн дагуу нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох эрхээ эдлэж шударга шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй.

Эрх чөлөөгөө хасуулсан хүн бүртэй харьцахдаа тухайн хүний угаас заяасан нэр төрийг нь хүндэтгэх ёсоор хандана.\*

#### Холбогдох хэм хэмжээ

##### ИУТЭОУП-ын 10/1/ дүгээр зүйл

Эрх чөлөөгөө хасуулсан бүх хүнтэй хүнлэг харьцаж, угаас заяасан нэр төрийг нь хүндэтгэнэ.

\* ИУТЭОУП-ын 10 дугаар зүйл, Америкийн Конвенцийн 5 дугаар зүйл, Америкийн Конвенцийн 25 дугаар зүйл түүнчлэн Африкийн Дүрмийн 4 болон 5 дугаар зүйлүүдийг үзнэ үү.

Энэхүү олон улсын жишиг хэмжээнд бүх улс орны хоригдол бүрт албадан саатуулах болон цагдан хорих наад захын хэм хэмжээг мөрдөх, эрх чөлөөгөө хасуулсан үед нь тухайн этгээдийн эдлэх бүх эрхийг эдлүүлэхийг заадаг.

Эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр эрх чөлөөгөө хасуулснаас болж ямар нэгэн албадлага, дарамт шахалтанд орох ёсгүй хэмээн Хүний Эрхийн Хороо мэдэгдсэн байдаг. Эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр хаалттай ертөнцийн зайлшгүй хязгаарлалттай нөхцөлд ч Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон Улсын Пактад заасан бүх эрхээ эдлэх ёстой.<sup>1</sup>

Мөн Хүний Эрхийн Хороо хоригдож байгаа хүний угаас заяасан нэр төрийг хүндэтгэх гэдэг нь түгээмэл тунхаглалын үндсэн зарчим мөн гэж заажээ. Энэхүү заалтуудад ямар ч улс санхүүгийн хүндрэлүүдээс болж хүнлэг бусаар харьцах ёсгүй гэж тогтоожээ. Саатуулагдсан болон хоригдсон хүмүүст шаардлагатай, тэдний хэрэгцээг хангах үйлчилгээг үзүүлэх ёстой.<sup>2</sup>

Энэхүү хэрэгцээт зүйлд хоол хүнс, ариун цэврийн хэрэгсэл, хувцас хунар, хөнжил гудас, эмнэлгийн үйлчилгээ, гэрэлтэй орчин, биеийн тамирын дасгал хийх болон өөрийн шашин шүтлэгээ шүтэх боломж, мөн бусадтай буюу ялангуяа гадаад ертөнцтэй харьцах зэрэг орно.

Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пактын 7-р зүйлд эрүү шүүлт болон хүнлэг бус доромжлон харьцахыг хориглосон байхад үүний 10-р зүйлд хоригдолтой хүнлэг ёсоор харьцахыг заасан байдаг. 10-р зүйлийг зөрчсөн цагдан хорих нөхцөл байдал гарвал 7-р зүйлийг ч бас мөн зөрчиж байгаа хэрэг юм.<sup>3</sup>

Нэгэн хоригдлын мэдүүлснээр түүнийг баривчлаад 500 жил болж буй шоронд аваачжээ. Тэнд хүүхэд, эмэгтэйчүүд нийлсэн 30-аад хүнийг хамтад нь хорьсон байжээ. Шоронгийн камер нь хулгана, бөөс, жоомонд баригдсан бохир заваан, маш хүйтэн байснаас гадна далайн усыг хоол ундандаа хэрэглэж байсан аж. Тэдэнд шээсний үнэр шингэсэн матрос, хөнжил өгдөг байж. Түүнчилэн тэнд амиа хорлох, эрүүдэн шүүх болон хоорондоо зодолдох нь элбэг байв. Энэ нь Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Пактын 10-р зүйлийг зөрчиж байна гэж Хүний Эрхийн Хороо мэдэгдсэн байна.<sup>4</sup>

Мөн тэднийг хоол хүнс болон бусад зүйлээр гачигдуулж байсан нь ИУТЭОУП-ын 10-р зүйлийг зөрчсөн гэж Хүний эрхийн хороо үзсэн байна.<sup>5</sup>

Руандагийн нэгэн хотод хүүхэд эмэгтэйчүүд, өндөр настан цагаачдыг маш хүнд байдалд хорьж байсан нь Африкийн Дүрмийн 5-р зүйлийг зөрчсөн хэрэг гэж Африкийн комисс үзжээ.<sup>6</sup>

Саатуулагдсан болон хоригдсон ямар ч этгээд өөртэй нь зөв боловсон харьцахыг шаардах, тэдний харьцааны талаар гомдол гаргах эрхтэй. Эрх бүхий албан тушаалтнууд гомдол, хүсэлт нэг бүрийг яаралтай авч хэлэлцээд хариуг нь хугацаанд нь өгөх үүрэгтэй бөгөөд хүлээж аваагүй тохиолдолд шүүх болон бусад эрх бүхий албан тушаалтанд хандах ёстой.\*

Францын хоригдлуудын зүй бус харьцааны талаар гаргасан ихэнхи гомдлын тун цөөнийг мөрдөн шалгасан байсан нь “ял завших явдлыг” дэвэргэж байгаа явдал мөн гэж Хүний Эрхийн Хороо үзсэн байна. Тиймээс Хүний Эрхийн Хороо хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудад зүй бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах харьцааны талаархи хоригдлуудын гомдлыг газар дээр нь очиж нэг бүрчлэн сонсох, ярилцах механизм бүрдүүлэхийг зөвлөжээ.<sup>7</sup>

\* Үндсэн Зарчим – 33 дугаар зарчим

## Ишлэл

1. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 21, догол мөр 3
2. Келли ба Ямайка (253/1987) 1991 оны 4 дүгээр сарын 8, Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл (A/46/40) 1991 он; Паркани болон Унгарын хэрэг (410/1990), 1990 оны 7 дугаар сарын 27, Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл (A/47/40) 1992 он
3. Манфред Новак, НҮБ-ын Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт: ИУТЭОУП-ын Тайлбар, 1993 он, хуудас 186
4. Гриффин ба Испани (493/1992) 1995 оны 4 дүгээр сарын 4, НҮБ-ын баримт бичиг ИУТЭОУП /с/57/1, 1996 оны 8 дугаар сарын 23.
5. Келли ба Ямайка (253/1987) 1991 оны 4 дүгээр сарын 8, Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл (A/46/40) 1991 он; 6. Organisation mondiale contre la torture, Association internationale des juristes democrates, Commission internationale des juristes, Union interafricaine des droits de l'homme v. Rwanda, (27/89, 46/91, 49/91, 99/93 тус тус), Африкийн Комиссын 10 дах удаагийн жил бүрийн Илтгэл, 1996 -1997, Хүний болон Улс Түмний Эрхийн тухай Африкийн Комисс /RPT /10th]

### 10.1.1 Хууль ёсны хорих газарт албадан саатуулагдах эрх

Хоригдогч этгээдийн гадаад ертөнцтэй харьцах, “сураггүй болгох”, эрүү шүүлт тулгагдах зэрэг эрх нь зөрчигдөхгүй байх нөхцлийг хангах нэг алхам нь цагдан хоригдож байгаа газар хууль ёсны байх явдал юм. Боломжтой бол саатуулагдсан этгээдийг байнга оршин суудаг газарт ойрхон орших албан ёсны баталгаажсан хорих газар, түүнийг хорих тухай захирамжийн дагуу саатуулах ёстой.\*

### 10.1.2 Хоригдох үеийн тайлан бүртгэл

Урьдчилан хорих болон хорих ангийн аль алинд нь эрх бүхий албан тушаалтнууд бүх хоригдлоос мэдүүлэг авч бүртгэл хөтлөн хадгалах ёстой. Энэхүү хөтөлсөн бүртгэлүүдийн мэдээлэл нь шүүх болон мөн бусад эрх бүхий албан тушаалтнууд, хоригдлын гэр бүлийн гишүүд болон мэдээллийг сонирхогч ямарч хүнд ойлгомжтой тодорхой байх ёстой.\*\*<sup>8</sup>

### 10.1.3 Эрүүл мэндийн туслалцааг цаг тухайд нь авах

Хэрвээ хоригдож буй этгээдэд эмнэлгийн үйлчилгээ зайлшгүй хэрэгтэй болсон нөхцөлд цаг тухайд нь эмнэлгийн тусламж үзүүлэх арга хэмжээ авна. Хоригдогч нь хуулийн дагуу ямар ч арга хэмжээ авагдсан байснаас үл хамааран боломжтой бүх эмнэлгийн үйлчилгээ авах эрхтэй.\*\*\*

Хууль сахиулагч албан тушаалтнууд нь хоригдлуудын эрүүл мэндэд байнга анхаарал тавих үүрэгтэй.^

**Эмчийн тусламж авах эрхийн тухай** бид 4.5-р бүлэгт дурдсан. Энэ бүлэгт хоригдлуудын эмнэлгийн болон эмчийн тусламж авах эрх болон эрүүл мэндэд үзүүлэх эмчилгээний чанарын тухай ойлголтууд тусгагдсан.^

Албадан саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалахын тулд Зан үйлийн зарчмын 24-р зүйл, Хоригдлуудтай Харьцах Наад захын жишиг Дүрмийн 25, 26-р зүйл, Европын хорих ангийн дүрэм болон Эмч нарын гүйцэтгэх үүргийн ёс зүйн зарчмын 30, 31-р зүйлд энэ тухай тусгасан байдаг.

Хоригдлуудтай Харьцах Наад захын жишиг Дүрмийн 25 болон Европын хорих ангийн дүрмийн 30.1-д өвчилсөн болон өвчтэй болохоо мэдэгдсэн эмчилгээ үзүүлэх ёстой эмнэлгийн жишиг хэмжээний дагуу онцгой анхаарал татаж байгаа хоригдол болон саатуулагдсан иргэдийг эмч үзэх буюу өвчтнүүдийг үргэлж эргэн тойрч онцгой анхаарал тавих ёстой гэж заасан байдаг. Харин Европын хорих ангийн дүрмийн 30.2-д, мөн Хоригдлуудтай Харьцах Наад захын жишиг Дүрмийн 25.2-р зүйлд хэрвээ эмч хоригдлуудыг удаан хугацаагаар хорьсноос, мөн хорихын ямар нэг нөхцөл байдлаас болж биеийн болон сэтгэл санааны эрүүл мэнд алдагдаж байна гэж үзвэл шоронгийн захиргаанд тайлагнаж байх ёстой гэж заасан байдаг.

Ингэснээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүс өөрт нь хүнлэг бус хүний нэр төрийг доромжлон харьцсан, эрүү шүүлт явуулсан үед эмчид нэн даруй мэдээлэх боломжтой болно хэмээн Эмнести Интернэшнл үзэж байна. Эмчид үзүүлэх үйл явц нь албан ёсны мөрдөн байцаалтыг хүнлэг бус доромжлон харьцсан болон эрүү шүүлт тулган явуулж байгаа тэрхүү байгууллагын хяналтаас ангид явагдах ёстой.

\* Үндсэн Зарчим – 11(2) ба 20 дугаар зарчим, Сураггүй Алга Бологсдын тухай Тунхагын 10 дугаар зүйл, Наад захын Жишиг Дүрмийн 7(2) дугаар дүрэм, Европын шоронгийн дүрэм-7(1) дүрэм болон Хүчээр сураггүй алга болгохоос бүх хүмүүсийг хамгаалах тухай Америкийн Улсуудын Конвенцийн 11 дүгээр зүйл

\*\* Сураггүй Алга Болгохоос бүх хүмүүсийг хамгаалах тухай Тунхагын 10(2) ба (3) дугаар зүйл, Наад захын Жишиг Дүрмийн 7 дугаар дүрэм, Үндсэн Зарчим – 12 дугаар зарчим, Хүчээр сураггүй алга болгохоос бүх хүмүүсийг хамгаалах тухай Америкийн Улсуудын Конвенцийн 11 дүгээр зүйл түүнчлэн Европын шоронгийн дүрэм-7(2) ба 8 дүрмүүд

\*\*\* Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд – 9 дүгээр дүрэм

^ Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хуулийн 6 дугаар зүйл

^^ Үндсэн Зарчим – 24 дүгээр зарчим, Наад захын Жишиг Дүрмийн 25 болон 26 дугаар дүрэм, Европын шоронгийн дүрэм ба Эмчийн ёс суртахууны тухай үндсэн зарчмын 29, 30 ба 31 дүгээр дүрэм

#### Ишлэл

7. Франц: Хүний Эрхийн Төлөв Байдлын Судалгааг Дүгнэх нь, НУБ-ын баримт бичиг, ИУТЭОУП /С/79/Нэмэлт 80, 1997 оны 8 дугаар сарын 4, догол мөр 16
8. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 20, догол мөр 11-ийг үзнэ үү.

Хэрвээ эмэгтэй хоригдол хүчиндүүлсэн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн бол эмэгтэй эмчид үзүүлж нэн даруй эмнэлгийн үзлэг шинжилгээнд орох ёстой. Энэ нь хүчээр хэрэг хүлээлгэх болон хүчирхийллийн эсрэг мэдээ мэдээлэл цуглуулахад маш хэрэгтэй хэмээн Эмнести Интернэшнл үзэж байна.

Эмч нарын гүйцэтгэх үүргийн ёс зүйн зарчмын 1-р зүйлд саатуулагдсан болон хоригдож буй хүмүүст үзүүлэх эмчилгээ сувилал нь эрх чөлөөтэй хүмүүст үзүүлэх эмнэлгийн тусламжтай яг адилхан хэм хэмжээнд байх ёстой хэмээн заасан байдаг. Харин 2 болон 5-р зүйл нь доор дурдсан нөхцлүүдэд зөрчигдсөн байна.

- Хүний нэр төрийг доромжлон хүнлэг бус харьцах болон эрүү шүүлт явуулах зэрэг аливаа ажиллагаанд оролцсон
- Хоригдлуудын эрүүл мэндийг хамгаалах болон эмчлэхэд хайхрамжгүй хандсан
- Хоригдлуудын нөхцөл байдал, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болохуйц аргуудыг байцаалтанд ашиглан олон улсын зарчмыг зөрчсөн
- Олон улсын хэм хэмжээг зөрчин хоригдогчдын бие махбод болон сэтгэл санаанд нь сөргөөр нөлөөлөхүйц шийтгэл болон арга хэмжээнд оролцсон буюу өөр ямар нэг замаар оролцсон
- Шаардлагагүй нөхцөлд буюу уг хоригдож буй этгээдийг бие, сэтгэцийн эрүүл мэндэд аюул занал учраагүй байхад номхруулах шинжтэй аливаа арга хэмжээ авахад оролцсон бол тус тус зөрчсөнд тооцно.

Саатуулагдсан болон хоригдсон этгээдийн эмчилгээ шинжилгээ бүрийг бичиж тэмдэглэн баримтыг хадгалах бөгөөд хоригдол үүнийг үзэх эрхтэй.\*

## 10.2 Урьдчилан хорих газарт байгаа хүмүүст нэмэлт хамгаалалт олгох

Эрүүгийн хэргээр сэжиглэгдэн баривчлагдан саатуулагдаж, ял шийтгэлээ эдлээгүй байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг олон улсын жишиг хэмжээнд тусгайлан авч үзсэн байдаг.\*\*

Эрүүгийн хэрэг үйлдсэн хэргээр сэжиглэгдэж байгаа болон шийтгэгдсэн, баривчлагдсан этгээдийг гэм буруу нь шүүхээр таслагдаагүй тохиолдолд түүнийг гэм буруугүйд тооцно./ Нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцох тухай 15-р бүлгийг үзнэ үү./ Гэм буруу нь шүүхээр таслагдаагүй хүнийг цагдан хорихдоо ял эдэлж буй хүмүүсээс тусад нь хорих хэрэгтэй гэж олон улсын жишиг дүрэмд заасан байдаг.\*\*\*

Шүүх хурлаас өмнө цагдан хоригдож байгаа хүмүүст анхаарах онцгой нөхцөл байдлууд:

- Ял эдэлж буй хүмүүсээс тусдаа хоригдох эрхтэй\*
- Өөрсдийгөө хамгаалах өмгөөлөгчтэй байх эрхтэй\*\*

### Холбогдох хэм хэмжээ

#### Үндсэн зарчмын 36.2

Энэ зарчмын 1 дэх хэсэгт заасан хэрэг хэлэлцэх ажиллагаа хялбар, шуурхай, зохих мөнгөгүй хүмүүсийн тухайд үнэ төлбөргүй байх ёстой. Саатуулсан байгууллага нь саатуулагдсан этгээдийн хэргийг нь хэлэлцэж байгаа байгууллагад үндэслэлгүйгээр удаашруулахгүйгээр хүргүүлнэ.

\* Үндсэн Зарчим – 26 дугаар зарчим

\*\* Үндсэн Зарчим – 36 (2) дугаар зарчим

\*\*\*ИУТЭОУП-ын 10(2) (а)дүгээр зүйл, Наад захын Жишиг Дүрмийн 84 (2)дугаар дүрэм, Америкийн Конвенцийн 5(4) дугаар зүйл, Европын шоронгийн дүрэм – 91 дүгээр дүрэм

- Хувийн зардлаар өөрсдийн шүдний болон дотрын эмчээр үйлчлүүлэх эрхтэй\*\*\*
- Ял эдэлж буй хүмүүсээс өөр хоригдлын хувцас болон өөртөө таарсан, өөрийнхөө цэвэр хувцсыг өмсөх эрхтэй. Мөн шүүх хуралд жирийн иргэдийн адил хувцас өмсөх эрх эдэлнэ.^
- Тэрхүү байгууллагын дэг, аюулгүй байдлын журамд нийцсэн мэдээллийн материал, ном, сонин сэтгүүл худалдаж авах эрхтэй.^

### 10.3 Албадан саатуулагдсан эмэгтэйчүүд

Хоригдож байгаа эмэгтэйг эрэгтэй яллагдагчаас тусад нь хорих бөгөөд эмэгтэй харгалзагчтай байна. Тэднийг тусдаа хорих байгууллагад юмуу хорих байрандаа тусдаа тасагт хорих бөгөөд эмэгтэй хүний удирдлага дор байна. Ямарч эрэгтэй ажилтаныг эмэгтэй ажилтан дагалдуулахгүйгээр эмэгтэйчүүдийн шоронд оруулах ёсгүй.^

Хүний Эрхийн Хороо АНУ эмэгтэйчүүдийн хорих ангиудад эрэгтэй харгалзагч тавьсанаар тэдний хувийн эрх чөлөөнд нь халдах, хүчирхийлэх зэрэг ноцтой хэрэг гарч байсан гашуун сургамжийг сануулж байна.<sup>9</sup>

Хоригдсон болон албадан саатуулагдсан эмэгтэй хоригдлын байцаалт болон нэгжлэгид заавал эмэгтэй харгалзагч байлцах ёстой.<sup>10</sup>

Шүүхийн болон хууль сахиулагч албан тушаалтнуудыг улсаас хүйсийн харьцааны талаар сургалтанд хамруулах ёстой.<sup>11</sup>

Эмэгтэйчүүдийн хорих ангиудад жирэмсэн болон төрсөн эмэгтэйчүүдийн асрах тусгай өрөөтэй байх ёстой. Боломжтой нөхцөлд эмэгтэйчүүдийг шоронгийн бус ердийн эмнэлэгт төрүүлэхэд анхаарвал зохино.+

Албадан саатуулагдсан болон хоригдсон эмэгтэй хоригдлуудтай жирэмсэн болон төрөх үед нэр төрийг нь хүндэтгэн харьцах бөгөөд хүч хэрэглэх, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон, харгис хэрцгий харьцахыг хориглоно.\*

#### Холбогдох хэм хэмжээ

##### ИУТЭОУП-ын 10.2 /а/

2. (а) онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд буруутнаар татагдсан этгээдийг ял шийтгүүлсэн этгээдээс тусгаарлаж, шийтгэгдээгүй этгээдийн эрх зүйн байдалд тохирсон жич дэглэмд байлгана.

##### Наад захын жишиг дүрэм 84,2-ын

Сэжигтэн яллагдагч нарыг гэм буруутайд тооцож үл болох учир тэдэнтэй зохих журмын дагуу харьцвал зохино.

\* ИУТЭОУП-ын 10(2) дүгээр зүйл, Америкийн Конвенцийн 5(4) дугаар зүйл түүнчлэн Наад захын Жишиг Дүрмийн 85(1) дугаар дүрэм, Европын шоронгийн дүрэм – 11(3) дүгээр дүрмүүдийг үзнэ үү.

\*\* Үндсэн Зарчим – 14 дүгээр зарчим, Европын шоронгийн дүрэм – 36(4) болон 93 дугаар дүрэм.

\*\*\* Наад захын Жишиг Дүрмийн 91 дүгээр дүрэм, Европын шоронгийн дүрэм – 98 дугаар дүрэм

^ Наад захын Жишиг Дүрмийн 88 дугаар дүрэм, Европын шоронгийн дүрэм – 95 дугаар дүрэм

^^ Наад захын Жишиг Дүрмийн 90 дүгээр дүрэм, Европын шоронгийн дүрэм – 97 дугаар дүрэм

^^^ Наад захын Жишиг Дүрмийн 8(а) болон 53 дугаар дүрэм

+ Наад захын Жишиг Дүрмийн 23(1) дугаар дүрэм, Европын шоронгийн дүрэм – 28 дугаар дүрэм

#### Ишлэл

9. АНУ: Хүний Эрхийн Төлөв Байдлын Судалгааг Дүгнэх нь, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП /С/79/Нэмэлт 50, 1995 оны 4 дүгээр сарын 7, догол мөр 20

10. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 16, догол мөр 8.

11. 1993 оны 12 дугаар сарын 20-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан Эмэгтэйчүүдийн Эсрэг Хүчирхийллийг Устгах Тухай Тунхаглалын 4 дүгээр зүйл, Эмэгтэйчүүдийн Эсрэг Ялгаварлан Гадуурхалыг Устгах Хороо, Ерөнхий Зөвлөмж № 19, (1992 он 11 дүгээр хуралдаан), 1994 оны 9 дүгээр сарын 24, НҮБ-ын Эрүү шүүлтийн талаарх Тусгай Илтгэгч (Хүний Эрхийн Комисс.4/1995/34)

\*ИУТЭОУП-ын 7 болон 10 дугаар зүйл, Африкийн Дүрмийн 5 дугаар зүйл, Америкийн Конвенцийн 5(2) дугаар зүйл, Европын Конвенцийн 3 дугаар зүйл.

\*\* ХЭТТ-ын 5 дугаар зүйл, ИУТЭОУП-ын 7 дугаар зүйл, Үндсэн Зарчим 6 дугаар зарчим, Африкийн Дүрмийн 5 ба Америкийн Конвенцийн 5(2) дугаар зүйлүүд болон Европын Конвенцийн 3 дугаар зүйл.

\*\*\* ИУТЭОУП-ын 4 дүгээр зүйл, Америкийн Конвенцийн 27(2) дугаар зүйл, Европын Конвенцийн 15 дугаар зүйл.

^ Эрүү Шүүлтийн Эсрэг Конвенцийн 2(2) дугаар зүйл, Эрүү Шүүлтийн Эсрэг Тунхаглалын 3 дугаар зүйл, Үндсэн Зарчим -6 дугаар зарчим, Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хуулийн 5 дугаар зүйл ба Эрүү шүүлтийн талаарх Америкийн улсуудын Конвенцийн 5 дугаар зүйл.

^^ Эрүү Шүүлтийн Эсрэг Тунхаглалын 2(3) дугаар зүйл, Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хуулийн 5 ба 8 дугаар зүйл түүнчлэн Эрүү шүүлтийн талаарх Америкийн улсуудын Конвенцийн 3 дугаар зүйл.

^^^ Эрүү шүүлтийн талаарх Америкийн улсуудын Конвенцийн 5 дугаар зүйл.

+ Эрүү Шүүлтийн Эсрэг Конвенцийн 1 дүгээр зүйл, Эрүү Шүүлтийн Эсрэг Тунхаглалын 1 дүгээр зүйл болон Эрүү шүүлтийн талаарх Америкийн улсуудын Конвенцийн 2 дугаар зүйл.

++ Наад захын Жишиг Дүрмийн 31 дүгээр дүрэм

## 10.4 Эрүү шүүлт болон хүнлэг бус харьцаж шийтгэхийг хориглоно

Хэнд ч эрүү шүүлт тулган, хэрцгий хүний ёсноос гадуур нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно.\*\*

Хүн бүр халдашгүй эрхтэй байна. Дайн дажин, улс төрийн тогтворгүй байдал, улс гүрнүүдийн онцгой нөхцөл байдалд байх үед ч энэ эрх зөрчигдөх ёсгүй.\*\*\* /Хязгаарлаж болохгүй эрхүүдийн тухай бүлэг 31.3-аас үзнэ үү./ Ямарч үед эрүүдэн шүүх болон өөр бусад харгис хэрцгий, хүнлэг бус хүний нэр төрийг доромжлон харьцах юм уу шийтгэж болохгүй.^12

Энэхүү эрх нь ялангуяа эрх чөлөөгөө хасуулсан хүн бүрт хамааралтай.

Бүх хууль сахиулагч албан тушаалтнуудад ямарч хүнд эрүү шүүлт тулгах, хэрцгий хүнлэг бус хүний нэр төрийг доромжлон харьцахыг хүлээн зөвшөөрөх, өдөөн хатгах, үйлдэхийг хориглоно. Мөн цол хэргэм, албан тушаалаа ашиглан тийм зүйл хийхийг тушааваас үүнийг гүйцэтгэх ёсгүй. Харин тэрхүү тушаалыг гүйцэтгэхээс татгалзаж, зохих газар мэдэгдэх ёстой.^1 Уг этгээд онц ноцтой байлаа ч түүнд эрүү шүүлт тулгах ёсгүй.^11

Эрүү шүүлт, хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийг хориглоно гэдэг нь хоригдолд сэтгэл санааны болон бие махбодийн дарамт үзүүлэхгүй байхыг хэлнэ.+

Сахилгын зөрчил гаргасны төлөө эрүү шүүлт тулгах, харанхуй гянданд хорих болон хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон шийтгэх зэргийг хатуу хориглоно.^12 /Биемахбодийн шийтгэлийн тухай бүлэг 25.4-өөс үзнэ үү/

Хүний Эрхийн Хороо бүх цагдан хорих газруудад эрүү шүүлт болон хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцахад хэрэглэж болохуйц багаж зэвсэггүй байх ёстой гэж заасан байдаг.^13

### 10.4.1 Удаан хугацаагаар ганцаарчлан хорих

Хүний эрхийн байгууллага нь хүнийг удаан хугацаагаар ганцаарчлан хорих явдал нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай пактын 7-р зүйлд заасан

#### Холбогдох хэм хэмжээ

##### ИУТЭОУП-ын 7 дугаар зүйл

Хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно. Тухайлбал, өөрийнх нь чөлөөтэй өгсөн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилтад оруулж болохгүй.

##### Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 5 дугаар зүйл

Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй.

##### Үндсэн зарчмын 6 дугаар зүйл

Саатуулагдсан болон хоригдсон нэг ч хүнийг эрүүдэн шүүж, буюу хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэж болохгүй. Эрүүдэн шүүж хэрцгийгээр хүнлэг бусаар харьцаж шийтгэхийг ямар ч тохиодолд зөвтгөхгүй.

#### Ишлэл

12. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 20, догол мөр 3.

13. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 20, догол мөр 11.



эрүү шүүлт болон хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцахыг хориглосныг зөрчсөн хэрэг гэж үзэж байна.<sup>14</sup>

Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмын 7-р зүйлд удаан хугацаагаар ганцаарчлан хорихыг шийтгэлийн хэлбэрээр хэрэглэхийг хориглосон байдаг.

Америк дундын комисс хүнийг удаан хугацаагаар ганцаарчлан хорих нь хуулийн дагуу шийтгэх арга хэмжээ биш бөгөөд үүнийг тогтмол хэрэглэхийг үл зөвшөөрнө.<sup>15</sup>

## 10.4.2 Хүч хэрэглэх

Олон улсын жишиг хэмжээнд хууль сахиулагч албан тушаалтнуудыг саатуулагдсан болон хоригдсон бүх хүмүүст хүч хэрэглэхийг хориглосон байдаг. Хууль сахиулагч албан тушаалтнууд гарцаагүй тохиолдолд үүргээ биелүүлэхэд л шаардлагатай хэмжээгээр хүч хэрэглэж болно.\*

Хууль сахиулагч албан тушаалтнууд хорих ангиудад зөвхөн тус байгууллагын аюулгүй байдал, хэв журам алдагдах болон хоригдлууд оргон зайлахыг завдсан үед, хууль ёсны хэв журам зөрчигдөх, өөрт нь болон бусад хүмүүсийн амь насанд аюул заналхийлсэн, ноцтой хүнд хохиролоос хамгаалах тохиолдолд хүч хэрэглэж болно. Хүч хэрэглэхгүйгээр зохицуулж үл болох тийм л үед энэ арга хэмжээг хэрэглэнэ.\*\*

Галт зэвсэг хэрэглэх явдлыг зөвхөн зэвсэг хэрэглэн эсэргүүцсэн, хүний амь нас хохироож болзошгүй, хууль зөрчсөн, бусдын аюулгүй байдалд занал учруулсан этгээдийг баривчлах болон зугтахыг завдсан үед хэрэглэх бөгөөд хэрэглэхгүй байх талаар хүчин чармайлт гаргавал зохино. Олон улсын жишиг хэмжээнд галт зэвсгийг хүний амь насыг хамгаалахын тулд зайлшгүй шаардлагатай үед хэрэглэнэ гэж заажээ.\*\*\*

## 10.4.3 Байцаалтын үед хүчээр дарамтлах

Эрүү шүүлттэй тэмцэх хороо нь албадан саатуулагдсан этгээдийг байцаахдаа бие махбодийн дарамт үзүүлэхийг хориглосон бөгөөд иймэрхүү арга нь хүлээн зөвшөөрөх зүйл биш гэж заасан байдаг.

Хэрвээ сэжигтэн иргэдийн аюулгүй байдалд заналхийлсэн халдлагын талаар мэдэж болзошгүй гэсэн нөхцөлд ч эрүү шүүлт хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжилон харьцах ёсгүй бөгөөд энэхүү аргыг хэрэглэж үл болно. Үүнд: бие махбодийг маш хүнд тарчлаан зовоох, унтуулахгүй байх айлган сүрдүүлэх, хүйтэнд дааруулах удаан хугацаагаар хөгжим чанга тавих зэрэг номхруулах шинжтэй үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Эрүү шүүлттэй тэмцэх хороо Израйлийн цагдаа нарын хэрэглэж байсан эдгээр арга нь даруй зогсоох хэрэгтэй арга хэмжээ болохыг заажээ.<sup>16</sup> /Байцаагдах үед эдлэх эрхүүдийн тухай Бүлэг 9-өөс үзнэ үү./

### Холбогдох хэм хэмжээ

#### Наад захын жишиг дүрэм 54,1 дүгээр зүйл

Хоригдолтой харьцахдаа зөвхөн өөрийгөө хамгаалах, эсхүл оргож зугатаахыг оролдсон, түүнчилэн дагаж мөрдөж байгаа хууль, дүрэмд нийцсэн тушаалийг идэвхитэй болон идэвхи хэлбэрээр эсэргүүцсэн тохиолдолд л хүч хэрэглэж болно. Хүчийг аргагүй хамгаалалтын хэм хэмжээнээс хэтрүүлж болохгүй бөгөөд энэ хэргийн талаар дээд албан тушаалтандаа нэн даруй мэдэгдэх ёстой.

\* Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хуулийн 3 дугаар зүйл

\*\* Наад захын Жишиг Дүрмийн 54 дүгээр дүрэм ба Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг хэрэглэх болон хүч хэрэглэх үндсэн зарчмууд – 16 дугаар зарчим

\*\*\* Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг хэрэглэх болон хүч хэрэглэх үндсэн зарчмууд – 9 дугаар зарчим

### Ишлэл

14. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 20, догол мөр 6

15. Америк Дундын Комиссын Жил бүрийн Илтгэл, 1991-1992 он, Америкийн Улсуудын Байгууллага /Ser.L/V/II.57, хуудас124, Уругвай

#### 10.4.4 Албадлага хэрэглэх

Олон улсын жишиг хэмжээнд албадан саатуулагдсан болон хоригдсон хүмүүст хэрэглэх гав дөнгө, болон номхотгогч цамц, гинж зэрэг номхруулах хэрэгслийг хэрэглэж болохгүй гэж тогтоосон байдаг. Номхруулах хэрэгслийг хэрэглэх арга хэлбэрийг шоронгийн төв захиргаа тодорхойлно. Шийтгэх зорилгоор гав дөнгө болон гинжийг номхруулах хэрэгсэл болгон хэрэглэж болохгүй. Номхруулахдаа шаардлагатай нөхцөл байдал үүсээгүй бол удаан хугацаагаар хэрэглэхгүй байвал зохино.\*

Эмч нарын гүйцэтгэх үүргийн ёс зүйн зарчмын 5-д заасан зарчмыг эрүүлийг хамгаалах ажилтнууд ялангуяа эмч нар хоригдож байгаа болон саатуулагдсан хүмүүсийг номхруулах шинжтэй аливаа ажиллагаанд оролцсон нь уг этгээдийн болон хоригдож байгаа болон саатуулагдсан бусад этгээд, тэрчлэн харгалзагчдын бие, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах зорилготой л биш бол мөн уг этгээдийн бие сэтгэцийн эрүүл мэндэд аюул занал учраагүй байхад уг ажиллагаанд оролцсоныг эрүүлийг хамгаалах ажилтнуутын гүйцэтгэх үүргийн ёс зүйг зөрчсөнд тооцно.\*\*

Албадан саатуулагдсан болон хоригдсон этгээдийг шүүх болон өөр бусад эрх бүхий албан тушаалтны өмнө аваачихдаа номхруулагч хэрэгслийг нь авсан байна.\*\*\*

#### 10.4.5 Биед нэгжлэг хийх

Саатуулагдсан болон хоригдсон этгээдэд биеийн нэгжлэгийг түүнтэй ижил хүйсний хүн хийх бөгөөд нэгжлэг хийлгэж байгаа хүний бие хүний хувьд угаас заяасан нэр төрийг нь хүндэтгэн харьцах ёстой.<sup>17</sup>

#### 10.4.6 Химийн болон шинжлэх ухааны туршилт хийх

Олон улсын жишиг дүрмээр албадан саатуулагдсан болон хоригдсон хүний өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр эмчилгээний болон анагаах ухааны туршилт хийхийг хатуу хориглоно.<sup>18</sup> Энэхүү туршилт нь албадан саатуулагдсан болон хоригдсон хүний эрүүл мэндэд хор учруулж болохуйц тохиолдолд түүний зөвшөөрлийг үл харгалзан үүнийг явуулахгүй байх ёстой.<sup>19</sup>

#### 10.4.7 Сахилгын арга хэмжээгээр дарамтлах

Аливаа шийтгэлийг хуулийн дагуу оногдуулах бөгөөд нэг ч хоригдолд нэг үйлдэлд давхар шийтгэл оногдуулж болохгүй гэж Хүний эрхийн хороо заасан

##### Холбогдох хэм хэмжээ

##### Наад захын жишиг дүрэм 33 дүгээр зүйл

Гав дөнгө, номхруулах цамц, гинж зэргх номхруулах хэрэгслийг шийтгэлийн журмаар хэрэглэж болохгүй. Дөнгө гинжийг номхруулах хэрэгсэл болгон хэзээ ч хэрэгжж болохгүй. Зөвхөн дараах тохиолдолд хэрэглэнэ.

1/ Тээвэрлэх үед оргон зайлахаас сэргийлэх зорилгоор хэрэглэж, шүүх буюу захиргааны байгууллагын мэдэлд өгмөгц суллаж байх

2/ Эмнэлгийн шинжтэй шалтгаанаар, эмчийн заавраар

3/ хоригдол өөртөө буюу бусдад гэм хор учруулах буюу материаллаг хохирол учруулахаас сэргийлж

\* Наад захын Жишиг Дүрмийн 33 болон 34 дүгээр дүрэм, Эмчийн ёс суртахууны тухай үндсэн зарчмын 5 дугаар зарчим, түүнчлэн Европын шоронгийн дүрэм – 39 дүгээр дүрэм

\*\* Эмчийн ёс суртахууны тухай үндсэн зарчмын 5 дугаар зарчим

\*\*\* Наад захын Жишиг Дүрмийн 33 дугаар дүрэм

^ ИУТЭОУП-ын 7 дугаар зүйл

^^ Үндсэн Зарчим 22 дугаар зарчим ба Европын шоронгийн дүрэм – 27 дугаар дүрэм

##### Ишлэл

16. НҮБ-ын баримт бичиг, CAT/C/SR.297/Нэмэлт.1 догол мөр 8

17. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 16, догол мөр 8; Америк Дундын Комисс, Илтгэл №38/96, Хэрэг 10.506, (Аргентина), 66,76 дугаар догол мөрүүд, 1996 оны 10 дугаар сарын 15.

18. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 20, догол мөр 7

байдаг. Хоригдлыг ямар үйлдэлд буруутгаж байгааг урьдчилан мэдээлж, эрх бүхий албан тушаалтнууд нь түүний хэргийн материалтай урьдчилан танилцаж нягт нямбай хянан хэлэлцэж шийдвэрлэх ёстой. Шаардлагатай нөхцөлд хоригдолд орчуулагчаар дамжуулан өөрийгөө хамгаалж харилцах боломж олгоно.\*

Албадан саатуулагдсан болон хоригдсон этгээд өндөр албан тушаалтны хянаж үзсэн хэв журам сахиулах шийдвэрийн дагуу шийтгэгдэх ёстой.\*\*

Харанхуй гянданд хорих болон хэрцгий хүнлэг бус буюу хүний нэр төрийг доромжлон харьцах шийтгэлийн төрлийг сахилгын зөрчил гаргасны төлөө хэрэглэхийг хориглоно.\*\*\*

#### **10.4.8 Эрүү шүүлт болон хүнлэг бус харьцаанаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх эрх**

Эрүү шүүлт болон хүнлэг бус хүний нэр төрийг доромжлон харьцах харьцаанаас хохирогчид хохирлоо нөхөн төлүүлэх, түүний дотор эрүүл мэнддээ аль болох бүрэн сэргээхэд шаардлагатай тохирсон төлбөр авах эрхтэй.^ Хохирлоо нөхөн төлүүлэх хэлбэрт: эрхээ сэргээлгэх, нөхөн төлбөр авах, засан сайжруулах эмчилгээ зэрэг орно.

\* Үндсэн Зарчим 30 дугаар зарчим, Наад захын Жишиг Дүрмийн 29 болон 30 дугаар дүрэм, Европын шоронгийн дүрэм – 35, 36 дугаар дүрэм

\*\* Үндсэн Зарчим 30 дугаар зарчим

\*\*\* Наад захын Жишиг Дүрмийн 31 дүгээр дүрэм, Европын шоронгийн 37 болон 38 дугаар дүрэм

^ Эрүү Шүүлтийн Эсрэг Тунхаглалын 11 дүгээр зүйл, Эрүү Шүүлтийн Эсрэг Конвенцийн 14 дүгээр зүйл болон Эрүү шүүлтийн талаарх Америкийн улсуудын Конвенцийн 9 дугаар зүйл.





ШУДАРГААР  
ШҮҮЛГЭХ ЭРХ

---

## Б ХЭСЭГ

# ШҮҮХ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ҮЕД ЭДЛЭХ ЭРХ

---

- |          |   |
|----------|---|
| Бүлэг 11 | Хууль болон шүүхийн өмнө эрх тэгш байх  |
| Бүлэг 12 | Хуулийн дагуу байгуулагдсан бие даасан, хараат бус болон шударга шүүхээр шүүгдэх эрх                      |
| Бүлэг 13 | Шударгаар шүүгдэх эрх   |
| Бүлэг 14 | Нээлттэй шүүгдэх эрх  |
| Бүлэг 15 | Гэм буруу нь нотлогдоогүй тохиолдолд гэм буруугүйд тооцох   |
| Бүлэг 16 | Сэжигтэн өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх                               |
| Бүлэг 17 | Эрүү шүүлт тулгаж буюу бусад хориотой аргуудыг хэрэглэж цуглуулсан нотлох баримт нотлох чадвараа алдах нь |
| Бүлэг 18 | Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тухайн гэмт хэрэгт зөвхөн нэг удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэх              |
| Бүлэг 19 | Хүндэтгэн үзэх шалтгаангүй тохиолдолд цаг алдалгүй хэргийг шүүхээр хянан шийдвэрлүүлэх эрх                |
| Бүлэг 20 | Өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлөгчийн туслалцаа авах эрх   |
| Бүлэг 21 | Шүүх хуралд оролцох, давж заалдах эрх   |
| Бүлэг 22 | Гэрчийг дуудах ба байцаах мэдээлэл авах эрх   |
| Бүлэг 23 | Орчуулагч авах болон орчуулга хийлгэх эрх   |
| Бүлэг 24 | Шүүхийн шийдвэр   |
| Бүлэг 25 | Шийтгэл   |
| Бүлэг 26 | Давж заалдах эрх  |



## БҮЛЭГ 11

### Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх

Шүүх хурлын явцад эрх тэгш байх баталгааг олон талаар хангасан байдаг. Үүнд хуулиар ялгаварлан гадуурхахыг хориглох болон шүүхэд тэгш эрхтэйгээр хандах, шүүх эрх тэгш харьцах эрхүүд багтана.

#### 11.1. Хуулийн өмнө эрх тэгш байх

#### 11.2. Шүүхийн өмнө эрх тэгш байх

##### 11.2.1 Шүүхэд чөлөөтэй хандах эрх

##### 11.2.2 Шүүх нь хэнийг ч ялгаварлан гадуурхах ёсгүй

### 11.1. Хуулийн өмнө эрх тэгш байх

Хүн бүр хуулийн өмнө тэгш эрхтэй.\* Хуулийн өмнө эрх тэгш байна гэдэг нь хуулиар ялгаварлан гадуурхагдахгүй, шүүгч болон албан тушаалтнууд нь хууль хэрэгжүүлэхдээ ямар нэгэн ялгаварлан гадуурхах хэлбэрийг гаргахгүй байхыг хэлнэ.

Хуулиар адил тэгш хамгаалуулах эрхийн агуулга нь хуулиар болон практикт ямарч тохиолдолд ялгаварлан гадуурхахыг хориглодог бөгөөд үүнийг төрийн байгууллагууд зохицуулж хамгаалж байдаг. Гэхдээ үүнд бүх төрлийн харьцааг ялгаварлахгүй байхыг бус зөвхөн бодит нөхцөлд буюу объектив шалгуурт нийцэхгүй, үндэслэлгүй байгааг ойлгоно.<sup>1</sup>

### 11.2. Шүүхийн өмнө тэгш эрхтэй байх

Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй.\*\* Энэхүү хуулийн өмнө тэгш эрхтэй байх эрх зүйт төрийн ерөнхий зарчим нь хүн бүр шүүхэд тэгш эрхтэйгээр хандах, шүүхээс эрх тэгш харьцах, гэсэн агуулгатай юм.

#### Холбогдох хэм хэмжээ

##### Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 7 дугаар зүйл

Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчилалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү Тунхаглалд харшлах аливаа алагчилалаас болон тийнхүү алагчилахыг өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй.

##### ИУТЭОУП-ын 2 дугаар зүйл

1. Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй.

##### ИУТЭОУП-ын 26 дугаар зүйл

Бүх хүн хуулийн өмнө тэгш байх бөгөөд аливаа алагчлалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрхтэй. Энэ үүднээс аливаа байдлаар алагчилах явдлыг хуулиар хориглох бөгөөд хууль нь арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн байдал буюу бусад байдлаар алагчилахаас бүх хүнийг адил тэгш үр нөлөөтэй хамгаалах баталгааг бүрдүүлэх ёстой.

\* ХЭТТ-ын 7 дугаар зүйл, ИУТЭОУП-ын 2(1), 3 ба 26 дугаар зүйл, Эмэгтэйчүүдийн Эрхийн Конвенцийн 2, 15 дугаар зүйл, Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг конвенцийн 2,5 ба 7 дугаар зүйлүүд, Африкийн Дүрмийн 2 ба 3, ба Америкийн Конвенцийн 8(2) ба 24 дугаар зүйлүүд болон Европын Конвенцийн 14 дүгээр зүйл түүнчлэн Америкийн Тунхаглалын 2 ба 18 дугаар зүйл

\*\* ИУТЭОУП-ын 14(1) дугаар зүйл, Эмэгтэйчүүдийн Эрхийн Конвенцийн 2, 15 дугаар зүйл, Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг конвенцийн 2 ба 5 дугаар зүйлүүд, Югославын Дүрмийн 21(1) дугаар зүйл, Руандагийн 21(1) дугаар дүрэм. Мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 67(1) дугаар зүйлийг үзнэ үү.

#### Ишлэл

1. Броекс болон Голландын хэрэг(172/1984), Хүний Эрхийн Хороо; Зваан-де Вриес ба Голландын хэрэг, (182/1984), Хүний Эрхийн Хороо, 1987 оны 4 дүгээр сарын 9.

Хүний эрхийн хороо Иргэний болон Улс Төрийн Эрхийн Олон Улсын Пактын /ИУТЭОУП/ 14.1-д Энэхүү Пактад оролцогч улс нь түүнд заасан иргэний болон улсын төрийн бүх эрхийг эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эдлэх нөхцлөөр хангахыг шаардсан нь тэгш эрхийн баталгаа болсон хэмээн тэмдэглэжээ.

Перугийн хуулинд шүүхийн өмнө зөвхөн нөхөр нь л гэр бүлийнхээ эд хөрөнгийн эзэмшигч байна заасан байдаг нь Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт-ыг зөрчиж байсныг Хүний эрхийн хороо илрүүлсэн байна.<sup>2</sup>

Гадаадын иргэд шүүхийн өмнө тэгш эрхтэй ба гадаадын иргэд нэгэнт тухайн улсын нутаг дэвсгэрт нэвтрэхээр зөвшөөрөгдсөн бол тэднийг Иргэний болон улс төрийн олон улсын пактад тусгагдсан эрхээ эдлэх эрхтэй гэж Хүний эрхийн хороо тодорхойлжээ. “Гадаадын иргэд шүүх болон тусгай шүүхийн өмнө тэгш эрхтэй.”<sup>3</sup> Энэхүү эрхийг тухайн амьдарч буй улсынхаа иргэн биш бие хүний эрхийн талаарх тунхаглалын 5–р зүйлд зохицуулсан байдаг.

### 11.2.1. Шүүхэд чөлөөтэй хандах эрх

Хүн бүр ялгаварлан гадуурхагдалгүйгээр шүүхэд тэгш хандах эрхтэй.

Зарим улсад эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдийн нэгэн адилаар шүүхэд хандахыг зөвшөөрдөггүй байна. Энэ нь Иргэний болон улс төрийн олон улсын пакт-ын 2, 3, 14, 26-р зүйл болон Эмэгтэйчүүдийн Конвенцийн 2, 15-р зүйлд заасан Олон улсын хэм хэмжээг зөрчиж байгаа юм.

Зарим оронд эмэгтэйчүүдийн шүүхэд мэдүүлэх эрх, шүүхээр хамгаалуулах болон хууль зүйн зөвлөгөө авахыг нь хуулиар хязгаарласан байдаг. Өөрөөр хэлбэл эмэгтэйчүүдийн өгсөн гэрчийн мэдүүлэг болон нотлох баримт нь эрэгтэйчүүдээс бага хүндлэгддэг, ач холбогдол багатайд тооцогддог аж. Ийм хууль, зан заншил нь эмэгтэйчүүдийг эрхээ бүрэн эдлэх болон эд хөрөнгөө адил тэгш хувааж авахыг нь хязгаарлаж биеэ даасан, хариуцлагатай нийгмийн гишүүн болж үнэлэгдэх тэдний байр суурийг хавчин боогдуулж байна гэж Эмэгтэйчүүдийг Ялгаварлан Гадуурхах Явдлыг Устгах Хороо мэдэгджээ.<sup>4</sup>

### 11.2.2. Шүүх нь хэнийг ч ялгаварлан гадуурхах ёсгүй

Эрүүгийн хэргийг шүүхээр адил тэгш авч үзэх хоёр чухал шаардлага тавигддаг. Үүний нэг нь шүүх хуралдаанд бэлтгэх болон шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх шатанд яллах болон өмгөөлөх талын аль алинд нь адил тэгш боломж олгох үндсэн зарчим юм.

Нөгөө нэг хэлбэр нь яллагдаж буй хүн бүр ИУТЭОУП-ын 2-р зүйлд тодорхойлсон ямарваа ялгаварлан гадуурхах явдалд өртөлгүйгээр бусад ижил төстэй гэмт хэрэгтний адил тэгш харьцуулах эрх эдэлнэ гэдэг нь ижил харьцах гэсэн үг биш харин бодит байдал, факт хэрхэн ижил төстэй байна тэнд шүүхийн хариу шийдвэр нь ижил байна гэсэн үг юм.\*

Хэрвээ шүүхийн эсвэл захиргааны шийдвэр ялгаварлан гадуурхах явдалд үндэслэвэл тэгш эрх зөрчигдөнө.

#### Холбогдох хэм хэмжээ

#### ИУТЭОУП-ын 14 дүгээр зүйл

1. Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй.

\* Эмэгтэйчүүдийн Эрхийн Конвенцийн 15 дугаар зүйл, Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг конвенцийн мөн 5 дугаар зүйл

#### Ишлэл

2. Ато де Авелланал ба Перу (202/1986), 1988 оны 10 дугаар сарын 28, Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл, (A/44/40), 1989 он, хуу 196

3. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 15, догол мөр 1 болон 7.

4. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн зүйлүүдийн Ерөнхий Тайлбар, 1996 оны 9 дүгээр сарын 24.



Эрүүгийн хэрэгт холбогдсон этгээдийг тухайлбал, эд материал эвдэж сүйтгэсэн хүнд “улс төрийн” юм уу “энгийн гэмт хэргийн сэдэлтэй үйлдсэн эсэхээс түүнд түүнд ижил баталгаа олгох асуудал гарч болно. Мөн хүйсийн ялгаварлалаар гэрчүүдийн мэдүүлгийг өөрөөр дүгнэх явдал нь шүүх тэгш харьцах эрхийг зөрчдөг өөр нэгэн тохиолдол юм.

Хуулиар болон практик дээр ялгаварлан гадуурхагдалгүйгээр эрх тэгш байх баталгааг засгийн газар бүр хангах стратеги зорилтыг хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн талаар Бээжингийн Тунхаглалд тодорхойлсон байдаг. Үүнд нь шүүх засаглал нь хүйсийн асуудалд эсрэг байр суурьтай байх болон хүйсээр ялгаварлан гадуурхах ямарч хууль тогтоомжийг хэрэглэхгүй байх тухай заасан байдаг.<sup>5</sup>

### **Холбогдох хэм хэмжээ**

#### **ХЭТТ-ын 10 дугаар зүйл**

Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.

### **Ишлэл**

5. Эмэгтэйчүүдийн талаарх Олон Улсын 4 дүгээр Бага Хурал, НҮБ-ын баримт бичиг, А/CONF.177/20, 1995 оны 10 дугаар сарын 17, хуудас 99.

## Бүлэг 12

### Хуулийн дагуу байгуулагдсан, бие даасан, хараат бус, шударга шүүхээр шүүгдэх эрх

Шударга шүүхийн үндсэн зарчим болон урьдчилсан нөхцөл нь тухайн хэргийг шийдвэрлэхдээ хуулийн дагуу байгуулагдсан шүүх нь бие даасан, хараат бус байж шударга шийдвэр гаргах явдал юм.

12.1 Хараат бус, бие даасан, шударга шүүхээр шүүгдэх эрх

12.2 Хуулийн дагуу байгуулагдсан шүүхээр шүүгдэх эрх

12.3 Эрх мэдэл бүхий шүүхээр шүүгдэх эрх

12.4 Бие даасан шүүхээр шүүгдэх эрх

12.4.1 Эрх мэдэл хуваарилах

12.4.2 Шүүгчийг томилох ба түүний ажиллах нөхцөл

12.4.3 Хэрэг хуваарилалт

12.5 Шударга шүүхээр шүүгдэх эрх

12.5.1 Шүүхийн хараат бус байдал

#### 12.1 Хараат бус, бие даасан хараат бус, шударга шүүхээр шүүгдэх эрх

Шүүхийн шударга үйл ажиллагааны үндсэн баталгаа бол тухайн шийдвэрийг ямар нэгэн улс төрийн байгууллага биш харин хуулийн дагуу байгуулагдсан, эрх мэдэл бүхий, хараат бус, шударга шүүх хянан шийдвэрлэж буй явдал юм. Хувь хүний шүүхэд хандах эрх нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь гэм буруутай гэгдэж буй этгээдийн баталгааны хамтаар тухайн хуулийн процессийн амин чухал асуудал юм.

Эрүүгийн шүүн таслах ажиллагаанд оролцож байгаа эсвэл гомдол гаргасан хүн бүр хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, бие даасан, хараат бус шүүхээр шүүгдэх эрхтэй.\*

Бие даасан, хараат бус шүүхээр шүүлгэх эрх нь Хүний Эрхийн Хорооны дурьдсан “салгаж болшгүй хүний туйлын эрх”-ийн үндэс суурь юм.<sup>1</sup>

Шүүхийн баталгаа нь Америкийн Конвенцийн дагуу улс орны онц байдлын үед ч эрх бүхий, бие даасан, шударга шүүхээр шүүлгэх зэрэг хүний эрхийг хамгаалах шаардлагатай юм.\*<sup>2</sup> **Бүлэг 31, Онцгой нөхцөл байдал үүссэн үед шударгаар шүүгдэх эрхийг үзнэ үү.**

#### Холбогдох хэм хэмжээ

##### ХЭТТ-ын 10 дугаар зүйл

Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.

##### ИУТЭОУП-ын 14.1 дүгээр зүйл

Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, хараат бус, тал үл харах шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.

\* ХЭТТ-ын 10 дугаар зүйл, ИУТЭОУП-ын 14(1) дүгээр зүйл, Америкийн Конвенцийн 8(1) ба 27(2) дугаар зүйлүүд, Америкийн Тунхаглалын 26 дугаар зүйл, Европын Конвенцийн 6(1) дүгээр зүйл, Африкийн Дүрмийн 7(1) ба 26 дугаар зүйл түүнчлэн Шүүх байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчмууд

#### Ишлэл

1. Гонзалез де Рио ба Перу (263/1987), 1992 оны 10 дугаар сарын 28, Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл, (A/48/40), 1993 он, хуудас 20.

Эрх бүхий, бие даасан шүүхээр шударгаар шүүлгэх эрхэд тавигдах шаардлага урьдчилсан шаардлага бол “шударга ёс зөвхөн хэрэгжих биш, хэрэгжсэн нь ил тод харагдах ёстой байдаг” юм.<sup>3</sup>

Аливаа стандартууд шүүхээс илүүтэй трибуналд хэрэглэгддэг. Европын шүүх нь Трибунал бол тогтоосон арга журмын дагуу болон эрх зүйт ёсны үндсэн дээр өөрийн эрх хэмжээний хүрээнд хэргийн шийдвэрлэхээр хуулийн дагуу байгуулагдсан шүүх чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага юм гэж тодорхойлсон.<sup>4</sup>

## 12.2 Хуулийн дагуу байгуулагдсан шүүхээр шүүгдэх эрх

Хэрэг шийдвэрлэж байгаа шүүх заавал хуулийн дагуу байгуулагдсан байх ёстой.\*\* Хуулиар байгуулагдсан шүүх нь Үндсэн хууль эсхүл хууль тогтоох байгууллагын гаргасан бусад хуулийн хүрээнд болон нийтийн эрх зүйн дагуу байгуулагдсан байх ёстой.

Эрүүгийн хэрэг бүрт зориулан шинэ шүүх /трибунал/ байгуулахгүйн тулд энэ шаардлагыг юм.\*\*\*

## 12.3 Эрх мэдэл бүхий шүүхээр шүүгдэх эрх

Эрх мэдэл бүхий шүүхээр шүүлгэх эрх гэдэг нь тухайн шүүх хэргийг харъяалан шийдвэрлэх эрх мэдэлтэй байхыг шаарддаг.

Хуульд заасны дагуу шүүхэд тухайн хэргийг шийдвэрлэх эрх мэдэл олгогдсон байдаг буюу хэргийн агуулга болон этгээдийн хувьд шүүхийн харъяалал тодорхойлогдох ба аливаа шүүх ажиллагаа хуульд заасан хугацаанд явагдана.

## 12.4 Бие даасан шүүхээр шүүгдэх эрх

Шударга шүүхийн үндэс нь шүүхийн бие даасан байдал юм. Энэ нь шийдвэр гаргагч нар тухайн хэргийг эрх мэдлийн аль нэг салбаа мөчир болон бусад хэн нэгний нөлөөлөл болон дарамт шахалт, хөндлөнгийн оролцоогүйгээр хуулийн дагуу, бодит нөхцөл байдал дээр тулгуурлан бие даан чөлөөтэй шийдвэрлэнэ гэсэн үг юм. Мөн түүнчлэн шүүгчээр томилогдож байгаа хүмүүсийг тэдний хууль, эрх зүйн мэргэжлийн ур чадварыг үндэслэн сонгосон байх ёстой гэсэн үг юм.

Шүүхийн бие даасан байдалд нөлөөлөх хүчин зүйлүүдийг Шүүхийн Бие даасан байдлын Үндсэн Зарчимд тусгаж өгсөн байдаг. Үүнд зүй бус гадны нөлөө эсхүл хөндлөнгийн оролцооноос шүүхийг хамгаалах эрх мэдлийн хуваарилалт болон техник хангамж ба шүүгчийн ажил албан тушаалын найдвартай байдал зэрэг бие даасан байдлын бодит хамгаалалтыг тусгасан байна.

### Холбогдох хэм хэмжээ

### Шүүх байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчмууд 5 дугаар зарчим

Хүн бүр хэргээ хуулиар тогтоосон байцаан шийтгэх журам хэрэглэдэг ердийн буюу тусгай шүүхээр хянуулан, шийдвэрлүүлэх эрхтэй.

\* Америкийн Конвенцийн 27(2) дугаар зүйл.

\*\* ИУТЭОУП-ын 14(1) дугаар зүйл, Америкийн Тунхаглалын 26 дугаар зүйл, Америкийн Конвенцийн 8(1) дугаар зүйл<sup>5</sup>, Европын Конвенцийн 6(1) дүгээр зүйл, болон Африкийн Дүрмийн 26 дугаар дүрмийг үзнэ үү.

\*\*\* Шүүх байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчмуудын 5 дугаар зарчмыг үзнэ үү.

### Ишлэл

1. Америк Дундын Шүүх, Зөвлөх санал OG-8/87, 1987 оны 1 дүгээр сарын 30, “Habeas Corpus Онц Байдал”, 1987, OAS/Ser.L/V/III.17 баримт бичиг 13, 1987; “Онц Байдлын үе дэх шүүхийн баталгаа”, Зөвлөмж санал OC-9/87 of 6 October 1987, Америк Дундын Шүүхийн жил бүрийн илтгэл, 1988, OAS/Ser.L/V/III.19 баримт бичиг 13, 1988
2. Европын шүүх, Делкоуртын хэрэг, 1970 оны 1 дүгээр сарын 17, цуврал 11-А 17, догол мөр 31
3. Хүний эрхийн Европын Шүүх, Срамекийн хэрэг, цуврал 84-А 17, 39-р тал, 1984 оны 10 дугаар сарын 22, Ван Леувэн болон Де Мейерэ нарын хэрэг, цуврал 43-А 24, 55-р тал, 1981 оны 7 дугаар сарын 23
4. Америкийн Конвенц шүүх хуулийн дагуу урьдчилан байгуулагдсан байхыг шаарддаг.

### 12.4.1 Эрх мэдэл хуваарилах

Ардчилсан нийгэмд эрх мэдлийн хуваарилалт нь шүүхийн бие даасан байдлыг хангах үндэс болдог.<sup>6</sup> Төрийн байгууллага болгон өөрийн гэсэн тусгай онцлог чиг үүрэгтэй байдаг. Шүүх нь байгууллагынхаа хувьд, шүүгч нар нь хувь хүнийхээ хувьд өөрт ноогдсон хэргүүдийг шийдвэрлэх онцгой эрх мэдэлтэй байх ёстой.

Шүүх нь бүхэлдээ болон шүүгч бүрийн хувьд төрийн эсхүл хувь хүний хөндлөнгийн оролцооноос ангид байх ёстой. Шүүхийн бие даасан байдлыг хуульд тодорхой зааж, төрөөс баталгаажуулах ба төрийн бүх байгууллагууд шүүхийг хүндэтгэх ёстой. Төрөөс шүүхийн захиргааны үйл ажиллагаанд улс төрийн болон бусад хөндлөнгийн оролцооноос хамгаалсан үйл ажиллагааны болон бүтцийн хамгаалалт хийх ёстой.\*

Шүүхийн бие даасан байдал нь шүүхийг шүүн таслах ажиллагаатай холбоотой бүх асуудалд онцгой эрх мэдэлтэй байхыг шаарддаг. Энэ нь хорих ялыг хөнгөрүүлэх болон уучлал үзүүлэхээс бусад асуудлаар шүүхийн шийдвэрийг аль нэг оролцогч талын ашиг сонирхолд нийцүүлэн аль нэг шүүхийн бус байгууллага хөндлөнгөөс оролцон өөрчилж болохгүй гэсэн үг.\*\*

Шүүхийн бие даасан байдал нь шүүхийн захиргааны ажлыг хариуцсан албан тушаалтнууд нь яллах асуудлуудыг хариуцсан албан тушаалтнуудаас бүрэн бие даасан байхыг шаарддаг. Заримдаа шүүхийн хараат бус байдалд хөндлөнгийн оролцоо шууд ордог.\*\*\*

\* Шүүх байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчмуудын 1 дүгээр зарчим.

\*\* Шүүх байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчмуудын 3 ба 4 дүгээр зарчмуудыг үзнэ үү.

\*\*\* Прокурорын ажилтны үүргийн 10 дах удирдах зарчим

#### Холбогдох хэм хэмжээ

#### Шүүх байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчим

##### 2 дугаар зүйл

Шүүх байгууллага нь хэргийг шийдвэрлэхдээ юуны өмнө бодит фактад үндэслэн, хуулийн дагуу, аливаа хязгаарлалт зүй бус нөлөөлөл, шан харамж, айлган сүрдүүлэлт зэрэг шууд ба шууд бус хөндлөнгийн оролцоогүйгээр хараат бусаар шийдвэрлэнэ.

##### 1-р зарчим

Шүүх байгууллагын бие даасан байдал нь тухайн улсын үндсэн хууль болон бусад хуульд баталгаажсан байдаг. Шүүхийн бие даасан байдлыг хүндэтгэн дагаж мөрдөх нь бүх засгийн газрын болон бусад байгууллагын үүрэг юм.

##### 3-р зарчим

Шүүх байгууллага нь шүүхэд хамраах бүх хэрэгт шүүн таслах ажиллагаа явуулах эрхтэй бөгөөд хуулиар олгодсон хэмжээнийхээ хүрээнд түүнийг шийдвэрлэх онцгой бүрэн эрхтэй.

##### 4-р зарчим

Шүүх ажиллагаанд зохисгүй эсвэл баталгаагүй яиар нэг хөндлөнгийн оролцоо болон шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах явдлын аль аль нь байж болохгүй.

#### Прокурорын ажилтны гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 10 дугаар зүйл

Яллах байгууллага нь шүүх чиг үүргээс хатуу тусгаарлагдсан байх ёстой.

#### Ишлэл

6. Куб дах Хүний Эрхийн Төлөв байдлын талаарх 7 дах Илтгэл, 1983, Америкийн Улсуудын Байгууллага, Ser.L/V/II.61, баримт бичиг 29; Экуадор дах Хүний Эрхийн Төлөв Байдлын Талаарх Илтгэл, Америкийн Улсуудын Байгууллага, Ser.L/V/II.96, баримт бичиг 10, 1 дэх хэвлэл, 1997 оны 4 дүгээр сарын 24

Африкийн комисс нь Засгийн газартай холбоотой хэргийг шүүх авч хэлэлцэхгүй байх талаар гаргасан Нигерийн Засгийн газрын 2 тогтоолыг авч хэлэлцсэн байна. Уг комисс үүнийг Африкийн тунхаглалын шүүх эрх мэдэлтэй холбогдох 7-р заалт, шүүхийн бие даасан байдлын тухай 26-р заалтуудад заасан баталгаануудыг тус тус зөрчиж байна гэж үзсэн. Комисс нь “шүүхийн харъяаллын ийм төрлийн сөрөг нөлөөлөл бол шударга бус зүйл, учир нь энэ нь өөрөө хүний эрхийн зөрчил бөгөөд цаашилбал бусад хүний эрхийн зөрчлүүдийг шийтгэх арга хэмжээ авалгүйгээр өнгөрөөхөд хүргэдэг” гэж үзсэн байна.<sup>7</sup>

Америк дундын комисс муж улсуудынхаа шүүхийн бие даасан байдалд шүүмжлэлтэй ханджээ. Үүнд Засгийн газруудын ашиг сонирхолтой зөрчилдсөн шийдвэр гаргасан шүүгч нарыг халах эсхүл шилжүүлэх, шүүгч нарын нэрийг дэвшүүлэхдээ тогтоолыг шүүхээр хүлээн зөвшөөрүүлэх гэх мэт зүйлүүд байгааг шүүмжилсэн байна. Мөн Чили улсад шүүх эрх мэдэл өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлж чадахгүй байгаа болон хүний эрхийн зөрчлийн талаархи гомдлыг хянан шалгаж чадахгүй байгааг, түүнчилэн Перуд терроризмын хэрэгт оролцсон шүүгч нарын нууцлал, аюулгүй байдлыг хангах тогтолцоог шүүмжилсэн байна. (Ил тод шүүгдэх эрхийг зөрчих 14.4 бүлгээс үзнэ үү.)<sup>8</sup>

Зарим улсад шүүх эрх мэдлийн тогтолцоо нь эрх мэдэл хуваарилах зарчмын шаардлагыг хангаж чадахгүй байна. (Тусгай шүүх ба цэргийн шүүх 29-р заалтыг үзнэ үү.)

Америк Дундын Комисс Никарагуагийн эрүүгийн шүүхийн ажиллагааг хянаж үзээд эрх барьж буй намын дэмжигч нар болох цагдаагийн бэлтгэл офицеруудаас шүүгчдийг гол төлөв бүрдүүлдэг байсан нь бие даасан, хараат бус шүүхэд хандах эрхийг зөрчсөн байна гэж үзжээ.<sup>9</sup>

Мөн Колумба ба Чили улсын цэргийн шүүийн бие даасан байдал хангалтгүй байгааг илрүүлсэн байна.<sup>10</sup>

Тухайн шүүхийн бие даасан байдлыг нь тодруулах зорилгоор Европын Комисс болон Шүүх шийдвэр гаргагч нарыг гүйцэтгэх эрх мэдлийн субъект болж чадаж байгаа эсэхийг хянаж байна.

Европын Комисс цэргийн шүүхийг шалгаж үзээд тэднийг бие даасан гэж үзсэн байна. Хэдийгээр шүүгчид цэргийн албан хаагч нар байсан боловч тэд зөвхөн арми, зэвсэгт хүчний албан хаагчийнхаа хувьд тэдний удирдлага дор байгаа субъект юм. Харин тэд шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхдээ шүүх чиг үүргийн хувьд дээд тушаалын албан тушаалтнуудаасаа хараат бус байсан байна.<sup>11</sup>

Гэсэн ч Европын шүүх Европын конвенцийн 6-р зүйлийн дагуу оюутнуудыг зөвшөөрөгдөөгүй жагсаалд оролцсоных нь төлөө шийтгэсэн хотын цагдаагийн зөвлөлийн шүүн таслах ажиллагааны бие даасан байдал хангалтгүй байгааг тэмдэглэсэн байна. Цагдаагийн зөвлөлийг уг журамд харьяалагддаггүй цагдаагийн ажилтан удирддаг ч дээрх албан тушаалд ажиллаагүй байх хугацаандаа цагдаагийн албан хаагчийн бусад үүргийг гүйцэтгэсээр байжээ.<sup>12</sup>

Шүүх тэмдэглэхдээ жирийн иргэд энэ этгээдийг цагдаагийн хүчний байгууллагад харьяалагддаг нэг гишүүн, өөрийн ахлагчид болон хамт ажиллагсаддаа төвийг сахидгай этгээд гэж үздэг.

## Ишлэл

- Иргэний Эрх Чөлөөний Байгууллага ба Нигер, (129/93), Африкийн Комиссын жил бүрийн 8 дах Илтгэл, 1994-1995 он. Хүний болон Улс Түмний Эрхийн тухай Африкийн Комисс /RPT/8th
- Чили дах Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл, 1985 он, Америкийн Улсуудын Байгууллага /Ser.L/V/II.66, 36-45 хуудас, Америк дундын Комиссын жил бүрийн илтгэл, 1996 он, Америкийн Улсуудын Байгууллага/Ser.L/V/II.95, баримт бичиг 97, хуудас 736.
- Америк Дундын Комиссын жил бүрийн Илтгэл, 1982-1983, Америкийн Улсуудын Байгууллага, Ser.L/V/II.61, баримт бичиг 22, 1 дэх хэвлэл, 1981он; Америк Дундын Комиссын жил бүрийн Илтгэл, 1983-1984, Америкийн Улсуудын Байгууллага, Ser.L/V/II/63, баримт бичиг 22.
- Америк Дундын Комисс, Колумбын Хүний эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл, Америкийн Улсуудын Байгууллага /Ser.L/V/II.53, баримт бичиг 22, хуудас 222; Америк Дундын Комисс, Чили дах Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл, 1985 он, Америкийн Улсуудын Байгууллага /Ser.L/V/II.66, баримт бичиг 17, 1985 он, хуудас 286, догол мөр 8.
- Сүттер ба Швейцари (8209/78) 1979 оны 3 дугаар сарын 1, 16DR166
- Белилосын хэрэг, 1988 оны 4 дүгээр сарын 29, цуврал 132 А 30.

### 12.4.2 Шүүгчийг томилох ба түүний ажиллах нөхцөл

Шүүхийн үйл ажиллагааны бие даасан байдал ба эрх мэдлийг хуваарилахын тулд шүүгч нарыг сонгох болон тэдний ажлын нөхцлийн талаар олон улсын стандартууд байдаг. Тэдгээрийн ихэнхи нь шүүн таслах ажиллагааны хараат бус байдлуудын тухай үндсэн зарчмуудад тодорхойлогдсон.

Шүүхийн үйл ажиллагааны хараат бус байдлыг хамгаалахын тулд шүүгч нарыг тухайн хүний эрх зүйн мэдлэг, мэргэшил, дадлага туршлагын үндсэн дээр сонгосон байхыг шаарддаг. Шүүгч нарыг тодорхой бус шалтгаанаар сонгож болохгүй бөгөөд тэд зүй зохистой мэргэшсэн байх ёстой.\* Шүүгч нарыг дээгүүр албан тушаалд дэвшүүлэхэд чадвар туршлага гэх мэт объектив үзүүлэлтүүдийг нь харгалзан үзсэн байх ёстой.\*\*

Төрөөс шүүхийг үйл ажиллагаагаа явуулахад нь зориулж хангалттай хангамжаар хангасан байх ёстой ба шүүгчдэд хангалттай цалин, тэтгэвэр олгох ёстой. Шүүгч нарын ажиллах хугацаа, нөхцөл, тэтгэвэрт гарах насыг хуулиар тодорхойлсон байх ёстой.\*\*\*

Хүний эрхийн Хороо Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14-р зүйлийн дагуу шударга шүүхэд хандах эрхийг хэрэгжүүлэхэд АНУ-ын хэд хэдэн мужуудад шүүгч нарын сонголтонд гадны нөлөөлөл байгааг дурдсан байна. Хүний эрхийн Хороо нь шүүгч нарын гавъяа зүтгэлийг үндэслэн бие даасан байгууллага томилох тогтолцоог санал болгосон. Мөн тус хороо АНУ-ын хэд хэдэн орон нутгийн шүүхийн үйл ажиллагааг мэргэжлийн бус, зохих мэдлэг боловсролгүй хүн явуулж байгааг дурьдсан байна.<sup>13</sup>

Хүний эрхийн Хороо Суданы шүүх эрх мэдлийн байгууллага нь хараат бус, бие даасан байж чадахгүй байгаа талаар дурьдсан байна. Үүнд шүүгч нарыг эрх зүйн мэдлэгтэй эсэхийг нь харгалзалгүйгээр сонгосон гэжээ. Түүнчлэн шүүгч нарын орон тоон дээр маш цөөхөн мусалим шашинтан бус хүн болон эмэгтэйчүүд ажилладаг. Иймээс шүүгч нар төр захиргаа, хяналтын байгууллагуудын дарамт шахалтанд ордог гэсэн байна.<sup>14</sup>

Шүүхийн хараат бус байдлыг хангахын тулд шүүгч нар шийдвэр гаргах бие даасан байдлаар хангагдсан байх ёстой. Тэдний гаргасан шийдвэрт ямар нэгэн улс төрийн хариу үйлдлээс ангид байна гэдгийг шүүгч нар мэдэж, мэдэрч байх ёстой. Томилогдсон эсхүл сонгогдсон ч бай, шүүгч нар тэтгэвэрт гарах нас хүртэл эсхүл тухайн албан тушаалын хугацаа дуусах хүртэл албан

#### Холбогдох хэм хэмжээ

##### Шүүхийн хараат бус байдлын үндсэн зарчим- 10 дугаар зүйл

Шүүхийн албан тушаалд шилж шалгаруулсан этгээд нь ёс зүйн өндөр чанар, чадвар, түүнчлэн эрх зүйн салбарт зохих бэлтгэл, мэргэжил эзэмшсэн байх ёстой. Шүүгчийг шилж шалгаруулах аливаа арга нь шүүгчийг хууль бус сэдлээр томилох явдал гаргуулахгүй байх ёстой. Шүүгчийг сонгон шалгаруулахдаа үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, шашин шүтлэг, улс төрийн ба бусад итгэл үнэмшил, үндэсний болон нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлаар ялгаварлан гадуурхаж болохгүй.

##### 11 дүгээр зарчим

Шүүгчдийн бүрэн эрхийн хугацаа, тэдний хараат бус байдал, аюулгүй байдал, зохих урамшил, ажиллах нөхцөл, тэтгэвэр болон тэтгэвэрт гарах нас нь зохих ёсоор хуулиар баталгаажсан байна.

\* Шүүх байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчмуудын 10 дугаар зарчим

\*\* Шүүх байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчмуудын 13 дугаар зарчим

\*\*\*Шүүх байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчмуудын 7 ба 11 дүгээр зарчим

#### Ишлэл

13. АНУ: Хүний Эрхийн Төлөв Байдлын Судалгааг Дүгнэх нь, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП/С/79/Нэмэлт 50, 1995 оны 4 дүгээр сарын 7, догол мөр 23

14. Судан: Хүний Эрхийн Төлөв Байдлын Судалгааг Дүгнэх нь, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП/С/79/Нэмэлт 85, 1997 оны 11 дүгээр сарын 19

тушаалаа хэвээр хашина гэсэн баталгаа байх ёстой. Өөрийн албан үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон эсхүл уг албан тушаалд харшлах үйл ажиллагаа явуулсан зэрэг тохиолдлуудад л тэднийг албан тушаалаас нь чөлөөлөх эсхүл эгүүлэн татаж болно.\*

Шүүгч ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд албан тушаалаас нь түтгэлзүүлэх, огцруулах зэрэг сахилгын арга хэмжээ авч болно. Шүүгчийн буруутай үйл ажиллагаанаас үүссэн хохирлыг төр нөхөн төлөх үүрэг хүлээж болно. Гэсэн ч шүүгч нар өөрийн албан үүргээ гүйцэтгэх үед тэдний зүй бус үйл ажиллагаанаас болж учирсан хохирол талаарх иргэний хэрэгт халдашгүй эрхтэй байна. Шүүн таслах ажиллагаатай нь холбоотой шүүгч нарын эсрэг гаргасан өргөдөл гомдлыг шударга зарчмаар авч хэлэлцсэн байх ёстой.\*\*

Хүний эрхийн Хороо Белоруссад БНУ-ын Ерөнхийлөгч ямар ч хамгаалалт баталгаагүйгээр Үндсэн хуулийн болон Дээд шүүхийн шүүгч нарыг огцруулах боломжтой байгааг анхааруулсан байна. Ерөнхийлөгч 2 шүүгчийг төрөөс тогтоосон торгуулийг ногдуулж, цуглуулж чадахгүй байна гэж огцруулжээ. Тус хороо нь Белорусс дахь шүүгч нарыг огцруулах, шийтгэх, албан тушаалд нь хэвээр байлгах үйл ажиллагаа нь шүүхийн хараат бус байдлын зарчимтай нийцэхгүй байна гэж үзсэн.<sup>15</sup>

### 12.4.3 Хэргийн хуваарилалт

Тухайн шүүхийн эрх мэдэлд байгаа хэргийг шүүх дотроо шүүгч нарт хуваарилах нь шүүхийн захиргааны дотоод асуудал мөн.\*\*\*

Хэрэв уг хэрэг нэгээс илүү шүүхэд харьяалагдах бол тухайн хэргийг аль шүүх авч хэлэлцэхийг дээд шатны шүүх нь шийдвэрлэх ба ингэхдээ объектив хүчин зүйлст үндэслэнэ.

### 12.5 Хараат бус шүүхээр хэргээ шүүлгэх эрх

Шүүх шударга байх ёстой. Шударга байх зарчим хэрэг болгонд хэрэгжих бөгөөд шийдвэр гаргадаг этгээдээс (мэргэжлийн болон орон тооны бус шүүгч эсхүл иргэдийн төлөөлөгч jury) урьдчилан шийдвэр гаргахгүй байх ёстой.<sup>16</sup>

Бодитоор шударга байх болон шударга байдлын илрэл нь шүүх үйл ажиллагааг хүндэтгэх үндэс болно.

#### Холбогдох хэм хэмжээ

##### Шүүх байгууллагын бие даасан хараат бус байдлын үндсэн зарчим 18-р зарчим

Шүүгчдийг зөвхөн үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон буюу эсхүл эрхэлж буй албан тушаалдаа нийцэхгүйгээр биеэ авч явсан шалтгаанаар албан тушаалаас нь түр зайлуулах буюу халж болно.

##### 19 дүгээр зарчим

Албан тушаалаас нь түр зайлуулах буюу халах шийгэх бүх журам нь шүүгчийн ёс зүйн дүрмээр тодорхойлогдвол зохино.

##### 20 дугаар зарчим

Сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас нь түр зайлуулах буюу халах тухай шийдвэрийг хараат бус байдлаар хянана.

\* Шүүх байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчмуудын 12 ба 18 дугаар зарчим

\*\* Шүүх байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчмуудын 16,17,19 болон 20 дугаар зарчим

\*\*\* Шүүх байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчмуудын 14 дугаар зарчим

#### Ишлэл

15. Беларус: Хүний Эрхийн Төлөв Байдлын Судалгааг Дүгнэх нь, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП /С/79/Нэмэлт 86, 1997 оны 11 дүгээр сарын 19, догол мөр 13  
16. Каргуннен болон Финландын хэрэг, (387/1989), 1992 оны 10 дугаар сарын 23, Хүний эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл, боть 2, (А/48/40), 1993 он, хуудас 120; Соллинс ба Ямайка, (240/1987), 1991 оны 11 дүгээр сарын 1, Хүний эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл, (А/47/40), 1992 он, хуудас 236, догол мөр 8.4.

\* Шүүх байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчмуудын 6 дугаар зарчим

\*\* Шүүх байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчмуудын 2 дугаар зарчим

\*\*\*Шүүх байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчмуудын 8 дугаар зарчим

## Ишлэл

17. Каргуннен болон Финландын хэрэг, (387/1989), 1992 оны 10 дугаар сарын 23, Хүний эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл, боть 2, (A/48/40), 1993 он, хуудас 120

18. Фей ба Австрийн хэрэг, 1993 оны 2 дугаар сарын 24, цуврал 255 A 13, догол мөр 34

19. Каргуннен болон Финландын хэрэг, (387/1989), 1992 оны 10 дугаар сарын 23, Хүний эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл, боть 2, (A/48/40), 1993 он, хуудас 120

20. Үндсэн Хуулийн Эрхийн Төсөл, (Замани, Лаквот болон бусад 6 хүний нэрийн өмнөөс) Нигерийн Хэрэг, (87/93), Африкийн Комиссын жил бүрийн 8 дах Илтгэл, 1994-1995 он. Хүний болон Улс Түмний Эрхийн тухай Африкийн Комисс /RPT/8th

Шударга шүүхээр шүүлгэх эрх нь шүүгч ба иргэдийн төлөөлөгч нар тухайн хэрэгт ямар нэгэн ашиг сонирхолгүй байх бөгөөд түүний тухай урьдчилан бий болсон ямар нэгэн бодол байхгүй байхыг шаарддаг.

Шүүх нь тухайн үйл ажиллагаа, журам зөв шударга явж байгаа болон талуудын эрхийг хүндэтгэсэн байхыг шаарддаг.\*

Хүний Эрхийн Хороо шударга байна гэдгийг “шүүгч нарыг тэдний өмнө тавьж байгаа асуудлын хувьд ямар нэгэн урьдчилсан бодолтой байх ёсгүй ба аль нэгэн талын сонирхолыг дэмжих зорилгоор ажиллах ёсгүй” гэж үзэж байгаа.<sup>17</sup>

Европын шүүх үүнийг “шүүгч нар хэрэг шийдвэрлэхээс өмнө тогтсон урьдчилсан таамаглалтай байх ёсгүй” гэж үздэг.<sup>18</sup>

Тухайн нөхцөл байдлыг зөвхөн нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэх ёстой ба үйл баримтууд хэрэглэгдэх хуулийн хүрээнд шийдэгдсэн байх ёстой. Энд ямар нэгэн хөндлөнгийн оролцоо, хориг, дарамт шахалт эсхүл заналхийлэл байхгүй байх ёстой\*\*

Шүүгч өөрийн албаны нэр төр, шүүхийн хараат бус байдлыг хадгалах хэмжээнд биеэ зөв авч явах ёстой.\*\*\*

### 12.5.1 Шүүхийн шударга байдлыг сорих

Шүүхийн шударга байдлыг шалгах нь тухайн үйл ажиллагааны бусад хэсэгт шийдвэр гаргадаг шүүгч өөр этгээдийн хувьд оролцох, мөн шүүгч нар тухайн үйл ажиллагаанд ямар нэгэн хувийн сонирхлоор оролцох эсхүл аль нэг талтай харилцаатай байх зэрэг олон янзын шалгуураар авч үздэг.

Хүний Эрхийн Хорооны шүүхүүдийн шударга байдлыг дараах 2 тестээр шалгадаг. Эхнийх нь бол объектив тест. Үүгээр тухайн шүүгчийг ямар нэгэн хувийн эргэлзээ болон сонирхол байхгүй гэсэн хангалттай баталгаа гаргадаг. /Энэ тестийн дагуу аль нэг талд хувийн сонирхолгүй гэсэн баталгаа гаргадаг. Дараагийнх нь бол субъектив, хувийн ашиг сонирхолыг субъектын хувьд шалгадаг тест. Хэдийгээр хэргийн аль нэг талд орох хандлагыг болон аль нэг талд бодитоор оролцох гэж тооцсон ч энд үндэсний хуулийн дагуу явагдах үйл ажиллагааны хүрээнд аль нэг талаар нотолгоо гаргаагүй тохиолдолд аль нэг шүүгч / иргэдийн төлөөлөгчийг/ шударга байна гэсэн үг гэсэн ерөнхий ойлголтыг ашиглана.

Хүний Эрхийн Хороо тэмдэглэхдээ хэрэв шүүгчийг шаардлага хангаагүй гэж үзэх үндэслэл хуульд заасан тохиолдолд үндэсний шүүх энэ заалтуудыг авч үзээд шалгуур үзүүлэлтүүдийг хангаагүй шүүгчийг өөрчлөх ёстой.<sup>19</sup>

Нэг шүүгч ба зэвсэгт хүчний 4 гишүүнээс бүрддэг цэргийн тусгай шүүхийг бий болгож түүнд иргэний эсэргүүцлийн хэргүүдийг шийдвэрлэх эрхийг олгосон нь Африкийн Тунхаглалын 7-1-д ийн заалтыг зөрчиж байна гэж Африкийн комисс үзсэн. Комисс энэхүү шүүхийн гишүүдээс үл хамааран түүний бүтэц дангаараа шударга бус боломжийг бүрдүүлдэг гэж үзсэн.<sup>20</sup>

Европын шүүх дараахь хэргүүдэд шударга бус хандлага байхгүй байна гэж үздэг. Үүнд:



- Хэргийг шийдвэрлэж байгаа шүүгч нь урьдчилан мөрдөн байцаалтанд оролцсон байсан. Үүнд сэжигтнийг урьдчилсан мөрдөн байцаах хугацаанд хорих шийдвэр гаргасан байж болно. Шүүх урьдчилан хорих шийдвэр гаргасан ч гэсэн тухайн шүүгчийг шударга бус гэж тооцож болохгүй. Харин энэ шийдвэрийн цар хүрээ болон шалтгааныг авч үзэж болох юм гэж Европын шүүх үздэг.<sup>21</sup>
- Европын шүүх үзэхдээ даргалж байгаа шүүгч хэргийн материалын үндсэн дээр шүүхээр авч хэлэлцэж байгаа хэргийг шийдвэрлэх шууд нотлох баримт байна гэж үзсэн тохиолдолд шүүгчийн шүүхийн өмнөх шатанд оролцсон тухайн хэргийн талаар нарийн мэдлэгтэй болсоноор түүнийг шийдвэр гаргахад шударга байхад нөлөөлөхгүй.<sup>22</sup>

Хэдийгээр тийм ч Европын шүүх дараах тохиолдолд шударга бус байна гэж үздэг. Үүнд:

- Давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч эрх мэдэл өндөртэй байдаг бөгөөд өмнө нь яллах албанд нөлөө бүхий албан тушаалд байсан нь шүүхийн шударга байдалд эргэлзээ төрүүлж байна гэж Европын шүүх үзжээ. Хэдийгээр Европын шүүх тухайн шүүгчийг өмнө нь прокурорын газрын ажилтан байхыг нь тийм ч чухал зүйл гэж үзээгүй боловч шүүхийн шударга эсэхэд эргэлзэж байгаагаа илэрхийлжээ.<sup>23</sup>
- Сэжигтнийг урьдчилан байцаах үед шүүгч нь сэжигтнийг хорих тушаал гаргасан, мөрдөн байцаалтын үед хэд хэдэн хэрэгт буруутган ял тулгаж байсны дараа шүүн таслах ажиллагааны шатанд уг хэрэгт оролцож, шийдвэрлэж болохгүй гэсэн байна.<sup>24</sup>

#### Холбогдох хэм хэмжээ

##### Африкийн Дүрмийн 7.1 /д/

Хүн бүр баривчлагдсан, саатуулагдсан шалтгаанаа мэдэх эрхтэй. Үүний тулд...

д/ аль болох богино хугацаанд хараат бус шүүхээр хэргээ шийдүүлэх эрхтэй

#### Ишлэл

21. Нортиер ба Голландын хэрэг, (31/1992/376/450), 1992 оны 8 дугаар сарын 24, хуудас 12.

22. Сарива де Карвало ба Португалын хэрэг, (14/1993/409/488), 1994 оны 4 дүгээр сарын 22, хуудас 11.

23. Пиерсакийн Хэрэг, 1982 оны 10 дугаар сарын 1, цуврал 53 А 14, догол мөр 31.

24. Де Кубберын хэрэг, 1984 оны 10 дугаар сарын 26, цуврал 86 А 13-16

## Бүлэг 13

### Шударгаар шүүгдэх эрх

Олон улсын хэм хэмжээнд шударгаар шүүлгэх эрхийг хэрэгжүүлэх нь шударга шүүхийн үйл ажиллагааны баталгаа болдог хэдий ч илүү өргөн хүрээтэй байдаг. Үүнд: үндэсний шүүн таслах ажиллагаа нь олон улсын хэм хэмжээтэй тохирч байгаа эсэх багтана. Гэвч тухайн хэрэг нь үндэсний болон олон улсын процессийн бүх баталгааг хангасан ч шударга шүүхийн үйл ажиллагааны шаардлагыг хангахгүй байж болно.

#### 13.1 Шударгаар шүүгдэх эрх

#### 13.2. Эрх тэгш байх

### 13.1 Шударгаар шүүгдэх эрх

Шударгаар шүүгдэх эрх нь шударга шүүхийн ойлголтын үндэс мөн. Хүн бүр шударгаар шүүгдэх эрхтэй.\*

Шударгаар шүүгдэх эрх нь эрүүгийн шүүн таслах ажиллагаанд тодорхой эрхүүд заагдсан байдгаараа онцлогтой юм. Энэхүү эрхүүдэд гэм буруу нь нотлогдоогүй бол буруугүйд тооцох, албадан саатуулахгүйгээр хэргийг шийдвэрлэх, өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх нөхцлөөр хангагдах, гэрчийг дуудан мэдүүлэг авах, хуулийг буцаан хэрэглэхээс хамгаалуулах эрхүүд зэрэг орно. Эдгээр эрх нь шүүхийн үйл ажиллагааны олон улсын хэм хэмжээнд зөвхөн наад захын баталгаа болно. Энэ бүх баталгаануудыг бүх хэрэг тохиолдолд биелүүлсэн ч тухайн шүүхийн үйл ажиллагаа нь шударга болсон гэдгийг бүрэн баталж чадахгүй. Шударгаар шүүгдэх эрх нь бие даасан баталгаануудыг нэгтгэснээс хамаагүй илүү өргөн ойлголт юм. Мөн тухайн хэргийн үйл ажиллагаанаас хамаардаг.<sup>1</sup>

Хүний эрхийн Хороо нь шударга шүүгдэх эрхийг хэрэгжүүлэхэд дараах хэд хэдэн нөхцлөөр хангагдсан байх ёстой гэж үздэг. Үүнд, тэгш боломж /доор заасаныг үз/, эсрэг талуудын үйл ажиллагааг хүндэтгэн мэтгэлзэх зарчим, байцаан шийтгэх ажиллагааг шуурхай явуулах зарчмыг хэрэгжүүлнэ.<sup>2</sup>

Хуучин Зайрын Ерөнхийлөгч Мабуту СэСэ СэКо-ийн үед улс төрийн сөрөг хүчний 8 зүтгэлтний шударгаар шүүгдэх эрхийг зөрчсөн байна гэж Хүний эрхийн хороо үзжээ. Тэднийг байцаан шийтгэх ажиллагааны баталгаагаар бүрэн хангалгүйгээр урт хугацааны ялаар шийтгэж, 1981 онд заримыг нь цөлж, үлдсэнийг гэрийн хорионд оруулжээ. Улмаар Засгийн газрыг унагах зорилготой үйл ажиллагаа явуулсан хэмээн Улсын Аюулгүй байдлын шүүхээр хэргийг нь тасалсан байна. Тэднээс шүүхээс өмнө ямар нэгэн байцаалт аваагүй байжээ. Тэднийг болон тэдний гэр бүлийнхнийг амьдран сууж байсан орон байраас нь хөөсөн бөгөөд үүнийгээ захиргааны арга хэмжээ гэж тайлбарласан байна. Хороо үүнээс гадна тэдний эрхийг дур зоргоороо албадан саатуулж, тэдний үгийг сонсохгүйгээр шударга, нээлттэй шүүхээр шүүлгэх эрхийг нь хязгаарлаж байсныг тогтоосон байна.<sup>3</sup>

#### Холбогдох хэм хэмжээ

#### ИУТЭТОУП-ын 14 дүгээр зүйл

1. Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, хараат бус, тал үл харах шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.

\* ХЭТТ-ын 10 дугаар зүйл, ИУТЭОУП-ын 14(1) дүгээр зүйл, Европын Конвенцийн 6(1) дүгээр зүйл, Америкийн Тунхаглалын 26 дугаар зүйл, Америкийн Конвенцийн 8 дугаар зүйл, Югославын Дүрмийн 20(1) дугаар зүйл, Руандагийн 19(1) дугаар дүрэм. Мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 64(2) ба 67(1) дугаар зүйлийг үзнэ үү.

#### Ишлэл

1. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 5; Хүний Эрхийн Америк Дундын Шүүхийн Зөвлөх Санал, ОС-11/90, ОС-11/90, Дотоодын хууль сахиулах байгууллагуудын шаардлагатай шат дамжлагыг гүйцээхгүй байх тохиолдол (Exceptions to the Exhaustion of Domestic Remedies) 1990 оны 8 дугаар сарын 10; Хүний Эрхийн Америк Дундын Шүүхийн жил бүрийн илтгэл, 1990, Америкийн Улсуудын Байгууллага/Ser L./V/ III.23 баримт бичиг 12  
2. Морил ба Францын Хэрэг, (207/1986), 1989 оны 7 дугаар сарын 28, Хүний эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл, (A/44/40), 1989 он, хуудас 210.

## 13.2 Эрх тэгш байх

Шударгаар шүүгдэх эрхийн заавал байх ёстой нэг зүйл бол хэрэгт оролцож байгаа талуудад тэгш боломж олгох зарчим юм. Шүүн таслах ажиллагааны явцад тэгш боломжоор хангагдсан байна гэдэг нь талууд шүүхийн үйл ажиллагаанд харилцан тэгш боломжтойтойгоор оролцох, хэрэгт хандах талаар адилхан байдалтай байна.<sup>4</sup> Талууд өөр өөрсдийнхөө хэргийг танилцуулахад тодорхой хэмжээний эсэргүүцэлтэй тулгарах боловч үүний нөхцлүүд нь эсрэг талыг хэт давуу байдалд хүргэх ёсгүй.

Эрүүгийн хэрэгт яллах тал өөрийн ар тал болох төрийн механизмийн бүх хүчийг ашиглаж байгаа үед нөгөө талын тэгш боломжоор хангагдах эрх нь өөрийгөө заавал хамгаалах баталгаа юм. Тэгш боломжоор хангагдах ойлголтын дагуу өмгөөлөл тухайн хэргийн өмгөөлөлд бэлтгэх яллах талтай адилхан тэгш боломжоор хангагдсан байх ёстой.<sup>5</sup> Үүнд өмгөөлөгч авах, гэрчийг дуудан мэдүүлэг авах, шүүн таслах ажиллагаанд биеэр оролцох зэрэг эрхүүд багтана. Харин сэжигтнийг өөрийгөө өмгөөлөхөд шаардлагатай мэдээлэлээр хангаагүй эсхүл гэрчээс мэдүүлэг авах боломж олгоогүй мөн давж заалдах шатны шүүхэд яллах тал оролцож байгаа тохиодолд сэжигтнийг биечлэн оролцуулаагүй бол энэ тэгш боломжоор хангагдах зарчмыг зөрчсөн гэж ойлгож болно./ **8-р бүлэг буюу Өмгөөлөлд бэлтгэх боломжтой цаг хугацаа, нөхцлөөр хангагдах эрхийг үзнэ үү.** /

### Ишлэл

3. Мпанданжила ет ал ба Заирын хэрэг, (138/1983), 1986 оны 3 дугаар сарын 26,
4. Оффер болон Хопфингер нарын хэрэг дээр гаргасан Европын Шүүхийн шийдвэр, 524/59 ба 617/59,
5. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 9, Фоучерийн Хэрэг, Европын Шүүх 25EH RR 234, хуудас 247

## Бүлэг 14

### Нээлттэй шүүгдэх эрх

**Нээлттэй шүүлгэх эрх бол шүүн таслах ажиллагааны хараат бус, шударга байх зарчмийн суурь баталгаа болдог бөгөөд шүүхийн тогтолцоон дахь олон нийтийн хамгаалал гэсэн үг юм.**

#### 14.1. Нээлттэй шүүгдэх эрх

#### 14.2. Нээлттэй шүүх хурал явуулах журам

#### 14.3. Нээлттэй шүүхийг хуралдуулахгүй байх онцгой тохиолдол

#### 14.4. Ил тод шүүгдэх эрхийг зөрчих

### 14.1 Нээлттэй шүүгдэх эрх

Урьдчилан тодорхой зааснаас бусад нөхцөлд бүх шүүн таслах ажиллагаа нээлттэй явагдах ёстой.\*<sup>1</sup> Олон улсын Хүний Эрхийн хэм хэмжээнд Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үед нээлттэй шүүгдэх эрхийг тусгасан байдаг.\*\*

Нээлттэй шүүгдэх эрхийн агуулга нь тухайн хэргийн оролцогч талуудаас гадна олон нийт бас шүүн таслах ажиллагаанд оролцох эрхтэй болохыг илэрхийлнэ. Олон нийт шүүн таслах ажиллагааг хэрхэн яаж явуулж байгааг, шүүн таслах ажиллагаагаар ямар шийдвэр гаргаж байгааг мэдэх эрхтэй.

Нээлттэй шүүгдэх эрх нь “олон нийт шүүн таслах ажиллагаанд ажиглагчаар оролцох явдал бөгөөд 1998 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар батлагдсан Хүний эрхийг хамгаалагчдын тухай тунхаглалд “Олон нийт нь хэргийг ажиглах эрхийн дагуу нээлттэй шүүн таслах ажиллагаанд суух, холбогдох олон улсын хэм хэмжээ болон үндэсний хууль тогтоомжийг оновчтой хэрэглэж байгаа эсэх талаар өөрийн саналыг гаргах” эрхтэй гэж тодорхой заасан байна.<sup>2</sup>

#### Холбогдох хэм хэмжээ

##### ХЭТТ-ын 10 дугаар зүйл

Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.

##### ИУТЭТОУП-ын 14 дүгээр зүйл

1. Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, хараат бус, тал үл харах шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.

Ардчилсан нийгэм дэх ёс суртахуун, нийгмийн хэв журам буюу үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс эсхүл талуудын хувийн амьдралын эрх ашгийн үүднээс, эсхүл нээлттэй явуулах нь шүүн таслах ажлын эрх ашгийг зөрчинө гэж шүүхээс үзсэн онцгой нөхцөл байдалд, тэрхүү шүүхийн өөрийн саналаар зайлшгүй гэж тогтоосон хэмжээгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийг шүүх ажиллагаанд бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт оролцуулахгүй байж болно; гэхдээ насанд хүрээгүй хүүхдийн эрх ашгийг хамгаалах, гэр бүлийн (matrimonial) эхнэр нөхрийн маргаан буюу хүүхдэд асран хамгаалагч тогтоохтой холбоотойгоос бусад эрүүгийн болон иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэр олон нийтэд нээлттэй байна.

\* ХЭТТ-ын 10 дугаар зүйл, ИУТЭОУП-ын 14(1) дүгээр зүйл, Европын Конвенцийн 6(1) дүгээр зүйл, Югославын Дүрмийн 20(4) дугаар зүйл, Руандагийн 19(4) дугаар дүрэм, Мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 64(7) ба 67(1) дугаар зүйлийг үзнэ үү.

\*\* ХЭТТ-ын 11 дүгээр зүйл, Үндсэн Зарчим 36(1) дугаар зарчим, Америкийн Конвенцийн 8(5) дугаар зүйлүүд болон Америкийн Тунхаглалын 26 дугаар зүйл.

#### Ишлэл

1. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 6.

2. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглал, 1998, НҮБ: E/CN.4/1998/L.18, ]

## 14.2. Нээлттэй шүүх хурал явуулах журам

Нээлттэй шүүх нь олон нийт хэвлэл мэдээллийнхний оролцоотойгоор олон нийтэд хүргэх аман шүүн таслах ажиллагааны хэлэлцүүлэг. Шүүхээс олон тохиолдолд шүүн таслах ажиллагаанд олон нийтийг оролцох боломжийг нь хязгаарлан хаалттай хийдэг. Нийтэд нээлттэй амаар хэлэлцэх шүүх хурал хэдийд явагдах хугацаа, байршлийн талаархи мэдээллийг олон нийтэд хүргэх ёстой ба боломжийн хэмжээнд сонирхол бүхий олон нийтийн гишүүнийг байлцуулах бололцоог хангасан байх ёстой.<sup>3</sup>

Бүх эрүүгийн хэрэг болон шүүхийн хэлэлцүүлгийн талаархи шүүхийн шийдвэрүүд зарим онцгой тохиолдлоос бусад үед эс тооцвол бүгд нээлттэй байна.

Давж заалдах шатны хуралдаан нээлттэй байх эсэх нь давж заалдах асуудлаасаа хамаарна. /Давж заалдах тухай эрхийн тухай бүлэг 21.3/

Европын шүүх, Европын комисс нь тухайн хэргийн онцлогоос шалтгаалан зөвшөөрөгдснийг эс тооцвол наад тал нь 1 удаагийн шүүн таслах ажиллагаа нээлттэй байх ёстой гэж үздэг. Европын шүүх хэрэв доод шатны шүүхийн амаар явуулах үйл ажиллагаа нээлттэй явагдсан тохиолдолд давж заалдах шатны шүүх хуралдааныг заавал нээлттэй буюу заавал аман хэлэлцүүлгээр явуулахыг шаарддаггүй. Хэдий тийм боловч давж заалдах шүүхэд ямар нэгэн хуулийн эсхүл нотолгоо пакт гарвал аман шүүн таслах ажиллагааны хэлэлцүүлэгийг явуулж болно.<sup>4</sup>

## 14.3. Нээлттэй шүүхийг хуралдуулахгүй байх онцгой тохиолдол

Тодорхой заасан онцгой нөхцөлд шүүх ажиллагааг нээлттэй явуулахыг нь хязгаарлаж болно.

Шүүн таслах ажиллагааны зарим хэсэгт нь эсхүл бүхэлд нь хэвлэл мэдээллийнхэнийг олон нийтийг оролцуулахгүй байх тохиолдол байдаг нь Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон Европын конвенцид адилхан тусгасан байдаг. Үүнд: жишээлбэл Ёс суртахууны хувьд бэлгийн халдашгүй байдал, эрх чөлөөнд халдсан гэмт хэрэгтэй холбоотой зарим гэмт хэргүүд /нийтийн хэв журам сахиулахтай холбоотойгоор / шүүхийн тасалгаанд хэв журам зохицуулах, ардчилсан нийгэмийг бэхжүүлэх үндэсний аюулгүй байдлын асуудлуудтай холбоотойгоор хүүхэд залуучуудын ашиг сонирхол, талуудын хувийн амьдралын нууцтай холбоотой шаардлагуудын дагуу зарим тусгай онцлог тохиолдолд шүүн таслах ажиллагааны нээлттэй зарчимтай нийцэхгүй байхад хүрдэг тохиолдол гарч болдог.\*

Энэ бүх онцгой тохиолдлыг тодорхой тайлбарласан байдаг. Хүний эрхийн Хороо тэмдэглэхдээ:” Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 14.1-д заасан онцгой тохиолдлоос бусад бүх тохиолдолд хэлэлцүүлгийг хэвлэл мэдээллийн ажилтныг оролцуулан олон нийтэд нээлттэй байлгах ёстой. Мөн тодорхой бүлэгт багтдаг хүмүүсээр олон нийтийн оролцоог хязгаарлаж болохгүй”. Олон улсын хуульд зааснаар тухайн орон үндэсний аюулгүй байдлын асуудлын хүрээг өөрсдөөр нь тодорхойлуулахыг сайшаадаггүй.

Олон улсын хууль нь тухайн орон үндэсний аюулгүй байдал гэдэгтээ юуг авч үзэхийг тодорхойлдоггүй ч үндэсний аюулгүй байдлын улмаас хязгаарлалт хийсэн нь хууль ёсны гэж зөвтгөх үндэслэл биш гэж үздэг. Олон улсын эрх зүйн салбар дахь шинжээчдийн үзэж байгаагаар хязгаарлалтын зорилго ба үр дүнг тухайн оршин тогтнох улс орны

\*ИУТЭОУП-ын 14.1, Европын конвенцийн 6/1-р зүйл

### Ишлэл

3. Ван Меүрс болон Голландын хэрэг, (215/1986), 1990 оны 7 дугаар сарын 13, Хүний эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл, (A/45/40), 1990 он, хуудас 210
4. Фредин болон Шведийн хэрэг, (№2), (20/1993/415/494), 1994 оны 2 дугаар сарын 26, хуудас 6-7
5. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 6.
6. Үндэсний Аюулгүй байдал, Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон Мэдээлэл авах эрхүүдийн талаарх Ёханесбургийн зарчим, 1995 онд Өмнөд Африкийн Бүгд Найрамдах улсын Ёханесбург хотноо болсон Хүний эрхийн шинжээчдийн бага хурлаар энэ зарчмыг тодорхойлсон.

бүрэн бүтэн байдал, хүч хэрэглэхээс хамгаалах, тухайн оронд тулгарсан аюулд хариу өгөх чадварын, энэ нь зэвсэгт аюул гэх мэт гадаад аюул эсхүл Засгийн Газрыг унагаах гэсэн оролдлого буюу дотоодын аюул гэх мэтээр холбох нь учир дутагдалтай гэсэн байна.<sup>6</sup>

Европын Комисс цөөнхийн эсрэг ыэлгийн хүчирхийлэл үйлдсэн хэрэгт Европын Конвенцийн 6-1-ийн дагуу нээлттэй зарчмаас татгалзаж болно.<sup>7</sup> гэж үзсэн байдаг.

Европын Шүүх нийгмийн хэв журмын асуудал ба аюулгүй байдлын шалтгаанаар олон нийт ба хэвлэл мэдээллийг оролцуулахгүй байх зарчмыг хорих байгууллагад ял эдлэж байгаа хоригдлуудын эсрэг сахилгын шүүн таслах ажиллагаанд ашиглаж болно гэж заасан байна. Шүүхээс энэхүү үйл ажиллагааг нээлттэй болгосноор төр захиргааны байгууллагууд хэтэрхий их дарамт учруулах боломжтой гэж үзжээ.<sup>8</sup>

Америкийн конвенцийн дагуу эрүүгийн шүүн таслах ажиллагааны нээлттэй зарчмын эрхийг зөвхөн шударга сонирхолыг хамгаалахад шаардлагатай тохиолдолд түтгэлзүүлж болно.\*

#### 14.4. Нээлттэй шүүхээр хянан шийдвэрлүүлэх эрх зөрчигдөх

Хүний эрхийн Хороо, Америкийн Дундын Комисс нь Перу Колумбад алан хядах үйл ажиллагаа ба хар тамхины хэргүүдэд явуулсан хаалттай шүүн таслах ажиллагаа явуулсныг шударга шүүхийн эрхийг зөрчсөн байна гэж тооцсон.

Перуд давж заалдах шатны хуралдаанд олон нийт оролцох, нээлттэй явуулах боломжийг хязгаарласан. Ийм шүүн таслах ажиллагааг явуулахдаа сэжигтнүүдийг торон дотор, шүүгчид гэмт хэрэгтнүүдэд өөрийгөө таниулахгүйн тулд хаалтны цаана байсан. Мөн шүүхийн бүх баримт дээр өөрийн нэрийн оронд дугаар ашиглаж байсныг “нүүргүй шүүх” гэж нэрлэжээ. Хүний эрхийн хороо Перугийн Засгийн газраас нүүргүй шүүхийн шүүн таслах ажиллагааг болиулахыг шаардаж, эрүүгийн хэрэгт/алан хядах үйл ажиллагааг оролцуулан/ бүх хүмүүст шинээр нээлттэй шүүн таслах ажиллагаа явуулахыг шаардсан.<sup>9</sup> Хэдийгээр 1997 оны 10 сард нүүргүй шүүхийн системийг байхгүй болгосон ч алан хядах үйл ажиллагаатай холбогдсон хэргүүдэд цэргийн шүүх эсхүл иргэний хорих газарт хаалттай шүүх хуралдаан явуулдаг хэвээр байна.

Үүнтэй ижил нүүргүй нууц шүүгчдээр шүүн таслах ажиллагаа явуулдаг Колумбын практикийг) Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон Америкийн конвенцийн ерөнхий зарчмыг зөрчиж байна гэж Хүний Эрхийн Хороо, Америк Дундын Шүүхээс буруушааж байсан.<sup>10</sup>

Нууц шүүхийн ажиллагааны аливаа хэлбэрийг устгаад түүний оронд эрх зүйн систем ялангуяа үндсэн баталгаануудыг улам хүчтэй болгохыг Америк Дундын Комисс зөвлөсөн байна. Чилийн цэргийн тусгай шүүх 2 иргэний нэгийг нь алж нөгөөг нь хүнд гэмтэл учруулсан цэргийн албан хаагчдын гэмт хэргийн шүүн таслах ажиллагааг явуулахад хохирогч нарыг тухайн шүүх хуралдаанд оруулах ямар ч боломж олгоогүй. Мөн энэхүү хаалттай байдал нь хохирогчдын өмгөөлөгч нарт шүүн таслах ажиллагаанд оролцох наад захын боломж олгоогүй, цэргийн байгууллагууд хэрэгт хавсаргасан нотлох баримтыг хянасан зэргийг Америкийн Дундын Комисс тогтоожээ.<sup>11</sup>

\*Америкийн Конвенцийн 8(5) дугаар зүйл

#### Ишлэл

7. Х ба Австрийн хэрэг, (1913/63), Страсбургын Хуулийн Хэргүүдийн Эмхэтгэл 2, 438 (1995 оны 4 дүгээр сарын 30), (хэвлэгдээгүй)
8. Кампбелл ба Феллийн хэрэг, 1984 оны 6 дугаар сарын 28, цуврал 80 А 42.
9. Перу: Хүний Эрхийн Төлөв Байдлын Урьдчилсан Судалгаа, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП/С/79 Нэмэлт 67, догол мөр 18 болон 24, 1996 оны 7 дугаар сарын 25
10. Америк Дундын Комисс, Колумбын Хүний эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл, Америкийн Улсуудын Байгууллага /Ser.L/V/II.84, баримт бичиг 39, 1993 он, хуудас 249
11. Хэрэг №9755, Чили, Америк Дундын Комисс, 132, 137, Америкийн Улсуудын Байгууллага /Ser.L/V/I.74, баримт бичиг 10, 1998 он

## БҮЛЭГ 15

### Гэм буруутай нь нотлогдоогүй тохиолдолд буруугүйд тооцох

Энэ нь эрүүгийн хэрэгт буруутгагдаж байгаа ямар ч этгээдийг шударга шүүхийн үйл ажиллагааны дагуу бурууг нь нотлогдох хүртэл буруугүй гэж тооцох эрх юм.

#### 15.1 Гэм буруу нь нотлогдоогүй тохиолдолд гэм буруугүйд тооцох

#### 15.2 Нотлох үүрэг

#### 15.3 Гэм буруугүй байдлыг нотлох процесс

#### 15.4 Гэм буруугүйд тооцогдсоны дараа

### 15.1 Нотлогдоогүй тохиолдолд гэм буруугүйд тооцох зарчим

Хүн бүр шударга шүүх ажиллагааны наад захын шаардлага хангагдсан болон хуулийн хүрээнд бүрэн нотлогдоогүй бол буруугүйд тооцогдох эрхтэй. Нотлогдох хүртэл хэнийг ч гэм буруутай мэт харьцаж болохгүй.\*

Нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцуулах эрх шүүхийн үйл ажиллагаа болон нотлох баримтыг үнэлэхэд хэрэглэгдэхээс гадна мөн урьдчилсан мөрдөн байцаалтанд шатанд шууд хамаарна. Сэжигтэн шүүн таслах ажиллагаанаас эрүүгийн ял оноохоос өмнө болон сэжигтэний гэм бурууг бүрэн нотлож баталгаажуулсан эцсийн шийдвэр гарах хүртэл энэ гэм буруугүй байх эрхийг эдэлнэ.

Нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцох зарчмаас өөрийн эсрэг албадан мэдүүлэг өгөхгүй байх эсхүл буруугаа хүлээхгүй байх эрх мөн мэдүүлэг өгөхгүй байх эрхүүд гарч ирдэг юм. **Сэжигтэн өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх** 16-р зүйлээс үзнэ үү.

Нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцох эрхийн дагуу шүүгч болон иргэний төлөөлөгчид хэргийн талаар ямар нэгэн урьчилсан шийдвэр гаргахгүй байх ёстой. Энэ нь прокурор цагдаа нарыг оролцуулан төр захиргааны байгууллагууд сэжигтний гэм буруутай эсэх талаар ямар ч урьдчилсан мэдэгдэл хийх ёсгүй.<sup>1</sup> Энэ нь мөн бусад холбогдох албан тушаалнуудад хамааралтай Мөн үүний дагуу засаг захиргааны байгууллагууд хэвлэл мэдээлэл болон нийгмийн бусад хүчтэй бүлэглэлүүд тухайн хэргийг шийдвэрлэхэд нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх үүрэгтэй байх ёстой.

Гэвч эрх бүхий байгууллагаас олон нийтэд эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын талаар мэдээлэх, сэжигтнийг нэрлэх, сэжигтнийг баривчилсан, хорьсон гэж мэдээлсэнээр тухайн хүнийг буруутай гэж зарлаагүй тул нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох эрхийг зөрчөөгүй гэж тооцно.<sup>2</sup>

### 15.2. Нотлох үүрэг

Шударга шүүн таслах ажиллагааны шаардлагыг хангасан хэргийн явцад нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцох зарчим нь эрүүгийн шүүн таслах ажиллагаанд ер бус нөлөөтэй юм. Энэ нь яллах тал нь сэжигтэй этгээдийн гэм буруутай эсэхийг нотлох үүрэгтэй гэсэн үг. Хэрэв үүнд ямар нэгэн үндэслэлтэй эргэлзээ байгаа тохиолдолд сэжигтнийг гэм буруутай гэж үзэхгүй.

Олон Улсын Эрүүгийн Шүүхийн /Ерөнхий нөхцлийн 66./33-р зүйл заалтад: “Сэжигтнийг яллахын тулд шүүх ямар нэгэн эргэлзээ байхгүйгээр

\* ХЭТТ-ын 11 дугаар зүйл, ИУТЭОУП-ын 14(2) дүгээр зүйл, Үндсэн Зарчим - 39 дүгээр зарчим, Африкийн Дүрмийн 7(1)(б) дугаар зүйл, Африкийн Комиссын Тогтоолын 2(Г) хэсэг, Америкийн Тунхаглалын 26 дугаар зүйл, Америкийн Конвенцийн 8(2) дугаар зүйл, Европын Конвенцийн 6(2) дүгээр зүйл, Югославын Дүрмийн 21(3) дугаар зүйл, Руандагийн 20(3) дугаар дүрэм. Мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 66 дугаар зүйл, Наад захын Жишиг Дүрмийн 84(2) дугаар дүрэм, Европын шоронгийн дүрэм-91 дүгээр дүрмүүдийг үзнэ үү.

#### Ишлэл

1. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 7.
2. Краусе ба Швейцарийн хэрэг, 13 DR 73, 1978 оны 10 дугаар сарын 3; Ворм болон Австрийн хэрэг, (83/1996/702/894), Европын шүүх, 1997 оны 8 дугаар сарын 29

сэжигтний гэм буруутайд бүрэн итгэлтэй байх ёстой. Хэдийгээр нотлох стандартууд бусад олон улсын стандартад тодорхой заагаагүй ч Хүний Эрхийн Хороо “Нотлогдоогүй бол гэм буруугүй гэсэн зарчмын дагуу нотлох үүргийг яллагч тал хүлээх бөгөөд гэм буруу нь бүрэн нотлогдоогүй эргэлзээтэй байвал сэжигтэнд ашигтайгаар шийдвэрлэнэ. Хэнийг ч гэм буруутай нь батлагдаагүй байхад буруутай гэж үзэхгүй юм.”<sup>3</sup>

Нотлогдоогүй бол гэм буруугүй байх зарчмын дагуу нотлох баримтыг гаргах болон шүүн таслах ажиллагаа явуулах журмаар шүүн таслах ажиллагаанд нотлох үүргийг яллах тал хүлээнэ.

Зарим оронд сэжигтнийг /яллагчийн өмнөөс/ хуулийн дагуу тодорхой үйл ажиллагааны зарим хэсгийг тайлбарлахыг шаарддаг. Тухайлбал сэжигтнээс тодорхой газарт /өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдсэн газар юм уу ойролцоох газарт/ байсан шалтгааныг шаардаж эсхүл тодорхой эзэмшиж байгаа эд зүйлүүдийн /хууль бус хил нэвтрүүлсэн бараа эсхүл хулгайлагдсан өмчийн/ талаар тайлбар тавихыг шаардаж болно. Ийм шаардлагуудыг хуульд оруулсаныг хуулиар тогтоосон урьдчилсан нөхцөлүүд гэж тодорхойлдог.

Энэ шаардлагуудыг нотлох үүргийг яллагчаас сэжигтэнд зөвшөөрөлгүй шилжүүлж байгаа болон нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцох зарчмыг зөрчиж байна гэсэн үндэслэлээр түдгэлзүүлдэг.

Европын шүүх “Хуулиар тогтоосон энэ урьдчилсан нөхцөлүүд нь заавал нотлогдоогүй бол гэм буруугүй зарчмыг зөрчөөгүй байж болно гэвч хуулиндаа үндэслэлтэйгээр хязгаарласанаа тайлбарласан байх ёстой” гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл сэжигтэн үүнийг эсэргүүцэх боломжоор хангагдсан байх ёстой.<sup>4</sup>

Америк дундын комисс гэмт хэргийг тодорхойлохдоо нотлогдоогүй бол гэм буруугүй зарчмыг үндэслэн сэжиглэгдэж байгаа буюу холбогдолтой гэдгээр бус хөдлөшгүй нотлогоог харгалзан үзнэ.<sup>5</sup>

### 15.3 Гэм буруугүй байдлыг нотлох процесс

Шүүх хуралдаан явуулснаар гэм буруугүй байдлыг нотолдог. Шүүгчид шүүх хуралдаан явуулалгүйгээр хохирогч, шүүгдэгчийн аль алинийх нь гэм буруутай болон, гэм буруугүйд үнэлэлт дүгнэлт өгөх эрхгүй.

Шүүх хуралдааны явцад шүүгдэгчийн зүгээс өөрсдийн гэм буруугүйг нотлох талаар онцгой анхаарал хандуулах ёстой.

Эдгээр шинж нь шүүхийн танхимд яллагдагчийг тусгай байранд оруулах, гав зүүхийг шаардах, шоронгийн хувцас өмсгөх, үсийг нь хусах зэрэг хамаарна.

Эдгээр шинжээс зайлсхийхийн тулд, тухайлбал яллагдагч нь өөрийн гэсэн хувцасгүй байвал Шүүх хуралдаанд иргэний хувцастай оролцох явдлыг хангах ёстой.\*

Ингэснээр гэм буруугийн тодорхой шинжийг агуулсан шударга бус хуралдаан явуулах эрсдэлийг багасгана.

Шүүхийн шийдвэр гаргахаас өмнөх тангарагтны шүүхийн тогтоолыг тусгасан хэд хэдэн хэрэгт Европын Комиссоос тодорхой байр сууриа илэрхийлдэг. Тухайлбал нэг хэрэгт шүүх шийдвэрээ гаргахаасаа өмнө яллагдагчийг урьд нь орон байрны хулгайд холбогдож байсан талаар авч үзсэн, бас өөр нэг хэрэгт яллагдагчийг өмнө нь дээрмийн хэрэг үйлдэж байсныг авч үзэж шийдвэрт нөлөөлсөн өөр нэг хэрэгт улсын

#### Ишлэл

3. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 7.
4. Пхам Хоанг болон Францын хэрэг, (66/1991/318/390), 1992 оны 9 дүгээр сарын 25,
5. Америк Дундын Комиссын жил бүрийн Илтгэл, 1996 он, Америкийн Улсуудын Байгууллага, Ser.L/V/II.95, баримт бичиг 7, хуудас 745, Перу



яллагчаас яллагдагчийн өмнөх хэд хэдэн хэргийн талаар мэдээлж шүүх түүнийг хамтатган зүйлчилсэн байжээ.<sup>6</sup>

#### 15.4 Гэм буруугүй гэж тооцогдсоны дараа

Шүүхийн эцсийн шийдвэрээр тухайн этгээдийг цагаатгасан бол энэхүү шийдвэр нь бүх улсын эрх бүхий этгээдийн хувьд заавал биелэгдэх хүчин чадалтай байна. Тиймээс прокурор ба цагдаа нь шүүхийн шийдвэр болон эрх зүйт хуулийг хүндэтгэн гэм буруугүйн нотолгоог үгүйсгэхгүй байхын тулд тухайн этгээдийг гэм буруутай байж болзошгүй гэж үзэхээс татгалзах хэрэгтэй.

Европын шүүх тухайн этгээдийг цагаатгасны дараа шүүх хурлаас өмнө урьдчилан хоригдож байсны нөхөн төлбөрийг өгөхөөс татгалзах шийдвэрийг тайлбарлахдаа тухайн этгээдийн гэм буруугүй байдлын талаар эргэлзэж байгаагаа Австралийн шүүх илэрхийлсэн нь гэм буруугүйн нотолгоог үгүйсгэсэн явдал хэмээн Европын шүүх үзсэн.<sup>7</sup>

Шведийн шүүх хэдийгээр яллах ажиллагаа хуульд заасан хугацаандаа багтан дуусахгүй байгаагаас шалтгаалан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа зогссон ч яллагдагч гэмт хэрэгт холбогдсон гэж үзэний үндсэн дээр гэм буруутай этгээдээр шүүхийн болон мөрдөн байцаалтын зардлыг төлүүлсэн нь гэм буруугүйд тооцогдох зарчмыг зөрчиж байна гэж Европын комисс үзэж байна.<sup>8</sup>

Нийтийн эрх зүйн тогтолцоотой маш олон улс эрүүгийн бус (иргэний) хэргийн харъяаллаас эрүүгийн харъяаллыг салгасан байдаг. Тухайн орнуудад эрүүгийн хэрэгт цагаатгагдсан этгээдэд эрүүгийн хэргийн бус шүүх ижил нөхцөл байдалд тулгуурлан гэхдээ өөр нотолгооны стандартыг хэрэглэн иргэний хариуцлага хүлээлгэхийг хориглодоггүй.<sup>9</sup>

Европын шоронгийн дүрэм-95(3) дүгээр дүрэм, Наад захын Жишиг Дүрмийн 17(3) дугаар дүрэм

#### Ишлэл

6. X ба Австри, 1967 оны 4 дүгээр сарын 3, 23 Coll. Dec.31; X ба Австри, 1966 оны 4 дүгээр сарын 1, 19 Coll. Dec.95; X ба Австри, 1965 оны 12 дүгээр сарын 14, 18 Coll. Dec.44
7. Секанина ба Австри, 1993 оны 8 дугаар сарын 25, 266-A Ser.A
8. A болон C ба Швейцарийн хэрэг, (10107/82), 1985 оны 12 дугаар сарын 4, 48 DR 35
9. Европын Комисс, X ба Австри, (9295/81), 1982 оны 10 дугаар сарын 6, 30 DR227

## Бүлэг 16

### Сэжигтэн өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх

Эрүүгийн хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээд өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, гэмт хэрэгт холбогдолгүй болохоо нотлох үүрэг хүлээхгүй./ 15-р бүлгээс үзнэ үү/

**16.1. Гэмт хэрэгт холбогдолгүй болохоо нотлох, өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх**

**16.2. Мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх**

**16.3. Хүч хэрэглэж мэдүүлэг гаргуулах**

#### 16.1. Гэмт хэрэгт холбогдолгүй болохоо нотлох, өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх

Эрүүгийн хэрэгт сэжиглэгдэж байгаа аливаа этгээд уг гэмт хэрэгт холбогдолгүй болохоо нотлох, мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй. Энэхүү хориглолт нь нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох зарчмын илэрхийлэл юм. Энэ зарчмын үүднээс гэм буруутай болохыг нь нотлох үүргийг байцаан шийтгэх ажиллагааны явцад прокурор хүлээнэ. Мөн хүнлэг бус хэрцгий хандах, эрүү шүүлт тулгахыг хориглосон байдаг.\*

Энэ суурь эрхийг Европын конвенцийн 6-р зүйлээс үндэслэн бий болсон гэж үздэг. Европын шүүх “Европын конвенцийн 6-р зүйл тусгайлан заагаагүй ч уг зүйл нь олон улсын стандарт болон хүлээн зөвшөөрөгдсөн шүүн таслах ажиллагааг шударга явуулах гол үндэс болох мөрдөн байцаалтанд сэжигтэн мэдүүлэг өгөхөөс татгалзах, өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх, мөн эрх бүхий албан тушаалтны зүй бус харицаанаас хамгаалах хамгаалалт олгосноор шүүн таслах ажиллагааны зарчмыг гажуудуулахаас урьдчилан сэргийлэх бөгөөд 6-р зүйлийн гол санааг баталгаажуулж байна” гэжээ.

Өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, гэм буруугүй болохоо нотлохын эсрэг хориглолт бол өргөн цар хүрээтэй юм. Үүний дагуу төрийн байгууллагуудыг шууд ба шууд бусаар бие махбодийн болон сэтгэл санааны албадлага хэрэглэх, шахалт үзүүлэх хэлбэрээр байцаалт явуулахыг хориглосон байдаг.<sup>1</sup>

Мөн эрүү шүүлт тулгах зэрэг бусад хүнлэг бус, зүй бус хандлагыг зөвшөөрдөггүй. Хүний эрх, хүний нэр төрийг хүндэтгэн харьцах ёстой бөгөөд үүнийг зөрчсөн аливаа хандлагыг хориглодог.<sup>2, 3</sup> Хорьж мөрдөхөд хүнлэг нөхцлөөр хангагдах эрх эрүү шүүлтээс ангид байх эрх гэсэн 10 дугаар бүлгийг харна уу.

#### Холбогдох хэм хэмжээ

##### ИУТЭОУП-ын 14 З/г/ дүгээр заалт

Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр дараахь наад захын баталгаагаар хангагдах эрхтэй:

г/ өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, бурууг хүлээх тулган шаардалтад өртөхгүй;

\* ИУТЭОУП-ын 14(3)(ё) дүгээр зүйл, Америкийн Конвенцийн 8(2)(ё) болон 8(3) дугаар зүйл, Үндсэн Зарчим – 21 дүгээр зарчим, Югославын Дүрмийн 21(4)(ё) дугаар дүрэм, Руандагийн Дүрмийн 20(4)(ё) дугаар дүрэм мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 67(1)(ё) дугаар зүйлүүд

#### Ишлэл

1. Маррей ба Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (41/1994/488/570), 1996 оны 2 дугаар сарын 8
2. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 14; Келли ба Ямайка (253/1987) 1991 оны 4 дүгээр сарын 8, Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл (А/46/40) 1991 он
3. Манфред Новак, НУБ-ын Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт: ИУТЭОУП-ын Тайлбар, 1993 он, хуудас 264

## 16.2 Мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх

Сэжигтэн шүүх болон мөрдөн байцаагчийн тавьсан асуултанд мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх нь олон улсын жишиг дүрмээр дараах хоёр нөхцөлд хамгаалагдсан байдаг. Үүнд сэжигтэн гэм буруутай нь тогтоогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох болон мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхүүд багтана.<sup>4</sup>

Сэжигтний мэдүүлэг өгөх эрх нь сэжигтэн төрлөөр устгах, хүн төрөлхтөний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг зэрэгт сэжиглэгдсэнээс бусад нөхцөлд Югославын зарчмын 42А зүйлд, Руандагийн зарчмын 42 А –р болон олон улсын иргэний эрхийн пактын 55 2-р бүлэгт албан ёсоор тодорхойлогдсон байдаг.

Европын шүүх хэрэв сэжигтэн мэдүүлэг өгөхөөс татгалзсан тохиолдолд түүнд зөвхөн татгалзсаных нь төлөө шийтгэл оногдуулсан бол энэ нь түүний өөрт нь тулгасан хэргийг үгүйсгэх болон шүүхээр гэм буруутай нь нотлогдоогүй байхад гэм буруугүйд тооцно хэмээх зарчмыг зөрчсөн хэрэг болно гэж үзэж байна. Гэвч мэдүүлэг өгөхөөс татгалзах нь хязгаартай байх хэрэгтэй гэж Европын шүүх үзэж байна. Хэрвээ шүүх сэжигтнийг мэдүүлэг өгөхөөс татгалзсаны төлөө түүнийг гэм буруутай гэсэн шийдвэр гаргасан бол энэ нь уг хэргийн байдлыг тал бүрээс нь авч үзээгүй хэрэг болно. Европын шүүх сэжигтний байцаалтыг түүний гэм буруу нь тогтоогдоогүй байхад гэм буруугүйд тооцогдох эрхийг нь зөрчилгүй, албадлага хэрэглэлгүй, дарамт шахалт үзүүлэлгүй явуулсан тохиолдолд сэжигтэн нь шүүх хурал болон мөрдөн байцаалтанд тэрхүү хэргийн газар байсан буюу түүнд оролцсон эсэхээ мэдүүлэхээс татгалзсан бол шүүх түүнийг буруутай гэсэн шийдвэр гаргаж болно гэж үздэг. Шүүхээс сэжигтнийг баривчилсны дараа 48 цагийн дотор өмгөөлөгч авахыг нь зөвшөөрөхгүй байх буюу түүнийг байцаах явцдаа түүнд мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхээ эдлэхийг зөвшөөрөхгүй байх нь Европын конвенцийн 6-р зүйлийг зөрчиж байна гэж үзэж байна.<sup>5</sup>

## 16.3 Хүч хэрэглэж мэдүүлэг гаргуулах

Сэжигтэн шүүн таслах ажиллагааны явцад мэдүүлгийг хүч хэрэглэж, шахалт үзүүлж авсан гэж мэдэгдсэн бол, шүүгч энэхүү мэдэгдлийг аль ч шатанд хянан шийдвэрлэх эрхтэй.<sup>6</sup> Тухайн мэдүүлэг нь эрүү шүүлт, хүнлэг бус, хэрцгий, хууль бус хандлагын үр дүнд бий болсон гэх мэдэгдлийг шүүгчийн оролцоотой холбогдох эрх бүхий байгууллага шуурхай шалгах ёстой.\*

Хорих ангид ял эдэлж буй хоригдлууд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нар эрүү шүүлт эсвэл хууль бус харилцааны талаар гомдол гаргаж болно. Ийм төрлийн бүх өргөдөл гомдлыг шуурхай авч үзэж шийдвэрлэх ёстой юм. Хэрэв тухайн өргөдлийг буцаасан эсхүл ямар нэгэн тодорхой шалтгаангүйгээр шийдвэрлэлгүй саатуулж байгаа тохиолдолд өргөдөл гаргагч энэ асуудлаар шүүх болон бусад захиргааны байгууллагуудад хандах эрхтэй. Ийнхүү өргөдөл гомдол гаргасанаараа ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.\*\* Мөн түүнчлэн эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар доромжлон харьцсан нь илэрвэл нэн даруй эрүүгийн хэрэг үүсгэж мөрдөн байцаалт явуулах ёстой байдаг.\*\*\* Яллагдагчийн гэм буруугаа хүлээсэн нотлох баримтыг эрүүдэн шүүж гаргуулсан бол шүүх түүнийг нотлох баримтаас хасна.

\* Эрүү Шүүлтийн Эсрэг Конвенцийн 13 ба 16 дугаар зүйлүүд ба Эрүү шүүлтийн талаарх Америкийн улсуудын Конвенцийн 8 дугаар зүйл.

\*\* Үндсэн Зарчим - 33 дугаар зарчим

\*\*\* Эрүү Шүүлтийн Эсрэг Конвенцийн 12 ба 16 дугаар зүйлүүд ба Эрүү шүүлтийн талаарх Америкийн улсуудын Конвенцийн 8 дугаар зүйл.

### Ишлэл

4. Маррей ба Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (41/1994/488/570), 1996 оны 2 дугаар сарын 8, догол мөр 45
5. Маррей ба Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (41/1994/488/570), 1996 оны 2 дугаар сарын 8
6. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 15

**Бүлэг 17****Эрүү шүүлт тулган буюу бусад хориотой аргыг хэрэглэж цуглуулсан нотлох баримт нотлох чадвараа алдах нь**

Хэнд ч эрүү шүүлт болон хүч хэрэглэх, хүнлэг бус хэрцгий харьцах замаар хэрэг хүлээлгэхийг хориглоно. (Хүний эрхийн тухай Америкийн Конвенцийн 8.3-р бүлэг).

**17.1 Эрүү шүүлт тулган буюу бусад хориотой аргыг хэрэглэж цуглуулсан нотлох баримт нотлох чадвараа алдах нь**

**17.2 Хүч хэрэглэж цуглуулсан нотлох баримт нотлох чадвараа алдах нь**

**17.2.1 Америкийн Конвенцийн 8.3 дугаар заалт**

**17.1 Эрүү шүүлт буюу бусад хориотой аргыг хэрэглэж цуглуулсан нотлох баримт нотлох чадвараа алдах нь**

Эрүү шүүлт тулгаж гаргуулсан аливаа мэдүүлгийг мөрдөн байцаалтын явцад сэжигтэн яллагдагчийг эрүүдэн шүүж мэдүүлэг авсан хэрэгт буруутгагдаж буй этгээдийн эсрэг нотлох баримт болгон ашиглахаас бусад тохиолдолд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд нотлох баримт болгон ашиглаж болохгүй.\* Мөн олон улсын хэмжээнд зөвхөн эрүүдэн шүүх аргаар мэдүүлэг гаргуулахаас гадна хүний нэр төрийг гутаан доромжилж, хүнлэг бус, хэрцгий харьцах аргаар мэдүүлэг гаргуулахыг хориглодог.\*\* Энэхүү зарчмууд нь зөвхөн сэжигтний мэдүүлэг бус гэрчийн мэдүүлэгт мөн үйлчилнэ.

\*Эрүү Шүүлтийн Эсрэг Конвенцийн 15 дугаар зүйл, Эрүү шүүлтийн талаарх Америкийн улсуудын Конвенцийн 10 дугаар зүйл.

\*\* Эрүү Шүүлтийн Эсрэг Конвенцийн 12 дугаар зүйл, Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 69(7) дугаар зүйл, Прокурорын ажилтны үүргийн 16 дах удирдах зарчим болон Үндсэн Зарчим – 27 дугаар зарчим

**Холбогдох хэм хэмжээ**

**Яллагдагчийн гүйцэтгэх үүргийн удирдах зарчмууд 16 дугаар удирдамж**  
Яллагчид хуулийн дагуу үүргээ шударгаар, шуурхай биелүүлж, хүний нэр төрийг хүндэтгэн хүний эрхийг хамгаалж, ингэснээрээ эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тогтолцоо тасалдалгүй ажиллах явцыг хангахад тус дөхөм үзүүлэх ёстой.

**Эрүүдэн шүүхийн эсрэг тунхаглалын 12 дугаар зүйл**

Эрүүдэн шүүж, эсхүл хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж гаргуулсан мэдэгдлийг нотлох баримтын хэмжээнд үнэлэхгүй бөгөөд харин эрүүдэн шүүсэн этгээдийн эсрэг ашиглаж болно.

**Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 15 дугаар зүйл**

Оролцогч улс бүр эрүүдэн шүүж хийлгэсэн мэдэгдлийг шүүн таслах ажиллагаанд нотлох баримт болгон хэрэглэхгүй бөгөөд харин түүнийг ийнхүү хийлгэсний нотлогоо болгон эрүүдэн шүүсэн гэмт хэрэгт яллагдаж буй этгээдийн эсрэг ашиглаж болно.

**ОУЭШ-ийн дүрэм 69,/7/ дугаар зүйл**

Дараах тохиолдолд энэ дүрмийн заалт буюу олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн хүний эрхийг зөрчиж авсан нотлох баримтыг хүлээн авахгүй

1/ зөрчил нь нотлох баримтын үнэн зөв эсэхэд ноцтой эргэлзээ төрүүлж байгаа бол

2/ нотлох баримт хэмээн үзэх нь шүүх хуралдааныг шударгаар явуулахтай нийцэхгүй байгаа болон түүнд ноцтой хохирол учруулахаар бол

## 17.2 Хүч хэрэглэж гаргуулсан нотлох баримт нотлох чадвараа алдах нь

Эрүүдэн шүүхээс гадна нотлох баримт гаргаж авах хориглосон хэд хэдэн арга хэлбэрүүд байдаг. Эдгээр аргаар олж авсан аливаа нотлох баримт нь нотлох чадвараа алдана. Хүч хэрэглэх, шахалт үзүүлэх аргаар олж авсан нотлох баримтуудыг ашиглахыг хориглож, Хүний Эрхийн Хорооноос “Эрүүдэн шүүлт болон бусад зүй бус харьцааны үр дүнд бий болсон мэдүүлэг болон материалыг байцаан шийтгэх ажиллагаанд ашиглахыг хуулиар хориглох ёстой” гэж үзсэн.<sup>1</sup> Мөн Хүний Эрхийн Хороо “Хориглосон аргаар цуглуулсан нотлох баримтыг ашиглахыг хуулиар хориглох ёстой”<sup>2</sup>, “хүч хэрэглэсэн, шахалт үзүүлсний улмаас гэм буруутай гэж хүлээсэн мэдүүлгүүдийг шүүн таслах ажиллагаанд нотлох баримтаас хасах ёстой.” гэж Хүний Эрхийн Хороо үзжээ.<sup>3</sup>

Дээрх зарчмуудын дагуу сэжигтэн, яллагдагчийг өөрийн эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах, хүч хэрэглэсэн, шахалт үзүүлсний улмаас гэм буруутай хэмээн мэдүүлэх зэргийг зөрчиж олж авсан нотлох баримтыг шүүхийн шийдвэрт давуу байдлаар үнэлж хэрэглэхийг хориглосон.\* 27-р зарчмын дагуу тухайн нотлох баримтыг олж авахдаа дээрх зарчмуудыг нийцүүлсэн эсэхийг тогтоохдоо нотлох баримтыг олж авах үед дээрхи зарчмуудыг зөрчсөн талаар ямар нэгэн гомдол гаргасан эсэхийг тодорхойлох замаар тооцох ёстой.\*\*

Мэдүүлгийг эрүү шүүлт тулгаж болон хүч хэрэглэсэн, шахалт үзүүлсэн, хүнлэг бус хэрцгий хандлагын үр дүнд гаргуулсан гэх гомдол байгаа тохиолдолд тухайн нотлох баримтыг хэрэгт ашиглахаас өмнө эхлээд уг нотлох баримтыг тусдаа шүүх хуралдаанаар авч үзэх ёстой гэж Эмнести Интернэшнл үзэж байна. Энэхүү шүүх хуралдаанаар тухайн мэдүүлгийг сэжигтэн яллагдагч өөрийн сайн дурын үндсэн дээр өгсөн эсэхийг хянаж үзнэ. Хэрэв мэдүүлгийг сайн дурын үндсэн дээр өгөөгүй гэж үзвэл тэрхүү нотлох баримтыг процесс ажиллагаанаас хасна. Прокурор сэжигтнийг гэм буруутай болохыг тогтоосон нотлох баримтыг сэжигтний эрхийг зөрчиж олж авсан болох нь хангалттай үндэслэлээр батлагдаж байвал түүнд хариуцлага тооцох бүх шаардлагатай алхамуудыг авах ёстой.\*\*\*

### 17.2.1. Америкийн конвенцийн 8.3-р заалт

Америкийн конвенцийн 8.3-д зааснаар хүч хэрэглэж шахалт үзүүлээгүй тохиолдолд сэжигтэн өөрөө гэм буруугаа хүлээсэн бол үүнийг үндэслэлтэй гэж үздэг. Энэ заалт нь 17.1-д заасан стандартаас 2 ерөнхий зарчмаар ялгаатай байна. 1-р ялгаа нь ямар нэгэн нотлох баримтанд биш зөвхөн сэжигтний өөрөө гэм буруугаа хүлээсэн мэдүүлэгтэй холбоотой, 2-р ялгаа нь хүч хэрэглэх, шахалт үзүүлэх аргаар гэм буруутай гэж хүлээлгэсэн мэдүүлгийг нь хавтаст хэргийн материалаас хасахтай холбоотой юм. Гэхдээ гэм буруутай болохоо хүлээсэн зарим мэдүүлэгт эрүү шүүлт болон хүнлэг бус хэрцгий харьцаа хэрэглээгүй байж болно.

Америк дундын комисс “сэжигтэн өмгөөлөгчид хандах, холбоо барих боломжгүй байхад буруугаа хүлээсэн мэдүүлгийг ашиглахыг нь Америкийн Конвенцийн дагуу сэжигтний эрхийг зөрчиж байна” гэж үзэж байна.<sup>4</sup>

#### Холбогдох хэм хэмжээ

#### Америкийн конвенцийн 8.3 дугаар зүйл

Ямар нэгэн дарамт шахалтгүйгээр сэжигтэн өөрийн гэм буруугаа хүлээсэн нь үндэслэлтэй бол энэ нь хүчин төгөлдөр болно.

\* Үндсэн Зарчим – 21 дүгээр зарчим

\*\* Үндсэн Зарчим – 27 дугаар зарчим

\*\*\* Прокурорын ажилтны үүргийн 16 дах удирдах зарчим

#### Ишлэл

1. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 20, догол мөр 12
2. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 14
3. Гүрж: Хүний Эрхийн Төлөв Байдлын Судалгааг Дүгнэх нь, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП/С/79/Нэмэлт 75, 1997 оны 5 дугаар сарын 5, догол мөр 26
4. 1989 оны 9 дүгээр сарын 29-ны №29/89 тоот Шийдвэр, (Никарагуа) Америкийн Улсуудын Байгууллага /Ser.L/V/II.77, баримт бичиг 7, хуудас 73-96;

## Бүлэг 18

### Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тухайн гэмт хэрэгт нь зөвхөн нэг удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэх

Хэнийг ч тухайн үеийн хуулиар гэмт хэрэгт тооцогдож байгаагүй үйлдлийнх нь төлөө шийтгэх, мөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тухайн гэмт хэргийн нь төлөө нэгээс дээш удаа шийтгэхийг хориглоно.

**18.1. Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийн хориглох**

**18.2 Нэг хэрэгт хоёр удаа ял ноогдуулахыг хориглох**

**18.2.1. Америкийн конвенциор нэг хэрэгт хоёр удаа ял тулгахыг хориглосон нь**

**18.3 Олон улсын тусгай шүүхүүд.**

#### 18.1. Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийн хориглоно

Үндэсний болон Олон улсын эрх зүй, Олон улсын хамтын нийгэмлэгээс тогтоосон эрх зүйн зарчмын дагуу тухайн гэмт хэргийг үйлдэх үед уг үйлдэл нь гэмт хэрэг гэж тооцогдож байгаагүй бол тус үйлдлийн нь төлөө ял шийтгэхийг хориглосон.\*

Эрүүгийн эрх зүйд энэ зарчим нь үндэсний онцгой тохиолдлуудаас бусад аливаа нөхцөлд хэрэглэгдэнэ.\*\* /31-р бүлгийг үзнэ үү/.

Энэхүү хориглолт нь эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхээс сэргийлдэг. Түүнчлэн эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг хориглоод зогсохгүй, мөн эрүүгийн хуульдаа гэмт үйлдлийг нарийн тодорхойлохыг тухайн улсаас шаарддаг.

Гэмт хэргийг тухайн улс үндэснийхээ бичмэл хуулийн дагуу тодорхойлдог бөгөөд энэ нь нийтийн эрх зүйн хэм хэмжээнээс үүсч бий болдог.

Олон улсын эрх зүйгээр гэмт хэрэг гэдэг нь олон улсын гэрээний эрх зүй, эсхүл олон улсын заншлын эрх зүйг зөрчсөн үйлдэл юм. Женевийн конвенциор хориглосон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг/ дайны гэмт хэргүүд/, боолчлол, эрүү шүүлт зэргийг үндэсний хууль тогтоомжоор гэмт хэрэг гэж заагаагүй ч олон улсын эрх зүйн дагуу гэмт хэрэг гэж үзнэ.\*\*\*

Тухайн улсын хуулиар эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг хэдийгээр зөвшөөрсөн ч тус гэмт хэргийг үйлдэх үед үйлчилж байсан хуулинд зааснаас илүү хүнд ял оноохыг хориглодог. /Ял шийтгэл 25-р бүлгээс үзнэ үү/

Хүний Эрхийн Хороо “Урагвайд хэдэн хэдэн хэрэгт сөрөг намын гишүүдийг “хориглосон бүлэг”-ийн гишүүн хэмээн цэргийн онцгой шүүхээр

#### Холбогдох хэм хэмжээ

##### ХЭТТ-ийн 11,2 дугаар зүйл

##### ИУТЭОУП-ын 15,1 дүгээр зүйл

“Хэрэг үйлдэх үед нь дотоодын хууль буюу олон улсын эрх зүйгээр эрүүгийн гэмт хэрэгт эс тооцож байсан ямар нэг үйлдэл буюу эс үйлдлээр хэнийг ч гэмт хэрэгтэн гэж буруутгаж болохгүй түүнчлэн эрүүгийн гэмт хэрэг үйлдэх үед хэрэглэж байснаас илүү хүнд ял шийтгэл оногдуулж болохгүй

\* ХЭТТ-ын 11(2) дугаар зүйл, ИУТЭОУП-ын 11 дугаар зүйл, Африкийн Дүрмийн 7(2) болон Америкийн Конвенцийн 9 дүгээр зүйл, Европын Конвенцийн 7 дугаар зүйл, түүнчлэн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 22 дугаар зүйл

\*\* ИУТЭОУП-ын 4 дүгээр зүйл, Америкийн Конвенцийн 27(2) дүгээр зүйл болон Европын Конвенцийн 15(2) дугаар зүйл

\*\*\* ХЭТТ-ын 11(2) дугаар зүйл, ИУТЭОУП-ын 15(1) дугаар зүйл ба Европын Конвенцийн 7(2) дугаар зүйл

шийтгэснийг Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 15-р зүйлийг зөрчсөн” гэж үзсэн байна.<sup>1</sup>

Африкийн комиссоос “Нигер хуулийг буцаан хэрэглэж байгаа нь Африкийн конвенцийн 7.2-ийг зөрчиж байна” гэж тэмдэглэжээ.<sup>2</sup>

## 18.2 Нэг хэрэгт хоёр удаа ял шийтгэхийг хориглох

Гэмт хэрэг үйлдсэн этгээд нь хэрэв тухайн үйлдэлдээ ял шийтгэгдсэн бол тэрхүү үйлдлийн нь төлөө дахин ял шийтгэхийг хориглоно.\*

Энэхүү хориглолт нь *ne bis in idem* зарчмын илэрхийлэл бөгөөд нэг гэмт хэрэг үйлдсэний төлөө нэгээс дээш удаа ял шийтгүүлэхээс эрх зүйн этгээдийг хамгаалдаг. Энэхүү хориглолт нь хэргийн хүнд хөнгөнөөс үл хамааран ба зөвхөн эрүүгийн хэрэгт л хамаатай болно

Хэдийгээр тухайн улсын хуулиар үйлдэл нь гэмт хэрэг гэж тооцогдохгүй байсан ч тухайн үйлдлийн шинж чанар болон оногдуулж болох ял шийтгэлээс хамаарч олон улсын стандартын хүрээнд гэмт хэрэг гэж тооцогдож болох юм.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тухайн гэмт хэргийн нь төлөө нэгээс дээш удаа ял шийтгэхийг хориглосон. Энэхүү хориглолтыг тухайн улсын хууль тогтоомж, холбогдох журмын дагуу ял шийтгэх, эсхүл гэм буруугүй болохыг нь тогтоосон шүүхийн эцсийн шийдвэр гарсны дараа хэрэглэнэ.

Ингэхдээ хэрэглэгдэж болох шүүхийн бүхий л хяналт, давж заалдах шат зэргийг дуусгасан, тэдгээрийн хөөн хэлэлцэх хугацаа нь мөн дууссан байх шаардлагатай.

Дээрх хориглолт нь үйлдсэн нэг гэмт хэрэгтээ шинээр шүүх хурал явуулах, шинээр ял шийтгүүлэх явдлаас сэргийлдэг. Өөр хэргийн харьяалалтай, өөр гэмт хэрэг үйлдсэнийх нь төлөө дахин шүүх хурал явуулах нь дээрх нэг гэмт хэргийн нь төлөө нэгээс дээш удаа ял шийтгэхийг хориглох зарчмыг зөрчихгүй.

Хүний Эрхийн Хороо “Италийн нэгэн иргэн Швейцарьт үйлдсэн гэмт хэргийнхээ төлөө шийтгүүлсний дараа Италид дахин шийтгүүлсэн” хэргийг авч үзээд тухайн үйлдсэн гэмт хэргийн төлөө нэгээс дээш удаа ял шийтгэхгүй гэсэн хориглолт зөвхөн тухайн улсад л хамаатай гэж үзсэн тул дээрх хориглолтыг зөрчсөн гэж үзээгүй байна.<sup>3</sup>

### Холбогдох хэм хэмжээ

#### ИУЭОУП-ын 14.7 дугаар зүйл

Үйлдсэн гэмт хэрэгтээ тухайн улсын хууль болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу эцэслэн шийтгүүлсэн буюу цагаатгагдсан хэнийг ч тэрхүү гэмт хэргээр нь дахин шүүх буюу шийтгэх ёсгүй.

#### Европийн конвенцийн 7-р протоколын 4 дүгээр зүйл

1. Үйлдсэн гэмт хэрэгтээ тухайн улсын хууль болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу эцэслэн шийтгүүлсэн буюу цагаатгагдсан хэнийг ч тэрхүү гэмт хэрэгт нь адилхан улсын шүүн таслах ажиллагааны дагуу эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаагаар дахин шүүх буюу шийтгэх ёсгүй.

2. Дээрх заалт нь тухайн улсын хууль болон эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар шинэ нотлох баримт, өмнө нь тогтоогдоогүй нөхцөл байдал шинээр илэрсэн эсхүл өмнөх байцаан шийтгэх ажиллагаанд хэргийн үр дүнд нөлөөлж болохуйц алдаа илэрсэн бол хэргийг дахин сэргээхэд саад болохгүй.

\* ИУТЭОУП-ын 14(7) дугаар зүйл, Европын Конвенцийн 7 дугаар Протокол

### Ишлэл

1. Вейнбергер ба Уругвай, (28/1978), 1980 оны 10 дугаар сарын 29, 1 Sel. Dec. 57, 12 ба 16 дугаар догол мөр, Пиетрарона ба Уругвайн хэрэг (44/1979), 1981 оны 3 дугаар сарын 27, 13.2 болон 17 дугаар догол мөр
2. Иргэний Эрх Чөлөөний Байгууллага ба Нигер, (129/93), Африкийн Комиссын жил бүрийн 8 дах Илтгэл, 1994-1995 он. Хүний болон Улс Түмний Эрхийн тухай Африкийн Комисс /RPT/8th

Тухайн үйлдсэн гэмт хэрэгт нэгээс дээш удаа ял оноохыг хориглосон нь байцаан шийтгэх ажиллагаа буруу явагдсан тохиолдолд тус хэргийг дахин сэргээх явдлаас сэргийлж чадахгүй. Шинээр илэрсэн нөхцлийн улмаас хэргийг сэргээх, шинэ процессын ажиллагаа явуулж, нэг хэрэг 2 эсхүл түүнээс илүү шүүн таслах ажиллагаа явуулах эсхүл шийтгэхийг хориглосон байна. Шинээр процесс ажиллагааг дараах тохиолдолд явуулж болно. Үүнд: нотлох баримтууд өөрчлөгдсөн, процедурын ноцтой алдаа гаргасан, шинээр илэрсэн нөхцөл байдлын үндсэн дээр дахин процесс ажиллагааг явуулж болно. /Шүүхийн алдаанаас үүссэн хохиролыг нөхөн төлүүлэх эрх 30-р бүлгээс үз./

### 18.2.1. Америкийн конвенцийн дагуу нэг гэмт хэрэгт хоёр ял тулгахыг хориглох

Америкийн конвенцийн 8-р зүйлийн 4-д заасны дагуу тухайн үйлдсэн гэмт хэргийн нь төлөө нэгээс дээш удаа ял шийтгэхийг хориглосон нь Иргэний болон Улс Төрийн Эрхийн пакт болон Европын конвенцийн 7-р зүйлд зааснаас ялгаатай ойлголт юм.

1-рт ИУТЭОУП болон Европын Конвенцийн дагуу тус конвенцид ял шийтгэл ба гэм буруугүйг тогтоох явдал хамаарч байгаа бол Америкийн конвенцийн хориглолт 7-р зүйлээр зөвхөн тухайн этгээдийг гэм буруугүй гэж нотлогдон шийдвэрлэгдсэн хэргүүдэд хамаарна. Хоёрдугаарт 7-р зүйлд нэг үйлдлийн төлөө нэгээс дээш удаа шүүгдэхийг хориглосон бол, Америкийн конвенциор нэг шалтгаант үндэслэлээр дахин процесс ажиллагаа явуулахыг хориглодог. Үүний дагуу хэрэв үйлдэл нь тухайн гэмт хэрэгтэй холбоотой байвал, өөр бие даасан үйлдэл гэж үзэхгүй дахин процесс ажиллагаа явуулахыг хориглодог. Америкийн Конвенцийн 8-4 дүгээр зүйлийн дагуу шинэ процесс ажиллагааны үр дүнд тухайн хүнийг гэм буруугүй гэдгийг нотолсон ч шинэ процесс явуулснаар хүний эрхийг зөрчсөн гэж үзнэ.<sup>4</sup>

### 18.3. Олон улсын тусгай шүүх

Хүмүүнлэгийн эрх зүйг ноцтой зөрчсөн үйлдлийнх нь төлөө үндэсний шүүхээр шүүгдсэн хүмүүсийг хуучин Югослав буюу Руандагийн олон улсын эрүүгийн шүүхээр дахин шүүж болно. Үүнд: Үндэсний хууль тогтоомжоор шүүгдэж байсан этгээдийн хэргийг ердийн гэмт хэрэг гэж тодорхойлсон, үндэсний шүүхийн үйл ажиллагаа шударга бус буюу бие даасан бус болсон тохиолдолд, эсвэл үндэсний шүүх ажиллагаа гэмт этгээдийг олон улсын эрүүгийн хариуцлагаас хамгаалсан буюу үндэсний шүүхээс ял оноогоогүй зэрэг нөхцлүүд болно. Хүмүүнлэгийн эрх зүйг ноцтой зөрчсөн үйлдлээр Югославын буюу Руандагийн олон улсын эрүүгийн шүүхээр мөн шүүгдсэн бол үндэсний шүүхээр дахин шүүгдэхгүй.\*

\* Югославын Дүрмийн 10 дугаар зүйл, Руандагийн 9 дүгээр дүрэм. Мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 20 дугаар зүйлүүдийг үзнэ үү.

#### Холбогдох хэм хэмжээ

Америкийн конвенцийн 8.4 дүгээр зүйл  
Анхан шатны шүүхийн шийвэрээр цагаатгагдсан этгээд нь тухайн шалтгаанаараа дахин шүүгдэх ёсгүй



## Бүлэг 19

### Хүндэтгэн үзэх шалтгаангүй тохиолдолд цаг алдалгүй хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх

Эрүүгийн хэргээр шийтгэгдэж байгаа аливаа этгээд нь хэргээ хэт сунжруулахгүйгээр хянан шийдвэрлүүлэх бүрэн эрхтэй. Шүүх хэргийг үндэслэл бүхий хугацаанд хэргийн нөхцөл байдлаас хамааран шийдвэрлэнэ.

**19.1 Хүндэтгэн үзэх шалтгаангүй тохиолдолд цаг алдалгүй хэргийг шүүхээр хянан шийдвэрлүүлэх**

**19.2. Боломжит хугацаа гэж юу вэ?**

**19.2.1. Хэргийн нөхцөл байдал**

**19.2.2. Шүүгдэгчийн хандлага**

**19.2.3. Эрх бүхий албан тушаалтны хандлага**

### 19.1. Хүндэтгэн үзэх шалтгаангүй тохиолдолд цаг алдалгүй хэргийг шүүхээр хянан шийдвэрлүүлэх

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь үндэслэл бүхий хугацааны дотор эхэлж, дуусгавар болсон байх ёстой.\* Энэхүү шаардлага нь шүүгдэгч өмгөөлүүлэхэд хангалттай цаг хугацаа, нөхцлөөр хангагдах эрхтэй тэнцэх /8-р бүлгийг үзнэ үү/ бөгөөд байцаан шийтгэх ажиллагаа нь хэт сунжрахгүйгээр эхлэх бөгөөд давж заалдах шатыг гүйцээсний дараагаар эцсийн шатанд ялыг онооно.

Тус эрх нь ИУТЭОУП-ын 14.3.с, Югославын дүрмийн 21.4с, Руандагийн дүрмийн 20.4с, ОУЭШ-ийн дүрмийн 67.1.с зүйлүүдэд “шүүхээс эрүүгийн хэргийг хэт хойшлуулалгүйгээр шийдвэрлэхийг шаардна” хэмээн заасан, Африкийн дүрмийн 7.1.d, Америкийн конвенцийн 8.1, Европын конвенцийн 6.1-д “бүх шүүх эрүүгийн болон бусад хэргийг үндэслэл бүхий хугацааны дотор шийдвэрлэнэ” хэмээх заалтуудаар баталгаажна. /“хэргийг хэт хойшлуулалгүйгээр шийдвэрлэх” болон “үндэслэл бүхий хугацаан дотор” гэдэг ойлголтуудын хооронд хэлний өөрчлөлтөөс шалтгаалсан зөрүү гаргахгүй байх нь практикт маш чухал ач холбогдолтой байна. /

Эрүүгийн хэргээр яллуулж буй этгээдийг урьдчилан хорих төвд саатуулж байгаа бол төр үндэслэлгүйгээр хэргийг нь хойшлуулахгүй байх, шүүх хурлыг илүү шуурхай явуулах үүргийг хүлээнэ. Олон улсын стандартын дагуу эрүүгийн хэргээр шийтгэгдсэн этгээд нь тодорхой нөхцөлд тогтоосон үндэслэл бүхий хугацааг биелүүлсэн тохиолдолд шүүхээс эдлүүлээгүй үлдсэн хорих ялаас нь чөлөөлж болно. (Үндэслэл бүхий хугацааны дотор шүүгдэх эрх болон хорих ялаас чөлөөлөгдөх нөхцлийг 7 дугаар бүлгээс харна уу.)

#### Холбогдох хэм хэмжээ

ИУТЭОУП-ын 14 дүгээр зүйлийн 14.3 (с)-д зааснаар -Эрүүгийн хэргээр яллагдах гэж байгаа этгээдийн хувьд “хүн бүр хамгийн наад зах нь дараах баталгааг адил тэгш байдлаар эдлэх эрхтэй. Үүнд С. Хэт хойшлуулалгүйгээр шалгуулах эрхтэй” хэмээсний дагуу энэхүү баталгааг эдэлнэ.

\* ИУТЭОУП-ын 14(3) (в) дүгээр зүйл, Африкийн Дүрмийн 7(1) (г) дугаар зүйл, Америкийн Конвенцийн 8(1) дугаар зүйл, Европын Конвенцийн 6(1) дүгээр зүйл, Югославын Дүрмийн 21(4)(в) дугаар зүйл, Руандагийн 20(4)(в) дугаар дүрэм. Мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 67(1)(в) дугаар зүйл.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг шүүхээс түргэсгэх нь эрх чөлөөтэй байх, гэм буруугүй гэх таамаглал байгаа тохиолдолд өөрийгөө хамгаалах эрхийг нь хязгаарлах боломжтой байдаг байна. Гэсэн хэдий ч үүний зорилго нь нөгөө талаасаа яллуулж буй этгээдийн хувь тавиланг хэт сунжруулахгүйгээр шийдвэрлэхэд оршино. Гэрч худал мэдүүлэг өгсөн, мэдүүлгүүд нь хоорондоо зөрсөн, гэрч оролцох боломжгүй болсон болон бусад нотлох баримтууд нь устсан, алга болсон нь хэрэг шийдвэрлэх хугацаа нь сунжирч тухайн этгээдийн өмгөөлөх эрхэд халдах хангалттай үндэслэл болохгүй. Мөн энэ нь гэм буруугүй гэх таамаглал байгаа эсэхээс үл хамааран эрүүгийн хэрэгт яллагдаж байгаа байгаа этгээд гутранги байдалд орж эргэлзээтэй байгаа нөхцөл байдлаас сунжруулахгүйн тулд хүлээн зөвшөөрөхөөс хамгаалах, баталгаажуулах зорилготой.

Энэхүү шалгах эрхийг ерөнхийд нь товчоор хэлбэл шүүн таслах ажиллагаа хойшилсоор байвал шударга ёс, үнэн байдал үгүйсгэгдсээр байдаг гэж ойлгож болно. Шүүгдэгч өөрөө эрх бүхий албан тушаалтанд байцаан шийтгэх ажиллагааг түргэсгэх хүсэлт гаргасан бол боломжит хугацааны дотор шүүгдэх эрхэд хамаарахгүй байна. Хэдийгээр тийм боловч байцаан шийтгэх үйл ажиллагааг батлах үүрэг нь шүүгдэгчид ерөнхийлөн тогтоосон хугацааны дотор хамаарахгүй байж болох бөгөөд шүүгдэгч нь онцгой хохиролоос шалтгаалж хойшлогдсон бол тогтоохгүй байж болдог.

Эрх бүхий албан тушаалтнаас мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж, тодорхой арга хэмжээ аван түүнийг сэжигтнээр тогтоосон цаг мөчөөс эхлэн энэхүү эрхийн үргэлжлэх хугацааг тодорхойлно. Энэ нь уг хэргийг сүүлчийн шатанд нь хүртэл хэлэлцүүлээд дууссан бөгөөд шүүхийн шийдвэр гарснаар дуусгавар болно. Хүний эрхийн комиссын тогтоосноор “түүний баталгааг зөвхөн шүүхээр шийдвэрлүүлэх шатнаас эхлэн хамааруулах хэрэгтэй гэх боловч мөн уг харилцаа дуусгавар болох буюу шүүхийн шийдвэрийг уншиж танилцуулсан хугацааг хамаарах бөгөөд түүнчлэн бүх шатыг хэт хойшлуулгүйгээр явуулах ёстой.” Шүүх анхан шатны болон давж заалдах шатны аль алинд нь хэргийг олон хойшлуулалгүйгээр үйл ажиллагаагаа явуулахын тулд үйл явц нь чөлөөтэй байх ёстой бөгөөд энэхүү эрх нь хүчин төгөлдөр болсон байх шаардлагатай.<sup>1</sup>

## 19.2. Боломжит хугацаа гэж юу вэ?

Шүүх хэрэг бүрийн нөхцөл байдлаас хамааран тухайн хэргийг боломжит хугацаанд нь шийдвэрлэдэг. Энэ нь дараах бүрэлдэхүүн хэсгийг агуулдаг. Үүнд: шүүгдэгч цагдан хоригдсон эсэх, үндэсний хууль тогтоомж, хэргийн ээдрээтэй байдал, шүүгдэгчийн зан байдал болон эрх бүхий албан тушаалтны зан байдал зэрэг орно. Шүүх 10 жил үргэлжилсэн хэргийг боломжит хугацааны дотор шийдвэрлэгдсэн хэмээн тооцож болох бол нэг жилээс доош хугацаанд үргэлжилсэн хэргийг үндэслэлгүйгээр хойшлогдсон гэж үзэх үндэслэлтэй байна.

Панамд нэгэн хүн амины хэрэгт сэжиглэгдэж байгаа хүнийг барьцаагаар гарах хөрөнгөгүй тул хэргийг шийдэж цагаатгах хүртэл гурван жил 6 сар хорьсон нь Хүний Эрхийн Хорооны үзэж байгаагаар түүний ялын дүгнэлтийг сонсгох болон шүүх хурлын хооронд удааширсан нь зөвхөн мөрдөн байцаалтыг сунжируулсан болон бодит байдлын улмаас болсон гэж тайлбарлах боломжгүй юм гэжээ.<sup>2</sup>

Америк дундын шүүхээс шүүх болон эрх бүхий байгууллагын удирдамж, хэргийн ээдрээ төвөгтэй нөхцөл байдал, үндэсний хууль тогтоомжийг авч үзсэний дараагаар шүүн таслах ажиллагааг 50 сар үргэлжлүүлсэн нэгэн хэргийг Америкийн конвенцийн 8.1-р зүйлийг ноцтой зөрчсөн байна гэж үзжээ.<sup>3</sup>

### Ишлэл

1. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 10
2. Дел Цид Комез ба Панамын хэрэг(473/1991), 1995 оны 7 дугаар сарын 19, НҮБ-ын баримт бичиг. ИУТЭОУП/С/57/1, 1996 он, хуудас 46
3. Суарез Росерогийн хэрэг, Эквадор, 1992 оны 11 дүгээр сарын 17

### 19.2.1. Хэргийн ээдрээтэй байдал

Үйл ажиллагаа явагдаж дуусахаас өмнө хэргийн ээдрээ төвөгтэй байдлын талаар авч үзэх нь боломжит хугацаа гэж үзэхэд олон хүчин зүйлс нөлөөлнө. Үүнд: холбогдох хэрэг хэр ноцтой, хэрэгтэнд оноогдох ялын тоо, ямар мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах шаардлагатай, гэмт хэрэгт оролцсон хүний тоо, гэрчийн тоо зэргээс хамаарах юм.

Эдийн засгийн болон мансууруулах бодистой холбогдох хэрэгт олон хэрэгтэн холбогдсон, олон улсын үзэл санааны зөрөлдөөн бүхий хэрэг болон хүнд хүн амины хэрэг, “алан хядагч нартай” холбоотой байгууллагатай холбогдох хэрэг нь жирийн эрүүгийн хэргээс илүү түвэгтэй байдаг бөгөөд хэрэг аль болох ахар хугацаанд шийдэгдэхгүй удааширдаг.

607 эрүүгийн хэрэгт 723 хэрэгтэн холбогдсон хэргийг найман жил нэг сарын хугацаанд шүүн тасласан нь анхан шатандаа боломжит хугацаа байна гэж Европын шүүх үзжээ. Гэтэл энэ хэрэг нь цааш нэлээн сунжирсан бөгөөд цэргийн шүүхэд шүүхийн тогтоолын үндэслэлийг бичгээр үйлдэхэд гурван жил орсон бөгөөд хоёр ч удаагийн давж заалдах шатны хурал нь зургаан жил гаруй болсон нь боломжит хугацаанаас хэтэрсэн байна.<sup>4</sup>

### 19.2.2 Шүүгдэгчийн хандлага

Шүүгдэгч эрүүгийн хэргийг шүүн таслах, шийдвэр гаргахад хамтран оролцох ёсгүй буюу өөрөөр хэлбэл шүүн таслах ажиллагаанаас татгалзах эрхгүй.<sup>5</sup> Гэхдээ шүүн таслах ажиллагааг хэт хойшлуулалгүйгээр явуулах эсэх нь шүүгдэгчийн хандлагаас хамаарч шийдэгдэнэ. Шүүгдэгч шүүн таслах ажиллагаанд оролцоогүй эсхүл оргон зайлсхийх оролдлого хийх юм уу, өмгөөлөгчөө сонгохгүй, ялын тогтоол сонсгоход байхгүй байх зэргээр шүүн таслах ажиллагаанд оролцохгүй байх нь эрх бүхий байгууллагаас шалтгаалж хойшлогдсонд тооцогдохгүй. Энэхүү хойшлуулалтын үр дүнд үндэслэл бүхий хугацааны дотор байцаан шийтгэх үйл ажиллагаа нь явагдсан эсэхийг тодорхойлоход шүүгдэгчид хамаарах хэсгийг хэрэгсэхгүй болно. Нэмж хэлэхэд шүүгдэгчийн өгсөн мэдүүлэгт бүр эхнээсээ л хэрэгт үр ашигтай, зайлшгүй шаардлагатай гэх нэг ч зүйл байхгүй бол түүнийг санаатайгаар саад учруулсанд тооцно.

### 19.2.3. Эрх бүхий албан тушаалтны хандлага

Эрх бүхий байгууллага нь шүүн таслах ажиллагааг явуулах үүрэгтэй. Хэрвээ шүүн таслах ажиллагааг аль нэг шатанд цалгардуулах, мөрдөн байцаах ажиллагаа болон шүүхээр хэргийг хэлэлцэх ажиллагааг зогсонги байдалд оруулах, тодорхой арга хэмжээ авахгүйгээр шалтгаангүйгаар цаг хугацаа алдвал үндэслэлгүйгээр цаг хугацаа хойшлуулсан хэмээн үзнэ. Иймэрхүү байдлаар эрүүгийн шүүхийн тогтолцоо нь өөрөө шүүх хурлын дүгнэлтийг хурдан гаргах нөхцөлд саад болж байвал шүүгдэгчийн боломжит хугацаанд хэргээ шийдүүлэх эрх зөрчигдөнө.

Канад улсад давж заалдах хурал гурван жилээр хойшилсон шалтгаан нь шүүх хурлын протоколыг бэлтгэх гэж 29 сар болсныг ИУТЭОУП-ын 14-р зүйлийг зөрчсөн байна гэдгийг Хүний Эрхийн Хороо шалган тогтоосон байна.<sup>6</sup>

Өөр нэг хэрэг дээр давж заалдах шатны баримтыг бүрдүүлж холбогдох давж заалдах шүүхэд бүртгүүлэхээр шилжүүлэх хүртэл 15 сар хагас болсон бөгөөд энэ тухай эрх бүхий байгууллага нь хангалттай тайлбар өгөөгүй зэргээс харахад энэ нь үндэслэл бүхий хугацаанд хэрэг шийдүүлэх эрхийг ноцтой зөрчсөн хэмээн Европын шүүх үзжээ.<sup>7</sup>

#### Ишлэл

4. Митап болон Мюфтооглу ба Турк, (6/1995/512/595-956), 1996 оны 3 дугаар сарын 25
5. Ягци болон Саргин ба Турк, (6/1994/453/533-534), 1995 оны 6 дугаар сарын 8
6. Пинкней ба Канад, (27/1978), 1981 оны 10 дугаар сарын 29, 10 болон 22 дугаар догол мөр
7. Бункети ба Голланд, (26/1992/371/445), 1993 оны 5 дугаар сарын 26

## Бүлэг 20

### Өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрх

Гэмт хэрэгт яллагдаж байгаа хүн бүр өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх буюу өөрөө өөрийгөө өмгөөлөх эрхтэй байдаг. Өөрсдийн сонгож авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, шүүн таслах ажлын шаардлагаас хамааран тэдэнд хууль зүйн туслалцаа үзүүлэхээр шүүхээс тохоон томилсон өмгөөлөгчтэй байх, өмгөөлөгч авсны хөлсийг төлөх чадваргүй бол үнэ төлбөргүйгээр өмгөөлүүлэх эрхтэй. Өмгөөлөгчтэйгээ тогтмол харилцаатай байх эрхтэй. /Бүлэг 3-аас Шүүх хурлын өмнө хуулийн зөвөлгөө авах эрхийн тухай үзнэ үү./

#### 20.1 Өмгөөлүүлэх эрх

#### 20.2 Өөрөө өөрийгөө өмгөөлөх эрх

#### 20.3 Өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрх

##### 20.3.1 Өмгөөлөгчийн эрхийн тухай

##### 20.3.2 Өмгөөлөгчөө сонгох эрх

##### 20.3.3 Томилогдсон өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, үнэ төлбөргүй хуулийн зөвлөлгөө авах эрх

#### 20.4 Өмгөөлөгчид итгэмжилсэн төлөөлөл олгох эрх

#### 20.5 Дадлага туршлагатай, нэр хүндтэй өмгөөлөгч авах эрх

#### 20.6 Өмгөөлүүлэхэд нь хавчих, айлган сүрдүүлэхийг хориглох нь

### 20.1 Өмгөөлүүлэх эрх

Гэмт хэрэгт яллагдаж байгаа хүн бүр өөрт нь тулгасан хэргийг өмгөөлүүлэх буюу өөрөө өмгөөлөх бүрэн эрхтэй.\*

\* ХЭТТ-ын 11(1) дугаар зүйл, ИУТЭОУП-ын 14(3) дүгээр зүйл, Африкийн Дүрмийн 7(1) (в) дугаар зүйл, Америкийн Конвенцийн 8(2) дугаар зүйл, Европын Конвенцийн 6(3) (в) дүгээр зүйл, Югославын Дүрмийн 21(4)(г) дугаар зүйл, Руандагийн 20(4)(г) дугаар дүрэм мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 67(1)(г) дугаар зүйл.

#### Холбогдох хэм хэмжээ

##### ИУТЭОУП-ын 14 дүгээр зүйлийн 14.3.(d)

“эрүүгийн хэрэгт яллаж байгаа аливаа этгээдийн хувьд дараах баталгаагаар адил тэгш хангуулах эрхтэй. Үүнд:

d) шүүх ажиллагаанд өөрөө өөрийгөө өмгөөлөх, сонгосон өмгөөлөгчөөрөө дамжуулан оролцох эрхтэй. хэрэв шүүгдэгч нь төлбөрийн чадваргүй бол шүүн таслах ажиллагааны шаардлагын дагуу түүнд үнэ төлбөргүйгээр хууль зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчийг шүүхээс томилж өгнө”

##### Африкийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.(c)

“аливаа этгээд нь шүүхийн үйл ажиллагааг сонсох эрхтэй. Үүнд дараах зүйлийг хамааруулна.

c) өмгөөлөх эрх, өөрийн сонгосон өмгөөлөгчөөрөө өмгөөлүүлэх эрх”

##### Америкийн конвенцийн 8 дугаар зүйлийн 8.2.(d)

“Эрүүгийн хэргээр шүүгдэж байгаа аливаа этгээдийг хуулиар гэм буруутайг нь тогтоох хүртэл гэм буруугүй гэж үзнэ. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад аливаа этгээд нь тэгш байдлаар дараах баталгааг эдэлнэ. Үүнд:

(d) шүүгдэгч нь өөрөө өөрийгөө өмгөөлөх, сонгосон өмгөөлөгчөөрөө дамжуулан өмгөөлүүлэх болон өмгөөлөгчтэйгөө чөлөөтэй, хувиараа уулзах эрхтэй”

Өмгөөлүүлэх эрхийг эдлүүлэхийн гол зорилго нь шүүгдэгч хэргийг нь шүүхээр хэлэлцэхэд биечлэн байлцаж, өөрөө өөрийгөө өмгөөлөхөд оршино. **(21 дүгээр бүлгийг харна уу.** Анхан шатны болон давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцох эрх) Шүүгдэгч сонгосон өмгөөлөгчөөрөө дамжуулан өөрийгөө өмгөөлүүлэх эрхтэй. Өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрхэнд өмгөөлөгчөө сонгох эрх, шүүн таслах ажлын шаардлагаар өмгөөлөгч тохоон томилуулах, шаардлагатай тохиолдолд үнэ төлбөргүйгээр өмгөөлүүлэх эрх багтана.

Яллагдаж байгаа хүн өмгөөлөгчтэйгээ уулзаж, өмгөөлүүлэхэд бэлтгэхэд хүрэлцэхүйц хугацаа, бодит бололцоотой байна. **/Бүлэг 8-ыг үзнэ үү./** Үүнээс гадна яллагдагч хэрэг шүүн таслахад ижил тэгш эрхтэйгээр гэрчийг дуудах болон шалгуулах эрхтэйгээр оролцоно. **/22 дугаар бүлгийг харна уу/**

## 20.2 Өөрөө өөрийгөө өмгөөлөх эрх

Гэмт хэрэгт яллагдаж байгаа хүн бүр өөрт нь тулгасан хэргийг өөрөө өмгөөлөх бүрэн эрхтэй.\*

Энэ тохиолдолд яллагдагч өмгөөлөгчийн туслалцаа авахыг хүсч болох бөгөөд шүүх хурал дээр өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрхтэй болохыг мэдэгдэнэ.

## 20.3 Өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрх

Өмгөөлүүлэгчээр өмгөөлүүлэхийн эн тэргүүний зорилт нь эрүүгийн хэрэгт яллагдаж байгаа хүний эрхийг хамгаалах, ялангуяа тэдний шударга шүүлгэх эрхийг хангахад оршино.

Гэмт хэрэгт яллагдаж байгаа хүн бүр эрхээ хамгаалахын тулд хуулийн зөвлөлгөө авах, өмгөөлүүлэх эрхтэй.\*\*

Хуулийн зөвлөлгөө авах эрхийг эрүүгийн хэргийг шүүн таслах бүх шатанд буюу шүүх хурлаас өмнө мөрдөн байцаахаас эхлэн эдлэх ёстой. **/Хуулийн зөвлөлгөө авах эрхийг хангах тухай Бүлэг 2.2.1-ээс, Шүүх хурлын өмнө хуулийн зөвлөлгөө авах эрхийн тухай Бүлэг 3-аас үзнэ үү./**

Хэрэгтэн шүүн таслахад оролцохгүй байсан үед ч өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрхээ эдлэх ёстой.

Цаазаар авах ял авч болзошгүй болсон хэрэг дээр хэрвээ хэрэгтнийг өмгөөлөх өмгөөлөгч байхгүй бол шударга байх үүднээс шүүх шүүн таслахгүй байхыг Хүний Эрхийн Хороо шаарджээ. **(Бүлэг 28-аас Цаазаар авах ялын тухай үзнэ үү.)**

### Холбогдох хэм хэмжээ

#### Европын конвенцийн 6 дугаар зүйлийн 6.3.с

“эрүүгийн хэргээр яллагдаж байгаа аливаа этгээд нь дараах эрхийг эдэлнэ. үүнд:

(с) өөрөө өөрийгөө өмгөөлөх, сонгосон өмгөөлөгчөөрөө дамжуулан өмгөөлөх болон хэрэв хууль зүйн туслалцаа авах төлбөрийн чадваргүй бөгөөд шүүн таслах ажиллагаанаас шаардлагатай тохиолдолд шүүхээс томилогдсон өмгөөлөгч авах эрхтэй”

#### Хуульчдын гүйцэтгэх үүргийн зарчмын 1 дэх зарчим

“аливаа этгээд нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүхий л үед эрх, ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор хуульчдаас хуулийн зөвлөгөө авах эрхтэй байна”

\* ИУТЭОУП-ын 14(3)(г) дүгээр зүйл, Америкийн Конвенцийн 8(2)(г) дугаар зүйл, Европын Конвенцийн 6(3)(в) дүгээр зүйл, Югославын Дүрмийн 21(4)(г) дугаар зүйл, Руандагийн 20(4)(г) дугаар дүрэм, Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 67(1)(г) дугаар зүйл

\*\* ИУТЭОУП-ын 14(3)(г) дүгээр зүйл, Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 1 дугаар зарчим, Африкийн Дүрмийн 7(1)(в) дугаар зүйл, Америкийн Конвенцийн 8(2)(г) ба (д) дугаар зүйл, Европын Конвенцийн 6(3)(в) дүгээр зүйл, Югославын Дүрмийн 21(4)(г) дугаар зүйл, Руандагийн 20(4)(г) дугаар дүрэм мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 67(1)(г) дугаар зүйл

### Ишлэл

1. Поитримол ба Франц, (39/1992/384/462), 1993 оны 11 дүгээр сарын 23, хуудас 10
2. Робинсон ба Ямайка (223/1987) 1989 оны 3 дугаар сарын 30, Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл (А/44/40) 1989 он, хуудас 245

Малави улсад Вера болон Ортон Чирвагийн хэргийг өмгөөлөгчгүйгээр шүүн тасалж цаазаар авах ял оноосон нь Африкийн Дүрмийн 7,1,с зүйлийг зөрчсөн гэж Африкийн Комисс үзжээ.<sup>3</sup>

Өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрх эдлэнэ гэдэг нь өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрхийг баталгаажуулах, өмгөөлөгчтэйгээ тогтмол уулзах бодит бололцоотой байх, сонгосон эсвэл томилогдсон өмгөөлөгчөөс хууль зүйн зөвлөгөө авна гэсэн үг юм.

\* Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 5 дугаар зарчим, Югославын Дүрмийн 21(4)(г) дугаар зүйл, Руандагийн 20(4)(г) дугаар дүрэм мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 67(1)(г) дугаар зүйл мөн ИУТЭОУП-ын 14(3)(г) дүгээр зүйлийг үзнэ үү.

\*\* ИУТЭОУП-ын 14(3)(г) дүгээр зүйл, Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 1 дугаар зарчим, Африкийн Дүрмийн 7(1)(в) дугаар зүйл, Америкийн Конвенцийн 8(2) (г) дугаар зүйл, Европын Конвенцийн 6(3)(в) дүгээр зүйл, Югославын Дүрмийн 21(4)(г) дугаар зүйл, Руандагийн 20(4)(г) дугаар дүрэм мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 67(1)(г) дугаар зүйлүүд

### Ишлэл

3. Ортон болон Вера Чирвагийн нэрийн өмнөөс Эмнести Интернэшнл ба Малави, (64/92, 68/92, 78/92 тус тус), Африкийн Комиссын жил бүрийн 8 дах илтгэл, 1994-1995 он. Хүний болон Улс Түмний Эрхийн тухай Африкийн Комисс/ RPT/8th

4. Эстрелла ба Уругвай, (74/1980), 1983 оны 3 дугаар сарын 29, 2 Sel. Dec 93, хуудас 95

5. Бүргос ба Уругвайн хэрэг, (R.12/52), 1981 оны 7 дугаар сарын 29, Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл (A/36/40) 1981 он, хуудас 176; Акоста ба Уругвай, (110/1981), 1984 оны 3 дугаар сарын 29, 2 Sel. Dec 148

6. Америк Дундын Комиссын жил бүрийн илтгэл, 1993, Америкийн Улсуудын Байгууллага Ser.L/V/II.85 баримт бичиг 9, 1 дэх хэвлэл, 1994 он, хуудас 493.

7. Баадер, Распе ба Холбооны Бүгд Найрамдах Герман, (7572/76, 7586/76, 7587/76), 1978 оны 7 дугаар сарын 8, 14DR64; Х болон Холбооны Бүгд Найрамдах Герман, (5217/71, 5367/72, ) 1972 оны 7 дугаар сарын 20, 42 Sel. Dec 139

8. Пинто болон Тринадад ба Тобаго, (232/1987), 1990 оны 7 дугаар сарын 20, Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл (A/45/40) 1990 он, боть 2, хуудас 73

### 20.3.1 Албадан саатуулагдсан этгээд өмгөөлөгч авах эрхтэй болохыг мэдэгдэх

Эрүүгийн хэргээр шүүн таслуулж байгаа хүн бүр өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрхээ эдлэх баталгааг авсан байх ёстой. Хэрэгтэн шүүх хурлын өмнө баривчлагдсан эсхүл албадан албадан саатуулагдаагүй байсан ч энэ эрхийг эдлэнэ. Иймд энэ эрхийг баталгаажуулах шаардлагатай. Өмгөөлүүлэхэд хүрэлцэхүйц цаг хугацаа болон бодит бололцоог хангахын тулд баталгааг урьдчилан олгоно.\* Хуулийн зөвлөлгөө авах эрхийг мэдэгдэх тухай Бүлэг 2.2.1-ийг үзнэ үү.

### 20.3.2 Өмгөөлөгч сонгох эрх

Шүүгдэгч, өмгөөлөгч хоёр нь хоорондоо итгэлцэх нь маш чухал учраас ихэвчлэн шүүгдэгч нь өмгөөлөгчөө сонгон авдаг.\*\*

Цэргийн шүүхээр яллагдагчид хоёр өмгөөлөгчийн нэгийг нь сонгох эрх олгосон нь өмгөөлөгчөө сонгох эрхийг зөрчсөн гэж Хүний эрхийн Хороо тогтоожээ.<sup>4</sup> Мөн цэргийн шүүхээр шүүн таслагдаж байгаа нэгэн шүүгдэгчийг өмгөөлөгчөө сонгоход нь зөвхөн цэргийн шүүхийн өмгөөлөгч нарын нэрсийн жагсаалт өгч, хэрэгтнийг ердийн шүүхийн өмгөөлөгч өмгөөлөх хүсэлт тавиад байхад ч цэргийн шүүхийн өмгөөлөгчийг сонгохыг хүчээр тулгасан нь өмгөөлөгчөө сонгох эрхийг зөрчсөн гэж Хүний Эрхийн Хороо үзсэн байна.<sup>5</sup>

Перу улсад өмгөөлөгч нь зөвхөн нэг удаа нэг алан хядлагын хэргээр яллагдагчийг өмгөөлнө гэсэн хууль гаргасан нь өмгөөлөгч сонгох эрхийг ноцтой зөрчиж байна гэж Америк Дундын Комисс мэдэгджээ.<sup>6</sup>

Нэгэн хэрэг дээр шүүгдэгчийн сонгосон өмгөөлөгч нь мөн хэрэгт сэжиглэгдэж байсан тул үндэсний шүүх өмгөөлөгчийг шүүх хуралд оролцуулахаас татгалзжээ. Мөн шүүгдэгчийн сонгосон өмгөөлөгч нь шүүх хурал дээр дүрэмт хувцасаа өмсөхөөс татгалзсан тул дотоодын шүүх өмгөөлөх зөвшөөрөл олгоогүй байсан нь Европын конвенцийг зөрчсөн явдал болоогүй байна гэж Европын комисс мэдэгджээ.<sup>7</sup>

Сонгосон өмгөөлөгчөөрөө төлөөлүүлэх эрх нь хэрвээ өмгөөлөгч мэргэжлийн ёс зүйн хүрээнд ажиллахгүй буюу шүүхийн тогтоолыг дагаж мөрдөхгүй байвал эрүүгийн шүүн таслах ажиллагаанд оролцуулахаас татгалзсан тохиолдолд хязгаарлагдана.

Мөн төрөөс өмгөөлөгчийн хөлсийг төлж байгаа бол шүүгдэгч заавал сонгосон өмгөөлөгчөө сонгох албагүй. Гэхдээ цаазаар авах ял оноох хэрэг дээр давж заалдах шат хүртэл шүүн таслах ажиллагааг хойшлуулах болсон ч шүүгдэгчийн

сонгосон өмгөөлөгчийг шүүх томилох нь зүйтэй.<sup>8</sup> (Бүлэг 28-аас Цаазаар авах ялын тухай үзнэ үү.)

Европын шүүх “Үндэсний шүүхээс өмгөөлөгчийг томилохдоо өмгөөлүүлэгчийн хүсэл зоригийг харгалзан үзвэл зохино. Тэдний хүсэл сонирхолд нийцэх өмгөөлөгч томилох нь хэдий хүндрэлтэй ч шударга ёсны үүднээс аль болох зохих түвшний, шалтааныг харгалзан үзэх нь зүйтэй” гэжээ.<sup>9</sup>

### 20.3.3 Өмгөөлөгч томилуулах ба үнэ төлбөргүй хууль зүйн зөвөлгөө авах эрх

Хэрвээ шүүгдэгч өөрөө сонгосон өмгөөлөгчгүй бол өмгөөлөгч томилуулж болно.\*

Америкийн конвенцийн 8.2-р зүйлийн (е) хэсэгт зааснаар “хэрвээ шүүгдэгч нь өөрийгөө өмгөөлөхгүй байхаар шийдэх юмуу хуулиар тогтоосон хугацаанд өмгөөлөгч олж чадаагүй тохиолдолд шүүгдэгчийг өмгөөлөх өмгөөлөгчийг тохоон томилно гэж заасан байдаг. Харин ИУТЭОУП-ын 14.3.d , Европын Конвенцийн 6.3-аар зүйлд шүүн таслах ажлын ашиг сонирхол шаардаж байгаа тохиолдолд гэж заасан байна.

Шүүн таслах ажиллагааны ашиг сонирхолоор өмгөөлөгчийг томилох шийдвэрийг гаргахдаа эн тэргүүнд хэргийн ээдрээтэй нөхцөл байдлыг харгалзан үзэх хэрэгтэй.

Хүний эрхийн хорооноос яллагдагчид өөрийн сонгосон өмгөөлөгч байхгүй тохиолдолд шүүхийн аль ч шатанд өмгөөлөгчөөр хангах ёстой гэж Хүний эрхийн Хороо үздэг.

Хурд хэтрүүлсэн хэрэгт холбогдсон нэгэн залуугийн хэргийг авч үзэх үед нь түүнийг компанийхаа үйл ажиллагааг албан ёсоор бүртгүүлээгүй хэмээн буруутгасан байсан нь тогтоогджээ. Хүний эрхийн Хорооноос түүнд оноосон хэрэгт улсын зардлаар өмгөөлөгч томилох шаардлагатай гэж үзсэн байна.<sup>10</sup>

ИУТЭОУП болон Европын конвенцийн дагуу яллагдагчийг үнэ төлбөргүй өмгөөлөгчөөр хангах ёстой гэж үздэг.<sup>11</sup>

Нэгдүгээрт шүүн таслах ажиллагааны ашиг сонирхолын үүднээс өмгөөлөгч томилох шаардлагатай байдаг бол мөн хоёрдугаарт Америкийн Конвенцийн 8/2/е/-д томилогдсон өмгөөлөгчийн зардлыг дотоодын эрх зүйн дагуу төрөөс гаргана гэж заасан байна.\*\* Түүнчлэн Америк дундын шүүх шударга шүүх ажиллагаанд өмгөөлөгч зайлшгүй хэрэгтэй бөгөөд төлбөрийн чадваргүй иргэнийг үнэ төлбөргүй өмгөөлөгчөөр хангах ёстой гэж үздэг.<sup>12</sup>

#### Холбогдох хэм хэмжээ

##### Америкийн конвенцийн 8 дугаар зүйлийн 8.2. (е)

“Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад аливаа этгээд нь дараах баталгааг адил тэгш байдлаар эдэлнэ. Үүнд:

(е) шүүгдэгч нь өөрөө өөрийгөө өмгөөлөх чадваргүй эсхүл хуулиар тогтоосон хугацааны дотор өмгөөлөгч авах боломжгүй бол дотоодын хууль тогтоомжинд заасны дагуу төрөөс төлбөрийг нь төлж өмгөөлөгчөөр хангуулан туслалцаа авах эрхтэй байна ”

\*ИУТЭОУП-ын 14(3)(г) дүгээр зүйл, Америкийн Конвенцийн 8(2)(г) дугаар зүйл, Европын Конвенцийн 6(3)(в) дүгээр зүйл, Югославын Дүрмийн 21(4)(г) дугаар зүйл, Руандагийн 20(4) (г) дугаар дүрэм мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 67(1)(г) дугаар зүйлүүд

\*\* ИУТЭОУП-ын 14(3) (г) дүгээр зүйл, Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 6 дугаар зарчим, Европын Конвенцийн 6(3)(в) дүгээр зүйл болон Африкийн Комиссын Тогтоолын 4 дүгээр хэсэг

#### Ишлэл

9. Кройссант ба Германы хэрэг, (62/1991/314/385), 1992 оны 9 дүгээр сарын 25, хуудас 12
10. Хенри, Дуглас нар ба Ямайка, (571/1994), 1996 оны 7 дугаар сарын 26, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП/ C/57/D/571/1994, догол мөр 9,2
11. ОФ ба Норвеги, (158/1983), 1984 оны 10 дугаар сарын 26, 2Sel.Dec.44
12. Хүний Эрхийн Америк Дундын Шүүхийн Зөвлөх Санал, ОС-11/90, ОС-11/90, Дотоодын хууль сахиулах байгууллагуудын шаардлагатай шат дамжлагыг гүйцээхгүй байх тохиолдол 1990 оны 8 дугаар сарын 10, Америкийн Улсуудын Байгууллага/Ser L./V/III.23 баримт бичиг 12, 1991, догол мөр 25-28

Мансууруулах бодистой холбоотой хэргээр ялагдсан нэгэн этгээдийн хэргийг авч үзээд Европын шүүх нь мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд шүүгдэгчийн хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа авах эрхийг үгүйсгэн Европын конвенцийн дугаар зүйлийн 6.3.с-ийг зөрчсөн байна” гэж үзжээ. Учир нь шүүхийн өмнөх шатанд боломжит бүх арга хэмжээ нь цогцоороо тавигддаг. Өөр хэрэгт тэнсэн харгалзах ялтай байсны улмаас яллагдагчид 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэсэн байна. Нэмж хэлэхэд, шүүгдэгч нь мансууруулах бодис хэрэглэдэг, удаан хугацааны туршид гэм буруутайд тооцогдож байгаа залуу байсан.<sup>13</sup>

Үүний нэгэн адилаар Европын шүүх нь давж заалдах шатанд 5 жилийн ял сонссон этгээдэд үнэ төлбөргүйгээр өмгөөлөгч томилох ёстой гэж үзсэн байна.<sup>14</sup>

Төрөөс ядуу, дорой иргэддээ зориулж эрх зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчөөр хангах бусад арга хэрэгсэл болон хүрэлцэхүйц хөрөнгө мөнгөөр хангах шаардлагатай.\*

## 20.4. Өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах эрх

Шүүгдэгч болон түүний өмгөөлөгчийн хооронд итгэмжлэлийн харилцаа үүсдэг.\*\* Эрх бүхий байгууллагаас энэхүү итгэмжилсэн харилцааг хэвийн хадгалах нөхцлөөр хангах шаардлагатай.

Хуульчдын баримтлах үндсэн зарчмын 22 дахь зарчимд зааснаар Засгийн газар нь хуульчид, тэдний харилцагчдаас мэргэжлийн харилцааныхаа хүрээнд харилцах аливаа харьцаа, зөвлөгөөний нууц шинж чанартай байхыг хүлээн зөвшөөрч хангах ёстой.\*\*\*

Хүний Эрхийн Хороо нь ИУТЭОУП-ын 14 дүгээр зүйлийн 14.3.(b)-д зааснаар өмгөөлөгчтэй байх эрхийн баталгаа нь “шүүгдэгчээс өмгөөлөгчид бүрэн дүүрэн итгэмжлэх эрхийг олгосон байх”-ыг шаардана хэмээн тайлбарласан байна.<sup>15</sup>

Цагдан хоригдсон этгээдэд эрх бүхий албан тушаалтнаас өөрийн өмгөөлөгчтэйгөө нүүр нүүрээ харалцан, утсаар эсхүл бичгийн хэлбэрээр гэх мэтээр уулзах хангалттай цаг, боломжоор хангах ёстой. Энэхүү уулзалт болон утсаар ярих нь хараа хяналтан дор явагдах боловч тэдний яриаг сонсох боломжгүй байх ёстой.^**(3 дугаар бүлгийг харна уу.)**

Мөн Хүний эрхийн хороо өмгөөллийн ажиллагаанд хэтэрхий хүнд суртал үзүүлж байгаа бол энэ нь ИУТЭОУП-ын 14 дүгээр зүйлд заасан шаардлагад нийцэхгүй хэмээн тогтоосон байна.<sup>16</sup>

Баривчлагдсан эсхүл хоригдсон этгээд болон тэдний өмгөөлөгчдийн хоорондын харилцааг шүүх хүлээн авч болохооргүй байвал гэмт хэргийг нарийвчлан авч үзэх буюу хэргийг үргэлжлүүлэхдээ тэднийг оролцуулалгүйгээр хэрэгт авагдсан нотлох баримтанд үндэслэн хэргийг шийдвэрлэнэ.^

### Холбогдох хэм хэмжээ

#### Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмуудын 3 дугаар зарчим

“Төрөөс ядуу, зайлшгүй шаардлагатай болон бусад бэрхшээлтэй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх болон шаардлагатай хөрөнгө мөнгө, бусад арга хэрэгслээр хангана. Мэргэжлийн өмгөөлөгчдийн холбоо нь энэхүү үйлчилгээг үзүүлэх боломж, бусад арга хэрэгслээр хамтран ажиллана”

\* Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 3 дугаар зарчим,

\*\* Америкийн Конвенцийн 8(2)(г) дугаар зүйл, Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 66 дугаар зүйл, Африкийн Комиссын Тогтоолын 2(Д)(1) хэсэг, Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 22 дугаар зарчим болон ИУТЭОУП-ын 14(2) дүгээр зүйлүүдийг үзнэ үү.

\*\*\* Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчим – 22 дугаар зарчим

^ Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 8 дугаар зарчим, Үндсэн Зарчим – 18 дугаар зарчим, Наад захын Жишиг Дүрмийн 93 дугаар дүрэм

^^ Үндсэн Зарчим – 18(5) дугаар зарчим

### Ишлэл

13. Куаранта ба Швейцарийн хэрэг, 1991 оны 5 дугаар сарын 24, 205 Ser.A 17
14. Максвелл ба Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улс (31/1993/426/505), 1994 оны 10 дугаар сарын 28, хуудас 10; Бонер ба Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улс (30/1993/425/504), 1994 оны 10 дугаар сарын 28, хуудас 10 – анхан шатны шүүх хурлаар яллагдагчид 8 жил хорил ял авсан.
15. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 9
16. Гурж: Хүний Эрхийн Төлөв Байдлын Судалгааг Дүгнэх нь, НУБ-ын баримт бичиг, ИУТЭОУП/С/79/Нэмэлт 75, 1997 оны 5 дугаар сарын 5, догол мөр 18



## 20.5. Дадлага туршлагатай, нэр хүндтэй өмгөөлөгч авах эрх

Хуульчид нь бусдыг өмгөөлөхдөө хууль тогтоомж болон холбогдох стандартууд, мөн хуульчийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээнд нийцсэн үйл ажиллагаагаар үйлчлэх ёстой. Түүнчлэн тэдгээр нь өөрсдийн үйлчлүүлэгчдээ өөрсдийнх нь эрх үүрэг болон эрх зүйн тогтолцооны талаар зөвлөх ёстой.\*<sup>17</sup> Мөн өмгөөлөгчид нь шүүхийн өмнө өөрийн үйлчлүүлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зайлшгүй шаардлагатай арга хэрэгслийг ашиглахаас гадна үүнд холбогдох бүхий л хэрэгцээтэй арга замыг нэмж олно.\*\* Шүүхийн үйл ажиллагааг дэмжиж, өөрийн үйлчлүүлэгчийн эрх ашиг сонирхлыг хамгаалахдаа хуульчид нь үндэсний болон олон улсын хэм хэмжээгээр зохицуулагдсан хүний эрх, үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалахыг эрэлхийлэх ёстой.

Америкийн дундын комисс нь өмгөөлөгч нь өөрийн үйлчлүүлэгчийг өмгөөлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд өмгөөллийн туслалцаа авах эрхийг зөрчигдсөн хэмээн үзнэ гэжээ.<sup>18</sup>

Шүүгдэгчид өмгөөлөгч томилох тохиолдолд эрх бүхий албан тушаалтан үйлчлүүлэгчийнх нь яллагдаж байгаа гэмт хэргийн үндсэн шинжид тохирсон туршлага, ур чадвар бүхий хуульчаар хангах үүрэгтэй. Эрх бүхий албан тушаалтан нь шүүгдэгчийг үр нөлөөтэй төлөөлж байгааг баталгаажуулах, шаардлага бүхий арга хэмжээг авах тусгай үүрэг хүлээнэ.<sup>19</sup> Хэрэв томилогдсон өмгөөлөгч нь үр нөлөөтэй байж чадаагүй бол эрх бүхий байгууллагаас өмгөөлөгчийн үүргээ дахин гүйцэтгэх эсхүл солих арга хэмжээ авна.<sup>20</sup>

Хүний эрхийн хороо АНУ-д болсон нэгэн хэргийг авч үзээд “байцаан шийтгэх онцгой ажиллагаанд яллагдагч нь ядуу байдлаасаа болж хангалттай нөлөө бүхий арга хэмжээ авч чадахгүй байгааг шүүх анхаарч чадварлаг өмгөөлөгч томилох тал дээр дутагдалтай байгаад санаа зовинож байгаагаа илэрхийлсэн байна.”<sup>21</sup>

Мөн Хүний эрхийн хороо албан ёсоор томилсон өмгөөлөгчөөс татгалзах шүүгдэгчийн сонголт хязгаарлагдмал нөхцөлтэй хэрэгтэй танилцаад, “прокурорын энэ хандлага” шүүгдэгчийн эрхийг хамгаалах нөхцлийг зөрчсөн” хэмээн үзсэн байна.<sup>22</sup>

Шүүгдэгчийг давж заалдах шатны шүүхэд төлөөлсөн өмгөөлөгчийн хэргийг Хүний эрхийн хороо авч үзээд өргөдлөө татаж авах, заавал давж заалдах албагүй гэдгийг мэдээлэх, анхааруулах зэргээр үр дүнтэй зөвлөмж өгөх нь өмгөөллийн ажиллагаанд багтана гэж үзсэн байна.<sup>23</sup>

## 20.6. Өмгөөлөгчийг хавчих, айлган сүрдүүлэхийг хориглох нь

Хуульчид (эрүүгийн хэрэгт яллагдаж байгаа этгээдийг төлөөлөхдөө дараах арга хэмжээг авна) мэргэжлийн үйл ажиллагаагаар сүрдүүлэг болон бусад муу нөлөөллөөс ангид байдлаар хэрэгжүүлнэ.^

Хүний эрхийн хорооноос “өмгөөлөгч нь мэргэжлийн хэм хэмжээний дагуу өмгөөлөх, үйлчлүүлэгчийг төлөөлөхдөө шүүхийн шийдвэрээс гадуур ямар нэгэн хязгаарлалт, нөлөөлөл, дарамт эсхүл бусад этгээдийн хөндлөнгийн оролцоогүйгээр хэрэгжүүлэх боломжтой байх шаардлагатай” гэж үзсэн.<sup>24</sup>

Өмгөөлөгчийг айлган сүрдүүлсний улмаас шүүхийн шатанд өмгөөлөгчгүй болж, улмаар шүүх хурал үргэлжлэн хуралдаж шүүгдэгчид цаазаар авах ял оноосон нэгэн хэргийг Африкийн Комиссын авч хэлэлцээд Африкийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.с-ийг зөрчсөн гэж үзжээ.<sup>25</sup>

\* Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчим – 13 дугаар зарчим

\*\* Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчим – 14 дугаар зарчим

\*\*\* Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчим – 6 дугаар зарчим

^ Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчим – 16 дугаар зарчим

### Ишлэл

17. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 9
18. Никарагуагийн Мискито гаралтай цөөнхийн эрхийн Төлөв байдлын талаарх илтгэл, Америкийн Улсуудын Байгууллага Ser.L/V/II.62 баримт бичиг 10, 3 дах хэвлэл, 1983 он.
19. Келли ба Ямайка (253/1987) 1991 оны 4 дүгээр сарын 8, Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл (A/46/40) 1991 он, хуудас 248, догол мөр 5.10
20. Артикогийн хэрэг, 1980 оны 5 дугаар сарын 13, цуврал 37 А 16
21. АНУ: Хүний Эрхийн Төлөв Байдлын Тайлбар, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП /C/79/ Нэмэлт 50, 1995 оны 4 дүгээр сарын 7, догол мөр 23
22. Эстрелла ба Уругвай, (74/1980), 1983 оны 3 дугаар сарын 29, 2 Sel. Dec 93, догол мөр 1.8, 8.6, 10,
23. Келли ба Ямайка (253/1987) 1991 оны 4 дүгээр сарын 8, Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл (A/46/40) 1991 он, хуудас 248,
24. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 9
25. Үндсэн Хуулийн Эрхийн Төсөл, (Замани, Лаквот болон бусад 6 хүний нэрийн өмнөөс) Нигерийн Хэрэг, (87/93), Африкийн Комиссын жил бүрийн 8 дах Илтгэл, 1994-1995 он. Хүний болон Улс Түмний Эрхийн тухай Африкийн Комисс /RPT/8th

## Бүлэг 21

### Шүүх хуралд оролцох, давж заалдах эрх

Эрүүгийн хэрэгт буруутгагдаж байгаа хэн ч хэргийг нь шүүхээр хянан хэлэлцэхэд өөрийн биеэр байлцах эрхтэй.

#### 21.1 Шүүх хуралд оролцох эрх

##### 21.2 Шүүгдэгчгүйгээр шүүх хурлыг явуулах

##### 21.3 Давж заалдах шатны шүүх хуралд оролцох эрх

#### 21.1 Шүүх хуралд оролцох эрх

Эрүүгийн хэрэгт яллагдаж байгаа хүн бүр хэргийг шүүхээр хянан хэлэлцэхэд байлцах, өөрийгөө биечлэн өмгөөлөх үүднээс шүүх хуралдаанд өөрийн биеэр оролцох эрхтэй.\* Шүүх хуралдаанд өөрийн биеэр оролцох эрх нь шүүх хуралдаан дээр өөрийгөө өмгөөлөх эрхийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэж үзэж болно. **(20-р бүлгийг үз, Өөрийгээ өмгөөлөх болон өмгөөлөгчийн туслалцаа авах эрх)**

Хэдийгээр шүүх хуралдаан оролцох эрхийн талаар Европын Конвенцид тусган дурдаагүй боловч, Европын Шүүхээс 6-р зүйлийн зорилго, агуулгыг тодорхойлсон байна. Тэдний тодорхойлсноор эрүүгийн хэрэгт шийтгэгдэж буй хүн бүр шүүхийн хэлэлцүүлгэд оролцох ёстой гэжээ.<sup>1</sup>

Америкийн Конвенцийн 8-р зүйлийн 8.2.d-д зааснаар шүүгдэгч өөрийн биеэр өөрийгөө өмгөөлөх эрхийг баталгаажуулсан бөгөөд шүүх хуралдаанд байлцах нь дээрхээс улбаалан гарсан эрх юм.<sup>2</sup>

Шүүн таслах ажиллагаанд байлцах эрх нь шүүгдэгчид (өмгөөлөгчид) шүүх хуралдаан болох цаг, байршилыг хангалттай хугацааны өмнө мэдэгдэх болон шүүгдэгчийг ямар нэг шалтгаангүйгээр шүүх хуралдаанд өөрийн биеэр оролцуулахгүй байхаас зайлсхийх үүргийг эрх бүхий холбогдох этгээдүүдэд оноодог.<sup>3</sup>

Хүний эрхийн Хорооноос эрх бүхий албан тушаалтнууд шүүгдэгчийн эрхийг баталгаажуулах талаар хүчин чармайлт тавихгүй, сул байгаад санаа зовинож байгаагаа илэрхийлжээ. Тэд Зайрын өмнөх эрх бүхий албан тушаалтнууд дуудах хуудсыг шүүгдэгчийн хаяг байршил тодорхой байсныг үл харгалзан хүргэлгүй, шүүх хуралдаанаас ердөө 3 хоногийн өмнө гардуулан хэргийг шийдвэрлэсэн нь шүүгдэгчийн эрхийг зөрчсөн гэж үзжээ.<sup>4</sup>

Шүүгдэгчийн шүүх хуралдаанд оролцох эрх тодорхой хугацаагаар хязгаарлагдаж болдог. Хэрэв шүүгдэгч шүүхийн хэрэг шийдвэрлэх үйл ажиллагаанд саад учруулж, улмаар шүүхээс шүүгдэгчийг цаашдын хуралдааны үйл ажиллагаанд оролцуулах нь зохисгүй гэж үзсэн тохиолдолд хязгаарлаж болдог байна. Хүний эрхийн Хорооноос хэрвээ шүүгдэгчид мэдэгдсэний дараагаар шүүгдэгч хуралдаанд оролцохоос зайлсхийсэн бол мөн хязгаарлаж болно гэж тодорхойлжээ.

Шүүгдэгч шүүх хуралдаан дээр шийтгэх тогтоол уншихад байлцахаас татгалзаж болно. Гэхдээ энэ нь зөвхөн тодорхой нөхцөл байдалд, бичгэн хэлбэрээр татгалзлаа үйлдэх ёстой.<sup>5</sup>

\* ИУТЭОУП-ын 14(3)(г) дүгээр зүйл, Югославын Дүрмийн 21(4)(г) дугаар зүйл, Руандагийн 20(4)(г) дугаар дүрэм. Мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 67(1)(г) дугаар зүйл,

#### Ишлэл

1. Европын Шүүх, Колозза болон Рубинат, 1985оны 2 дугаар сарын 12, цуврал 89 А 14, догол мөр 27
2. Панама дах Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл, Америкийн Улсуудын Байгууллага Ser.L/V/II.44баримт бичиг 38, 1 дэх хэвлэл, 1978 он.
3. Мбенге ба Зайр, (16/1977), 1983 оны 3 дугаар сарын 25, 2 Sel.Dec.76, хуудас 78
4. Мбенге ба Зайр, (16/1977), 1983 оны 3 дугаар сарын 25, 2 Sel.Dec.76, хуудас 78
5. Колозза болон Рубинат, 1985оны 2 дугаар сарын 12, цуврал 89 А 14, догол мөр 27; Поитримол ба Франц, (39/1992/384/462), 1993 оны 11 дүгээр сарын 23, хуудас 10-ыг үзнэ үү.

## 21.2 Шүүгдэгчгүйгээр шүүх хурлыг явуулах

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14-р зүйлийн 14.3.d-ийг уншвал шүүгдэгч биечлэн байгаагүй тохиолдолд түүнгүйгээр шүүх хурлыг явуулах нь зөвшөөрөгдөөгүй гэдэг нь ойлгогдох болно.

Энэхүү тайлбар нь өмнөх Югославын ОУ-ын Эрүүгийн Шүүхийг үүсгэн байгуулах зөвлөмжтэй хамт гарсан НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын илтгэлд дурдагдсан байна. Үүнд: “Шүүгдэгч Олон Улсын Эрүүгийн Шүүхийн өмнө биечлэн ирээгүй байгаа тохиолдолд шүүх хурлыг эхэлж болохгүй. Шүүгдэгчийг оролцуулаагүй шүүх хуралдаан нь Югославын ОУ-ын Эрүүгийн Шүүхийн дүрэмд зөвшөөрөгдсөн байлаа ч ИУТЭОУП-ын 14-р зүйлд нийцэхгүй байгаа л бол ерөнхийдөө хүлээн зөвшөөрөгдөх ёсгүй юм гэжээ.”<sup>6</sup> Югославын эрүүгийн хууль, Руандагийн эрүүгийн хууль болон Олон улсын эрүүгийн шүүхийн дүрэмд шүүгдэгчгүй явагдах шүүх хурлыг үл зөвшөөрдөг.

Хэдийгээр Хүний эрхийн хороо 10 жилийн өмнөөс онцгой нөхцөлд шүүх хурлыг тухайн этгээдийг оролцуулахгүйгээр хийх, ингэхдээ тухайн шүүгдэгч нь шүүх хуралдааны талаар мэдээлэл хүлээн авсан, тодорхой хугацааны өмнө шүүхийн зарлан дуудах хуудас түүнд хүргэгдсэн, тэрчлэн шүүгдэгчид өөрийгөө өмгөөлөх боломжийг олгосон байх ёстой гэж үзэж байсан<sup>7</sup>

Дээрх онцгой нөхцөл байдал гэдэг нь давхар болгоомж шаарддаг. Хүний эрхийн хороо “хүндэтгэх шалтгаанаар шүүгдэгчгүйгээр шүүх хурлыг явуулах тохиолдол байх ч шүүгдэгчийн өөрийгөө өмгөөлөх эрхийг эдлүүлэх, түүнийг баталгаажуулах нь нэн чухал юм.”<sup>8</sup> Хэрэв шүүгдэгч шүүх хуралдаанд оролцохгүй гэж шийдвэрлэсэн бол өмгөөлөгчөөр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх эрх дээрх эрхэд хамаарна гэж үзсэн байна.<sup>9</sup>

Хэрвээ шүүгдэгчид мэдэгдэл хүргүүлээгүйгээр түүнийг байлцуулалгүй шүүх хурал явуулбал шүүгдэгч эрхээ сэргээлгэхээр шаардах эрхтэй.<sup>10</sup>

Өөрийгөө өмгөөлөх, эсвэл өмгөөлөгчөөрөө өмгөөлүүлэх, өмгөөлөгчдөө нотлох баримт сэлт гаргаж өгөх, гэрчийг оролцуулах талаар санал болгохын тулд шүүгдэгч шүүх хуралдаанд биечлэн оролцож, яллах дүгнэлтийг бүрэн хэмжээгээр нь сонсох нь зөв гэж Эмнести Интернэшнл үздэг. Мөн шүүх хурал шүүгдэгчийн оролцоогүйгээр явагдах цорын ганц нөхцөл бол хэрвээ шүүгдэгч тодорхой хугацаанд оролцох боломжгүй томоохон саад, шалтгаантай тулгарсны дараагаар өөрсдөө зориудаар оролцохоос татгалзсан нөхцөлд шүүх хурлыг явуулж болно гэж үздэг. Ийм тохиолдолд видео болон аудио холбоогоор шүүгдэгчийг шүүх хурлыг үйл ажиллагааг үзэх, оролцох боломжийг бүрдүүлэх ёстой. Хэрвээ дээрхээс өөр шалтгаанаар шүүгдэгч шүүх хуралдаанд оролцоогүй тохиолдолд шүүхийн шийдвэр хүчингүйд тооцогдож, өөр шүүхэд хэргийг шинээр дахин авч хэлэлцэх ёстой гэж Эмнести Интернэшнл үздэг.

### Холбогдох хэм хэмжээ

#### Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт:

“Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр дараах наад захын баталгаагаар хангагдах эрхтэй:  
d) хэргийг шүүхээр хянан хэлэлцэхэд өөрийн биеэр байлцах

### Ишлэл

6. Аюулгүйн Зөвлөлийн Тогтоол 808-ын 2 дугаар хэсгийн дагуу Ерөнхий Нарийн Бичгийн Даргын бэлтгэсэн Илтгэл, (1993), НҮБ-ын баримт бичиг, S/25704, 1993 оны 5 дугаар сарын 3 болон S/25704/Corr.1, 1993 оны 7 дугаар сарын 30, Хэсэг 5 А, догол мөр 101
7. Мбенге ба Зайр, (16/1977), 1983 оны 3 дугаар сарын 25, 2 Sel.Dec.76, хуудас 78
8. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 9
9. Пелладоах ба Голландын хэрэг, 1994 оны 9 дүгээр сарын 22, 297В цуврал А 35; Лала ба Голланд, 1994 оны 9 дүгээр сарын 22, 297-А цуврал А 13; Поитримол ба Франц, (39/1992/384/462), 1993 оны 11 дүгээр сарын 23, хуудас 11.
10. Колозза болон Рубинат, 1985оны 2 дугаар сарын 12, цуврал 89 А 14

### 21.3 Давж заалдах шатны шүүх хуралд оролцох эрх

Давж заалдах шатны шүүх хуралд биечлэн оролцох эрх нь тухайн хуралдааны үйл явцын мөн чанараас хамаардаг. Ялангуяа шүүх тухайн хэрэгт хуульзүйн баримт шалгаж байна уу шүүгдэгчийн ашиг сонирхол хамгаалагдсан, хэрэгжсэн эсэхийг шалгаж байна уу гэдгээс хамаардаг.

Хэрвээ давж заалдах шатны шүүх аль алиныг шалгах эрх бүхий байвал шударга шүүх хуралдаан нь шүүгдэгчийг шүүх хуралдаанд оролцуулахыг шаарддаг.

Европын Шүүх Норвегийн Дээд Шүүхэд шүүгдэгчийн эрх зөрчигдсөн гэж үзжээ. Дээд шүүх доод шатны шүүхийн шүүгдэгчийг гэм буруугүй гэж үзсэн шийдвэрийг няцаан, факт болон хууль зөрчсөн эсэх асуудлыг авч үзсэн байна. Ингэхдээ тэд шүүгдэгчид зарлан дуудах хуудас явуулаагүй бөгөөд хүргэх арга хэмжээ авах талаар юу ч хийгээгүй байна. Европын шүүхээс үзэхдээ шүүгдэгчийг өөрийн биеэр оролцуулан нотлох баримт шинжлээгүй тохиолдолд доод шатны шүүхийн гэм буруугүй гэх үзсэн шийдвэрийг няцаах үндэслэлгүй гэжээ. Европын Шүүх мөн энэ тохиолдолд Дээд шүүх шүүгдэгчид зарлан дуудах хуудас хүргүүлэх үүрэгтэй байсан ба шүүгдэгчийг оролцуулан шууд нотлох баримтуудыг авах ёстой байсан гэж үзсэн байна.<sup>11</sup>

Хэрвээ шүүгдэгчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд түүнийг төлөөлөн оролцсон тохиолдолд шүүгдэгчийг биечлэн байлцсан гэж үзэж болно.

Хүний эрхийн хорооноос үзэхдээ Ямайкагийн шүүх хуралдаанд шүүгдэгч өөрөө хуралдаанд оролцолгүй түүний өмгөөлөгч төлөөлөн оролцсон явдал нь зөрчил гаргаагүй гэж үзжээ. Ямаикад зөвхөн хуульд нийцсэн эсэх асуудлыг давж заалдах шатны шүүхэд авч үздэг байна.<sup>12</sup>

Хэрвээ давж заалдах шатны шүүх зөвхөн доод шатны шүүхийн шийдвэр хуульд нийцсэн эсэх маргааныг авч хэлэлцдэг байсан бол Европын шүүхээс шүүх хуралд биечлэн оролцох эрхийг чухалчилан тогтоохгүй байсан.

Итали улсад болсон Кассацийн Шүүх хуралдаанд шүүгдэгчийн өмгөөлөгч шүүх хуралдаандаа оролцох боломжгүй болж, улмаар орлох хуульчийг олж чадаагүйгээс шүүгдэгч төлөөлөгч хоцорсон гэх хэргийг Европын Шүүхээс Европын конвенцийг зөрчсөн гэж үзээгүй байна. Учир нь Кассацийн Шүүх хуульд нийцсэн эсэх асуудлыг авч үзсэн бөгөөд үүний процедур нь тодорхой бичигдсэн байжээ. Шүүхийн сонсголын шатанд өмгөөлөгч нь тухайн шатны шүүх хурлын асуудлаар гомдол гаргах нь хязгаарлагдмал байдаг. Европын Шүүхээс үзэхдээ шүүх хуралд шүүгдэгчийг, шүүх хуралдаанд шүүгдэгчийн өмгөөлөгч төлөөлөн оролцохгүй (эсвэл орны өмгөөлөгчийг сонсгохоор явуулахгүй байх) сонголт хийсэн шийдвэр нь улсын хүлээх хариуцлага биш гэж үзсэн байна.<sup>13</sup>

Эрх мэдэл тэгш байх зарчим давж заалдах шатны шүүх хурлын турш үргэлжилнэ. (Эрх мэдлийн тэгш байдал, 13.2 дахь бүлэг)

#### Ишлэл

11. Боттен ба Норвеги (50/1994/497/579), 1996 оны 2 дугаар сарын 19, хуудас 22; мөн Кремзоу ба Австрийн хэрэг, (29/1992/374/448), 1993 оны 9 дүгээр сарын 21, хуудас 16.

12. Хенри ба Ямайка, (230/1987)1991 оны 11 дүгээр сарын 1, Хүний Эрхийн Төлөв Байдлын Илтгэл, (A/47/40), 1992 он, 225

13. Триподи ба Итали, (4/1993/399/477), 1994 оны 2 дугаар сарын 22

## Бүлэг 22

### Гэрчийг дуудах ба байцаах эрх

Эрүүгийн гэмт хэрэгт холбогдож байгаа хүн бүр өөрийнх нь эсрэг мэдүүлэг өгч байгаа гэрчийг байцаалгах, өөрийн өмнөөс гэрч оролцуулах, шалгуулах эрхтэй.

#### 22.1 Гэрч

#### 22.2 Яллагдагчийн эсрэг мэдүүлэг өгсөн гэрчүүдийг байцаах өмгөөлөгчийн эрх

##### 22.2.1 Далд гэрч

##### 22.2.2 Яллах талын гэрчийг байцаахад тавих хязгаарлалт

##### 22.2.3 Өмгөөлөх талын гэрчийг дуудах ба байцаах эрх

##### 22.2.4 Хохирогч ба гэрчийн эрхүүд

### 22.1.Гэрч

Талуудын тэнцүү нөхцөл боломж ба өмгөөллийн эрхийн үндсэн элемент нь яллагдагчийн гэрч нарыг дуудах ба байцаалгах эрх юм.\* Энэ эрхийн дагуу яллагдагч нь яллах талтай адил гэрч нарт хандах, тэднийг байцаалгуулахад адил тэнцүү эрхтэй байх, үүнийг нь баталгаажуулах асуудал чухал байдаг.<sup>1</sup>

Гэрчийг дуудах, байцаах эрхийн дагуу өмгөөлөгч нь сэжигтний нэрийн өмнөөс нотлох баримт гаргах, гэрч нарыг асуух эсхүл сэжигтний эсрэг байгаа нотлох баримтуудыг шалгах боломжоор хангагдсан байх ёстой. Гэрчүүдийг өмгөөлөх ба яллах тал байцаалгаснаар шүүхэд нотлох баримт сонгох болон шалгах боломжийг олгодог.

Эрх зүйн өөр, өөр тогтолцооноос болж байцаах эсхүл байцаагдах гэсэн ойлголтуудыг олон улсад хэмжээнд өөр өөрөөр хэрэглэдэг. Олон улсын эрх зүйн тогтолцоо дотор нэг талаараа эсрэг талууд гэрчүүдийг байцаан мэтгэлцдэг бол нөгөө эрх зүйн тогтолцоо нь хуулийн байгууллагууд гэрч нарыг байцаадаг юм.<sup>2</sup>

Яллагдагчийн эсрэг мэдүүлэг өгсөн гэрчийг байцаах, эсхүл өөрийн гэрч нарыг дуудан байцаалгах эрх зарим хязгаарлалттай байж болно. Эдгээр баталгаа нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын -14-3-и-д, Европын Конвенцийн 6.3.-д Африкийн комиссийн шийдвэрийн 2.3.и зүйл, Америкийн Конвенцийн 8.2(е) зүйл заалтад тусгалаа олсон байдаг.

#### Холбогдох хэм хэмжээ

**Иргэний болон улс төрийн эрхийн Олон улсын Пактын 14 дүгээр зүйлийн 3(е) :**

Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр дараахь наад захын баталгаагаар хангагдах эрхтэй:

- өөрийнх нь эсрэг мэдүүлэг өгч байгаа гэрчийг байцаалгах, эсрэг гэрчтэй адил нөхцлөөр өөрийн өмнөөс гэрч оролцуулах, шалгуулах

\* ИУТЭОУП-ын 14(3)(д) дүгээр зүйл, Америкийн Конвенцийн 8(2) (е) дугаар зүйл, Европын Конвенцийн 6(3) (г) дугаар зүйл, Африкийн Комиссын Тогтоолын 2(Д) (3) хэсэг, Югославын Дүрмийн 21(4)(д) дугаар зүйл, Руандагийн 20(4)(д) дугаар дүрэм болон Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 67(1) дугаар зүйл,

#### Ишлэл

1. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 9
2. Манфред Новак, НУБ-ын Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт: ИУТЭОУП-ын Тайлбар, 1993 он, НП Энгел, хуудас 262

\* ИУТЭОУП-ын 14(3) (д) дүгээр зүйл, Европын Конвенцийн 6(3)(г) дүгээр зүйл, Америкийн Конвенцийн 8(2)(е) дугаар зүйл, Африкийн Комиссын Тогтоолын 2(Д) (3) хэсэг, Югославын Дүрмийн 21(4)(д) дугаар зүйл, Руандагийн 20(4)(д) дугаар дүрэм мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 67(1)(д) дугаар зүйлүүд

## 22.2. Яллагдагчийн эсрэг мэдүүлэг өгсөн гэрчүүдийг өмгөөлөгч байцаах эрх

Эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа бүх этгээд нь тэдний эсрэг мэдүүлэг өгч байгаа гэрчийг байцаалгах эрхтэй байдаг.\*

Сэжигтэн өөрийгөө өмгөөлөхөд бэлдэхэд хангалттай цаг боломжоор хангагдсан байх ёстой. Тэрхүү эрхийн дагуу яллах талын гэрч нарыг байцаахад бэлтгэх, боломжоор хангагдсан байх ёстой. Энэ нь шүүн таслах ажиллаанд яллах талаас оролцох гэрч нарын талаар урьдчилсан мэдэгдлүүдийг өмгөөлөх талд өгсөн байх үүргийг хүлээлгэж байна. Хэдий тийм боловч процессийн явцад өмнө мэдэгдээгүй гэрч нарын мэдүүлгийг танилцуулсан үед өмгөөлөх талын байцаалтыг бэлтгэх хангалттай цаг хугацаагаар хангах эрхийг түр түтгэлзүүлж болдог юм.<sup>3</sup>

Сэжигтний эсрэг мэдүүлэг өгсөн гэрчүүдийг байцаах эрхийн дагуу бүх нотлох баримтуудыг нээлттэй шүүхийн хэлэлцүүлэг дээр сэжигтнийг байлцахад танилцуулах ёстой гэж үздэг бөгөөд ингэснээр нотлох баримт, гэрч нарын үнэнч шударга байдлыг шалгуулах боломжтой юм. Энэ зарчимаас хэдэн онцгой тохиолдол байдаг хэдий ч энэ онцгой тохиолдлууд хамгаалалтын эрхийг үгүйсгэхгүй.

Европын шүүхээс хар тамхи наймаалах хэргүүдэд гэрч нарыг шүүхэд авчрах гэх мэт хүндрэлүүд гардагийг тэмдэглэхдээ “ хэдийгээр хүндрэлүүд байгаа ч энэ нь өмгөөлөх талын гэрч нарыг байцаах эрхийг хязгаарлах үздэслэл болохгүй гэж үзсэн.<sup>4</sup>

Нэгэн хар тамхины наймааны хэрэгт, Европын шүүх сэжигтний эрхийг зөрчсөн гэж үзсэн байна: Шүүх гэмт хэрэгтнүүдийн дотор ажилладаг/ нууц цагдаагийн агентийн мэдүүлэг, утасны ярианы бичлэг сонсгосны дараа уг мэдүүлэгийн үндсэн шийдвэрээ гаргасан нь шүүгдэгчийн эрхийг зөрчсөн гэж үзжээ. Шүүгдэгч тухайн бичлэгийг шалгах боломжгүй. Нууц цагдаагийн ажилтны амь настай холбоотой учраас уг цагдаагийн ажилтныг шүүхэд хүрэлцэн ирж мэдүүлэг өгүүлэх нэрээр нь заах боломжгүй ажээ. Гэвч энэ хэрэгт цагдаагийн нууц ажилтныг нэргүй гэрч биш, тангараг өргөсөн цагдаагийн ажилтан гэдгийг шүүгч мэдэж байсан бөгөөд шүүгдэгч ч уг цагдаагийн ажилтантай 5 удаа уулзаж байсан гэдгийг Европын шүүхээс тэмдэглэсэн байна.<sup>5</sup>

### 22.2.1 Далд гэрч

Нэргүй гэрчийн мэдүүлгийг ашиглах нь гэрчийг шалгах яллагдагчийн эрхийг зөрчдөг. Учир нь яллагдагчид тухайн гэрчийн үнэн зөв байдлыг шалгах талаар хангалттай мэдээлэл өгдөггүй. Ийм учраас нэргүй гэрчээс ирсэн нотлох баримтыг ашигласанаар тухайн процессийг шударга бус гэж үнэлэхэд хүргэдэг.

Хар тамхины наймаа, террорист ажиллагаа, бослого, зэвсгийн хууль бус наймаа зэрэг хэргүүд дээр шүүгч, прокурор ба гэрч нарын нэрийг өмгөөлөх талынхнаас нуудаг Колумбын нүүргүй шүүхийн тогтолцоог Хүний Эрхийн Хороо шүүмжилсэн байна. Тус Хороо энэ тогтолцоог Иргэний болон улс төрийн эрхийн тухай пактын 14-р зүйлийн 3.б-г зөрчиж байна гэж үзээд цаашид халахыг санал болгосон.<sup>6</sup> Үүний нэгэн адил Америк дундын комисс “нүүргүй гэрчийн талаар санаа зовниж байна” гэжээ. Түүнчилэн тодорхой бус гэрч нарын мэдүүлгийн үндсэн дээр яллахыг зөвшөөрсөн хуулийг Үндсэн хуульд нийцэхгүй

#### Ишлэл

3. Адамс ба Ямайка, (607/1994), 1996 оны 10 дугаар сарын 30, НУБ-ын баримт бичиг: ИУТЭОУП /С/58/607, 1994  
4. Саиди ба Францын хэрэг, (33/1992/378/452), 1993 оны 9 дүгээр сарын 20, хуудас 17  
5. Люди ба Швейцари, (17/1991/269/340), 1992 оны 6 дугаар сарын 15  
6. Хүний Эрхийн Төлөв Байдлын Судалгааг Дүгнэх нь, НУБ-ын баримт бичиг, ИУТЭОУП /С/79/Нэмэлт 75, 1997 оны 4 дүгээр сарын 9, 21 ба 40 дүгээр догол мөр

байна гэсэн Колумбын үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг Америк дундын Комисс сайшаасан байна.<sup>7</sup> Комисс тэмдэглэхдээ прокурорын нэрийг зөвхөн тусгай нөхцөлийн дагуу мэдэгдэх, мөн дээрх зарчмыг өөрчлөхгүйгээр үндэсний эрх зүйн тогтолцооны зохион байгуулалт нь сэжигтний эрхийг хамгаалах болон шударгаар шүүлгэх баталгаагаар хангаж чадахгүй байна гэжээ. Перу ба Колумбын нэргүй гэрчүүдээс авсан мэдүүлгийг ашиглах нь шударга шүүх зарчимд нийцэхгүй байна гэж үзжээ.<sup>8</sup>

Хэдийгээр Европын шүүх нэргүй гэрчүүдийг бүхий л хэрэгт ашиглахыг хориглоогүй ч тэдгээрийн мэдүүлгийг ашиглахад маш нарийн хязгаарлалт байх ёстой гэж зөвлөсөн.<sup>9</sup>

Европын шүүх “Бүх нотлох баримтууд нээлттэй шүүхийн хэлэлцүүлгэнд танилцуулагдах ёстой бөгөөд яллагдагчийн эсрэг талын гаргаж буй үндэслэлүүдтэй танилцах боломжоор хангасан байх ёстой. Хэдийгээр энэ зарчмыг онцгой тохиолдолд хэрэгжүүлэхгүй байж болох боловч үүгээр өмгөөллийн /өмгөөлөх талын гэрчийг асуух/ эрхийг зөрчиж болохгүй. Европын Конвенцийн 6.1 ба 3-р зүйлд зааснаар мэдүүлэг өгч байгаа үед эсхүл түүний дараа яллагдагчийн эсрэг мэдүүлэг өгч байгаа гэрчийг шалгах ба асуулгах тэнцүү ба хангалттай боломжоор сэжигтнийг хангах нь үндсэн гол зарчим мөн гэж үзсэн.

Европын шүүх 2 нэргүй гэрч цагдаагийн офицерт мэдүүлэг өгч офицер нь шүүхэд мэдүүлэг өгсөн хэргийг авч үзсэн.<sup>10</sup> Европын Шүүх хэдийгээр өмгөөлөгч гэрчүүдэд бичгээр асуултаа тавих боломжтой байсан ч гэсэн энэ тохиолдолд яллагдагчийн эрхийг зөрчсөн гэж үзсэн. Европын шүүх тэмдэглэхдээ тухайн гэрчийг тодруулах боломжгүйгээс яллах тал өмгөөлөх талаас давуу эрхтэй байгаа учир адил тэнцүү боломжоор хангагдах зарчимтай зөрчилдөж байна. Гэрчүүдийн үнэнч шударга байдлыг шалгах мэдээллээр дутмаг байсан.<sup>11</sup> гэж үзсэн байна.

Европын шүүх яллагдагчийг нэргүй цагдаагийн офицерийн мэдүүлгийн үндсэн дээр гэмт хэрэг үйлдсэн хэмээгдсэн хэргийг шалгасан байна. Уг хэрэгт өмгөөлөгч гэрчийн нэрийг тодруулах төдийгүй шууд асуулгаар түүний үнэн зөв байдлыг шалгах болон түүний гадаад байдлыг тодорхойлох боломжгүй байжээ. Цагдаагийн офицерүүд шүүгчид нотлох баримт гаргах үед шүүгдэгчийн өмгөөлөгч, прокурор нар тусгай өрөөнд байж асуулт хариултыг тусгай шугамаар сонсож байсан байна. Ийм арга хэмжээ авсан нь тухайн офицерийн нэрийг дэлгэхээс болгоомжилсонтой холбоотой гэжээ. Гэвч Европын шүүх ийм арга хэмжээг өмгөөлөх тал гэрч нарт асуулт тавих, тэдний үнэнч байдлыг шалгах боломжийг орлож чадаагүй учраас тухайн шүүн таслах ажиллагааг ерөнхийдөө шударга бус гэж үзсэн.<sup>12</sup>

Эмнести Интернэшнл Колумба, Перу гэх мэт орнуудад нэргүй мэдүүлэг ашиглахыг ялангуяа олон улсын шүүхэд түүнийг ашиглахыг эсэргүүцэж ирсэн.

## 22.2.2. Яллах талын гэрчүүдийг байцаахад тавих хязгаарлалт

Сэжигтний эсрэг мэдүүлэг өгч байгаа гэрчийн эрхийг дараах үндэслэлээр хязгаарлаж болно. Үүнд: Сэжигтний биеэ авч явах байдал /

### Ишлэл

7. Америк Дундын Комисс, Колумбын Хүний эрхийн Төлөв Байдлын тухай 2 дах Илтгэл, Америкийн Улсуудын Байгууллага /Ser.L/V/II.84, баримт бичиг 39, 1993 он, хуудас 96, 95 болон 249

8. Америк дундын Комиссын жил бүрийн илтгэл, 1996 он, Америкийн Улсуудын Байгууллага/Ser.L/V/II.95, баримт бичиг 7, хуудас 658 ба 736.

9. Доорсон ба Голландын хэрэг, 1996 оны 3 дугаар сарын 26, 2 цуврал А 470, догол мөр 69

10. Ван Менчелен болон бусад (55/1996/674/861-864), 1997 оны 4 дүгээр сарын 23, догол мөр 51

11. Виндешийн Хэрэг, 1990 оны 9 дүгээр сарын 27, 186 цуврал А 11 мөн Костовски ба Голландын хэрэг, 1989 оны 11 дүгээр сарын 20, 166 цуврал А 20

12. Ван Менчелен болон бусад (55/1996/674/861-864), 1997 оны 4 дүгээр сарын 23

жишээ нь сэжигтэн оргосон байдал/, гэрчид хандах боломжгүй болсон, тухайн улсаас гарсанч шинэ хаягаа мэдэгдэлгүйгээр байршлаа сольсон эсхүл гэрч нь үндэслэлтэйгээр аливаа аюул заналхийлэлд өртөхөөс айж болгоомжилсон зэргээр сэжигтэний өмгөөлөгч гэрчээс асуух боломжгүй болсон

Сэжигтэн тухайн орноос гарсанаас хойш 3 жил болсны дараа буцаж ирсэн, яллах талын гэрч ирээгүй хэрэгт Европын шүүх тухайн гэрчийг ирээгүйгээр нь яллах үйл ажиллагааг зогсоох шаардлагагүй гэж үзээд, эрх бүхий байгууллага шаардлагатай хүнийг олж ирэх талаар хүчин чармайлт гаргаагүй гэж үзсэн байна. Байхгүй байгаа гэрчийн цагдаад өгсөн мэдүүлэг, шүүхэд өгсөн бусад нотлох баримт үнэн зөвийг нотолсон гэж Европын шүүх үзсэн байна.

Хүний Эрхийн Хороо ба Европын шүүх тухайн процессоор бий болсон нотлох баримтуудыг өмгөөлөх талд шалгах боломж олгоогүй гэж тусгай тэмдэглээгүй бол сэжигтэн гэрчийг шалгах эрхээсээ түтгэлзсэн гэж тооцдог.<sup>13</sup>

Тухайн орныг орхисон цагдаагийн ажилтны байцаалтыг нотлох баримт гэж үзэхийг зөвшөөрсөн нь сэжигтний эрхийг зөрчөөгүй гэж Хүний эрхийн Хороо үзсэн байна. Түүний мэдүүлгүүд урьдчилсан хэлэлцүүлгийн үед өгсөн байсан бөгөөд тэр үед өмгөөлөгч асуулт тавих боломжтой байсан гэж үзжээ.

Сэжигтэн Хүний эрхийн хороонд цагдаагийн мэдүүлэг нь процесст байгаа бусад нотлох баримтуудтай зөрчилдөж байгаа, мөн уг цагдаа энэ процесст биеэр оролцохгүй байгаагаас сэжигтэнд цагдааг байцаалгах эрхээр хангагдаагүй байна гэж мэдэгдсэн. Гэвч Хүний Эрхийн Хороо үзэхдээ өмгөөлөгч энэ нотлох баримтуудыг шүүхийн процесст танилцуулахад татгалзаагүй, мөн прокурортой адил нөхцөлтэйгээр урьдчилсан хэлэлцүүлгийн үед өмгөөлөгч цагдааг шалгах боломжтой байсан гэж үзсэн. Иргэний ба Улс Төрийн Эрхийн пактын 14-3-и-д зааснаар прокурор ба өмгөөлөгч гэрч нарыг шалгахад тэнцүү боломжоор хангагдсан байх ёстой. Гэвч өмгөөлөгч яллах талын гэрч нарыг процессийн үйл явцад шалгахаас түтгэлзүүлэх боломжтой байна.<sup>14</sup>

### 22.3. Өмгөөлөх талын гэрчийг дуудах ба байцаалгах

Эрүүгийн хэрэгт яллагдаж байгаа ямар ч этгээд түүний эсрэг мэдүүлэг өгч байгаа гэрчүүдийн адил өөрийн талын гэрч нарыг дуудах болон байцаалгах эрхтэй.\*

Яллах талын гэрч нарыг дуудах адил нөхцөлөөр өмгөөлөх талын гэрчийг дуудах эрх нь ямар гэрчийг оролцуулах талаар эрүүгийн шүүхэд өргөн боломжийг олгосон ч шүүгч нар зөвшөөрч тэнцүү боломж ба шударга үйл ажиллагааны зарчимуудыг зөрчихгүй байх явдлыг хангаж өгөх ёстой.

Европын конвенцийн 6.3-д заалтын дагуу сэжигтний талын гэрч болгоныг байлгах, байцаалгах шаардлагагүй ч тэгш боломжийн зарчмын үндсэн дээр шүүх аль гэрчийг дуудах талаар шийдвэрлэх ёстой гэж Европын шүүх үзсэн. Сэжигтний шаардлагын дагуу 4 гэрчийг байцаах асуудлыг шүүх ямар нэгэн шалтгаангүй татгалзсан байсныг шүүхийн шударга үйл ажиллагааны зарчмыг зөрчсөн гэж Европын шүүх үзсэн байна.<sup>15</sup>

Өмгөөлөх талын гэрч мэдүүлэг өгөх хүсэлтэй байсан ч тээврийн

\*ИУТЭОУП-ын 14(3)(д) дүгээр зүйл, Европын Конвенцийн 6(3) (г) дүгээр зүйл, Америкийн Конвенцийн 8(2)(е) дугаар зүйл, Африкийн Комиссын Тогтоолын 2(Д)(3) хэсэг, Югославын Дүрмийн 21(4)(д) дугаар зүйл, Руандагийн 20(4)(д) дугаар дүрэм мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 67(1)(д) дугаар зүйлүүд

#### Ишлэл

13. Артнер ба Австри, (39/1991/291/362), 1992 оны 8 дугаар сарын 28, хуудас 7  
14. Компасс ба Ямайка, (375/1989), 1993 оны 10 дугаар сарын 19, НУБ-ын баримт бичиг, ИУТЭОУП /C/49/D/375/1989 он, хуудас 6



асуудлаас болж тодорхой заасан хугацаанд ирж чадаагүй хүн амины хэргийн дээр шүүх процессыг залруулах эсвэл гэрчийг тээврийн хэрэгслээр хангах ёстой байсан гэж үзэж Хүний Эрхийн Хороо энэ хэрэгт Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 14/1 14/3е заалтуудыг зөрчсөн гэж үзсэн.<sup>16</sup>

Гэвч, өнгөрсөн хугацаанд хэд хэдэн хэргүүдэд сэжигтний шаардсан гэрчийг үнэн зөв байдлыг тодруулахад тухайн гэрч нэмэр болохгүй гэсэн шалтгаанаар дотоодын шүүхээс ирүүлээгүй нь сэжигтний эрхийг зөрчөөгүй гэж Европын Комиссоос үзсэн байна.<sup>17</sup>

## 22.4 Хохирогч ба гэрчийн эрх

Хохирогч ба бусад гэрчүүдийг учирж болзошгүй аюул заналхийллээс хамгаалуулах эрх сэжигтний шударга шүүхийн үйл ажиллагаагаар хангуулах эрхтэй тэнцвэржсэн байх ёстой. Үүний тулд, шүүх дараахь арга хэмжээ хэрэглэж болно: процессын явцад хохирогч, гэрчийг туслалцаа, мэдээллээр хангах, “шүүхийн дотоод үзэмжийн” дагуу процессын зарим хэсгийг эсвэл бүхэлд нь хаалттай болгох / **Нээлттэй шүүгдэх эрх, 14 бүлгээс үзнэ үү** /, нотлох баримтыг электрон ба бусад тусгай аргаар танилцуулах.

Хэрэв гэрч нарын амь нас, эрх, эрх чөлөө болон аюулгүй байдалд ямар нэгэн аюул учирч болзошгүй байгаа тохиолдолд шүүн таслах ажиллагааг ямар нэгэн хор уршиг бий болгохгүйгээр зохион байгуулсан байх ёстой гэж Европын шүүх тэмдэглэж байна. “Шударга шүүхийн зарчмуудын дагуу зарим хэргүүдэд өмгөөлөх талын эрхүүд мэдүүлэг өгөхөөр дуудагдсан хохирогч, гэрч нарын эрхтэй тэнцвэржсэн байх ёстой” гэж үзсэн.<sup>18</sup> Гэвч өмгөөлөх талын эрхийг хязгаарладаг арга хэмжээний цар хүрээг аль болохоор багасгах ёстой гэж Европын шүүх үзсэн.<sup>19</sup>

Процессын баталгаануудыг хөндөхгүйгээр гэрч ба шинжээчдийн хувийн аюулгүй байдлыг хамгаалах талаар арга хэмжээ авах шаардлагатай гэж Америк Дундын Комисс сануулсан байна.<sup>20</sup>

НҮБ-ын Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаархи хууль цаазын хохирогч үндсэн зарчмуудад “шүүх болон засаг захиргааны журам дор дуудсан байдлаар хохирогчдын шаардлагад нийцсэн тус дэм үзүүлэхийн тулд..... хувийн ашиг сонирхол нь холндогдсон тохиолдолд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зохих шатанд хохирогчийн хүсэлт, саналыг хүлээн авч хянан үзэх боломжоор хангах, ... ёстой гэж заасан байна.<sup>21</sup> Түүнчилэн хүнд гэмт гэмт хэргийн улмаас хохирсон этгээдэд байцаан шийтгэх ажиллагааны явц, үр дүн, хохиролын хэмжээ, тэдний оролцох талаар мэдээлэл өгөхөөс гадна, тэд энэ мэдээлэл хүсвэл цаг алдалгүйгээр уг мэдээллээр хангах талаар арга хэмжээ авсан байх ёстой гэж тунхаглалд заасан байна.<sup>22</sup>

### Холбогдох хэм хэмжээ

#### Америкийн конвенцийн 8.2-н (f)

Эрүүгийн хэрэгт яллагдсан хүн бүр хуульд зааснаар түүний гэм буруутай нь нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрхтэй. Байцаан шийтгэх ажиллагааны үед хүн бүр дараах наад захын баталгааг эдлэх эрхтэй:

f. Шүүх хуралдаанд оролцож байгаа гэрчүүдийг байцаах болон тухайн нөхцөл байдлын талаар мэдэж буй гэрч, шинжээч болон бусад этгээдийг хамгаалах эрх

### Ишлэл

15. Видал ба Бельги, (14/1991/266/337), 1992 оны 4 дүгээр сарын 22
16. Грант ба Ямайка, (353/1988), 1994 оны 3 дугаар сарын 31, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП /C/50/D/353/1988 он, хуудас 10
17. X ба Австри, 1973 оны 5 дугаар сарын 31, X ба Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, 1973 оны 4 дүгээр сарын 6, X ба Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, 1970 оны 4 дүгээр сарын 1, 37 Coll.Dec.119; X ба Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, 1970 оны 7 дугаар сарын 21, 35 Coll.Dec.127
18. Доорсон ба Голландын хэрэг, 1996 оны 3 дугаар сарын 26, 2 цуврал А 470, догол мөр 70
19. Ван Менчелен болон бусад (55/1996/674/861-864), 1997 оны 4 дүгээр сарын 23, догол мөр 54 ба 58
20. Америк Дундын Комисс, Колумбын Хүний эрхийн Төлөв Байдлын тухай 2 дах Илтгэл, Америкийн Улсуудын Байгууллага /Ser.L/V/II.84, баримт бичиг 39, 1993 он, хуудас 109
21. Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглалын 6(б) зүйл.

Хүчин болон бусад бэлгийн хүчирхийлэл зэрэг эмэгтэйчүүдийн эсрэг гэмт хэргүүдэд байцаах, яллах ба шүүгдэх явцыг тусгай арга хэмжээний дагуу явуулах шаардлагатай байж болно. Ийм хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд ихэнхдээ мэдүүлгэ өгөх нь хүн байдаг. Хуучин Югославын Олон улсын онцгой шүүхийг бий болгоход ийм төрлийн хэргүүдэд эмэгтэй байцаагч, прокурор оролцох ёстой гэж НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга цохон хэлсэн байна. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой хэргүүдэд оролцож байгаа шүүгч ба бусад хуулийн ажилтнууд энэхүү асуудлын талаар зохих мэдлэгтэй болох зорилгоор холбогдох сургалтанд хамрагдах ёстой гэж Эмнести Интернэшнл үздэг. Шүүхүүд /Олон улсын эрүүгийн шүүхийг оролцуулан/ яллагдагчийн шударгаар шүүгдэх эрхийг хөндөхгүйгээр эмэгтэй хохирогч, тэдний гэр бүл, гэрч нарыг болзошгүй аюул, эвгүй байдал үр дагавараас нээлттэй шүүхийн үйл ажиллагааны явцад хамгаалах талаар шаардлагатай арга хэмжээ авах ёстой гэж Эмнести Интернэшнл шаардсан.<sup>23</sup>

#### Ишлэл

22. Эмнести Интернэшнл, Олон Улсын Эрүүгийн Шүүх: Зөв шийдвэр гаргах нь: хэсэг 2, 1997 оны 7 дугаар сар, (ЭИ индекс: IOR40/11/97), хуудас 36; Эмнести Интернэшнл, Олон Улсын Эрүүгийн Шүүх: Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах нь, 1998 оны 3 дугаар сар, (ЭИ индекс: IOR40/06/98),

## Бүлэг 23

### Орчуулагч авах ба орчуулуулах эрх

Гэмт хэрэгт яллагдаж буй хүн бүр шүүн таслах үйл ажиллагаа явуулж байгаа хэлийг ойлгохгүй, уг хэлээр ярьдаггүй тохиолдолд мэргэжлийн орчуулагч болон хэлмэрчийн туслалцааг үнэ төлбөргүй авах эрхтэй. Түүнчлэн орчуулсан баримт бичиг авч хэрэглэх эрхтэй.

#### 23.1 Орчуулга ба тайлбар

#### 23.2 Туршлагатай орчуулагч авах эрх

#### 23.3 Бичиг баримтыг орчуулуулах эрх

### 23.1 Орчуулга ба тайлбар

Орчуулагч, хэлмэрч авах эрх нь шүүгдэгч шүүн таслах үйл ажиллагаа явуулж буй хэлийг бүрэн ойлгож, уншиж, ярьж чадахгүй байгаа тохиолдолд шүүн таслах үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хэлмэрч нь шүүгч, шүүгдэгч, гомдол гаргагчийн хооронд аман орчуулга хийнэ. Орчуулагч нь бичиг баримтыг холбогдох хэлэнд нь хөрвүүлнэ.

Эдгээр үйл ажиллагаа нь шударгаар шүүлгэх, хоёр тал шүүн таслах үйл ажиллагаанд тэгш эрхтэйгээр оролцох (**8 дугаар бүлэг 13.2-г үзнэ үү**), хуулийн хүрээнд өөрийгөө хамгаалах эрхээ эдлэхэд нь чухал үүрэг гүйцэтгэнэ.

Орчуулагч болон хэлмэрчийн туслалцаагүйгээр шүүгдэгч нь шүүх хуралдааны явцыг бүрэн ойлгож, өөрийгөө үр ашигтайгаар өмгөөлөх боломжгүй болох юм. Өгсөн мэдүүлгийнхээ дагуу байцаагдаж байгаа шүүгдэгчийн шударгаар шүүлгэх эрхээ эдлэхэд зайлшгүй шаардагдах угтвар нөхцөл нь орчуулагч авах эрх юм.

### 23.2 Туршлагатай орчуулагч авах эрх

Гэмт хэрэгт яллагдаж буй хүн бүр шүүн таслах үйл ажиллагаа явуулж буй хэлийг ойлгохгүй, уг хэлээр ярьдаггүй тохиолдолд хэлмэрчийн туслалцааг үнэ төлбөргүй авах эрхтэй.\* Орчуулга нь мэргэжлийн өндөр түвшинд, үнэн зөв, утга төгөлдөр байх ёстой. Иргэний болон улс төрийн эрхийн тухай тухай олон улсын пактын 67.1.f-д мэргэжлийн өндөр ур чадвартай хэлмэрчийн туслалцааг авах эрхийг баталгаажуулсан байдаг.

Хэлмэрч авах эрх нь өөрийгөө өмгөөлөх эрх, болон түүнд бэлтгэх үйл ажиллагаа явуулах шаардлагатай хугацаа авах эрхийн салшгүй нэг хэсэг нь юм.

Хүний эрхийн комисс энэ эрхийн талаар “Шүүн таслах үйл ажиллагаа явуулж буй хэлийг мэдэхгүй эсхүл бүрэн гүйцэд ойлгохгүй байх нь шүүгдэгчийг өөрийгөө өмгөөлөх эрхээ эдлэхэд нь бэрхшээл учруулдаг гол хүчин зүйл юм.” хэмээн тэмдэглэсэн байдаг.<sup>1</sup>

#### Холбогдох хэм хэмжээ

#### Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14.3 дугаар зүйл

Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр дараахь наад захын баталгаагаар хангагдах эрхтэй:

(f) шүүн таслах ажиллагаа явуулж байгаа хэлийг ойлгохгүй буюу уг хэлээр ярьдаггүй тохиолдолд орчуулагчийн туслалцааг үнэ төлбөргүй авах;

\* ИУТЭОУП-ын 14(3)(е) дүгээр зүйл, Америкийн Тунхаглалын 8(2)(а) дугаар зүйл, Европын Конвенцийн 6(3)(д) дүгээр зүйл, Африкийн Комиссын Тогтоолын 2(Д)(4) хэсэг, Югославын Дүрмийн 21(4)(е) дугаар зүйл, Руандагийн 20(4)(е) дугаар дүрэм. Мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 67(1)(е) дугаар зүйлүүдийг үзнэ үү.

#### Ишлэл

Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 13

\* Үндсэн зарчим - 14 дүгээр зарчим

Мөрдөн байцаалт, урьдчилсан байцаалт, цагдаагийн байцаалт зэрэг эрүүгийн хэргийг шалгах бүх шатны үйл ажиллагаанд хэлмэрч авах эрхээ бүрэн эдэлнэ.\* (тухайн хүний ойлгодог хэлийг анхаарах 2.4 болон Орчуулагч авах эрх 9.4 бүлгийг үзнэ үү.)

Энэхүү эрхээ эдлэхийн тулд шүүгдэгч эсхүл түүний өмгөөлөгч нь хэлмэрчид хүсэлт гаргана.

Хэлмэрчийн туслалцааг чөлөөтэй авах эрх нь шүүн таслах үйл ажиллагаа явуулж буй хэлийг ойлгохгүй буюу үг хэлээр ярьдаггүй хүн бүрт тухайн улсын иргэн байх эсэхээс нь үл хамааран адил тэгш үйлчлэх ёстой гэдгийг хүний эрхийн комисс тодорхой заасан байна.<sup>2</sup>

Хэрвээ шүүгдэгч нь шүүн таслах ажиллагаа явуулж буй хэлийг хангалттай хэмжээнд ойлгож ярьдаг боловч өөр хэлээр ярихыг хүсвэл шүүхээс хэлмэрчийн туслалцааг чөлөөтэй авах эрхээр хангах шаардлагагүй.

Шүүгдэгч болон гэрч нар нь Франц хэлээр (шүүн таслах ажиллагаа явуулж буй хэл) бус өөрсдийн эх хэл болох Бретон хэлээр мэдүүлэг өгөхийг хүсчээ.

Харин шүүхээс тэд өөрсдийгөө Францаар хангалттай хэмжээнд илэрхийлэн, ойлгох чадвартай байсан учир тэдэнд хэлмэрч өгөхөөс татгалзсан байна. Хүний эрхийн комисс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактыг зөрчөөгүй хэмээн үзэж байгаа аж.<sup>3</sup>

Шүүхээс ямарч шийдвэр гарсан шүүгдэгчийн хэлмэрчийн туслалцааг үнэ төлбөргүй авах эрхэд нөлөөлөхгүй.

Европын шүүхээс шүүгдэгчийг яллах үед эрх бүхий этгээд түүгээр хэлмэрчийн хөлсийг төлүүлэх нь хэлмэрчийн туслалцааг үнэ төлбөргүй авах эрхийг зөрчиж буй хэрэг юм гэж үзжээ.<sup>4</sup>

\*\* Америкийн Тунхаглалын 8(2)(а) дугаар зүйл болон Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 67(1)(е) дугаар зүй

### 23.3 Баримт бичгийг орчуулуулах эрх

Америкийн хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 2 дах хэсэгт бичиг баримт орчуулах орчуулагчийн тусламж авах эрхийн талаар тодорхой тусгасан байдаг. Бодит байдал дээр шүүгдэгчийн хэлмэрч авах эрхэд үнэ төлбөргүйгээр холбогдох бичиг баримтаа орчуулуулах эрх багтдаг.\*\* Гэсэн хэдий ч Хүний эрхийн комисс, болон Европын шүүхээс баримт бичгийн аман орчуулга нь ямар ч нөхцөлд шүүгдэгчийг эрхээ хамгаалахад хангалттай гэж үзжээ.<sup>5</sup>

Хэрвээ шүүгдэгч холбогдох бичиг баримтаа орчуулуулахыг хүсвэл шүүн таслах үйл ажиллагааны үеэр хүсэлтээ гаргах түүнчлэн өөрийгөө өмгөөлөхийн тулд хуулийн хүрээнд нэмэлт үйлчилгээ авч буй энэхүү эрхээ зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх хэрэгтэй.

Америкийн комисс бичиг баримтаа орчуулуулах эрх нь шүүн таслах үйл ажиллагаан дах суурь эрх гэж үзжээ.<sup>6</sup>

#### Ишлэл

2. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 13
3. Кадорет болон Бихан ба Франц (221/1987 болон 323/1988), 1991 оны 4 дүгээр сарын 11, Хүний Эрхийн Төлөв Байдлын Илтгэл, (A/46/40), 1991 он, хуудас 219; Барзиг ба Франц, (327/1988), 1991 оны 4 дүгээр сарын 11, Хүний Эрхийн Төлөв Байдлын Илтгэл, (A/46/40), 1991 он, хуудас 262,
4. Люедике, Белкасем ба Кок, 1978 оны 11 дүгээр сарын 28, 29 цуврал А 17-19,
5. Харвард ба Норвег, (451/1991), 1994 оны 7 дугаар сарын 15, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП /C/51/D/451/1991 он,
6. Никарагуан Мискито гаралтай цөөнхийн хүний эрхийн Төлөв байдлын талаарх илтгэл, Америкийн Улсуудын Байгууллага Ser.L/V/II.62 баримт бичиг 10, 3 дах хэвлэл, 1983 он.

## БҮЛЭГ 24

### Шүүхийн шийдвэр

Шүүх хуралдааныг хаалттай явуулахаас бусад бүх тохиолдолд шүүх хэргийг ил таслан шийдвэрлэх бөгөөд шүүхээр хэргээ шийдвэрлүүлж байгаа хүн бүр шүүхийн шийдвэр гаргах эрх бүхий этгээдээр хэргээ шийдвэрүүлэх түүнчлэн шүүхийн шийдвэрийн үндэслэлийг мэдэх эрхтэй.

#### 24.1 Шүүхийн шийдвэрийг нээлттэй байлгах эрх

#### 24.2 Шүүхийн шийдвэрийн үндэслэлийг мэдэх эрх

#### 24.3 Боломжит хугацаанд шүүлгэх эрх

### 24.1 Шүүхийн шийдвэрийг нээлттэй байлгах эрх

Эрүүгийн шүүх хуралдааныг хаалттай явуулахаас бусад бүх тохиолдолд шүүх хэргийг нээлттэй буюу ил таслан шийдвэрлэнэ\*.

Энэхүү зарчмыг тусгай болон цэргийн, мөн давж заалдах шатны бүх шүүх мөрдөх ёстой.<sup>1</sup>

ИУТЭОУП-ын 14.1-р зүйлд зааснаар шүүх хуралдааныг хаалттай явуулах онцгой нөхцөл байдалд насанд хүрээгүй хүүхдийн эрх ашгийг хамгаалах, гэр бүлийн буюу эхнэр нөхрийн маргаан түүнчлэн хүүхдэд асран хамгаалагч тогтоох асуудал багтдаг байна.

Америкийн конвенцийн 8 дугаар зүйлийн 5 дах хэсэгт эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагааг хэргийн оролцогчдын хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж болох онцгой тохиолдлоос бусад нөхцөлд нээлттэй буюу илээр таслан шийдвэрлэнэ гэжээ. Нээлттэй шүүлгэх эрхийн үндсэн зорилго нь шүүх, түүний үйл ажиллагааны ил тод байдлыг хангах явдал юм.

Түүнчлэн тухайн шүүн таслах ажиллагаанд хамааралгүй хөндлөнгийн этгээдээр шүүх хуралдааны явцыг хянуулж, нээлттэй шүүлгэх эрхийг хангаж байх ёстой аж. Нээлттэй шүүх хуралдаан дээр шүүхийн шийдвэрийг иргэдэд уншиж танилцуулах буюу бичгээр хэвлэн тараана.

Шүүн таслах үйл ажиллагааг зөвхөн тодорхой нэг бүлэг хүмүүст буюу шүүх хуралдааныг явуулдаг эрх бүхий этгээдүүдэд л ойлгогдохоор зохион байгуулвал энэ нь нээлттэй шүүлгэх эрхийг зөрчиж байгаа хэрэг юм. Нээлттэй шүүх хуралдаан дээр шүүхийн шийдвэрийг чангаар уншиж тайлбарлахгүй ч гэсэн хэргийн оролцогчдод шүүхийн шийдвэрийн нэг нэг хувийг өгөх ёстой бөгөөд өөрийн ашиг сонирхолоо хамгаалж буй хэн бүхэнд хамаарах шүүхийн шийдвэрийг хувилж өгөх нь Европын конвенцийн 6.1 –ийг зөрчсөн хэрэг огтхон ч биш хэмээн Европын шүүх үзэж байгаа аж.<sup>2</sup>

#### Холбогдох хэм хэмжээ

##### ИУТЭОУП-ын 14.1 зүйл анги

Насанд хүрээгүй хүүхдийн эрх ашгийг хамгаалах, гэр бүлийн буюу эхнэр нөхрийн маргаан түүнчлэн хүүхдэд асран хамгаалагч тогтоох асуудлаас бусад нөхцөлд эрүүгийн хэргийн шүүн таслах үйл ажиллагааг нээлттэйгээр явуулна.

\* ИУТЭОУП-ын 14(1) дүгээр зүйл, Европын Конвенцийн 6(1) дүгээр зүйл, Югославын Дүрмийн 23(2) дугаар зүйл, Руандагийн 23(2) дугаар дүрэм болон Америкийн Тунхаглалын 8(5) дугаар зүйл мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 74(5) ба 76(4) дугаар зүйлүүдийг үзнэ үү.

#### Ишлэл

1. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 4
2. Сүттерийн хэрэг, цуврал А, Боть 74, 1984 оны 2 дугаар сарын 22

Шүүх хуралдааныг нээлттэй явуулах зарчим нь (дээр дурдсан онцгой нөхцөл байдлаас бусад бүх тохиолдолд) хэргийн оролцогч биш иргэдэд ч хамаарна.<sup>3</sup>

Хүний эрхийн комисс нь шүүгдэгчийг шүүх хуралдаанд оролцуулаагүй, шүүх хуралдааныг нээлттэй явуулаагүй, шүүх шийдвэрийн хувийг тарааж өгөөгүй зэрэг шүүх хуралдааныг нээлттэй явуулах зарчмын зөрчлүүдийг илрүүлжээ.<sup>4</sup>

## 24.2 Шүүхийн шийдвэрийн үндэслэлийг мэдэх эрх

Шүүхээс тогтоол, шийдвэрийнхээ үндэслэлийг тайлбарлаж өгөхийг шаардах нь нээлттэй шүүлгэх эрхийн нэг илрэл юм.<sup>5</sup> Шүүхийн шийдвэрийн үндэслэлийг мэдэх эрх нь шүүгдэгчийн давж заалдах эрхэд маш чухал үүрэгтэй (26-р бүлгийг үз. Давж заалдах эрх).

Ямайкын давж заалдах шатны шүүхээс гаргасан шүүхийн шийдвэрээ бичгээр шүүгдэгчид өгөөгүй байна. Ингэснээр шүүгдэгчийн дээд шатны шүүхэд гомдол гарган хэргийн нөхцөл байдлыг өөрт ашигтайгаар шийдвэрлүүлэх боломжийг хязгаарлсан бөгөөд Хүний эрхийн хорооноос шүүгдэгчийн эрх зөрчигдсөн хэмээн үзжээ.<sup>6</sup>

ИУТЭОУП-ын 74.5-д нотлох баримт болон дүгнэлтэнд үндэслэсэн шүүхийн тогтоол, шийдвэр нь үнэн зөв, алдаагүй байна хэмээн заасан байдаг.\*

## 24.3 Боломжит хугацаанд шүүлгэх эрх

Боломжит хугацаанд шүүлгэх эрх нь аль болох богино хугацаанд хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр (анхан болон давж заалдах шүүхэд) гарна гэсэн үг юм. (**Боломжит хугацаанд шүүлгэх эрх. Бүлэг 19**)

Ямайкагийн давж заалдах шүүхийн дээрх эс үйлдэл нь шүүгдэгч боломжит хугацааны дотор шүүхийн шийдвэрийг бичгээр гаргуулж авах, ял шийтгэлээ дээд шүүхээр дахин хянуулах эрхийг хязгаарласан байна<sup>7</sup> гэж Хүний эрхийн хороо үзжээ.

\* Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 74(5) дугаар зүйл, Югославын Дүрмийн 23(2) дугаар зүйл, Руандагийн 22(2) дугаар дүрэм

### Ишлэл

3. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 4
4. Тоурон ба Уругвай, (32/1978), 1981 оны 3 дугаар сарын 31, 1 Sel.Dec.61
5. Хаджианацассиоу ба Грек, (69/1991/321/393), 1992 оны 12 дугаар сарын 16, догол мөр 33
6. Хамилтон ба Ямайка, (333/1988), 1994 оны 3 дугаар сарын 23, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП /C/50/D/333/1990 он, 1994 он, хуудас 5-6
7. Кюрриэ ба Ямайка, (377/1989), 1994 оны 3 дугаар сарын 29, Хүний Эрхийн Төлөв Байдлын Илтгэл, боть 2, (A/49/40), 1994 он, хуудас 73

## БҮЛЭГ 25

### Ял

Гэм буруутай болох нь шүүхээр тогтоогдсон этгээдэд л ял шийтгэл онооно. Хэрэгтэнд тохирсон ял шийтгэлийг оногдуулах бөгөөд энэ нь олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу байна.

**25.1 Ялыг хэзээ оногдуулах вэ?**

**25.2 Ямар ялыг оногдуулж болох вэ?**

**25.3 Ял шийтгэл нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчих ёсгүй.**

**25.4 Бие махбодийн шийтгэл**

**25.5 Хорих нөхцөл байдал**

**25.6 Хоморголон шийтгэхийг хориглох**

### 25.1 Ялыг хэзээ оногдуулах вэ?

Шударга ёсонд нийцсэн олон улсын хэм хэмжээний дагуу шүүх хуралдаанаар гэм буруутай болох нь тогтоогдсоны дараа ял шийтгэлийг онооно.

Хүний Эрхийн Хороо шүүхээс шүүгдэгчид шударга бус ял оноож түүнийг хорьсон хэрэг гарч байсныг ИУТЭОУП-ыг зөрчсөн гэж үзжээ.<sup>1</sup>

### 25.2 Ямар ялыг оногдуулж болох вэ?

Шударга шүүхээр гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдсоны дараа оноосон ял нь түүний үйлдсэн гэмт хэргийн хүнд хөнгөнөөс шалтгаалж түүнд тохирсон ял байна.<sup>2</sup> Ял болон түүний төрлийн аль аль нь олон улсын хэм хэмжээг зөрчих ёсгүй.

Шүүх нь тухайн гэмт хэрэг үйлдэх үед хэрэглэж байснаас илүү хүнд ял ногдуулж болохгүй. Гэмт хэрэг үйлдсэний дараа тийм гэмт хэрэгт хөнгөн ял оногдуулахаар болсон бол түүнийг тухайн гэмт хэрэгтэнд хэрэглэнэ.\*

Гэмт хэрэг үйлдэх үед хуулиар тухайн гэмт хэрэгт цаазаар авах ял ногдуулаагүй байсан бол гэмт хэрэгтэнд уг ялыг оноож үл болно. Бүлэг 28 - Цаазаар авах ял, Бүлэг 27.7- Хүүхэд ба Ял шийтгэл сэдэвийг үзнэ үү.

### 25.3 Ял шийтгэл нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчих ёсгүй.

Ял шийтгэл болон ял эдлүүлэхдээ эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хүнлэг бусаар харьцах, угаас заяасан нэр төрийг доромжлон гутаах зэргээр олон эмжээг зөрчих ёсгүй.

#### Холбогдох хэм хэмжээ

##### ИУТЭОУП-ын 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг

“Хэрэг үйлдэх үед нь дотоодын хууль буюу олон улсын эрх зүйгээр эрүүгийн гэмт хэрэгт эс тооцож байсан ямар нэг үйлдэл буюу эс үйлдлээр хэнийг ч гэмт хэрэгтэн гэж буруутгаж болохгүй түүнчлэн эрүүгийн гэмт хэрэг үйлдэх үед хэрэглэж байснаас илүү хүнд ял шийтгэл оногдуулж болохгүй. Гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш тийм хэргийн ялыг хуулиар хөнгөрүүлсэн бол уг хэрэгтэнд тэрхүү хөнгөлсөн ялыг хэрэглэнэ”.

\* ХЭТТ-ын 11 дүгээр зүйл, ИУТЭОУП-ын 15(1) дугаар зүйл, Америкийн Тунхаглалын 9 дүгээр зүйл, Европын Конвенцийн 7(1) дүгээр зүйл болон Африкийн Дүрмийн 7(2) дугаар зүйл.\*

#### Ишлэл

- 1.Пинто болон Тринадад ба Тобаго, (512/1992), 1996 оны 7 дугаар сарын 16, НУБ-ын баримт бичиг, ИУТЭОУП /C/37/D/512/1992 он
2. Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх ба Гэмт Хэрэгтнүүдтэй харьцах НУБ-ын 8 дах Конгрессын Илтгэл, НУБ-ын баримт бичиг, /A/ Конг.144/28, 1991 оны 4 дүгээр сарын 2, Тогтоол 1(a), 5(v), 1990 он.

\* ХЭТТ-ын 5 дугаар зүйл, ИУТЭОУП-ын 7 дугаар зүйл, Эрүү Шүүлтийн Эсрэг Конвенц, Эрүү Шүүлтийн Эсрэг Тунхаглал, Үндсэн Зарчим – 6 дугаар зарчим, Африкийн Дүрмийн 5(2) дугаар зүйл Америкийн Тунхаглалын 26 дугаар зүйл, Европын Конвенцийн 3 дугаар зүйл.

\*\* Эрүү Шүүлтийн Эсрэг Конвенцийн 3 дугаар зүйл

### Ишлэл

3. Report of the Special Rapporteur on torture, UN Doc. E/CN.4/1988/17 p.14; E/CN.4/1993/26, p. 131; Nigel Rodley, *The Treatment of Prisoners Under International Law*; Achene Boulesbaa, "Analysis and Proposals for the Rectification of the Ambiguities Inherent in Article 1 of the UN Convention on Torture", *Florida International Law Journal*, Vol. 5, No. 3, Summer 1990, 317; See Karima Bennoune, "A Practice Which Debases Everyone Involved: Corporal Punishment Under International Law", in 20 ans consacrés à la réalisation d'une idée, *Recueil d'articles en l'honneur de Jean-Jacques Gautier*, Association for the Prevention of Torture, Geneva, 1997

4. Соерын хэрэг, (1/1989/161/217), 1989 оны 7 дугаар сарын 7

5. Карима Бенноуне, "Оролцсон бүхийг басамжилан доромжилдог практик: Олон улсын эрх зүйн бие махбодыг тарчлаан зовоох ял, 20 ans consacrés à la réalisation d'une idée, *Recueil d'articles en l'honneur de Jean-Jacques Gautier*, Эрүү Шүүлгээс Хамгаалах Холбоо, Женев, 1997 он

6. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 20, догол мөр 5

7. Судан: Хүний Эрхийн Төлөв Байдлын Судалгааг Дүгнэх нь, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП /С/79/Нэмэлт 85, 1997 оны 11 дүгээр сарын 19

Эрүү шүүлт тулгах буюу хүний ёсноос гадуур харьцан, шийтгэхийг бүрэн хориглоно.\* / Эрүү шүүлт тулгах болон хүнлэг бус харьцаж шийтгэхийг хориглоно Бүлэг 10,4-ийг үзнэ үү./ Хуулийн дагуу буюу болгоомжгүй байдлын улмаас шаналган зовоох нь энэхүү тодорхойлолтод хамаарахгүй.

“Хуулийн дагуу” гэдэг нь Эрүү шүүлтийн эсрэг Тунхаглалын 1-р зүйл болон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 1-р зүйлд зааснаар үндэсний болоод олон улсын хэм хэмжээний аль алинд хууль ёсоор зөвшөөрсөнийг дурдсан байна. Иймээс дотоодын хуулиар зөвшөөрсөн боловч, олон улсын стандартыг зөрчиж эрүү шүүлт тулгасан буюу харгис, хүнлэг бусаар угаас заяасан нэр төрийг гутаан харьцсан буюу шийтгэсэн байвал тухайн зөвшөөрлийг хориглоно. Эрүү шүүлтийг хориглосон бусад олон улсын хэм хэмжээгээр ч үүнийг тайлбарласан байдаг.<sup>3</sup>

Эрүү шүүлтийн талаархи Америк хоорондын Конвенцийн 2-р зүйлд үндэсний хэмжээнд хууль сахиулах байгууллага нь хэрвээ тус гэрээг зөрчсөн арга хэмжээ авсан байвал “хуулийн дагуу” хэмээн хэрэглэх ёсгүй гэж заажээ.

Олон улсын хэм хэмжээгээр хэн нэгэн этгээдийг эрүүдэн шүүх буюу хүнлэг бусаар нэр төрийг гутаан доромжилж харьцах буюу шийтгэж болзошгүй гэсэн баттай үндэслэл байвал оролцогч улс уг этгээдийг өөр улсад албадан гаргах, буцаах шилжүүлэх ёсгүй.\*\*

Гэмт хэрэг хийх үедээ сэтгэл мэдрэлийн өвчтэй байсан байж болзошгүй 18 настай хүүг АНУ-руу албадан шилжүүлэх болсон нэгэн хэргийг Европын шүүх шалгажээ. Тус шүүхээс түүнийг албадан шилжүүлсэнээр түүнд цаазаар авах ял оноож, улмаар ялыг гүйцэтгэх хүртэл хүнд нөхцөлд 6-8 жил хоригдох болзошгүй байгаа тул энэ нь Европын конвенцийн эрүү шүүлт болон зүй бусаар харьцах, шийтгэхийн эсрэг 3-р зүйлийг зөрчиж байна гэж тогтоожээ.<sup>4</sup>

## 25.4 Бие махбодийн шийтгэл

Бие махбодийн шийтгэл гэдэг нь шүүхийн тогтоолоор эсхүл эрх бүхий байгууллагын шийдвэрээр хүнийг зодох болон бусад хэлбэрээр бие махбодийг шаналган зовоож шийтгэхийг хэлнэ. Жишээлбэл: ороолгох, саваадах, ташуурдах, тамгалах, хайрах гэх мэт.<sup>5</sup>

НҮБ-ын харьяа байгууллага, шинчээчид болон Европын шүүх бие махбодийн шийтгэл нь эрүүдэн шүүх, хүнлэг бусаар угаас заяасан нэр төрийг гутаан доромжлох буюу шийтгэхийг хориглосон хэм хэмжээг илт зөрчиж байна гэж мэдэгдсэн. Хэдийгээр онц хүнд гэмт хэрэг үйлдсэн ч, улс төрийн байдал тогтворгүй байлаа ч хэнийг ч ямар ч шалтгаанаар дээрхи байдлаар шийтгэж үл болно.

Хүний Эрхийн Хороо ИУТЭОУПакт дахь эрүү шүүлтийг хориглолт нь бие махбодийн шийтгэлийг мөн агуулдаг бөгөөд шийтгэл, сахилга бат тогтоох, боловсрол олгох арга хэмжээ болгож хэтрүүлэн шийтгэх нь мөн хамаарна.<sup>6</sup> гэж үзсэн байна.

Хүний эрхийн Хорооноос Судан улсад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ороолгох, тайрах, чулуугаар шидэх ял оноож байгаа нь ИУТЭОУП-ыг зөрчиж байна гэж мэдэгджээ.<sup>7</sup> Үүнтэй адил Ирак улсад тамгалах, тайрах ял оноож байгааг нэн дариу зогсоож, хойшлуулалгүйгээр энэхүү



хуулийг хүчингүй болгох хэрэгтэй гэж Хүний Эрхийн Хороо үзжээ.<sup>8</sup>

1997 оны 4-р сард НҮБ-ыг Хүний Эрхийн Комиссоос улс орны засгийн газруудад “хүний бие махбодийг тарчлаан зовоох ял шийтгэх нь хүнлэг бус, хүний угаас заасан нэр төрийг дормжилсон шийтгэл төдийгүй эрүүдэн шүүсэнтэй адил” гэж анхааруулсан байна.<sup>9</sup>

1997 онд НҮБ-ын эрүүдэн шүүхийн асуудлаархи Тусгай илтгэгч “хүний бие махбодийг тарчлаан зовоох ялаар шийтгэх нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийг хориглосон заалттай үл нийцнэ” гэж мэдэгдсэн байна.<sup>10</sup>

Европын шүүх ч мөн адил бие махбодийн шийтгэл нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийг хориглосныг зөрчиж байна. Жишээлбэл үг хэлээр доромжилсны төлөө 15 настай хүүхэд модон саваагаар ороолгуулах ялаар шийтгүүлсэн нь хүнлэг бус шийтгэл юм гэж үзжээ.

Бие махбодийн шийтгэлийг гэмт хэргийн болон сахилга батын шийтгэл болгон хэрэглэх нь шударга шүүхийн олон улсын эрх зүйгээр хориглосон хэм хэмжээг зөрчиж байгаа юм.

Олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр бие махбодийг тарчлаан зовоох албадан саатуулагдсан болон хоригдсон хүнд сахилга бат сахиулах зорилгоор тулгахыг хориглодог. /Бүлэг 10.4-өөс Эрүү шүүлт тулгах болон хүнлэг бус харьцаж шийтгэхийг хориглох тухай үзнэ үү./<sup>\*</sup>

## 25.5 Хорих нөхцөл

Хоригдлыг хорьж байгаа нөхцөл байдал нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчих ёсгүй.

Наад захын жишиг дүрмийн 56, 81-р дүрэмд шоронд хорих ял эдлэж байгаа хүмүүстэй харьцах зарчмуудыг зааж өгсөн байдаг. Үүнд шоронгийн тогтолцоо нь хүнийг өөрийгөө мэдэх эрхийг хасаж, эрх чөлөөгүй болгож байгаагаас илүүгээр нэмэгдэх ёсгүй.<sup>\*\*</sup> Тэнд мөрдөгдөж байгаа дэглэм нь шоронгийн болон эрх чөлөөт амьдралын ялгааг аль болохоор багасгахад чиглэгдсэн байх шаардлагатай.<sup>\*\*\*</sup>

Олон улсын жишиг хэмжээгээр хүнийг ганцаарчлан удаан хугацаагаар хорих, гавлах, дөнгөлөх, хууль сахиулагч субъектүүдийн зүгээс хүч хэрэглэх явдлыг хязгаарладаг. /Бүлэг 10,4-өөс Эрүү шүүлт тулгах болон хүнлэг бус харьцаж шийтгэхийг хориглох үзнэ үү./

## 25.6 Хоморголон шийтгэхийг хориглох

Гэмт хэрэгт оноох шийтгэлийг зөвхөн тухайн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд л ногдуулна. Олон улсын жишиг хэмжээгээр хоморголон шийтгэхийг хориглодог.<sup>^</sup> Африкийн дүрмийн 7,2-р зүйлд “шийтгэлийг зөвхөн гэмт хэрэгтэнд буюу хувь хүнд оноох ёстой” гэж заасан байдаг бол Америкийн конвенцийн 5,3-р зүйлд “ял шийтгэлийг эрүүгийн хэрэгтэнээс өөр хэнд ч оноох ёсгүй” гэжээ.<sup>^^</sup> /Бүлэг 32,5,1-нээс Хоморголон шийтгэхийг хорих тухай үзнэ үү./

\* Наад захын Жишиг Дүрмийн 31 дүгээр дүрэм, Европын шоронгийн дүрэм-37 дугаар дүрэм

\*\* Наад захын Жишиг Дүрэм – 57 дугаар дүрэм

\*\*\* Наад захын Жишиг Дүрмийн 60 дүгээр дүрэм болон Европын шоронгийн дүрэм-64 дүгээр дүрэмээс хойших бүх дүрэм, Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 106 дугаар зүйл

^ Африкийн Дүрмийн 7(2) дугаар зүйл

^^ Америкийн Конвенцийн 5(3) дугаар зүйл

### Ишлэл

8. Ирак: Хүний Эрхийн Төлөв Байдлын Судалгааг Дүгнэх нь, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП /С/79/Нэмэлт 84, 1997 оны 11 дүгээр сарын 19, догол мөр 12

9. Тогтоол 1997/38, Хүний Эрхийн Комисс, 53 дугаар чууган илтгэл (1 дүгээр хэсэг), (Хүний Эрхийн Комисс.4/1997/150), хуудас 125

10. НҮБ-ын Эрүү Шүүлтийн Талаарх Тусгай Илтгэгч, НҮБ-ын баримт бичиг, Хүний Эрхийн Комисс.4/1997/7, 5 дугаар хэсэг, догол мөр 6

11. Тюрерын хэрэг, цуврал А 26, 1978 оны 4 дүгээр сарын 25

Европын шүүх гэм буруугүйд тооцох нь эрүүгийн хэргийг үйлдсэн этгээдтэй хамааралтай байсан бүх хүмүүст хамаарна гэж дүгнэжээ. Татвар төлөөгүй байсан хүн нас барсны дараа хамаатан саданд нь торгууль оноосон тул тэд үл хөдлөх хөрөнгөө зарж татварыг төлжээ. Энэ нь гэм буруугүйд тооцох эрхийг зөрчиж байна гэж тус шүүх үзэж байна.<sup>12</sup>

#### **Холбогдох хэм хэмжээ**

##### **Наад захын жишиг дүрмийн 57 дугаар дүрэм**

Хууль зөрчигчийг нийгэм орчны хүрээнээс тусгаарлаж буй арга хэмжээнүүд нь хүнийг өөрийгөө мэдэх эрхийг хасч, эрх чөлөөгүй болгодоороо зохих цээрлэлийг үзүүлдэг. Тийм учир ганцаарчлан тусгаарлах арга хэмжээг зайлшгүй буюу сахилгыг чангатгах шаардлагаас урган гараагүй тохиолдолд авч хэрэгжүүлж болохгүй. Өөрөөр хэлбэл энд яригдах журмаас бусад байдлаар хүндрүүлсэн тарчлаан зовоох шинжтэй үйл ажиллагаа явуулах ёсгүй.

##### **Наад захын жишиг дүрмийн 60.1 дүгээр дүрэм**

Тус газарт мөрдөгдөж буй дэглэм нь хүн чанарыг алдагдуулдаг, үүрэг хариуцлагыг умартуулдаг шоронгийн болон эрх чөлөөт амьдралын тэр ялгааг аль болохоор багасгахад чиглэгдсэн байх учиртай.

##### **Наад захын жишиг дүрмийн 61 дүгээр дүрэм**

Хоригдлуудтай харилцахдаа, тэдний нийгмээс тусгаарлагдсан байдлыг нь биш харин тэд түүний гишүүд хэвээр байгаа гэдгийг тодотгож харьцах хэрэгтэй. Тийм учир хоригдлуудыг нийгмийн амьдрал руу буцаан оруулах зорилгоор олон нийтийн байгууллагуудын бүх боломжийг ашиглах тус хорих газрын ажилтай холбож, хамтын ажиллагааг тогтоох хэрэгтэй. Хорих газар болгонд хоригдлын гэр бүлтэйгээ харилцах сайн харилцааг бататган дэмжих, олон нийтийн болон бусад иргэний байгууллагатай харьцах ажлыг хариуцах ажилтантай байх хэрэгтэй. Хоригдлууд нь хууль шийтгэлийн агуулгын хүрээнд өөрийн иргэний эрх ашиг, нийгмийн хангамж болон бусад нийгмийн хөнгөлөлтийг үзэж, эдлэх эрх, боломжтой байхад чиглэсэн арга хэмжээ авах хэрэгтэй.

#### **Ишлэл**

12. А.П, М.П, ба Т.П  
Швейцарийн хэрэг,  
(71/1996/690/882), Европын  
Шүүх, 1997 оны 8 дугаар сарын  
29

## Бүлэг 26

### Давж заалдах эрх

Ямар нэг гэмт хэрэгт ял шийтгүүлсэн хүн бүр шийтгэгдсэнээ болон оноосон ялыг эргэж хянуулахаар хуулийн дагуу дээд шатны шүүхэд давж заалдах эрхтэй.

#### 26.1 Давж заалдах эрх

#### 26.2 Дээд шатны шүүхийн хяналт

#### 26.3 Бүрэн хянах

#### 26.4 Давж заалдах шатанд шударгаар шүүлгэх баталгаа

### 26.1 Давж заалдах эрх

Ямар нэг гэмт хэрэгт ял шийтгүүлсэн хүн бүр шийтгэгдсэнээ болон оноосон ялыг эргэж хянуулахаар хуулийн дагуу дээд шатны шүүхэд давж заалдах эрхтэй.\*

Европын конвенцид давж заалдах эрхийг тусгаагүй хэдий ч Европийн шүүх тус конвенцийн 6-р зүйлд шударга шүүхэд давж заалдах эрх нь хүний салшгүй эрх гэдгийг илэрхийлсэн бөгөөд 7 протоколын 2 дугаар зүйлд энэ эрхийг баталгаажуулсан гэж үзжээ.

Тусгай шүүхээс гаргасан тогтоолоороо уг шийдвэрийн эсрэг давж заалдахыг хориглосон нь давж заалдах эрхийг зөрчсөн хэмээн Африкийн комисс үзжээ. Тусгай шүүх нь цаазаар авах ялыг хүмүүст оноох, шүүн таслах эрхтэй бөгөөд тус шүүхийн оноосон ял нь захирагчаар батлагдах эсвэл түтгэлздэг бөгөөд захирагчийн шийдвэрийн эсрэг давж заалдах эрхгүй хэмээн хуульчлагдсан байжээ.<sup>1</sup>

Гэм буруутай эсэх, оноосон ялыг дээд шатны шүүхээр хянуулах эрх нь үндсэндээ гэмт хэргийн хүнд хөнгөнөөс үл хамааран, аливаа гэмт хэрэгт гэм буруутайд тооцогдсон хүн бүрт хамаатай билээ. Хүний эрхийн хорооноос зөвхөн онц ноцтой гэмт хэргээр энэ хязгаарлагдахгүй гэж мэдэгдсэн байна.<sup>2</sup>

Хүний эрхийн хороо нэг жил хүртэлх хорих ялтай хэргүүдэд дотоодын эрх зүйд гэмт хэрэг гэж ангилсанаас үл хамааран давж заалдах эрхийн баталгаагаар хангах ёстой гэж үзсэн.<sup>3</sup>

Гэвч Европын конвенцийн 7 дугаар Протоколын 2/2/-т тухайн хэрэг нь ерийн гэмт хэрэг бол мөн анхан шатандаа улсын дээд шүүхээ шүүгдсэн бол эсвэл цагаатгагдсаныхаа дараа давж заалдан гэм буруутай нь тогтоосон этгээдэд давж заалдах эрхийг нь хязгаарлаж болно гэж заасан байна.

#### Холбогдох хэм хэмжээ

##### ИУТЭОУП-ын 14/5/ дугаар зүйл

Гэмт хэрэгт гэм буруутайд тооцогдсон хүн бүр өөрийн гэм буруу болон ялыг хуульд зааснаар дээд шатны тусгай шүүхээр хянуулах эрхтэй.

\* ИУТЭОУП-ын 14(5) дүгээр зүйл, Америкийн Конвенцийн 8(2)(ж) дугаар зүйл, Европын Конвенцийн 7 дугаар Протоколын 2 дугаар зүйл, Африкийн Комиссын Тогтоолын 3 дугаар хэсэг, Югославын Дүрмийн 24 дүгээр зүйл, Руандагийн 23 дугаар дүрэм, Мөн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 81(б) дугаар зүйл, Африкийн Дүрмийн 7(а) дугаар зүйл.

#### Ишлэл

1. Үндсэн Хуулийн Эрхийн Төсөл, (Вахаб Акаму, Г. Адега болон бусад хүмүүсийн нэрийн өмнөөс) Нигерийн Хэрэг, (60/91), Африкийн Комиссын жил бүрийн 8 дах Илтгэл, 1994-1995 он түүнчлэн Үндсэн Хуулийн Эрхийн Төсөл, (Замани, Лаквот болон бусад 6 хүний нэрийн өмнөөс) Нигерийн Хэрэг, (87/93), Африкийн Комиссын жил бүрийн 8 дах Илтгэл, 1994-1995 он. Хүний болон Улс Түмний Эрхийн тухай Африкийн Комисс /RPT/8th -ыг үзнэ үү.
2. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 17
3. Салгар де Монтего ба Колумб, (64/1979), 1982 оны 3 дугаар сарын 24, хуудас129-130

## 26.2 Дээд шатны шүүхийн хяналт

Хуулийн дагуу гэм буруутай нь тогтоогдсон, ял шийтгэгдсэн шийдвэрт гомдол гаргасан хэргийг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллага нь дээд шатны шүүх юм. Аливаа хэргийг ойролцоогоор хоёр шатанд гомдол гаргах эрхтэй байх бөгөөд анхан шатны шүүхээс хоёр дахь шатны шүүх нь илүү эрх мэдэлтэй байна.

Хүний эрхийн үндэсний комиссын шаардлагыг анхан шатны шүүх бүрэн хангадаггүй болохыг судлан тогтоосон байна.<sup>4</sup>

ИУТЭОУП-ын 14.5-р зүйлд аливаа улсад шүүхээр дахин давж заалдуулах ёстой гэж загаагүй ч үүнд заасан “хуулийн дагуу” гэдэг нь хэрвээ дотоодын хуулиар эрүүгийн хэргийг шийдвэрлэх шатанд давж заалдах эрхийг олговол шийтгэгдэж байгаа хэрэгтэн нь давж заалдсан тохиолдолд илүү үр дүнд хүрч чадна гэж тус хороо үзэж байна.<sup>5</sup>

## 26.3 Бүрэн хянах

Шүүх давж заалдсан хэргийг хянан хэлэлцэхдээ хэргийн бүх ажиллагааг бүрэн хянаж үзэх үүрэгтэй.

Америк дундын комиссоос тогтоохдоо тухайн улсын үүрэг нь зөвхөн Дээд шүүхэд давж заалдах эрхийг хангасан хуулийг багтаад зогсохгүй энэ хэргийг эдлүүлэх хэрэгжүүлэх арга хэмжээг авах явдал гэжээ. Панамд журам гаргаж, давж заалдах өргөдөл гаргах хэт богино хугацаа заасан атлаа давж заалдах шатандаа шүүхээр хэлэлцэх болтол маш удаан хүлээдэг зэрэг бодит амьдрал дээр энэ эрхийг хэрэгжүүлэхгүй байх олон саад тотгорын нэг гэж үзсэн байна.<sup>6</sup>

Хууль бусаар болон дур зоргоор яллахын эсрэг НҮБ-ын Тусгай Илтгэгч давж заалдах шатанд зөвхөн хуулийн талыг баримтлаад бодит байдлыг үл харгалзан шийдвэр гаргаж байгаад сэтгэл зовинож буйгаа илэрхийлжээ. Тэрээр үүнтэй холбон Алжирын Дээд шүүхийн хяналтын талаар дурджээ. Мөн адил Кувейт улсын Аюулаас хамгаалах шүүхэд хуулийн ба бодит байдлын аль алиныг авч үзэж байж хэргийг дахин хянах ёстой бүтэн нэг шатыг алгассан учираас хэрэгтэн олон улсын эрх зүйн хэм хэмжээнд заасан давж заалдах эрхийг эдэлж чадахгүй байгааг тэр дурджээ.<sup>7</sup>

Давж заалдах шатны шүүх “хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах”-аас илүүг хянаж үзэх ёстой.

Америк дундын Комисс Америкын Конвенцид заасан энэ эрхийг бүрэн хянахдаа давж заалдах шатанд зөвхөн өмнөх шүүхийн протоколыг хянаад зогсохгүй давж заалдах болсон шалгааныг шалгах ёстой гэж заажээ.<sup>8</sup>

## 26.4 Давж заалдах шатанд шударгаар шүүлгэх баталгаа

Олон нийтэд ил тод, шударга шүүлгэх эрхээ давж заалдах шатанд хэрэгтэн эдлэх ёстой. Үүнд давж заалдахад хүрэлцээтэй цаг нөхцлөөр хангагдсан байх, өмгөөлүүлэх, эсрэг талынхаа танилцуулсныг нотлуулах, хууль ёсны, хараат бус, шударга шүүх хурлын өмнө байцаагдах хангалттай хугацаатай байх, хүрэлцээтэй хугацаанд олон нийтэд нээлттэй сайтар шүүн тунгаасан шүүхийн шийдвэр гаргуулах зэрэгт эрх тэгш байх эрх орно.

### Ишлэл

4. Салгар де Монтебо ба Колумб, (64/1979), 1982 оны 3 дугаар сарын 24, 1 Sel.Dec 127, хуудас 129-130
5. Хенри ба Ямайка, (230/1987)1991 оны 11 дүгээр сарын 1, Хүний Эрхийн Төлөв Байдлын Илтгэл, (A/47/40), 1992 он,
6. Панама дах Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл, Америкийн Улсуудын Байгууллага Ser.L/V/II.44баримт бичиг 38, 1 дэх хэвлэл, 1978 он.
7. Хууль Бусаар болон Дур Зоргоор Яллахын Эсрэг НҮБ-ын Тусгай Илтгэгчийн Илтгэл, 1993 оны 12 дугаар сарын 7, НҮБ-ын баримт бичиг, Хүний Эрхийн Комисс.4/1997/7 болон Манфред Новак, НҮБ-ын Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт: ИУТЭОУП-ын Тайлбар, 1993 он, НП Энгел, хуудас 266
8. Хэрэг 9850, Америк Дундын Комиссын жил бүрийн Илтгэл, 1990-1991 Америкийн Улсуудын Байгууллага, Ser.L/V/II.79, баримт бичиг 12, 1991 он, хуудас 74-76, Аргентина



ШУДАРГААР  
ШҮҮЛГЭХ ЭРХ

---

## В ХЭСЭГ

### ОНЦГОЙ ХЭРГҮҮД

---

- |          |  |
|----------|--|
| Бүлэг 27 | Хүүхэд   |
| Бүлэг 28 | Цаазаар авах ял  |
| Бүлэг 29 | Шүүх болон цэргийн шүүх  |
| Бүлэг 30 | Шүүхийн алдаанаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх эрх                 |
| Бүлэг 31 | Онцгой нөхцөл байдал байсан үед шударгаар шүүгдэх эрх                |
| Бүлэг 32 | Зэвсэгт мөргөлдөөний үед хэргийг шүүхээр шударгаар шийдвэрлүүлэх эрх |



## Бүлэг 27

### Хүүхэд

Хүүхдүүд насанд хүрэгсэдтэй адил шүүхээр хэргээ шударгаар шийдвэрлүүлэх баталгааг эдлэхийн зэрэгцээ тусгай хамгаалалтанд байх эрхтэй.

- 27.1 Хэргээ шударгаар шийдвэрлүүлэх хүүхдийн эрх
- 27.2 Хүүхдийн тухай тодорхойлолт
- 27.3 Хуулиуд зөрчилдөх нөхцөлд хүүхэдтэй хэрхэн хандах талаархи үндсэн зарчмууд
  - 27.3.1 Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг таслан шийдвэрлэх тогтолцоо тусдаа байх
  - 27.3.2 Хялбаршуулсан шүүн таслах ажиллагаа
  - 27.3.3 Насанд хүрээгүй хүүхдийн хэргийг шуурхай шийдвэрлэх
  - 27.3.4 Нууцлал
- 27.4 Баривчлах болон урьдчилан хорих
- 27.5 Шүүх ажиллагаа
- 27.6 Шүүхийн шийдвэр
- 27.7 Ял
  - 27.7.1 Хориглосон ялын төрөл
- 27.8 Хоригдол хүүхдүүд

#### 27.1 Хэргээ шударгаар шийдвэрлүүлэх хүүхдийн эрх

Хүүхдүүд насанд хүрэгсэдтэй адил хэргээ шударгаар шийдвэрлүүлэх баталгааг эдлэхийн зэрэгцээ тусгай хамгаалалтанд байх эрхтэй. Энэ бүлэгт хүүхдүүдэд тэдний наснаас нь хамаарч олгогдох ёстой нэмэлт хамгаалалтын талаар өгүүлэх болно.

Олон улсын хэмжээнд “насанд хүрээгүй хүүхдийн шүүн таслах ажиллагаа” гэх нэр томъёог хэрэглэх нь гэмт хэрэгт яллагдаж, сэжиглэгдэж байгаа хүүхдийн шүүх ажиллагааг насанд хүрэгсдийн ерөнхий процессоос ялгах, насанд хүрээгүй хүүхдийг тусгайлсан шүүн таслах ажиллагааны явцад хамгаалах, харилцах зарчмыг тодорхойлох талаасаа ач холбогдолтой. Энэ гарын авлагад ч “насанд хүрээгүй хүний шүүн таслах ажиллагаа” гэсэн нэр томъёог хэрэглэсэн. Насанд хүрээгүй хүний хэргийг авч хэлэлцэх тусгай тогтолцоог буй болгосон улс орнууд ч мөн дээрх нэр томъёог хэрэглэдэг. Олон улсын стандартын дагуу насанд хүрээгүй хүүхдийн хэргийг шийдвэрлэх тусгайлсан тогтолцоотой байхыг улс орнуудад зөвлөсөн байдаг бөгөөд энэ талаар мөн доор өгүүлэх болно.

Хүний эрхийн тухай олон улсын гэрээнд ч насанд хүрээгүй хүний хэргийг авч хэлэлцэх стандартын тухай заасан байдаг, тухайлбал, Хүүхдийн эрхийн конвенцийн 1, 37, 40 дүгээр зүйл, Хүүхдийн эрхийн тунхаглал, Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах тухай НҮБ-ын дүрэм, Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай удирдамж (Риядийн удирдамж), Насанд хүрээгүй хүмүүсийн талаархи байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг журам (Бээжингийн журам). Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 10.2, 10.3, 14.4, 24 дүгээр зүйл.

Хүний эрхийн хорооны тэмдэглэснээр “насанд хүрээгүй бүх л хүн Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлд заасан болон насанд хүрсэн хүний эдлэх ёстой эрх, эрх чөлөөг эдлэх эрхтэй.”<sup>1</sup>

Мөн түүнчлэн Хүүхдийн эрхийн тухай Конвенцид хүүхэд бүр нь эрхээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай бүхий л олон улсын конвенц болон үндэсний хуулийг хэрэглэх эрхтэй.\*

\*Хүүхдийн Эрхийн Конвенцийн 41 дүгээр зүйл

#### Ишлэл

1. Хүний Эрхийн Хороо  
Ерөнхий Тайлбар 13, догол мөр  
16

\*Насанд хүрээгүй хүний эрхийг зөрчихөөс хамгаалах тухай НҮБ-ын удирдамжийн 11(a) дүгээр дүрэм  
\*\* Хүүхдийн Эрхийн Конвенцийн 1 дүгээр зүйл

\*\*\* Хүүхдийн Эрхийн Конвенцийн 40(3)(a) дүгээр зүйл

^ Бээжингийн Дүрэм – 4 дүгээр дүрэм

^^ Насанд хүрээгүй хүний эрхийг зөрчихөөс хамгаалах тухай НҮБ-ын удирдамжийн 11(a) дүгээр дүрэм

## 27.2 Хүүхэд гэж хэн бэ?

Хүүхэд гэдэгт 18 насанд хүрээгүй хүнийг хамааруулдаг нийтлэг ойлголт байдаг бөгөөд 18 насанд хүрээгүй хүн бүр нь шүүн таслах ажиллагааны тусгай хамгаалалтанд байх эрхтэй. Насанд хүрээгүй хүний эрхийг зөрчихөөс хамгаалах тухай НҮБ-ын удирдамжинд “насанд хүрээгүй хүн гэдэгт 18 нас хүрээгүй хүнийг ойлгоно” гэжээ.\* Мөн түүнчлэн Хүүхдийн эрхийн тухай Конвенцид үндэсний хуулиар өөрөөр заагаагүй бол хүүхэд гэдэгт 18 нас хүрээгүй хүнийг хэлнэ гэж тодорхойлсон байна.\*\* Хүүхдийн насыг ихэвчлэн дотоодын эрх зүйгээр тодорхойлдог ч энэ нь олон улсын стандартаас зөрөх ёсгүй.

Дотоодын эрх зүйгээр мөн насанд хүрээгүй хүүхдэд эрүүгийн ял ногдуулж болох насыг зааж өгөх нь зүйтэй.\*\*\* Ял эдлүүлж болох хүүхдийн насыг хэт доогуур тогтоож болохгүй бөгөөд энэ нь хүүхдийн сэтгэл санаа, оюун ухаан бүрэн хөгжиж дуусаагүй байдаг гэдгийг анхаарах ёстой.^

Тухайн улсын хуулиар тогтоосон насны хязгаараас доош настай хүүхдийн эрх чөлөөг хасахыг хориглоно.^

## 27.3 Хуулиуд зөрчилдөх нөхцөлд хүүхдэд хэрхэн хандах талаархи үндсэн зарчмууд

Олон улсын хэмжээнд насанд хүрээгүй хүний процессийн холбоотой эрхийг баталгаажуулж өгсөн байдаг. Олон улсын гэрээний дагуу улс бүр нь хүүхдийн ашиг сонирхлыг дээд зэргээр хамгаалах үүрэг хүлээж, хүүхдийн үйлдсэн гэмт хэрэгт нь нийцүүлэн арга хэмжээ авах, түүний хувийн нөхцөл байдлыг тусгайлан авч үзэхийг шаарддаг байна.

### Холбогдох хэм хэмжээ

#### Хүүхдийн эрхийн конвенц, 40.2.b

(b) эрүүгийн хууль зөрчсөн хэмээн сэрдэгдсэн буюу яллагдагчаар татагдсан хүүхэд бүрийг дараахь наад захын баталгаагаар хангана:

i/ гэм буруутай нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцох;

ii/ ямар хэрэгт яллагдагчаар татаж байгааг өөрт нь шууд бөгөөд шуурхай мэдэгдэх, зохих тохиолдолд эцэг эх, түүний хууль ёсны асран хамгаалагчаар нь дамжуулан мэдэгдэж, өмгөөлөгч, эрх зүйн болон бусад шаардлагатай туслалцаа үзүүлэх;

iii/ эрх зүйн болон бусад туслалцаа үзүүлж, хүүхдийн дээд ашиг сонирхолд харшлахгүй бол нас, нөхцөл байдал, эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчдын хүсэл зоригийг харгалзан нэг талын эрх ашигт үйлчлэхгүй, хараат бус, эрх бүхий байгууллага, шүүхээр асуудлыг шударга шүүлгэх;

iv/ мэдүүлэг өгөх, гэм буруугаа хүлээхийг албадахгүй байх; эсрэг мэдүүлэг өгөх гэрчийг байцаах, байцаалгах, эрх тэгш нөхцөлд хүүхдийн өмнөөс гэрчийг байцаах, гэрчийг байлцуулах;

v/ эрүүгийн хууль зөрчсөн хэмээн гаргасан шийдвэр, түүний дагуу авсан арга хэмжээг нэг талын эрх ашигт үйлчлэхгүй, хараат бус, эрх бүхий дээд шатны байгууллагаар хянуулах;

vi/ байцаан шийтгэх ажиллагааны хэлийг ойлгохгүй буюу уг хэлээр ярьж чадахгүй бол орчуулагчийн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх;

vii/ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд хүүхдийн хувийн байдлыг бүрэн хүндэтгэх.



Хүүхэдтэй холбоотой бүхий л асуудал, үйл ажиллагаа, үүнд шүүхийн, захиргааны болон хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих ёстой.\*\*

Насанд хүрээгүй хүний шүүн таслах ажиллагааны тогтолцооны хүрээнд хүүхдийн сайн сайхныг харгалзаж, дээдлэх ёстой бөгөөд насанд хүрээгүй хууль зөрчигчдөд авах арга хэмжээ нь түүний үйлдсэн зөрчил, тухайн хүүхдийн нөхцөл байдалтай уялдах ёстой.\*\*\*

Улс бүр нь гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа болон яллагдаж буй хүүхдийн нэр хүнд, нэр төрөө хүндэтгэхийг шаардах эрхийг нь хүлээн зөвшөөрөх ёстой бөгөөд хүүхдийн нас, хүүхдийн нийгэмших, нийгэмдээ гүйцэтгэх үүргийг нь харгалзан үзэх ёстой.^

Мөн түүнчлэн улс нь хүүхдийн эрхийг хэрэгжүүлж, тэдний аюулгүй байдлыг хангах, хүүхдийн биеийн болон сэтгэл санааны сайн сайхан байдлыг дэмжиж, эргээд засан хүмүүжүүлэх асуудлыг ч анхаарах нь зүйтэй.^

Нийгмийн хэм хэмжээ болон үнэт зүйлтэй нийцэхгүй байгаа хүүхдийн үйлдэл нь ихэвчлэн хүүхдийн төлөвших нэг хэсэг бөгөөд олон тохиолдолд хүүхдийг насанд хүрсэнээр алга болдог гэдгийг ч харгалзах нь зүйтэй.^^

Хүүхэд бүр нь үг үзэл бодлоо илэрхийлэх эрхтэйг учирлан, шүүхийн болон шүүхийн өмнөх бүхий л үйл ажиллагаанд шууд буюу төлөөлөгчөөрөө дамжуулан үгээ хэлэх эрхийг хүүхдэд олгох ёстой. Хүүхдийн нас, төлөвшсөн байдал зэргийг нь харгалзаж үзэл бодлыг сонсож, ач холбогдол өгч байх нь зүйтэй.+

### 27.3.1 Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг таслан шийдвэрлэх тогтолцоо тусдаа байх

Ихэнх олон улсын стандартын дагуу насанд хүрээгүй хүүхдийн хэргийг авч хэлэлцэх тусгайлсан тогтолцоо байгуулахыг зөвлөдөг бөгөөд энэ нь заавал гэсэн утгатай биш юм.++

Гэвч Америкийн конвенцийн дагуу насанд хүрээгүй хүний хэргийг тусгайлсан шүүхээр авч хэлэлцэхийг шаарддаг.+++

\* ИУТЭОУП-ын 24(1) дүгээр зүйл, Америкийн Конвенцийн 19 дугаар зүйл болон Хүүхдийн Эрхийн Тунхаглалын 2 Дугаар зарчим

\*\* Хүүхдийн Эрхийн Конвенцийн 3(1) дүгээр зүйл

\*\*\* Бээжингийн Дүрмийн 5 болон 17.1 дүгээр дүрмүүд

^ Хүүхдийн Эрхийн Конвенцийн 40(1) дүгээр зүйл

^^ ИУТЭОУП-ын 14(4) дүгээр зүйл, Насанд хүрээгүй хүний эрхийг зөрчихөөс хамгаалах тухай НҮБ-ын удирдамжийн 1 дүгээр дүрэм

^^^Риядын Удирдамжийн 5(д) зүйл

+ Хүүхдийн Эрхийн Конвенцийн 12 дугаар зүйл

++ Хүүхдийн Эрхийн Конвенцийн 40(3) дүгээр зүйл болон Бээжингийн Дүрмийн 2.3 дугаар дүрэм

+++ Америкийн Конвенцийн 5(5) дугаар зүйл.

#### Холбогдох хэм хэмжээ

**Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 14.4 дүгээр зүйл**  
4. Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тэдний насыг болон засч хүмүүжихэд нь дэмжлэг үзүүлүүштэйг харгалзсан байх ёстой.

\* Хүүхдийн Эрхийн Конвенцийн 40(3)(б) дүгээр зүйл болон Бээжингийн Дүрмийн 11 дүгээр дүрэм

\*\* ИУТЭОУП-ын 10(2) дүгээр зүйл, Хүүхдийн Эрхийн Конвенцийн 40(2)(б)(3) дүгээр зүйл болон Бээжингийн Дүрмийн 20 дугаар дүрэм, Америкийн Конвенцийн 5(5) дугаар зүйл

\*\*\* Хүүхдийн Эрхийн Конвенцийн 40(2)(б)(3) дүгээр зүйл болон Бээжингийн Дүрмийн 8 ба 21 дүгээр дүрэм

^ Бээжингийн Дүрмийн 21 дугаар дүрэм

^^ Бээжингийн Дүрмийн 21.2 дугаар дүрэм, Насанд хүрээгүй хүний эрхийг зөрчихөөс хамгаалах тухай НҮБ-ын удирдамжийн 19 дүгээр дүрэм

^^^ Хүүхдийн Эрхийн Конвенцийн 9 дүгээр зүйл ба Хүүхдийн Эрхийн Тунхаглалын 6 дугаар зарчим

+ Хүүхдийн Эрхийн Конвенцийн 37(б) дүгээр зүйл, Насанд хүрээгүй хүний эрхийг зөрчихөөс хамгаалах тухай НҮБ-ын удирдамжийн 1 дүгээр дүрэм, Бээжингийн Дүрмийн 19 дүгээр дүрэм, Риядын Удирдамжийн 46 дугаар зүйл

++ ИУТЭОУП-ын 10(2)(б) дүгээр зүйл, Хүүхдийн Эрхийн Конвенцийн 37(в) дугаар зүйл, Бээжингийн Дүрмийн 13.4 дүгээр дүрэм, Насанд хүрээгүй хүний эрхийг зөрчихөөс хамгаалах тухай НҮБ-ын удирдамжийн 29 дүгээр дүрэм, Америкийн Конвенцийн 5(5) дугаар зүйл

+++ Хүүхдийн Эрхийн Конвенцийн 37(в) дүгээр зүйл ба , Насанд хүрээгүй хүний эрхийг зөрчихөөс хамгаалах тухай НҮБ-ын удирдамжийн 29 дүгээр дүрэм

## Ишлэл

2.НҮБ-ын Эрүү шүүлтийн талаарх Тусгай Илтгэгчийн илтгэл (Хүний Эрхийн Комисс.4/1998/17) догол мөр 48

### 27.3.2 Хялбаршуулсан шүүн таслах ажиллагаа

Насанд хүрээгүй хүүхдийн хэргийг аль болохоор хялбаршуулсан журмаар явуулж болох бөгөөд энэ нөхцөлд хүүхдийн эрх, хууль зүйн баталгаар сайтар хангах ёстой . Энэ нь гол төлөв нийгмийн болон бусад арга хэрэгслээр дамжуулан авч хэлэлцэхийг хэлж байгаа.\*

### 27.3.3 Насанд хүрээгүй хүний хэргийг шуурхай шийдвэрлэх

Насанд хүрээгүй хүний хэргийг аль болохоор түргэн шуурхай шийдвэрлэх ёстой.\*\*

### 27.3.4 Нууцлал

Хүүхдийн сэтгэл санааг хамгаалах үүднээс ял тулгагдаж байгаа эсвэл сэжиглэгдэж байгаа хүүхдийн нууцыг холбогдох процессийн хуулиар хамгаалсан байх ёстой.\*\*\*

Насанд хүрээгүй хүний гэмт хэргийн бүртгэлийн талаар мэдээллийг нууцлах ёстой бөгөөд эрх бүхий этгээдээс бусад этгээдэд өгч болохгүй.^ Эдгээр мэдээллийг тухайн хүүхдийг насанд хүрсний дараа түүний эсрэг бусад шүүх ажиллагаанд ашиглах ёсгүй.^

## 27.4 Баривчлах болон урьдчилан хорих

Хүүхдийг баривчлах талаар хэд хэдэн олон улсын эрх зүйн зарчим байдаг ч хамгийн гол нь хүүхдийг эцэг эхээс нь салгахгүй байх, хүүхдийн ашиг сонирхолыг нэн тэргүүнд харгалзах ёстой.^^

Хүүхдийг баривчлах, түр саатуулах, хорих арга хэмжээ нь хамгийн сүүлд авах ёстой арга хэмжээ байх ёстой бөгөөд энэхүү арга хэмжээг авахдаа хуулийг чандлан сахиу үүрэгтэй төдийгүй хугацааг хамгийн богиноор тогтоох нь зүйтэй.+

Шүүх хурлаа хүлээж буй хүүхдийг аль болохоор насанд хүрээгүй хүмүүсээс тусгаарлах хэрэгтэй.\*\*

Эрүү шүүлтийн талаар тусгай илтгэгчийн мэдээлснээр насанд хүрэгчидтэй цуг албадан саатуулагдсан хүүхдүүд биеийн, бэлгийн болон сэтгэл санааны дарамт, хүчинд автагдах явдал байсан гэжээ.<sup>2</sup>

Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 37.с дүгээр зүйлд заасны дагуу насанд хүрээгүй хүнийг хэрэв энэ нь түүний ашиг сонирхолд нийцэж байвал зөвхөн гэр бүлийн насанд хүрсэн хүмүүстэй нь цуг байлгахад бусад тохиолдолд насанд хүрсэн хүмүүстэй хамт байлгаж болохгүй гэжээ.<sup>+++</sup>

### Холбогдох хэм хэмжээ

#### Бээжингийн дүрмийн 8 дугаар дүрэм:

8.1 Насанд хүрээгүй хүний хувийн нууцтай байх эрхийг бүхий л шатанд хамгаалах нь түүнийг олон нийтийн шившиг, нэр өгөх зэрэг байдлаас хамгаалах зорилготой.

8.2 Насанд хүрээгүй хүний нэр усыг заасан мэдээллийг олон нийтэд мэдээлж болохгүй.

Хууль зөрчсөн гэж сэжиглэгдэж байгаа хүүхдийг баривчлах эсвэл урьдчилан хорих нөхцөлд хэрэв энэ нь хүүхдийн эрх ашигт харшлахгүй л бол нэн даруй түүний эцэг эхэд нь мэдэгдэх хэрэгтэй. Хэрэв нэн даруй мэдэгдэх боломжгүй бол аль болох нэн даруй мэдэгдэх шаардлагатай.\*

Хууль сахиулах байгууллагынхан хүүхэдтэй харьцахдаа түүний хууль ёсны байдлыг хүндэтгэж, түүнд хохирол учруулахгүйгээр, хүүхдийн сайн сайхны төлөө харьцах үүрэгтэй.\*\*

Насанд хүрээгүй хүмүүстэй харьцуулахад олон улсын стандартын дагуу насанд хүрээгүй хүүхдийг аль болохоор саатуулахгүй байхыг зөвлөдөг. Хүүхдийг баривчлах, албадан саатуулахаас аль болохоор зайлсхийх нь зүйтэй гэдэг бөгөөд түүнээс өөр арга хэмжээ байхгүй нөхцөлд л хэрэглэх нь зүйтэй. Хэрэв насанд хүрээгүй хүнийг баривчилж албадан саатуулсан бол тэдэнтэй холбоотой хэргийг нэн түрүүнд анхаарч аль болохоор хурдан шийдэх нь зүйтэй.\*\*\*

Улс орнууд хуулиараа хүүхдийг хорьж болохгүй насны заагийг тодорхойлж өгөх ёстой.^

Иргэний болон улс төрийн эрхийн тухай Конвенцийн 10.2.b-д заасны дагуу насанд хүрээгүй хүүхдийн хэргийг хурдан шийдвэрлэх нь уг Конвенцийн 9.3-г заасан шүүх ажиллагааг боломжийн түргэн хугацаанд шийдэх ёстой зарчимтай уялдаатай (**Долдугаар бүлэг**). Энэ нь мөн шүүх ажиллагааг үндэслэлгүйгээр хойшлуулахгүй байх тухай 14.3.c-д тусгагджээ (**19 дүгээр бүлэг**). Эдгээрийн зорилго нь насанд хүрээгүй хүний хэргийг аль болохоор шуурхай шийдүүлэх юм. Энэ нь тэдгээрийг даруй суллах болон шүүхийн шийдвэрийг хурдан гаргуулахад нөлөөлнө.<sup>3</sup>

### Холбогдох хэм хэмжээ

#### Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 37.b

“Ямар ч хүүхдийг хууль бусаар эсвэл албадан баривчилж, эрх чөлөөг нь хасаж болохгүй. Хүүхдийг баривчлах, саатуулах, хорих арга хэмжээ нь зөвхөн хуульд заасны дагуу авагдах ёстой бөгөөд үүнээс өөр арга хэмжээ байхгүй нөхцөлд хэрэглэгдэж, хамгийн богино хугацаанд байх ёстой”.

#### Иргэний болон улс төрийн эрхийн тухай Пактын 10.2.b

“Сэжигтэн, яллагдагчаар татагдсан хүүхдийн хэргийг шүүхээр нэн тэргүүнд хурдан шийдэх ёстой”.

#### Баривчлагдсан, саатуулагдсан хүүхдийн эрхийг хамгаалах талаар НҮБ-ын журам, 17 дугаар заалт

“Шүүхийн өмнөх ажиллагаанд хүүхдийг зөвхөн онцгой нөхцөлд л баривчилж болох бөгөөд аль болохоор энэ арга хэмжээнээс зайлсхийх нь зүйтэй. Үүний оронд өөр арга хэмжээ авах нь зүйтэй. Нэгэнт хүүхдийг баривчилж, саатуулсан бол түүнтэй холбоотой хэргийг насанд хүрээгүй хүмүүсийг шүүх, байцаах эрхтэй субъектүүд нэн тэргүүнд шуурхай шийдвэрлэнэ.”

#### Бээжингийн дүрэм. 13.1 болон 13.2

“13.1 хүүхдийг баривчлах арга хэмжээг эцсийн арга хэмжээ байх ёстой бөгөөд хугацаа нь ч хамгийн богино байх ёстой.

\* Хүүхдийн Эрхийн Конвенцийн 9(4) дүгээр зүйл, Бээжингийн Дүрмийн 10.1 дүгээр дүрэм, Насанд хүрээгүй хүний эрхийг зөрчихөөс хамгаалах тухай НҮБ-ын удирдамжийн 22 дугаар дүрэм

\*\* Бээжингийн Дүрмийн 10.3 дүгээр дүрэм

\*\*\*ИУТЭОУП-ын 10(2)(б) дүгээр зүйл, Хүүхдийн Эрхийн Конвенцийн 37(б) дугаар зүйл, Насанд хүрээгүй хүний эрхийг зөрчихөөс хамгаалах тухай НҮБ-ын удирдамжийн 17 дугаар дүрэм, Бээжингийн Дүрмийн 13 дугаар дүрэм

^ Насанд хүрээгүй хүний эрхийг зөрчихөөс хамгаалах тухай НҮБ-ын удирдамжийн 11(а) дүгээр дүрэм

### Ишлэл

3. Манфред Новак, НҮБ-ын Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт: ИУТЭОУП-ын Тайлбар, 1993 он, хуудас 190-191

\* Хүүхдийн Эрхийн Конвенцийн 37(г) дугаар зүйл, Бээжингийн Дүрмийн 10.2 дугаар дүрэм

\*\* Бээжингийн Дүрмийн 13.5 дугаар дүрэм, Насанд хүрээгүй хүний эрхийг зөрчихөөс хамгаалах тухай НҮБ-ын удирдамжийн IV(Г) хэсэг ба 18 дугаар дүрэм

\*\*\* Хүүхдийн Эрхийн Конвенцийн 37(в) дүгээр зүйл

^ Хүүхдийн Эрхийн Конвенцийн 37(а) ба (в) дүгээр зүйл, Риядын Удирдамжийн 46 дугаар зүйл

^^ Хүүхдийн Эрхийн Конвенцийн 40(2)(б)(2) дүгээр зүйл

^^^ ИУТЭОУП-ын 14(4) дүгээр зүйл, Насанд хүрээгүй хүний эрхийг зөрчихөөс хамгаалах тухай НҮБ-ын удирдамжийн 1 дүгээр дүрэм

13.2 баривчлах саатуулах арга хэмжээг өөр арга хэмжээгээр тухайлбал хяналт, эрчимтэй асран хамгаалалт, гэр бүлд нь байлгах, асран хүмүүжүүлэх газар байрлуулах замаар орлуулж болно”.

Насанд хүрсэн хүмүүсийн адил хүүхдүүд нь баривчлагдаж саатуулагдсан нөхцөлд өмгөөлөгчийн туслалцаа авах, ямар шалтгаанаар баривчлагдсан талаар мэдэх эрхтэй. (3 дугаар бүлэг, 6-р бүлэг). Насанд хүрээгүй хүүхдийг суллах, эсхүл хугацааг нь сунгах асуудлыг нэн даруй шийдвэрлэх ёстой.\*

Албадан саатуулагдсан хүүхдийг халамжилж, хамгаалж, туслалцаа үзүүлж байх хэрэгтэй.\*\*

Насанд хүрээгүй хүмүүс нь захидалаар харилцах, бусадтай холбоо тогтоох эрхтэй байх бөгөөд тэдэнд онцгой тохиолдлоос бусад тохиолдолд эцэг эхтэйгээ уулзах боломжийг өгөх ёстой.\*\*\*

Насанд хүрсэн хүмүүсийн адил баривчлагдсан болон саатуулагдсан хүүхдүүд нь доромжлогдох ёсгүй. Тэдэнд эрүү шүүлт тулгах, тэдэнтэй хэрцгий хүнлэг бусаар харьцахыг хориглоно.^ Мөн тэдний насанд нь тохируулан харьцах нь зүйтэй. (4 болон 10 дугаар бүлэг).^

## 27.5 Шүүх ажиллагаа

Насанд хүрээгүй хүмүүстэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэх нь хүүхдийн эрх, аюулгүй байдал зэргийг хүндэтгэж, хүүхдийн нас болон тэднийг засан хүмүүжүүлэх асуудлыг анхаарах талаасаа байх ёстой.^^^ Энэ нь хүүхдийг гэмт хэргийн хар толбоноос хамгаалах болон түүнийг шийтгэх гэхээсээ илүү засан хүмүүжүүлэх, сургах талаас нь шүүх ажиллагааг явуулах ёстой гэдгийг анхаарах хэрэгтэй.^

### Холбогдох хэм хэмжээ

#### Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 37.d:

“(d) эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд бүр эрх зүйн болон бусад зохих туслалцааг даруй авах, түүнчлэн эрх чөлөөгөө хасуулсан нь хуулийн үндэслэлтэй эсэхийг шүүх буюу эрх бүхий хараат бус, аль нэг талын эрх ашигт үйлчлэхгүй байгууллагаар тогтоолгох, шуурхай шийдвэрлүүлэх эрхтэй”.

#### Бээжингийн журам 13.3 болон 13.5:

13.3 Шүүхийн өмнөх ажиллагааны явцад баривчлагдсан насанд хүрээгүй хэн бүр нь НҮБ-ын хоригдогсодтой харьцах талаар наад захын журамд заасан эрх, эрх чөлөөг эдлэх эрхтэй.

13.5 Саатуулагдсан үедээ насанд хүрээгүй хэн бүр нь тэдний нас, хүйс, хувь мөн чанартай нийцүүлсэн нийгмийн, боловсролын, амралтын, сэтгэл санааны, эмнэлгийн зэрэг туслалцааг авах эрхтэй.

#### Хүүхдийн эрхийн конвенцийн 37.а болон с:

(а) хүүхдэд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхгүй байх, 18 насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэрэгт цаазаар авах буюу суллах боломжгүйгээр бүх насаар нь хорих ял оногдуулахгүй байх;

(с) эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд бүрд насных нь хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг харгалзан нэр төрийг нь хүндэтгэн, хүнлэг хандана. Дээд ашиг сонирхолд нь харшилна гэж үзээгүй бол эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд бүрийг насанд хүрэгчдээс тусгаарлах, онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд гэр бүлтэйгээ харилцаатай байх, уулзах боломжоор хангах;

### Ишлэл

4. Манфред Новак, НҮБ-ын Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт: ИУТЭОУП-ын Тайлбар, 1993 он, НП Энгел, хуудас 265-66

Хүүхдийн хувийн нууцыг хамгаалах зорилгоор хүүхэдтэй холбоотой хэргийг хаалттай хэлбэрээр явуулах бөгөөд энэ нь шүүх ажиллагааг нээлттэй явуулах зарчмаас ялгагдах онцгой тохиолдол юм.\* (14.3 дугаар бүлэг).

Шүүх ажиллагааны явцад хүүхдүүд нь өмгөөлөгчтэй байх эрхтэй бөгөөд өөрийн үзэл бодлоо илэрхийлэх чадвартай хүүхдүүдэд аливаа шүүхийн болон захиргааны хэрэг шийдвэрлэх явцад шууд буюу төлөөлөгчөөрөө дамжуулан үгээ хэлэх боломжийг олгож байх ёстой.\*\*/\*\*

## 27.6 Шүүхийн Шийдвэр

Хүүхдийг гэмт хэргийн толбоос нь хамгаалах үүднээс тэдэнтэй холбоотой хэргийн шийдвэрийг олон нийтэд зарлаж болохгүй. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14.1-т заасны дагуу хүүхэдтэй холбоотой хэргийн шийдвэрийг олон нийтэд зарлахгүй байхыг зөвшөөрсөн байдаг.^ (24-р бүлэг. Шүүхийн шийдвэр)

## 27.7 Ял

Хүүхдэд ял ногдуулахдаа түүний ашиг сонирхлыг харгалзан үзэх нь нэн чухал юм. Хүүхдэд ял ногдуулахдаа нэн тэргүүнд түүний сайн сайхан, засан хүмүүжүүлэх байдлыг харгалзан үзэх нь зохистой.^

Аливаа ял нь хүүхдийн үйлдсэн хэрэг болон нөхцөл байдалд тохирсон байна.^

Хүүхдийг хорих шийдвэр нь онцгой нөхцөлд ногдох зөвхөн эцсийн арга хэмжээ байх ёстой. Бээжингийн журмын 17.1.с-д заасны дагуу хүүхдийг хорих шийдвэрийг зөвхөн бусдын эсрэг хүнд хэрэг үйлдсэн, эсвэл хүнд гэмт хэрэг үйлдсэн нөхцөлд өөр арга хэмжээ авч болохгүй нөхцөлд ногдуулна.\*

### Холбогдох хэм хэмжээ

#### Иргэний болон улс төрийн эрхийн Пактын 14.4:

“4. Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тэдний насыг болон засч хүмүүжихэд нь дэмжлэг үзүүлүүштэйг харгалзсан байх ёстой.”

#### Бээжингийн дүрэм: 14.1, 14.2:

“14.1 Насанд хүрээгүй хүнтэй холбоотой хэргийг шударга шүүх ажиллагааны зарчмын дагуу эрх бүхий байгууллага, үүнд шүүх, зөвлөл зэрэг байгууллагаар шийдвэрлэнэ.

14.2 Шүүх ажиллагааг хүүхдийн ашиг сонирхолыг дээд зэргээр хамгаалах байдлаас явагдах ёстой төдийгүй түүнд уг ажиллагаанд оролцох, өөрийгөө илэрхийлэх эрхийг олгосон, түүнийг ойлгосон уур амьсгалтай явагдах ёстой”.

#### Хүүхдийн эрхийн тухай Конвенц 40.4:

:4. Хүүхдийн аж байдал, үйлдсэн хэргийн байдалд тохируулан хандах үүднээс асрамжлах, хянан харгалзах, зөвлөгөө өгөх, туршилтын хугацаа тогтоох, асран хүмүүжүүлэх газар, боловсрол, мэргэжлийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, чиглүүлэх тухай захирамж гаргах, түр асрамжид шилжүүлэх зэргээр бусад олон хувилбарын арга хэмжээ авах нь чухал.

\* Хүүхдийн Эрхийн Конвенцийн 40(2)(б)(2) дүгээр зүйл, Европын конвенцийн 6(1) дугаар зүйл, ИУТЭОУП-ын 14(1) дүгээр зүйл

\*\* Хүүхдийн Эрхийн Конвенцийн 40(2)(б)(2) дүгээр зүйл ба Бээжингийн Дүрмийн 15 дугаар дүрэм

\*\*\* Хүүхдийн Эрхийн Конвенцийн 12 дугаар зүйл

^ИУТЭОУП-ын 14(1) дүгээр зүйл, Хүүхдийн Эрхийн Конвенцийн 40(2)(б)(7) дүгээр зүйл

^^ Хүүхдийн Эрхийн Конвенцийн 40(4) дүгээр зүйл, Бээжингийн Дүрмийн 17 дугаар дүрэм. Түүнчлэн ИУТЭОУП-ын 14(4) дүгээр зүйл, Хүүхдийн Эрхийн Конвенцийн 40(1) дүгээр зүйл, Хүүхдийн Эрхийн Тунхаглалын 7 дугаар зарчмуудыг үзнэ үү.

^^^ Хүүхдийн Эрхийн Конвенцийн 40(4) дүгээр зүйл, Бээжингийн Дүрмийн 5 болон 17.1 дугаар дүрмүүд.

\*Хүүхдийн Эрхийн Конвенцийн 37(б) дугаар зүйл, Насанд хүрээгүй хүний эрхийг зөрчихөөс хамгаалах тухай НҮБ-ын удирдамжийн 1 ба 2 дугаар дүрэм, Бээжингийн Дүрмийн 17 ба 19 дүгээр дүрэм

\*\* Бээжингийн Дүрмийн 17.3 дугаар дүрэм

\*\*\* Насанд хүрээгүй хүний эрхийг зөрчихөөс хамгаалах тухай НҮБ-ын удирдамжийн 64 дүгээр дүрэм

^ Хүүхдийн Эрхийн Конвенцийн 37(б) дугаар зүйл

^^ ИУТЭОУП-ын 6(5) дугаар зүйл, Хүүхдийн Эрхийн Конвенцийн 47(а) дугаар зүйл, Цаазаар Авах Ялын Хамгаалалтын 3 дугаар хэсэг, Бээжингийн Дүрмийн 17.2 дугаар дүрэм, Америкийн Конвенцийн 4(5) дугаар зүйл

^^^ ИУТЭОУП-ын 4 дүгээр зүйл, Америкийн Конвенцийн 27 дугаар зүйл

+ ИУТЭОУП-ын 10(3) дугаар зүйл, Хүүхдийн Эрхийн Конвенцийн 37(в) дугаар зүйл, Насанд хүрээгүй хүний эрхийг зөрчихөөс хамгаалах тухай НҮБ-ын удирдамжийн 28 ба 29 дүгээр дүрэм, Бээжингийн Дүрмийн 26.3 дугаар дүрэм, Европын Шоронгийн Дүрмийн 11(4) дүгээр дүрэм

++ Риядын Удирдамжын 54 дүгээр зүйл

# Насанд хүрээгүй хүний эрхийг зөрчихөөс хамгаалах тухай НҮБ-ын удирдамжийн 67 дугаар дүрэм

## Насанд хүрээгүй хүний эрхийг зөрчихөөс хамгаалах тухай НҮБ-ын удирдамжийн 64 дүгээр дүрэм

### Хүүхдийн Эрхийн Конвенцийн 37(в) дугаар зүйл

#### Хүүхдийн Эрхийн Конвенцийн 28 дугаар зүйл, Хүүхдийн Эрхийн Тунхаглалын 7 дугаар зарчмуудыг үзнэ үү.

## Ишлэл

5. Хүүхдийн Эрхийн Хороо, Судалгааг Дүгнэх нь, Австрали, НҮБ-ын баримт бичиг, ХЭХ/С/15/ Нэмэлт.79, 1997 он, догол мөр 15

## 27.7.1 Хориглосон ялын төрөл

Насанд хүрээгүй хүүхдэд бие махбодийг шийтгэл ногдуулж болохгүй.\*\*

Хүүхдийн эрхийн хорооны тэмдэглэснээр бие махбодийн тарчлаан зовоох ял ногдуулах нь Хүүхдийн эрхийн конвенцид нийцэхгүй.<sup>5</sup>

Хүүхдийн эрхийг хязгаарласан болон хүч хэрэглэсэн арга хэмжээг зөвхөн онцгой нөхцөлд л хэрэглэж болох бөгөөд энэ нь бусад арга хэмжээг авсан ч үр дүнд хүрээгүй хийгээд эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авсны дараа, хуульд заасан нөхцөлд л хэрэглэгдэх ёстой. Тэдгээр нь хүний нэр хүндийг гутаасан, доромжилсон байж болохгүй бөгөөд цаг хугацааны хувьд ч боломжийн хэрээр хамгийн богино байх ёстой. \*\*\* (10 дугаар бүлэг).

Насаар нь хорих ялыг гэмт хэрэг үйлдэх үедээ 18 нас хүрээгүй байсан хүнд ногдуулж болохгүй.^

Ихэнх орны үндэсний хуулиар нь насны хязгаарыг хэрхэн зааснаас үл хамаарч, мөн шүүх ажиллагааг хэрэгжүүлэх явцад тухайн хүний нас хэд байснаас үл хамаарч, гэмт хэрэг үйлдэх үедээ 18 нас хүрээгүй хүнд цаазаар авах ял ногдуулж болохгүй^^ (28 дугаар бүлэг, цаазаар авах ял). Гэмт хэрэг үйлдэх үедээ насанд хүрээгүй хүмүүсийн хувьд цаазаар авах ял ногдуулахгүй байх нь бүхий л үед, бүхий л нөхцөлд хэрэглэгддэг.^^^

## 27.8 Хоригдол хүүхдүүд

Насанд хүрээгүй хүнийг насанд хүрсэн хүнээс тусад нь хорьж тэдний нас болон эрх зүйн байдалд нийцүүлж харьцах ёстой. +

Ямар ч хүүхдэд эрүү шүүлт тулгаж, хэрцгий хүнлэг бусаар харьцаж болохгүй. Мөн түүнчлэн энэхүү шаардлага нь түүнд хэрцгий бөгөөд нэр төрийг нь гутаасан хариуцлага ногдуулж болохгүй нөхцөл байдалд мөн хамаарна^^ (10 дугаар бүлэг).

Хүүхдийн нэр хүндийг гутаасан, хэрцгий зэрэг сахилгын арга хэмжээ, тухайлбал биед нь гэмтэл учруулах шийтгэл, харанхуй өрөөнд суулгах, хоол, гэр бүлийн гишүүдтэй уулзах эрхийг нь хасах, олноор нь шийтгэх зэрэг хүүхдийн бие болон сэтгэл санаанд нь хохирол учруулах шийтгэл, арга хэмжээ ногдуулахыг хориглоно.#

Хүүхдийн эрх чөлөөг нь хязгаарлах нь зөвхөн өөр арга хэмжээ хэрэглэж болохгүй бөгөөд эцсийн арга хэмжээ болсон нөхцөлд л хэрэглэгдэнэ.##

Зөвхөн онцгой нөхцөлд л хязгаарлаагүй бол хүүхэд нь гадаад ертөнцтэй холбоо тогтоох, гэр бүлийн гишүүдтэйгээ уулзах эрхтэй байна.### Мөн түүнчлэн хүүхэд нь сурч боловсрох эрхтэй.####

## Холбогдох хэм хэмжээ

### Бээжингийн журам 17.1.a болон 17.1.b

Эрх бүхий байгууллага нь үйл ажиллагаандаа дараахт зарчмыг баримтална:

a. Хүүхдийн эсрэг арга хэмжээг авахдаа гэмт хэргийн хүндийг харгалзан үзэхээс гадна тухайн хүүхдийн нөхцөл байдал, хэрэгцээ, нийгмийн хэрэгцээ зэргийг харгалзан үзэх нь зохистой.

b. Насанд хүрээгүй хүний эрх чөлөөг маш нарийн судалж бодсоны дараа хасаж болох бөгөөд хугацаа нь хамгийн багаар байх нь зүйтэй.

### Бээжингийн журам. 26.1

Хүүхдийг засан хүмүүжүүлэх газар байрлуулах нь тэдэнд шаардлагатай халамж, хамгаалалт үзүүлэх, сургах зорилготой бөгөөд энэ нь эргээд тэдэнд нийгэмдээ үр дүнтэй үүрэг гүйцэтгэхэд нь тус дэм болох талаасаа ач холбогдолтой.

## БҮЛЭГ 28

### Цаазаар авах ял

Эмнести Интернэшнл нь бүх төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ял ногдуулах, хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхийг эсэргүүцдэг. Цаазаар авах ял авсан хүмүүс олон улсын хүний эрхийн жишиг хэмжээнд нийцсэн шударгаар шүүлгэх болон бусад нэмэгдэл баталгаагаар хангагдах ёстой. Эдгээр нэмэгдэл баталгаагаар хангаагүй нөхцөлд цаазаар авах ял ногдуулахыг хориглоно.

- 28.1 Цаазаар авах ялыг халах
- 28.2 Ялыг хөнгөрүүлж буй заалтаас бусад заалтыг буцаан хэрэглэхгүй байх
- 28.3 Цаазаар авах ял оногдуулах хэргийн тоог цөөрүүлэх
- 28.4 Цаазаар авах ял оногдуулж болохгүй хүмүүс
  - 28.4.1 Насанд хүрээгүй хүмүүс
  - 28.4.2 Өндөр настан
  - 28.4.3 Сэтгэцийн эмгэгтэй хүмүүс
  - 28.4.4 Жирэмсэн болон нярай эмэгтэйчүүд
- 28.5 Шударгаар шүүлгэх баталгаагаар хангагдах эрх
  - 28.5.1 Үр нөлөөтэй зөвөлгөө авах эрх
  - 28.5.2 Өөрийгөө өмгөөлүүлэхэд бэлтгэхэд хүрэлцэхүйц хугацаа, бололцоотой байх эрх
  - 28.5.3 Хэргээ цаг алдалгүй шийдвэрлүүлэх эрх
  - 28.5.4 Давж заалдах эрх
- 28.6 Уучлал үзүүлэх буюу ялыг хөнгөрүүлж өгөх хүсэлт гаргах эрх
- 28.7 Цаазаар авах ялыг гүйцэтгэж болохгүй үе
- 28.8 Ял оногдуулах ба цаазаар авах ялыг гүйцэтгэх хоорондын хугацаа
- 28.9 Цаазаар авах ялтай хоригдолын шоронгийн нөхцөл

#### 28.1 Цаазаар авах ялыг халах

Эмнести Интернэшнл нь бүх төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулах, хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэх, амьд явах эрхийг хасах ял оногдуулахын эсрэг байр суурьтай байдгийг дээр дурьдсан билээ.

Түүнчлэн ямар ч нөхцөлд эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэж болохгүй. / 10.4 бүлэгээс үзнэ үү /

Амьд явах эрх бол хүний суурь эрх.\* Тийм ч учраас энэ эрх хэзээ ч зөрчигдөх ёсгүй.\*\*

Өнөөгийн нөхцөлд цаазаар авах ялыг халахыг уриалах нь олон улсын хүний эрхийн жишиг хэмжээ болоод байгаа.\*\*\*

Цаазаар авах ялыг халах зорилго бүхий олон улсын гэрээг олон улсын хамтын нийгэмлэг батлан гаргасан билээ. Түүнчлэн ИУТЭОУП-ын хоёрдугаар нэмэлт Протокол, Цаазаар авах ялыг халах тухай Америкийн хүний эрхийн конвенцийн Протокол, Европийн Конвенцийн 6-р Протоколд энхийн цагт цаазаар авах ялыг хориглох тухай болон цаазаар авах ялыг халах тухай тусгайлан заасан заалтууд бий.^

\* ХЭТТ-ын 3 дугаар зүйл, ИУТЭОУП-ын 6 дугаар зүйл, Хүүхдийн Эрхийн Конвенцийн 6 дугаар зүйл, Африкийн Дүрмийн 4 дүгээр зүйл, Америкийн Тунхаглалын 1 дүгээр зүйл, Америкийн Конвенцийн 4 дүгээр зүйл, Европын Конвенцийн 2 дугаар зүйл

\*\* ИУТЭОУП-ын 4(2) дугаар зүйл, Америкийн Конвенцийн 27(2) дүгээр зүйл

\*\*\* ИУТЭОУП-ын 6(6) дугаар зүйл, Америкийн Конвенцийн 4(2) ба 4(3) дүгээр зүйл

^ ИУТЭОУП-ын 2 дугаар Нэмэлт Протокол, Хүний Эрхийн тухай Америкийн Конвенцийн Цаазаар авах ялыг халах Нэмэлт Протокол, Европын Конвенцийн 6 дугаар Нэмэлт Протокол

Бүс нутгийн болон олон улсын байгууллагууд, түүнчлэн хүний эрхийн мэргэжилтнүүд цаазаар авах ялыг халахыг дэмждэг.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей цаазаар авах ял оноодог гэмт хэргийн тоог цөөрүүлэх, цаашдаа цаазаар авах явдлыг халах чигийг баримтлахыг дэмждэг.

Хүний эрхийн хороо ИУТЭОУП-ын 6 дугаар зүйл нь цаазаар авах ялыг халахыг дэмжсэн утгатай хэмээн үздэг. Хороо цаазаар авах ялыг халах нь хүний амьд явах эрхийг баталгаажуулж буй хэрэг гэж дүгнэжээ.<sup>2</sup>

1997, 1998 онд НҮБ-ын Хүний Эрхийн Хороо бүх улсад цаазаар авах ялыг оногдуулахыг хойшлуулах, түүнчлэн бүрэн халахыг уриалсан боловч энэ уриалгаа бүрэн хэмжээнд биелээгүй юм.<sup>3</sup>

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл хуучнаар Югослав болон Угандад олон улсын Эрүүгийн Шүүх байгуулахдаа төрлөөр устгах, хүн төрөлхтөний эсрэг болон дайны гэмт хэрэг гэх мэт жигшүүртэй хэргүүдээс бусад тохиолдолд цаазаар авах ялыг хэрэглэхгүй байх шийдвэрийг гаргаж энэ зарчмыг чанд баримтлан ажиллахаар болсон билээ.<sup>4</sup>

## 28.2 Ялыг хөнгөрүүлж буй заалтаас бусад заалтыг буцаан хэрэглэхгүй байх

Өөрөөр хэлбэл цаазаар авах ялыг оногдуулсан нь тухайн хэрэгт холбогдох үед оногдуулж болох байсан ялаас илүү хүндэрсэн байж болохгүй гэсэн үг юм. Гэмт этгээдийн эрх зүйн байдлыг дордуулж болохгүй.

НҮБ-ын Тусгай Илтгэгч цаазаар авах ялыг өргөжүүлэхгүй байх, нэгэнт уг ялыг халсан тохиолдолд дахин хэрэглэхгүй байхыг уриалсан төдийгүй энэ зарчим нь ИУТЭОУП-ын 6.2-т мөн тусгалаа олсон хэмээн тэмдэглэсэн байна.<sup>5</sup>

Түүний дээр гэмт хэрэгт үйлдэх үед оногдуулж болох байсан ялаас илүү хүнд хэлбэр нь цаазаар авах ял байж болохгүй.\*\*

Түүнчлэн хууль тогтоомжийн өөрчлөлтөөр тухайн гэмт хэрэгт хөнгөн ял хэрэглэхээр заасан бол гэмт хэрэгт холбогдсон этгээдэд ашигтайгаар хянан шийдвэрлэнэ.<sup>^^</sup>

Америкийн конвенцоор тогтоосон цаазаар авах ялыг хатуу хориглосон байдаг. Мөн тухайн хэрэгт цаазаар авах ял хэрэглэхийг хүчингүй болгосныг дахин сэргээж хэрэглэхийг хориглосон байдаг.\*<sup>6</sup>

### Холбогдох хэм хэмжээ

#### ИУТЭОУП-ын 6.6 дугаар зүйл

Энэ зүйлийн аль ч заалт нь энэхүү Пактад оролцогч аль нэгэн улс цаазаар авах ялаа цуцлахыг хойшлуулах буюу ерөөсөө цуцлах үндэслэл болохгүй.

#### Америкийн конвенцийн 4.2, 4.3 дугаар зүйл

4.2. цаазаар авах ялыг халаагүй улс орнуудад цаазаар авах ялыг зөвхөн хамгийн ноцтой гэмт хэргүүдэд тухайн гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө батлагдсан уг ялыг тодорхойлсон хуулийн дагуу шүүхийн эцсийн шийдвэрээр оногдуулдаг.

\* ИУТЭОУП-ын 6(2) дугаар зүйл, Цаазаар Авах Ялын Хамгаалалтын 2 дугаар хэсэг, Америкийн Конвенцийн 4(2) дугаар зүйл болон Европын Конвенцийн 2(1) дугаар зүйлүүдийг үзнэ үү.

\*\* ХЭТТ-ын 11 дүгээр зүйл, ИУТЭОУП-ын 15 дугаар зүйл, Америкийн Конвенцийн 9 дүгээр зүйл, Европын Конвенцийн 7 дугаар зүйл ба Африкийн Дүрмийн 7 дугаар зүйл

^ИУТЭОУП-ын 15(1) дугаар зүйл, Америкийн Конвенцийн 9 дүгээр зүйл

^^ Цаазаар Авах Ялын Хамгаалалтын 2 дугаар хэсэг

### Ишлэл

1. Тогтоол 32/61, 1997 оны 12 дугаар сарын 8 –нд батлагдсан. Ерөнхий Ассамблейн баталсан Тогтоол Шийдвэр, (A/32/45), 1978 он, хуудас 136
2. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 6, догол мөр 6
3. Тогтоол 1997/12, Хүний Эрхийн Комисс, (Хүний Эрхийн Комисс.4/1997/150); Тогтоол 1997/38, Хүний Эрхийн Комисс, 54 дугаар чууган илтгэл (1 дүгээр хэсэг), (Хүний Эрхийн Комисс.4/1998/L6.12)
4. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн Шийдвэр, 1993 оны 5 дугаар сарын 25-ны 825 болон 1994 оны 11 дүгээр сарын 8-ны 955 тус тус
5. НҮБ-ын “хууль бус, дур зоргоороо цаазаар авах явдлын тухай” Тусгай илтгэгчийн АНУ-д хийсэн айлчлалын илтгэл, Хүний Эрхийн Комисс/1998/68/Нэмэлт.3, 1998 оны 1 дүгээр сарын 22, хуудас 3



## 28.3 Цаазаар авах ял ногдуулах хэргийн тоог цөөрүүлэх хүрээ

Цаазаар авах ялыг бүрэн устгаагүй улсад цаазаар авах ялыг зөвхөн тодорхой төрлийн ноцтой хэрэгт л оногдуулж болох юм.<sup>^</sup>

Хүний Эрхийн Хороо “цаазаар авах ялыг тодорхой цөөн тооны ноцтой хэрэг үйлдсэн үед хуулийн дагуу явагдсан шүүх хуралдааны шийдвэрээр гаргана” гэсэн нөхцөл биелсэн үед уг ял оноож болохыг дурьдсан байдаг.<sup>7</sup>

Түүнчлэн цаазаар авах ялыг гагцхүү хүний амь хохироосон буюу бусад ноцтой хүнд үр дагаварт зориуд санаатай хүргэсэн гэх мэт хязгаарлагдмал тооны хамгийн хүнд хэргийн учир оногдуулж болохоор заажээ.<sup>^^8</sup>

НҮБ-ын хууль бус, дур зоргоороо цаазаар авах явдлын тухай Тусгай илтгэгч “эдийн засгийн болон мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг, түүнтэй адил бусад хэрэгт цаазаар авах ял оноохыг зогсоох хэрэгтэй” гэдгийг дурьдсан байдаг.<sup>9</sup>

Хүний Эрхийн Хороо зарим ноцтой хэргийг оруулахгүйгээр гаж секс, албаны хөрөнгө ашиглан шамшигдуулах, дээрэм хийх эсвэл ИУТЭОУП-ын 6- зүйлд тохирохгүй хэрэг үйлдснийх нь төлөө цаазаар авах ял ногдуулахаас зайлсхийх хэрэгтэй гэсэн байр суурьтай байдаг.<sup>10</sup>

АНУ-ын муж улсуудад цаазаар авах ялыг их хэмжээгээр оногдуулж байгаа бөгөөд Хүний Эрхийн хороо Холбооны хуулийн дагуу цаазлагдсан хүмүүсийн тоо сүүлийн үед нэмэгдэх болсонд санаа зовниж байгаагаа илэрхийлсэн юм. Тус Хороо нь цаазаар авах ял ногдуулах хэргийн тоог цөөлөх, Холбооны болон мужийн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахыг уриалсан байна.<sup>11</sup>

Америкийн Конвенцид улс төрийн болон бусад нийтлэг хэрэгт цаазаар авах ял оногдуулахыг хориглосон байдаг.<sup>^^^</sup>

### Холбогдох хэм хэмжээ

#### ИУТЭОУП-ын 15.1 дүгээр зүйл

Хэрэг үйлдэх үед нь дотоодын хууль буюу олон улсын эрх зүйгээр эрүүгийн гэмт хэрэгт эс тооцож байсан ямар нэг үйлдэл буюу эс үйлдлээр хэнийг ч гэмт хэрэгтэн гэж буруутгаж болохгүй түүнчлэн эрүүгийн гэмт хэрэг үйлдэх үед хэрэглэж байснаас илүү хүнд ял шийтгэл оногдуулж болохгүй. Гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш тийм хэргийн ялыг хуулиар хөнгөлсөн бол уг хэрэгтэнд тэрхүү хөнгөлсөн ялыг хэрэглэнэ.

\* Америкийн Конвенцийн 4 дүгээр зүйл

^ ИУТЭОУП-ын 6(2) дугаар зүйл, Америкийн Конвенцийн 4(2) дүгээр зүйл, Цаазаар Авах Ялын Хамгаалалтын 1 дүгээр хэсэг

^^ Цаазаар Авах Ялын Хамгаалалтын 1 дүгээр хэсэг

^^^ Америкийн Конвенцийн 4(4) дүгээр зүйл

### Ишлэл

6. Хүний Эрхийн Америк Дундын Шүүхийн Зөвлөх Санал, ОС-3/83, 1983 оны 9 дүгээр сарын 8, Америкийн Улсуудын Байгууллага/Ser L./V/ III.10 баримт бичиг 13, 1984 он
7. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 6, догол мөр 7
8. НҮБ-ын “хууль бус, дур зоргоороо цаазаар авах явдлын тухай” Тусгай илтгэгчийн АНУ-д хийсэн айлчлалын илтгэл, Хүний Эрхийн Комисс/1998/68/Нэмэлт.3, 1998 оны 1 дүгээр сарын 22, хуудас 7
9. НҮБ-ын “хууль бус, дур зоргоороо цаазаар авах явдлын тухай” Тусгай илтгэгчийн илтгэл, ИУТЭОУП /C/79/ Нэмэлт.85, 1997 оны 11 дүгээр сарын 19, хуудас 13
10. Судан: Хүний Эрхийн Төлөв Байдлын Судалгааг Дүгнэх нь, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП /C/79/Нэмэлт 85, 1997 оны 11 дүгээр сарын 19
11. АНУ: Хүний Эрхийн Төлөв Байдлын Судалгааг Дүгнэх нь, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП /C/79/Нэмэлт 50, 1995 оны 4 дүгээр сарын 7, догол мөр 16, 31

\*\*ИУТЭОУП-ын 6(5) дугаар зүйл, Хүүхдийн Эрхийн Конвенцийн 37(а) дугаар зүйл, Цаазаар Авах Ялын Хамгаалалтын 3 дугаар хэсэг болон Бээжингийн Дүрмийн 17.2 дугаар дүрэм, Америкийн Конвенцийн 4(5) дугаар зүйл

\*\*\* Америкийн Конвенцийн 4(5) дугаар зүйл

^ Цаазаар Авах Ялын Хамгаалалтын 3 дугаар хэсэг

^^ ИУТЭОУП-ын 15(1) дугаар зүйл, Америкийн Конвенцийн 4(5) дугаар зүйл  
Цаазаар Авах Ялын Хамгаалалтын 3 дугаар хэсэг

### Ишлэл

12. 1949 оны Женевын Конвенцийн 1 болон 2 дугаар Нэмэлт Протоколын 6(4) дугаар зүйл. Уг зүйлээр тухайн гэмт хэрэг үйлдэгдэх үед 18 – аас доош настай байсан яллагдагчид цаазаар авах ял ногдууллахыг хориглодог.

13. Тогтоол №3/87 (АНУ) Хэрэг 9647, Америк Дундын Комиссын жил бүрийн илтгэл, 1986-1987, Америкийн Улсуудын Байгууллага Ser.L/V/II.71 баримт бичиг 9. Комисс АНУ 2 насанд хүрээгүй гэмт хэрэгтнийг цаазаар авах ял үедээ хэдийгээр соёрхон батлаагүй ч гарын үсэг зурсан Конвенцоо зөрчсөн хэмээн үзсэн юм.

14. АНУ: Хүний Эрхийн Төлөв Байдлын Судалгааг Дүгнэх нь, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП /С/79/Нэмэлт 50, 1995 оны 4 дүгээр сарын 7, догол мөр 23

15. ЭЗНЗ Тогтоол, 1989/64, 1989 оны 5 дугаар сарын 24-нд батлагдсан, НҮБ-ын баримт бичиг: E/1989/INF/7

16. НҮБ-ын “хууль бус, дур зоргоороо цаазаар авах явдлын тухай” Тусгай илтгэгчийн илтгэл, НҮБ-ын баримт бичиг: A/51/457, догол мөр 115

17. ЭЗНЗ Тогтоол, 1989/64, 1989 оны 5 дугаар сарын 24-нд батлагдсан, НҮБ-ын баримт бичиг: E/1989/INF/7

18. АНУ: Хүний Эрхийн Төлөв Байдлын Судалгааг Дүгнэх нь, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП /С/79/Нэмэлт 50, 1995 оны 4 дүгээр сарын 7, догол мөр 16

19. НҮБ-ын “хууль бус, дур зоргоороо цаазаар авах явдлын тухай” Тусгай илтгэгчийн илтгэл, НҮБ-ын баримт бичиг: A/51/457, догол мөр 115

## 28.4 Цаазаар авах ял оногдуулж болохгүй хүмүүс

Олон улсын хэм хэмжээнд 18 насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдсэн хүмүүс, 70-аас дээш настай хүмүүс, жирэмсэн болон нярай эмэгтэйчүүд болон сэтгэцийн өвчтэй хүмүүст цаазаар авах ялыг ногдуулж болохгүй гэсэн жишиг үйлчилдэг.

### 28.4.1 Насанд хүрээгүй хүмүүс

18 насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдсэн хүмүүст цаазаар авах ял ногдуулж болохгүй бөгөөд шүүх хуралд буюу ял ногдуулахдаа тэдний насны байдлыг харгалзахгүй.\*<sup>12</sup> / шүүх хурал явагдаж байгаа тэр үед гэмт хэрэгтэн хэдэн настай байх нь хамаагүй. Гагцхүү насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдсэн гэдгийг нь анхаарах /

Америк дундын комисс хүүхдэд цаазаар авах ял оноодог хуулийн хэм хэмжээний эсрэг байр суурьтай байдаг бөгөөд ИУТЭОУП болон Америкийн Конвенцид нэгдэн орох, үндэсний хууль тогтоомж, гэрээ хэлэлцээрүүдээ түүнд нийцүүлэхийн төлөө идэвхитэй үйл ажиллагаа явуулахыг уриалж байна.<sup>13</sup>

Түүнчлэн НҮБ-ын Хүний Эрхийн Хороо АНУ-ын муж улсуудад 18 насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдсэн хүмүүст цаазаар авах ял оногдуулж байгаад сэтгэл эмзэглэж байгаагаа илэрхийлсэн билээ. Тус хороо 18 насанд хүрэхээсээ өмнө гэмт хэрэг үйлдсэн хүмүүст цаазаар авах ял оногдуулахгүй байхыг уриалж байна.<sup>14</sup>

### 28.4.2 Өндөр настан

Америкийн Конвенцийн 4.5-д 70-аас дээш настай хүмүүст цаазаар авах ял оногдуулахыг хориглосон заалт байдаг.\*\*\*

Түүнчлэн НҮБ-ын Эдийн Засаг, Нийгмийн Зөвлөл улс орнуудад цаазлах ял ногдуулах насны дээд хэмжээ тогтоохын төлөө идэвхитэй ажиллаж байна.<sup>15</sup>

### 28.4.3 Сэтгэцийн өвчтэй хүмүүс

Сэтгэцийн өвчтэй хүмүүст цаазаар авах ял оногдуулж болохгүй.^ Энэ нь шүүх ажилгааны явцад сэтгэн бодох чадвараа алдсан хүмүүст мөн хамаатай.<sup>16</sup>

НҮБ-ын Эдийн Засаг, Нийгмийн Зөвлөл улс орнуудад сэтгэн бодох чадвараа алдсан хүмүүст цаазаар авах ял оногуулахгүй байхыг уриалж байна.<sup>17</sup>

Түүнчлэн сэтгэн бодох чадвараа алдсан хүмүүсийн хэргийг шүүх явцад тавих анхаарал дутагдаж байгаад Хүний Эрхийн Хороо эмзэглэж байгаагаа илэрхийлсэн байна.<sup>18</sup>

### 28.4.4 Жирэмсэн болон нярай эмэгтэйчүүд

Жирэмсэн болон нярай эмэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй.^/^^<sup>19</sup>

## 28.5 Шударгаар шүүлгэх эрх

Цаазаар авах ялыг гүйцэтгэсэн тохиолдолд тэр нь эцсийнх байдгаас шүүх хурлыг олон улсын болон бүс нутгийн хэм хэмжээг баримтлан хуулийг дагуу хийж голч шийдвэр гаргах ёстой. Шүүх ажиллагааны өмнө, шүүх ажиллагааны явцад, ер нь шүүх ажилгааны бүх шатанд олон улсын жишиг хэмжээнд нийцсэн, шударга байх зэрэг баталгаагаар хангах нь зүйтэй. Эмнести Интернэшнл цаазаар авах ял оноох үйлдэл бүр хүний амьд явах эрхийг нь зөрчиж байна гэж үздэг. Хэдийгээр энэ үзэл нь дэлхий нийтээр түгэн тараагүй ч олон улсын хүний эрхийн байгууллага, судлаачид шударга бус шүүх ажиллагаа хүний амьд явах эрхийг бүдүүлгээр зөрчдөг гэдэгтэй санал нэгтэй байдаг юм.

Хэний ч амьд явах эрхийг дур мэдэн хасаж болохгүй. \*\*\*

Амьд явах эрх бол хүн бүрийн салшгүй эрх мөн - энэ эрхийг хуулиар хамгаална. Хэний ч амийг дур мэдэн бүрэлгэж болохгүй хэмээн ИУТЭОУП-ын 6.1-т заан хориглосон нь төрөөс цааз оноож буй аливаа нөхцөлийг хуулиар хязгаарлах, түүнд хатуу хяналт тавихыг шаарддаг.<sup>20</sup>

Шүүхийн шийдвэргүйгээр, мөн давж заалдах боломж олгохгүйгээр цаазаар авах нь ИУТЭОУП-д нийцэхгүй, хүний амьд явах эрхийг зөрчсөн үйлдэл болно гэж Хүний эрхийн хороо үздэг.<sup>21</sup>

Хүний Эрхийн Хороо цаазаар авах ял оноодог хэргийг шийдвэрлэх шүүх ажиллагаа нь ИУТЭОУП-д заасан доорх баталгаагаар хангасан байх ёстой гээд:

- Шударга, хараат бус шүүхээр шүүлгэх
- Гэм буруу нь шүүхээр тогтоогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох
- Бусдын дарамт шахалтанд өртөхгүй байх
- Дээд шатны шүүхээр дахин хянуулах
- Цаазаар авах ял авсан хүн бүр уучлал гуйх буюу ялыг хөнгөрүүлж өгөх хүсэлт гаргах эрхийг эдлүүлэх ёстой гэсэн үндэслэлийг гаргаж байна.<sup>22</sup>

Цаазаар авах ялыг гэмт хэрэгт яллагдаж байгаа этгээдийн гэм буруу нь хэргийн байдлыг өөрөөр тайлбарлах боломжгүй итгэл үнэмшилтэй, тодорхой ойлгомжтой нотлох баримтаар тогтоогдсон тохиолдолд л оногдуулж болно.<sup>^^</sup> Цаазаар авах ял оноохдоо бусдын нөлөөнд автагдаагүй шүүх хуралдааны хүчин төгөлдөр шударга шийдвэрээр, ИУТЭОУП-ын 14-р зүйлийг чанд баримтлах ёстой. Хэрэгт сэжиглэгдсэн буюу цагдан хоригдсон үеэс эхлэн шүүх ажиллагааны бүх шатанд хууль зүйн туслалцаа авах эрхийг олгоно. Яллагдагч нь шүүх ажиллагааны бүх шатанд хууль зүйн туслалцаа авах эрхтэй.<sup>^^^</sup>

### Холбогдох хэм хэмжээ

#### ИУТЭОУП-ын 6.2 дугаар зүйл

Цаазаар авах ялыг цуцлаагүй улсад уг ялыг зөвхөн онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир энэхүү Пакт болон Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенцийн заалтад нийцсэн бөгөөд тухайн гэмт хэрэг үйлдэх үед хүчинтэй байсан хуулийн дагуу этгээдэд оногдуулж болно. Энэхүү ялыг гагцхүү эрх бүхий шүүхийн эцсийн шийдвэрийн дагуу гүйцэтгэж болно.

\*\*\* ИУТЭОУП-ын 6(1) дугаар зүйл, Африкийн Дүрмийн 4 дүгээр зүйл Америкийн Конвенцийн 4(1) дүгээр зүйл

^ ИУТЭОУП-ын 6(2) дугаар зүйл

^^ Цаазаар Авах Ялын Хамгаалалтын 4 дүгээр хэсэг

^^^ Цаазаар Авах Ялын Хамгаалалтын 5 дугаар хэсэг

### Ишлэл

20. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 6, догол мөр 3  
21. НУБ-ын баримт бичиг, ИУТЭОУП/С/47/Д/282, догол мөр 10.6; Келли ба Ямайка (253/1987) 1991 оны 4 дүгээр сарын 8, Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл (А/46/40) 1991 он  
22. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 6, догол мөр 7

НҮБ-ын хууль бус, дур зоргоороо цаазаар авах явдлын тухай Тусгай илтгэлд “цаазаар авах ял оноохдоо бусдын нөлөөнд автагдаагүй эрх бүхий шүүх хуралдааны хүчин төгөлдөр шударга шийдвэрээр, олон улсын болон бүс нутгийн хуулийн хэм хэмжээг чанд баримтлан оноож болно. Гэм буруу нь хуулийн дагуу тогтоогдох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй, өөрийгөө гэм буруугүй гэдгийг нотлохын тулд гэрч, баримт цуглуулах хүсэлт гаргах эрхтэй. Түүнчлэн дээд шатны шүүхээр хэргээ дахин хянуулах болон ял авсан хүн бүр ял хэлтэрүүлэх буюу ялыг хөнгөрүүлж өгөх хүсэлт гаргах эрхийг эдлэнэ.<sup>23</sup>

Доорх дэд хэсэгт / **28.5.1-ээс 28.5.4-д** / эрүүгийн хэрэгт яллагдаж буй хүмүүст зориулан шударга шүүх хурал явуулах баталгааг гаргасан./ дээрх хэсгүүдэд давтагдаагүй болно / Эдгээр нь зөвхөн цаазаар авах ял оногдуулах шүүх хуралдаанд хүний эрхийг хамгаалахад нэмэлт хүчин зүйл болдог.

### 28.5.1 Үр нөлөөтэй зөвлөгөө авах эрх

Эрүүгийн хэрэгт цагдан хоригдсон буюу саатуулагдсан аливаа хүн цагдан хоригдсоноос эхлэн шүүх хуралдааны бүх шатанд хуулийн үр нөлөөтэй зөвлөгөө авах эрхтэй. \*/Шүүхийн өмнөх шатанд хуулийн туслалцаа авах эрх 3-р хэсгээс, өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрх 20.3-р хэсгээс үзнэ үү. /

Түүнчлэн цаазаар авах ялаар яллагдаж байгаа хүн шүүх ажиллагааны бүх шатанд өөрөө өөрийгөө өмгөөлөх буюу сонгож авсан өмгөөлөгчөөрөө өмгөөлүүлэх эрхтэй.

Цаазаар авах ял оногдуулах шүүх ажиллагааны бүх шатанд хуулийн үр нөлөөтэй зөвлөгөө авах эрхээр хангагдсан байвал зохино.<sup>24</sup> НҮБ-ын Эдийн Засгийн болон Нийгмийн Зөвлөл /

Цаазаар авах ял шийтгэгдсэн хоригдолд хуулийн үр нөлөөтэй зөвлөгөө өгөхийг Хүний Эрхийн Хороо өөрийн үндсэн зарчмаа болгодог. Үүнийгээ шүүх ажилгааны бүх шатанд хэрэгжүүлдэг. Шүүгдэгчид үр нөлөөтэй хуулийн зөвлөгөө өгөх бололцоогоор хангахгүйгээр цаазаар авах ял оноож болохгүй.<sup>25</sup>

Цаазаар авах ял ногдуулах шүүх хуралдааны явцад шүүгдэгч нь өөрийг нь өмгөөлж буй өмгөөлөгч тус хэрэгт үр нөлөөтэй өмгөөлж чадахгүй байгаа буюу өөр ямар нэг үндэслэл бүхий шалтгаанаар өмгөөлөгчөөсөө татгалзах буюу өөр өмгөөлөгч авах эрхтэй.

Гэмт хэрэгт ялагдсан хүмүүсийн адил цаазаар авах гэмт хэрэгт ялагдсан этгээд анхан болон давж заалдах шатны шүүхэд өмгөөлөгчөө сонгон төлөөлүүлэх эрхтэй байдаг. Өмгөөлөгч нь яллагдагчийг үнэ төлбөргүйгээ өмгөөлөхөөр томилогдсон бол яллагдагчид өмгөөлөгчийг солих, сонгох эрх байдаггүй. Гэсэн хэдий ч Хүний эрхийн хорооноос цаазаар авах ялтай гэмт хэрэгт тухайн улс нь шүүх хуралдаанд яллагдагчийн сонгосон өмгөөлөгчийг заавал оруулах ёстой. Тухайн улс нь цаазаар авах гэмт хэрэгт өмгөөлөгч оролцуулах тодорхой үүрэг хүлээдэг. Өмгөөлөгч ямар нэгэн үр нөлөө үзүүлэхгүй, өмгөөлөгчийн үр чадвараа хангалттай гаргахгүй байгаа нь илэрхий байвал өмгөөлөгчийг солих үүрэг хүлээнэ. Шүүгдэгч нь төрөөс томилогдсон өмгөөлөгчийг давж заалдах шүүх хуралд дэмжлэг үзүүлээгүй гэж үзвэл өмгөөлөгчөө солих эрх түүнд нээлттэй гэж Хүний эрхийн хороо үзсэн байна.

\* ИУТЭОУП-ын 14(3)(г) дүгээр зүйл, Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын 1 дүгээр зарчим, Африкийн Дүрмийн 7(1)(в) дугаар дүрэм, Америкийн Конвенцийн 8(2)(г) болон (д) дугаар зүйл, Европын Конвенцийн 6(3)(в) дугаар зүйлүүдийг үзнэ үү.

#### Ишлэл

23. НҮБ-ын “хууль бус, дур зоргоороо цаазаар авах явдлын тухай” Тусгай илтгэгчийн илтгэл, НҮБ-ын баримт бичиг: A/51/457, догол мөр 111  
24. ЭЗНЗ Тогтоол 1989/64, 1989 оны 5 дугаар сарын 24, НҮБ-ын баримт бичиг: E/1989/INF/7, догол мөр 128, мөн Цаазаар авах ялын Хамгаалалтыг үзнэ үү  
25. Келли ба Ямайка (253/1987) 1991 оны 4 дүгээр сарын 8, Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл (A/46/40) 1991 он  
26. НҮБ-ын “хууль бус, дур зоргоороо цаазаар авах явдлын тухай” Тусгай илтгэгчийн илтгэл, НҮБ-ын баримт бичиг: Хүний Эрхийн Комисс/1996/4, догол мөр 547

## 28.5.2 Өмгөөлүүлэхэд бэлтгэхэд боломжит хугацаа, нөхцлөөр хангагдах эрх

Эрүүгийн хэрэгт яллагдсан бүх хүн өөрийгөө өмгөөлөхөд бэлтгэхэд хүрэлцэхүйц хугацаа, бололцоогоор хангагдсан байх эрхтэй\*. /**Өөрийгөө хамгаалахад бэлтгэхэд хүрэлцэхүйц хугацаа, бололцоогоор хангагдсан байх, 8 дахь хэсгээс үзнэ үү** /

Дээрх эрх нь цаазаар авах ял оногдуулах хэргийн хувьд чухал ач холбогдолтой.

Цаазаар авах ялаар шийтгэгдсэн этгээд, түүний өмгөөлөгч нь шүүх хурлаас өмнө бэлтгэхэд боломжит хугацаа, бололцоогоор хангагдсан байх ёстой гэж Хүний Эрхийн Хороо анхааруулж байна.<sup>32</sup>

## 28.5.3 Хэргээ цаг алдалгүй шийдвэрлүүлэх эрх

Эрүүгийн хэрэгт яллагдсан этгээд мөрдөн байцаалт болон шүүхээр шийдвэрлэх хугацааг нь оруулаад хэргээ цаг алдалгүй шийдвэрлүүлэх эрхтэй.\*\* /Хэргээ цаг алдалгүй шийдвэрлүүлэх эрх, 19-р зүйлээс үзнэ үү /

Хүний Эрхийн Хороо цаазаар авах хэрэг төдийгүй бусад бүх хэргийг шүүх цаг алдалгүй шийдвэрлэвэл зохино гэж үзсэн.

Хүний эрхийн хороо цаазаар авах ял оноосон хэрэгт дор дурдсан хугацааг хэтэрхий урт гэж үзсэн:

1. баривчилснаас эхлээд шүүхэд шилжүүлэх хүртэл 7 хоног саатуулах;
2. шүүхээс өмнөх шатанд 16 сар баривчлах;
3. шүүх хурал болон давж заалдах шатны шүүх хурлын хооронд 31 сар.<sup>33</sup>

## 28.5.4 Давж заалдах эрх

Цаазаар авах ял шийтгэгдсэн хүн бүр дээд шатны шүүхэд давж заалдах гомдол гаргах эрхийг эдэлнэ.\* /**Давж заалдах эрх, 26-р хэсгээс үзнэ үү**/

Цаазаар авах ял шийтгэгдсэн хүн бүр дээд шатны шүүхэд давж заалдах гомдол гаргах эрхийг эдлэх бөгөөд энэ эрхийг нь заавал хэрэгжүүлэх арга хэмжээ авах шаардлагатай юм\*\*

НҮБ-ын хууль бус, дур зоргоороо цаазаар авах явдлын тухай Тусгай Илтгэгч “Шүүх ажиллагааны явцад баримт болон хууль зүйн талаар дээд шатны шүүхэд давж заалдах гомдол гаргах эрхийг баталгаажуулж өгөх ёстойг” тэмдэглэсэн байдаг.<sup>34</sup>

### Холбогдох хэм хэмжээ

#### ИУТЭОУП-ын 6.4 дүгээр зүйл

Цаазаар авах ял шийтгүүлсэн хүн бүр уучлал эрэх буюу ял хөнгөрүүлэх хүсэлт гаргах эрхтэй. Бүх тохиолдолд өршөөл, уучлал үзүүлэх буюу цаазаар авах ялыг хөнгөрүүлж болно.

#### Америкийн конвенцийн 4.6 дугаар зүйл

Цаазаар авах ял шийтгүүлсэн хүн бүр бусад бүх хэрэгт олгогддог ял хөнгөрүүлэх, уучлал, өршөөл хүсэх эрхтэй. Цаазаар авах ял нь эрх бүхий этгээдийн шийдвэр хүлээгдэж байх үед хэрэгжихгүй.

\* ИУТЭОУП-ын 14(3)(б) дүгээр зүйл, Америкийн Конвенцийн 8(2)(в) дугаар зүйл, Европын Конвенцийн 6(3)(б) дугаар зүйл, Африкийн Комиссын Тогтоолын 2(Д)(1) хэсэг

\*\* ИУТЭОУП-ын 9(3) ба 14(3) (в) дүгээр зүйл, Африкийн Дүрмийн 7(1)(г) дугаар дүрэм, Америкийн Конвенцийн 7(5) болон 8(1) дугаар зүйл, Европын Конвенцийн 6(1) дугаар зүйл

\* ИУТЭОУП-ын 14(5) дүгээр зүйл, Америкийн Конвенцийн 8(2)(ё) дугаар зүйл, Европын Конвенцийн 7 дугаар Протоколын 2 дугаар зүйл, Африкийн Комиссын Тогтоолын 3 дугаар хэсэг, Африкийн Дүрмийн 7(а) дугаар зүйл

\*\*Цаазаар авах ялын хамгаалалтын 6 дугаар хэсэг

\*\*\* ИУТЭОУП-ын 6(4) дугаар зүйл, Цаазаар авах ялын хамгаалалтын 7 дугаар хэсэг, Америкийн Конвенцийн 4(6) дугаар зүйл

### Ишлэл

27. Робинсон ба Ямайка (223/1987) 1989 оны 3 дугаар сарын 30, Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл (А/44/40) 1989 он, хуудас 245
28. Пинто болон Тринадад ба Тобаго, (232/1987), 1990 оны 7 дугаар сарын 20, Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл (А/45/40) 1990 он, боть 2, хуудас 73
29. Артикогын хэрэг, 1980 оны 5 дугаар сарын 13, цуврал 37 А 16
30. Пинто болон Тринадад ба Тобаго, (232/1987), 1990 оны 7 дугаар сарын 20, Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл (А/45/40) 1990 он; Келли ба Ямайка (253/1987) 1991 оны 4 дүгээр сарын 8, Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл (А/46/40) 1991 он
31. Буррелл ба Ямайка, (546/1993), 1996 оны 7 дугаар сарын 18, ИУТЭОУП/С/57/Д/546/1993, 1996 он
32. Келли ба Ямайка (253/1987) 1991 оны 4 дүгээр сарын 8, Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай Илтгэл (А/46/40) 1991 он
33. МакЛауранс ба Ямайка, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП/С/60/Д/702/1996, 1997 оны 9 дүгээр сарын 29
34. НҮБ-ын “хууль бус, дур зоргоороо цаазаар авах явдлын тухай” Тусгай илтгэгчийн илтгэл, НҮБ-ын баримт бичиг: Хүний Эрхийн Комисс/1997/60, догол мөр 62

### 28.6 Уучлал үзүүлэх буюу буюу ялыг хөнгөрүүлж өгөх хүсэлт гаргах эрх

Цаазаар авах ял шийтгүүлсэн хүн бүр уучлал хүсэх буюу ялыг хөнгөрүүлж өгөх хүсэлт гаргах эрхтэй. \*\*\*

### 28.7 Цаазаар авах ялыг гүйцэтгэж болохгүй үе

Цаазаар авах ялыг давж заалдах эрхийн хугацаа дуусаагүй байхад түүнчлэн олон улсын байгууллагууд болон хандаж болох бүх газруудад ял хэлтэрүүлэх буюу ялыг хөнгөрүүлж өгөх хүсэлт гаргаад хариу авах хугацаа дуусаагүй байхад гүйцэтгэж болохгүй.

Цаазаар авах ялыг зөвхөн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр л гүйцэтгэвэл зохино.\*

Цаазаар авах ялыг давж заалдах эсэх нь тодорхой бус байхад болон ялыг хөнгөрүүлэх, уучлалын хүсэлт гаргаад хариуг нь аваагүй байхад гүйцэтгэж болохгүй.\*\*Эмнести Интернэшнл дээр дурьдсан хүсэлтийг зөвхөн улс орныхоо шүүхэд төдийгүй Хүний эрхийн хороо, Хүний эрхийн Америк хоорондын комисс, Хүний эрхийн Америк хоорондын шүүх, Хүний эрхийн Европын шүүх, Хүний эрхийн Европын комисс зэрэг олон улсын байгууллагууд гаргах нь зүйтэй гэж үздэг.

НҮБ-ын Эдийн Засгийн болон Нийгмийн Зөвлөл НҮБ-ын гишүүн улсуудаас хэрвээ цаазаар авах бол цаазаар авах ялын шийдвэртэй холбоотойгоор давж заалдсан болоод ял хэлтэрүүлэх хүсэлт гаргасан албан ёсны бүрэн мэдээллийг хүлээн авсны үндсэн дээр гүйцэтгэхийг уриалсан байна.<sup>35</sup>

НҮБ-ын хууль бус, дур зоргоороо цаазаар авах явдлын тухай Тусгай илтгэгч “цаазаар авах шүүх ажиллагааны явцад гаргасан зарим хүсэлтийг албан ёсны мэдээлэлдээ тусгаагүй, цаазаар авах шүүх ажиллагааны явцад гаргасан уучлал гуйсан, ялыг хөнгөрүүлж өгөх хүсэлтийг одоог хүртэл шийдээгүй байсан нь илэрсэн” гэж дурьдсан байна.<sup>36</sup>

### 28.8 Цаазаар авах ял ногдуулах ба гүйцэтгэх хоорондын хугацаа

Улсууд ял оногдуулахдаа шүүх хуралдаанд бэлтгэх болон ял авсан тохиолдолд ял хэлтэрүүлэх хүсэлт гаргаад түүний хариуг нь сонсох хүрэлцэхүйц хугацаа өгөх хэрэгтэй.<sup>37</sup>

НҮБ-ын хууль бус, дур зоргоороо цаазаар авах явдлын тухай Тусгай Илтгэгч “цаазаар авах ял тулгаж шүүх ажиллагааг эхлэхээс зургаан сараас багагүй хугацааны өмнө түүнд мэдэгдэх нь зүйтэй. Энэ нь өөрийгөө хамгаалахад бэлтгэхэд хүрэлцэхүйц хугацаа гэж ойлгоно. Үүний зэрэгцээ ял авсан тохиолдолд ял хөнгөрүүлэх буюу уучлал хүсэх хүрэлцэхүйц хугацаа өгөх ёстой.”<sup>38</sup>

### 28.9 Цаазаар авах ял бүхий хүмүүсийн хоригдох нөхцөл

Цаазаар авах ялтай хүмүүсийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцах ба шийтгэхийг хориглох ёстой. /эрүү шүүлтээс хамгаалагдах эрх, 10-р хэсгээс уншина уу/

НҮБ-ын Эдийн Засгийн болон Нийгмийн Зөвлөл цаазаар авах ялтай хоригдож хүмүүстэй харицахдаа “хоригдож буй болон цаазаар авах ялтай хоригдож хүмүүстэй харьцах наад захын жишиг дүрэм /НҮБ-ын/-ийг баримтлах хэрэгтэй гэдгийг анхааруулж байна.”<sup>39</sup>

\* ИУТЭОУП-ын 6(2) дугаар зүйл, Цаазаар авах ялын хамгаалалтын 5 дугаар хэсэг, Америкийн Конвенцийн 4(2) дугаар зүйл

\*\* Цаазаар авах ялын хамгаалалтын 8 дугаар хэсэг, Америкийн Конвенцийн 4(6) дугаар зүйл болон ИУТЭОУП-ын 14(5) болон 6(4) дүгээр зүйлүүд

#### Ишлэл

35. ЭЗНЗ Тогтоол 1996/15, 1996 оны 7 дугаар сарын 23-нд батлагдав

36. НҮБ-ын “хууль бус, дур зоргоороо цаазаар авах явдлын тухай” Тусгай илтгэгчийн илтгэл, НҮБ-ын баримт бичиг: Хүний Эрхийн Комисс/1997/60, догол мөр 553

37. ЭЗНЗ Тогтоол 1996/15, 1996 оны 7 дугаар сарын 23-нд батлагдав

38. НҮБ-ын “хууль бус, дур зоргоороо цаазаар авах явдлын тухай” Тусгай илтгэгчийн илтгэл, НҮБ-ын баримт бичиг: Хүний Эрхийн Комисс/1997/60, догол мөр 553

39. ЭЗНЗ Тогтоол 1996/15, 1996 оны 7 дугаар сарын 23-нд батлагдав

## 29 дүгээр бүлэг

### Тусгай ба онцгой цэргийн шүүх

Шударгаар шүүлгэх эрх нь бүхий л тусгай болон цэргийн шүүхэд хэрэглэгддэг.

#### 29.1. Тусгай ба онцгой шүүх

#### 29.2. Төрөлжсөн шүүх

#### 29.3. Бүхий л төрлийн шүүхээр шударгаар шүүлгэх эрх

#### 29.4. Хуулиар тогтоосон шүүх эрх мэдэл

#### 29.5. Хараат бус бие даасан байдал

#### 29.6. Цэргийн шүүх

#### 29.6.1. Шударга, хараат бус, бие даасан шүүх

#### 29.6.2. Цэргийн албан хаагчдыг цэргийн шүүхээр шүүх

#### 29.6.3. Цэргийн шүүхээр энгийн иргэдийг шүүх

### 29.1. Тусгай ба онцгой шүүх

Дэлхийн олон оронд байх тусгай болон онцгой шүүх нь ихэнхдээ шүүхийн үйл ажиллагааны зарчмыг баримталдаггүй. Жишээлбэл онцгой болон тусгай шүүхэд дээрмийн болон галт зэвсэгтэй холбоотой хэргийг шүүх хурал, ноцтой эрүүгийн хэргийн, хувьсгалч шинж чанартай шүүхийг тусгай болон онцгой шүүхэд хамааруулдаг.

Ердийн шүүхтэй харьцуулахад тусгай болон онцгой шүүхийн процесс нь шударга шүүхийн баталгаа сул байдаг. Хүний Эрхийн Хороо: “эдгээр шүүхийг байгуулах шалтгаан нь шударга ёсны хэм хэмжээг дагаж мөрддөггүй тусгай болон онцгой үйл ажиллагаа явуулах боломж олгоход оршдог” гэжээ.<sup>1</sup>

Хүний Эрхийн Хороо нь шударга болон ердийн эсэхээс үл шалтгаалан бүхий шүүхэд ИУТЭОУП-ын 14-р зүйлийг дагаж мөрдөх ёстойг тодорхой илэрхийлсэн байдаг.<sup>2</sup>

НҮБ-ын дур мэдэн баривчлахын эсрэг ажлын хэсэг “дур мэдэн баривчлах хамгийн гол шалтагийн нэг нь хэрхэн нэрлэгдэхээс үл хамааран тусгай болон цэргийн шүүхийн оршин байгаа явдал” гэж үзсэн байна. Түүнчилэн эдгээр шүүхийн аль нь ч ИУТЭОУП-аар болон Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон түүнтэй адилтгах гэрээ, хэлэлцээрт заасан шударгаар шүүгдэх эрхийг баталгаажуулаагүйгээс гадна хэрэгжүүлэхгүйг ажлын хэсэг тогтоосон байна.”<sup>3</sup>

Хүний Эрхийн Хороо нь баривчлах, нэгжлэг хийх болон 4 өдрийн турш (2 удаа болон энгийн хугацаа) цагдаагийн хяналтад баривчлах зөвшөөрөл олгох эрх бүхий прокурорыг оролцуулдаг шүүн таслах ажиллагааг хүлээн зөвшөөрсөн Францын Терроризмийн эсрэг хуулийн тухай илэрхийлсэн байдаг. Тэрхүү хуулийн дагуу яллагдагч ердийн шүүхийн зарим эрхээ эдлэж чаддаггүй. Тухайлбал, яллагдагч нь тусгай шүүхийн шийдвэрийн эсрэг давж заалдах, цагдаагийн хяналтад хоригдох эхний 72 цагийн турш хуульчтай уулзах эрхийг эдэлдэггүй байна.<sup>4</sup>

#### Ишлэл

1. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 4
2. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 4
3. НҮБ-ын дур мэдэн баривчлахын эсрэг ажлын хэсгийн илтгэл, НҮБ-ын баримт бичиг, Хүний Эрхийн Комисс/1996/40, хуудас 26
4. Франц: Хүний Эрхийн Төлөв Байдлын Судалгааг Дүгнэх нь, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП /C/79/Нэмэлт 80, 1997 оны 8 дугаар сарын 4, догол мөр 23

Америк хоорондын Комисс гэрчээс мэдүүлэг авах нууц байцаалт болон шүүгч, прокурорын аливаа ажиллагаа, террорист халдлагатай холбоотой хэргийг шүүх тусгай шүүхийг үгүй болгох талаар санал дэвшүүлжээ.<sup>5</sup>

Тусгай болон онцгой шүүхийн ажиллагаан дахь шударга ёсны байдалд дүгнэлт хийж үзвэл дараах ойлголтуудад анхаарлаа хандуулах шаардлагатай байгаа юм. Үүнд: шүүхийг хуулийн дагуу байгуулах, ялгаварлалгүй, эрх тэгш баталгааг зөрчин шүүн таслах ажиллагаа явуулах, хэргийг шийдвэрлэхдээ шүүгч бие даасан байх, шүүгч шударга, чадвартай байх, шүүхийн процесс нь олон улсын хэм хэмжээнд заасан шударга шүүхийн баталгааны наад захын хэм хэмжээнд нийцэх зэрэг болно.

Тусгай болон онцгой шүүх нь олон улсын хэм хэмжээний хувьд дутагдалтай байгаа учир Эмнести Интернэшнл түүнийг халах буюу шинэчлэх зорилготой юм.

## 29.2. Төрөлжсөн шүүх

Ихэнх улс оронд тусгай шүүх нь насанд хүрээгүй гэмт хэрэгтэн, мөн тусгай гэмт хэрэгт холбогдогчидтой холбоотойгоор байгуулагддаг. Тухайлбал, хөдөлмөрийн, далайн эрх зүйн, гэр бүлийн маргаан гэх мэт

Төрөлжсөн шүүхүүд нь эрүүгийн хэрэгт холбогдогчдыг арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон, бусад үзэл, үндэсний болон нийгмийн бүлэг, хөрөнгө, төрөлхийн болон нийгмийн гарал байдалд үндэслэн гэмт хэрэгтэний бүлэгт хамааруулж үл болно. Эдгээр шүүхүүд нь шүүхийн өмнө тэгш эрхэй байх зарчим болон үл ялгаварлан гадуурхах зарчимтай зөрчилддөг.\* (хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх 11-р зүйлийг үз)

Гэхдээ тодорхой үндэслэлээр бүлэг хүмүүсийг шүүх тусгай шүүх байгуулахыг зөвшөөрч болох юм. Тухайлбал, насанд хүрээгүй гэмт хэрэгтнийг шүүх нь хүүхдийн хэргийг, цэргийн шүүх нь цэргийн гэмт хэрэгт холбогдсон цэргүүдийн хэргийг шүүх зэргээр шударга шүүхийн баталгааг бүрэн хангаж болох юм.

Тусгай шүүхийн нэг төрөл болох цэргийн шүүх нь ялангуяа, хүний эрхийг зөрчсөн цэргийн албан хаагч эсвэл энгийн иргэдийн хэргийг шүүх тохиолдолд шударга шүүхийн баталгаа тодорхой хэмжээнд нэмэгддэг. (өмнөхийг үз)

## 29.3. Бүхий л төрлийн шүүхээр шударгаар шүүлгэх эрх

Ихэнх олон улсын хэм хэмжээнд тусгай шүүхийн *per se* байгуулалтыг хориглодоггүй. Гэхдээ эдгээр шүүхүүд нь хараат бус, бие даасан, эрх бүхий болон шударга ажиллагаа явуулах шударга ёсны баталгааг хүлээн зөвшөөрөх шаардлагатай байдаг.

Хүний Эрхийн Хороо тусгай болон цэргийн шүүхэд энгийн иргэдийн хэргийг шүүх явдлыг хориглоогүй ИУТЭОУП-д тодруулга хийсэн ба, “тэдгээр шүүхээр иргэдийн хэргийг шүүлгэх нь маш онцгой бөгөөд ИУТЭОУП-ын 14-р зүйлд заасан баталгааны дагуу явагдах ёстой гэж үзжээ.”<sup>6</sup>

Шүүн таслах ажиллагааны бие даасан, хараат бус байх үндсэн зарчим нь энгийн шүүхийн шүүн таслах ажиллагааны байр суурийг эзлэх болон хууль

\* ХЭТТ-ын 2, 7 ба 10 дугаар зүйл, ИУТЭОУП-ын 2 ба 14 дүгээр зүйл, Африкийн Дүрмийн 2 ба 3 дугаар зүйл, Америкийн Конвенцийн 1 ба 8 дугаар зүйл, Европын Конвенцийн 14 дүгээр зүйл,

### Ишлэл

5. Америк Дундын Комисс, Колумбын Хүний эрхийн Төлөв Байдлын тухай 2 дах Илтгэл, Америкийн Улсуудын Байгууллага /Ser.L/V/II.84, баримт бичиг 39, 1993 он, хуудас 109

6. Хүний Эрхийн Хороо Ерөнхий Тайлбар 13, догол мөр 4



зүйн процессыг зохих ёсоор хангахгүй байхыг хориглоно. Тэрхүү баталгаа нь хүн бүр энгийн шүүхээр шүүлгэх эрх, хуулийн дагуух ажиллагаанд үндэслэгдэх эрхийг агуулж байгаа юм. \*

Хуульд үндэслэгдэн хараат бус, бие даасан шүүх эрх бүхий Тусгай гэмт хэргийн шүүхээр хоёр ялтанг ялласан хэрэгтэй холбогдуулан Европын Конвенциор аливаа дотоодын тусгай шүүхийн бие даасан, хараат бус байхыг баталгаажуулаагүй байна гэж Европын шүүх үзсэн.<sup>7</sup>

## 29.4. Шүүх эрх мэдэл

Бүхий л шүүхийн шүүн таслах ажиллагаанд тавигдах шаардлага нь хуульд үндэслэгдсэн байх (ИУТЭОУП-ын 14.1, АК-ын 8, Америкийн тунхаглалын 24, Европын конвенцийн 6.1-р зүйлүүд) ба ад hoc шүүх болон тусгай шүүх, цэргийн шүүхийн тэгш байдлыг хангах ёстой.

Хүний Эрхийн Хороо тусгай шүүхийн шүүн таслах ажиллагаа нь хуулиар хатуу тогтоогдсон байх ёстой хэмээн үзсэн байна.<sup>9</sup>

Хүний Эрхийн Хороо Иракт тусгай шүүхээр шүүлгэх гэмт хэргийн жагсаалтыг өргөжүүлсэнд санаа зовниж байгаагаа илэрхийлсний дагуу Дотоод хэргийн сайд болон Ерөнхийлөгчийн зөвлөл тэдгээр хэргийг бусад шүүх рүү шилжүүлэх асуудлыг авч хэлэлцсэн байна.<sup>10</sup>

Европийн хороо шүүхийн эсхүл тусгай шүүхийн бүтэц зохион байгуулалт, шүүхийн өмнөх шатны статусыг тодорхой тогтоох ёстой гэж мэдэгдсэн.<sup>11</sup>

## 29.5. Хараат бус, бие даасан шүүх

Ердийн болоод тусгай, онцгой шүүхүүд нь үйл ажиллагааны хувьд бие даасан байх шаардлагатай ба тэдний шийдвэр нь хараат бус байх ёстой. **Хуулинд үндэслэгдсэн хараат бус, бие даасан шүүхийн эрх, 12-р зүйл**

Африкийн Комисс Нигерийн тусгай шүүх Африкийн Хартийн 7.1-г зөрчин засгийн газрын гүйцэтгэх салбарт хамаарах, хуулийн мэдлэггүй хүмүүсээр шүүхээ бүрдүүлэн дээрэм, галт зэвсгийн хэргийг шийдүүлдэг байсныг тогтоожээ.<sup>12</sup>

Дээрхийн адил зөрчлийг Африкийн комисс мөн тогтоосон бөгөөд олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үеэр үүсгэн байгуулагдсан тусгай шүүхийн бүрэлдэхүүнд 1 шүүгч, 4 зэвсэгт хүчний алба хаагч орсон нь Африкийн Хартыг зөрчсөн үйлдэл болсон юм. Африкийн Комисс “энэ шүүх нь гүйцэтгэх засаглалын салбарын хүмүүсээр шүүх бүрэлдэхүүнээ бүрдүүлсэн, шүүхийн шийдвэр гүйцэтгэх салбарынхан дангаар батлан гаргадаг болохыг” тэмдэглэсэн байна.<sup>13</sup>

Америк хоорондын комисс Колумба, Перугийн терроризмтой холбоотой хэргийг тусгай шүүхээр хэрхэн шийдвэрлэснийг хянаж үзээд тус хэргийн гэрчүүд нууцаар баримт өгсөн, шүүгч болон прокурор нарыг адилтган үзсэн зэрэг нь Америкийн конвенцид заасан шүүх хараат бус байх, шударга байх зарчмуудыг зөрчсөн үйлдэл болохыг тогтоогоод байна.

\* Шүүх байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчмуудын 5 дугаар зарчим

### Ишлэл

7. Х болон У ба Ирландын хэрэг, (8299/78), 1980 оны 10 дугаар сарын 10, 22DR51

8. Р.Б.Лиллич “Иргэний Эрх” Т.Мерон, Олон улсын эрх зүй дэх Хүний Эрх: Хуулийн болон Бодлогын Асуудлууд, 1984 он  
9. Ирак: Хүний Эрхийн Төлөв Байдлын Судалгааг Дүгнэх нь, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП /С/79/Нэмэлт 84, 1997 оны 11 дүгээр сарын 19, догол мөр 12

10. Ирак: Хүний Эрхийн Төлөв Байдлын Судалгааг Дүгнэх нь, НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП /С/79/Нэмэлт 84, 1997 оны 11 дүгээр сарын 19, догол мөр 12

11. Кроциани ба Итали (8603/79, 8722/79, 8723/79, 8729/79), 1980 оны 12 дугаар сарын 18

12. Үндсэн Хуулийн Эрхийн Төсөл, (Вахаб Акаму, Г. Адега болон бусад хүмүүсийн нэрийн өмнөөс) Нигерийн Хэрэг, (60/91), Африкийн Комиссын жил бүрийн 8 дах Илтгэл, 1994-1995 он түүнчлэн Үндсэн Хуулийн Эрхийн Төсөл, (Замани, Лаквот болон бусад 6 хүний нэрийн өмнөөс) Нигерийн Хэрэг, (87/93), Африкийн Комиссын жил бүрийн 8 дах Илтгэл, 1994-1995 он. Хүний болон Улс Түмний Эрхийн тухай Африкийн Комисс /RPT/8th -ыг үзнэ үү.

13. Үндсэн Хуулийн Эрхийн Төсөл, (Вахаб Акаму, Г. Адега болон бусад хүмүүсийн нэрийн өмнөөс) Нигерийн Хэрэг, (60/91), Африкийн Комиссын жил бүрийн 8 дах Илтгэл, 1994-1995 он түүнчлэн Үндсэн Хуулийн Эрхийн Төсөл, (Замани, Лаквот болон бусад 6 хүний нэрийн өмнөөс) Нигерийн Хэрэг, (87/93), Африкийн Комиссын жил бүрийн 8 дах Илтгэл, 1994-1995 он. Хүний болон Улс Түмний Эрхийн тухай Африкийн Комисс /RPT/8th -ыг үзнэ үү.

14. Колумба дахь хүний эрхийн төлөв байдлын 2-р илтгэл, Америкийн улсуудын байгууллага, Ser.L/V/II.84, баримт бичиг 39, 1993 он. хуудас 239; Америк дундын комиссын жил бүрийн илтгэл 1996 он, Америкийн улсуудын байгууллага, Ser.L/V/II.84, баримт бичиг 7, 1997 он. хуудас 736-737;

## 29.6. Цэргийн шүүх

Ихэнх улс оронд цэргийн шүүх нь ихэвчлэн цэргийн бие бүрэлдэхүүнтэй холбоотой хэргийг шүүн тасалдаг. Харин зарим оронд, энгийн иргэдийн хэргийг цэргийн шүүхээр авч хэлэлцэх явдал ч байдаг. Цэргийн болоод энгийн иргэн байхаас үл хамааран цэргийн шүүх нь олон улсын стандартад нийцсэн шударга шүүхийн баталгааг хангах ёстой.

Цэргийн шүүхийн үйл ажиллагаа шударга байх, шүүгчид нь хараат бус бие даасан байх, хөндлөнгийн нөлөөнөөс ангид байх, шүүх бие даасан шийдвэр гаргах эрхтэй байгаа талаар дүн шинжилгээ хийх нь чухал юм.

### 29.6.1. Хараат бус, бие даасан байдал

Шүүх нь үйл ажиллагааны хувьд бие даасан шийдвэр нь хараат бус байх ёстой гэх шаардлага бүхий л шүүхэд тэр дундаа цэргийн болоод тусгай шүүхэд мөн хамаарна. (Хуулинд үндэслэгдсэн хараат бус, бие даасан шүүхийн эрх, 12-р зүйл)

Цэргийн шүүхийн бүрэлдэхүүн нь дийлэнх тохиолдолд цэргийн хүмүүсээс бүрддэг. Зарим оронд, цэргийн шүүхийн шүүгчид цэргийн болон энгийн хуулийн мэргэжилтэн байдаг бол зарим нь огт хуулийн мэдлэггүй хүмүүс байдаг. Асуудлын гол нь цэргийн шүүх хараат бус, шүүгчид нь мэргэжлийн боловсролтой байх ёстой бөгөөд шүүхийн үүргийг таниулж, удирдлагаасаа үл хамааран бие даан шийдвэр гаргах явдал чухал юм.

Үүний дээр, ихэнх цэргийн шүүхийн шүүгчид нь энгийн шүүхийн шүүгчидтэй харьцуулахад хуулийн мэдлэг дутуу байдаг учраас яллагдагч нарын эрхийг ихээхэн зөрчдөг болохыг Америк хоорондын Комисс тодорхойлжээ.

Америк хоорондын Комисс 1985 оноос Чилийн цэргийн шүүхэд сургалт хийж эхлэсэн бөгөөд үүний үр дүнд шүүхийн хараат, бус бие даасан байдал нь мэдэгдэхүйц сайжирсан гэдгийг дурьдах хэрэгтэй.

Мөн цэргийн шүүхийн шүүгчид нь ихэнхдээ цэргийн хүмүүс байдаг учир зарим оронд дээд удирдлагаасаа хамааралтай, хараат байдаг гэдгийг Америк хоорондын Комисс батлажээ. Америк хоорондын Комисс Перугийн цэргийн шүүх нь гүйцэтгэх байгууллагын удирдлага дор байсан бөгөөд батлан хамгаалах яамны шууд хяналтад ажилладаг нь шүүхийн хараат бус, бие даасан, бүрэн эрхтэй байх зарчмыг зөрчсөн үйлдэл гэдгийг тогтоожээ.

Энгийн иргэдийн хэргийг цэргийн шүүхээр шийдвэрлэх нь Америк хоорондын Конвенцийн 8 болон 25 дугаар зүйлийг зөрчиж байгаа бөгөөд цэргийн шүүх нь зөвхөн арми цагдаагийн дотор сахилга дэглэм тогтоох үүрэгтэйгээр байгуулагдаж, энэ зорилгоор л үйл ажиллагаагаа явуулах ёстой гэж Америк хоорондын комисс тайлбарласан байдаг.

#### Холбогдох хэм хэмжээ

НҮБ-ын Сураггүй алга бологсдын талаархи тунхаглалын 16 дугаар

#### зүйл

Дээрх 1 дүгээр хэсгийн 4.1-д заагдсан гэмт хэргийг үйлдсэн гэгдэх этгээд нь тусгай шүүх, тэр дундаа цэргийн шүүхээр бус тухайн улсын ердийн шүүхээр шүүгдэнэ.

## 30 дугаар бүлэг

# Шүүхийн алдаанаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх эрх

Шүүхийн алдаанаас хохирсон хүн бүр нөхөн төлбөр авах эрхтэй.

### 30.1 Шүүхийн алдаанаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх эрх

#### 30.2 Шүүхийн алдаа

### 30.1 Шүүхийн алдаанаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх эрх

Шүүхийн алдааны улмаас хохирол амссан хүн бүр төрөөс нөхөн төлбөр авах эрхтэй байдаг.\* Энэ нь хууль бусаар баривчилсны төлөө нөхөн төлбөрөөс ялгаатай.

#### 30.2 Шүүхийн алдаа

Шүүхийн алдаа гэдэгт шүүхийн процессийг ноцтойгоор зөрчих, тухайлбал ял шийтгүүлсэн этгээдийг урьдчилан ялласан зэрэг юм.<sup>1</sup>

Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын 14.6 болон Европын Конвенцийн 7 дугаар протоколд заасны дагуу нөхөн төлбөр авахын тулд хувь хүн нь:

а. Гэмт хэрэг үйлдсэн гэж эцсийн шийтгэл ногдуулсан байх. Эцсийн шийтгэл гэдэг нь тухайн хэргийн талаар цаашид давж заалдах болон хянан шийдвэрлэх хүсэлт гаргах боломжгүй, бүхий л арга хэмжээг авч барагдуулсан.<sup>2</sup>

б. Шүүхийн шийдвэрийн үр дүнд ял эдэлсэн. Ял нь хорих эсвэл бусад төрлийн ял байх.

#### Холбогдох хэм хэмжээ

#### Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 14 (б):

6. Эрүүгийн хэрэг үйлдэж, шүүхийн эцсийн шийдвэрээр ял заагдсан бөгөөд шинэ буюу шинээр илэрсэн үйл баримт шүүн таслах ажиллагааны алдааг хөдөлбөргүй нотолсны учир оногдуулсан ялыг хожим хүчингүй болгосон буюу хэргийг цагаатгасан бол тэрхүү мэдэгдээгүй байсан үйл баримт тухайн үедээ илрээгүй нь бүхэлдээ буюу зарим талаар уг хүний буруугаас болсон гэдэг нь батлагдаагүй бол тийнхүү шийтгүүлсэн этгээд хуулийн дагуу хохирлоо нөхөн төлүүлнэ.

#### Америкийн конвенцийн 10 дугаар зүйл:

“Шүүх тогтолцооны буруутай үйл ажиллагааны улмаас шийтгүүлсэн хэн бүр нь хуульд заасны дагуу нөхөн төлбөр авах эрхтэй”.

\*\* ИУТЭОУП-ын 14(б) дүгээр зүйл, Америкийн Конвенцийн 10 дугаар зүйл, Европын Конвенцийн 7 дугаар Протоколын 3 дугаар зүйл, Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн 75 дугаар зүйлийг үзнэ үү.

#### Ишлэл

1. Европын Шүүх, Европын Хүний Эрхийн Конвенцийн 7 дугаар Протоколын Тайлбар Илтгэл, 1985 он
2. Д.Ж.Харрис, М.О'Боил, С. Варбрик, Европын Хүний Эрхийн Конвенцийн Хууль, 1995 он

## 31 дүгээр бүлэг

### Онц байдал үүссэн үед шударгаар шүүгдэх эрх

Зарим хүний эрх нь туйлын байдаг бөгөөд ямар ч тохиолдолд, түүнийг хязгаарлаж үл болно. Гэхдээ улс орнууд онц байдлын үед хүний эрхийн гэрээ конвенцын дагуу тэдгээр эрхийг түдгэлзүүлж болдог.

#### 31.1. Хуулийг хэсэгчлэн хүчингүй болгох

#### 31.2. Шаардлага ба уялдаа

##### 31.2.1. Онц байдал мөн үү ?

#### 31.3. Хязгаарлаж болохгүй эрхүүд

##### 31.3.1. Америк хоорондын тогтолцооны дагуух шүүхийн баталгаа

#### 31.4. Шударга шүүхийн эрхийг хязгаарлаж үл болох нөхцөл

##### 31.4.1. Хүний эрхийн Олон Улсын гэрээ

##### 31.4.2. Гэрээний бус хэм хэмжээ

##### 31.4.3. Хүмүүнлэгийн эрх зүй

#### 31.5. Олон улсын үүргээ үүргээ биелүүлэх

### 31.1. Хуулийг хэсэгчлэн хүчингүй болгох

Хүний зарим эрх нь туйлын байдаг бөгөөд ямар ч тохиолдолд, түүнийг хязгаарлаж үл болно. Хэдий тийм ч хүний зарим эрхийн олон улсын гэрээнүүд нь тодорхой нөхцөл байдал бий болсон тохиолдолд тухайн нөхцөлд нарийн зохицуулагдсны үндсэн дээр хүний эрхийн баталгаануудыг түр зогсоох эрхийг улс оронд олгосон байдаг. Ийнхүү хязгаарлах шалтгаан нь дайн, үймээн самуун болон байгалийн аливаа гамшигаас бий болсон нөхөшгүй хохирлоос зайлсхийх улсын эрхийг тогтооход оршино. Харин практикт, Үндэсний аюулгүй байдалд аюул тулгарч буй нэрийн дор хүмүүсийн эрхийг хязгаарлаж хууль бусаар урвуулан ашигласаар байгаа юм.

Тухайн улс онц байдал зарлахдаа, Засгийн газарт хуулийн хэм хэмжээгээр үүрэг болгодог бөгөөд тухайн хуулийг батлахаас өмнө онц байдал зарлаж болохгүй. Харин Засгийн газар онцгой эрх мэдлийн зөвшөөрөгдөх хүрээнд болон дүрэм журамд нийцүүлэн тунхагласан онц байдлын нөхцөл байдлын үед олон улсын болон үндэсний тогтоосон хэм хэмжээг үл хайхарсаар байгаа юм. Онцгой эрх мэдлийн зөвшөөрөгдөх хүрээнд болон дүрэм журмуудыг Зарим хүний эрхийн ноцтой зөрчил нь онц байдлын үед олонтой гардаг.

Хүний эрхийн Олон улсын гэрээ, конвенцид заасны дагуу хязгаарласан эрхүүдэд зарим шударга шүүхийн хамгаалалт багтдаг. Гэвч энэ байдал улсын хамгийн эцсийн онц байдал болох зэвсэгт мөргөлдөөний үед шударга шүүхээр хамгаалуулах хүний эрхийн хамгаалалт болдог хүмүүнлэгийн эрх зүг багтаасан тухайн улсын бусад олон улсын эрх зүйн үүргүүдтэй зөрчилдөх ёсгүй юм. Түүнчлэн ийнхүү хуулийг түр түдгэлзүүлэх явдал нь заавал байх ёстой процедурын чухал шаардлагуудыг хангах ёстой байдаг.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын дагуу, Улс үндэстний амьдралд аюул занал тулгарч, энэ тухай албан ёсоор зарлаж нийтийг хамарсан онц байдал тогтоосон үед хүний эрхийн үүргүүдийг түр түдгэлзүүлж болохоор заасан байдаг. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 4-р зүйлээр засгийн газар зарим хүний эрхийг дараах тохиолдолд түдгэлзүүлж болно. Үүнд

- а) Тухайн нөхцөл байдал нь ийнхүү түдгэлзүүлэхийг хатуу шаардаж байгаа;
- б) Ийнхүү түдгэлзүүлэх нь тухайн улсын бусад олон улсын үүргүүдтэй зөрчилдөхгүй байх;
- в) Онц байдал албан ёсоор зарласан улс орны засгийн газар нь ямар эрхийг, ямар учир шалтгаантайгаар түдгэлзүүлэх тухайгаа НҮБ-ийн Аюулгүйн Зөвлөлд нэн даруй мэдэгдэх

Түдгэлзүүлж болохгүй эрхүүд нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 4-р зүйлд заасан эрхүүд (31.3-г үз.) бөгөөд тэдгээр нь шударгаар шүүгдэх эрхийг агуулдаггүй. Гэхдээ тухайн эрхийг дам байдлаар илэрхийлж болох юм.\*<sup>1</sup>

Сүүлийн үед, Хүний Эрхийн Хороо Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын шударгаар шүүлгэх эрхтэй холбоотой заалтыг хуулиар өөрчлөж болохгүй гэж үзсэн бөгөөд “улс орон нь ... хүнийг дур мэдэн баривчлах болон хорих, ... гэм буруутай нь нотлогдохгүй байхад гэм буруутайд тооцох, ... зэрэг эрхүүдийг хязгаарлаж болохгүй ба 14-р зүйлд заасан тодорхой хязгаарлалтыг зөвшөөрч болох боловч, шударга шүүхийн эрхийг ерөнхийд нь хязгаарлаж болохгүй”<sup>2</sup>

Хүний Эрхийн Хороо Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийг улсын тайлан дахь тайлбараар болон бие даасан хэргийн дүгнэлтээр дамжуулан аажмаар харуулсан ба 14-р зүйл дэх шударга шүүхийн зарим эрх, Хабис Корпус /habeas corpus/ дах эрхийн харагдах байдал нь хуулийг түр түдгэлзүүлэх явдал биш юм.<sup>3</sup>

Африкийн Хартид онц байдлын талаарх заалт байхгүй бөгөөд хүний эрхийг хязгаарлахыг зөвшөөрдөггүй байна. Харин Америкийн Конвенцоор оролцогч улсын тусгаар тогтнол, улсын аюулгүй байдалд, дайны болон нийгмийн бусад аюул тулгарч байгаа тохиолдолд хуулийн заалтыг түр хүчингүй болгохыг зөвшөөрдөг ч “эрхийн хамгаалалтад шүүхийн баталгаа зайлшгүй чухал” (31.3.1-г үз.) гэх байр суурийг баримталдаг. Харин Европын Конвенцоор дайн болон улс, үндэстний амьдралд тулгарсан бусад нийтийн

### Холбогдох хэм хэмжээ

#### Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 4-р зүйл:

1. Улс үндэстний амьдралд аюул занал тулгарч, энэ тухай албан ёсоор зарлаж нийтийг хамарсан онц байдал тогтоосон үед энэхүү Пактад оролцогч улс уг Пактаар хүлээсэн үүргээсээ тухайн нөхцөл байдлын хурцадмал шинжид дүйх хэмжээгээр ухарсан арга хэмжээ авч болох бөгөөд тэр нь олон улсын эрх зүйгээр хүлээсэн бусад үүрэгт нь харшлах ёсгүйгээс гадна зөвхөн арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг буюу нийгмийн гарлаар алагчилах явдалд хүргэхгүй байх ёстой.
2. Энэ заалт нь 6, 7, 8, /1, 2 дахь хэсэг/, 11, 15, 16, 18 дугаар зүйлээс ямар нэгэн байдлаар ухрах үндэслэл болохгүй.
3. Ухрах эрхээ хэрэгжүүлж буй, энэхүү Пактад оролцогч аливаа улс ухарч байгаа заалт болон ухрах болсон шалтгааны талаар уг Пактад оролцогч бусад улсад Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар уламжлан даруй мэдэгдэх ёстой. Түүнчлэн ухарсан үүргээ сэргээсэн хугацааг мөнхүү зуучлагчаар уламжлан мэдэгдсэн байх ёстой.

\* ИУТЭОУП-ын 4 дүгээр зүйл

### Ишлэл

1. The administration of justice and the Human Rights of Detainees, The right to a fair trial, S.
- С. Черниченко ба В.Триэт, НҮБ-ын баримт бичиг, Хүний эрхийн Комисс/Sub.2/1994/24 (1994 он), догол мөр128
2. НҮБ-ын баримт бичиг, А/39/40 1984 он, хуу 144
3. НҮБ-ын баримт бичиг, ИУТЭОУП/С/21/ Нэмэлт 6, 1994 он

онц байдалын үед хуулийг түр түдгэлзүүлэхийг зөвшөөрсөн байдаг. Гэрээ бүр хэзээ ч хязгаарлаж үл болох эрхүүдийг өөр өөрөөр тусгасан байна. (31.3-г үз.)

Зарим хүний эрх тухайлбал амьд явах, эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бусаас хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхээс ангид байх эрхүүдийг ямар ч нөхцөлд хязгаарлаж үл болно. Тэдгээр хязгаарлаж болохгүй эрхүүдэд зарим шударга шүүхийн баталгаа агуулагддаг ч бүгдээрээ хамаарагддаггүй.

Хөгжиж буй олон улсын нэгдмэл санаа болох habeas corpus болон amparo нь хүний эрхийг хязгаарлаж үл болно гэж үзэх болсон. НҮБ-ын Хүний Эрхийн Хороо “habeas corpus болон онц байдлын үед хязгаарлаж үл болох хүний эрхийн бусад адил дүрэм журмуудын адил дүрэм журам тогтоох” –ыг бүхий л улсад зарлан тунхагласан юм.<sup>4</sup> Америк хоорондын шүүх мөн хүний халдашгүй байх эрхийг хязгаарлаж үл болно гэж тодорхойлжээ.

Хүний Эрхийн Хороо “Хэрвээ улсууд нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14-р зүйлд заасны дагуу шударга шүүхийн процессыг онц байдлын нөхцөлд зогсоохоор шийдсэн бол, энэ хязгаарлалт нь бодит нөхцөлд тохирч байх, түүнчлэн 14-р зүйлийн 1 дэх хэсэг дэх бусад нөхцлийг хүндэтгэх шаардлагатай.” гэж үзсэн байдаг.

Тухайн улс иргэдийнхээ эрхийг уландаа гишгэж болзошгүй явдал нь үндэсний хямралын үед олонтой тохиолддог. Онц байдлыг зарлах нь зөвхөн шүүхийн ажиллагаанд тайлбаргүйгээр онц байдлын хэм хэмжээ, дүрэм журам нэвтрүүлэх эрх бүхий гүйцэтгэх засаглалын үүрэг байдаг. Эмнести Интернэшнл шударга шүүхийн баталгаа нь онц байдлын үед хүний эрхийн хамгаалахад чухал учраас хязгаарлаж үл болно гэж үздэг. Түүнчлэн онцгой байдлын үед шүүгчийн бие даасан байдал, захиргааны байгууллагыг үндэсний болон олон улсын хуулийн дагуу ажиллахыг шаарддаг нь хамгийн чухал зүйл юм.

### 31.2. Зайлшгүй байдал ба пропорц тэнцүү чанар

Шүүхээр шударгаар шүүлгэх эрх нь хязгаарлах нөхцөл байдлыг хатуу шаарддаг. Пропорционал зарчим нь тухайн үүргийн түдгэлзүүлэлт нь улс үндэстний өмнө тулгараад байгаа онц байдалд зайлшгүй шаардлагатай нөхцөлтэй дүйцсэн байхыг шаарддаг. Түүнчлэн хуулийг түр түдгэлзүүлэх шаардлагыг хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн салбараас хянаж үзэх ёстой болдог.

Тухайн эрхтэй өрсөлдөх хэм хэмжээ болон хуулийг хэсэгчлэн өөрчлөх аливаа аргын хэмжээ хүрээ нь (газарзүйн болон цаг хугацааны хувьд) “улс үндэстний өмнө тулгарсан байлдааны онц байдалд зайлшгүй хэмжээгээр зохицуулагдсан байх ёстой”.<sup>5</sup>

Европын шүүхээс хуулийг түр түдгэлзүүлэх арга хэмжээ авах шаардлагатай эсэх болон хуулийн дагуу хийгдсэн гэж үзэхийн тулд тухайн асуудлыг шийдэхэд энэ арга хэмжээнээс хүний эрхэд илүү хохирол багатай өөр арга хэмжээг ашиглах боломжгүй болсон байхыг тодорхойлох шаардлагатай гэж үзжээ. Нэмэлт болгож хэлэхэд, энэхүү арга нь тухайн асуудлыг шийдэхэд хувь нэмэр болох ёстой юм.<sup>6</sup>

Европын шүүх “Их Британий Засгийн газар хуулийг түр түдгэлзүүлэхийг Хойд Ирландад мэдэгдэхээс татгалзаад зогсохгүй Хойд Ирландад бий болсон нөхцөл дэх зайлшгүй арга хэмжээний үндсэн дээр шүүх болон шүүх эрх мэдлийн байгууллагын өмнө нэн даруй авчрахгүйгээр хүмүүсийг барьж саатуулдагаараа хоригдлын эрхийг зөрчсөөр байна” гэж үзжээ.<sup>7</sup> Энэхүү шүүхийн шийдвэрийн дагуу, Нэгдсэн вант улсын засгийн газар энэ арга хэмжээг заавал байх ёстой бөгөөд алан хядагч

#### Ишлэл

4. Комиссын Шийдвэр 1994/32
5. Манфред Новак, НҮБ-ын Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт: ИУТЭОУП-ын Тайлбар, 1993 он, хуудас 186
6. Лаулесс ба Ирланд, А 3, 1961 он
7. Брoгaн ет ал ба Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, 1988 оны 11 дүгээр сарын 29, 1456 цуврал А-30-34

нарт хуулийн дагуу шийтгэл оногдуулахад шаардлагатай байсан гэж мэдэгдсэн байна. Энэхүү мэдэгдэл нь дараах үндэслэлүүдийн дагуу хангалтгүй байсан юм. Тухайлбал, баривчлан хорих хүрээнд шүүхийн хяналтын дутагдалтай байдал нь нөхцөл байдалд шаардлагатай тиймэрхүү арга хэмжээ авах үндэслэл болохгүй юм.<sup>8</sup> /Эмнести Интернэшнл тухайн хэрэгт гуравдагч этгээдээр оролцсон бөгөөд баривчлагдсан этгээдүүдийг тусгаарлан хорих эхний 48 цагийн турш эрүү шүүлт, зүй бус харьцаанаас хамгаалах баталгаа хангалтгүй байсан хэмээн маргасан байна./

Америк хоорондын шүүх шаардлагатай аливаа үйлдэл нь “хууль бус хэдий ч онцгой нөхцөл байдалд тохирсон байх” шаардлагатай юм.<sup>9</sup>

### 31.2.1. Онц байдал мөн үү?

Олон улсын эрх зүйн дагуу онц байдлыг зөвхөн тухайн улсын тусгаар тогтнол, улс орны бүрэн бүтэн байдалд нүүрлэсэн аюул занал, албадлага гэх мэт сүйрэл, онцгой нөхцөл байдал нүүрлэсэн тохиолдолд л зарладаг.

Тодорхойлвол, онц байдал нь тухайн нөхцөл дэх түр зуурын хууль зүйн хариу үйлдэл юм. Байнгын онц байдал гэдэг нь утгын хувьд зөрүүтэй ойлголт. Харамсалтай нь, заримдаа онц байдал нь байнгын шинжтэй болдог. Учир нь энэ нь нэг удаа зарлагдаад хэзээ ч цуцлагдахгүй байх, дахин дахин зарлагдах эсвэл тухайн арга хэрэглүүр нь онц байдал дууссаны дараа ердийн хуульд хадгалагдан үлдсэн тохиолдолд онц байдал байнга байсаар байдаг.

Европын шүүх, Европын конвенцийн талууд улс, үндэстний өмнө тулгарсан, нийтийг хамарсан онц байдлын талаар шийдвэрлэх нь “хүлээн зөвшөөрөхийн хувьд өргөн хүрээ”- тэй байдаг гэж үзсэн.

Европын шүүх: Гэрээнд оролцогч улс бүр эхний удаа тухайн улсад онц байдал зарласнаар аюул учирсныг тодорхойлохыг улс өөрөө тогтооно. Хэрэв шаардлагатай бол энэ онц байдлыг даван туулах шаардлагатай эсэх талаар тухайн улс өөрөө шийднэ. Тухайн үйл ажиллагаатай шууд холбоотойгоор олон улсын шүүгч нараас илүүтэйгээр Үндэсний байгууллагууд онц байдлын талаар, түүнийг зогсоох шалтгаан ба цар хүрээний талаар шийдвэр гаргах илүү боломжтой юм. Иймээс Европын конвенцийн 15.1-р заалт ийм байгууллагуудад үнэлгээний эрхийг үлдээдэг. Гэвч Европын комисс ба шүүх онц байдлыг зарлах шаардлагатай эсэхийг тодорхойлдог.<sup>10</sup>

Ийнхүү онц байдал зарласан ч бай зарлаагүй ч бай энэ талаар Европын комисс өөрийн гэсэн дүгнэлт гаргана гэж тодорхойлсон байна.<sup>11</sup>

#### Ишлэл

8. Бранниган, МакБрайде ба Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, 1993 оны 5 дугаар сарын 26, A258-6, 1993 он

9. Америк дундын шүүхийн жил бүрийн илтгэл, 1987 он, Америкийн улсуудын байгууллага, Ser.L/V/II.84, баримт бичиг 13, хуудас 28;

10. Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улс ба Ирланд, 1978 оны 1 сарын 28, A25, догол мөр 207; Бранниган МакБрайде ба Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улс 1993 оны 5 сарын 26 A258-6 хуудас 49, догол мөр 43;

11. Бранниган МакБрайде ба Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улс 1993 оны 5 сарын 26 A258-6 хуудас 80, догол мөр 45;

### 31.3. Ямар ч нөхцөлд хязгаарлаж болохгүй эрх

Энэ нь хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцид болон олон улсын заншлын эрх зүйд үндэслэсэн зарим эрхүүдийг ямар ч нөхцөлд үл хязгаарлаж болно. Шударгаар шүүлгэхтэй шүүхтэй хамааралтай эрхүүдэд, тухайлбал, амьд явах эрх, эрүү шүүлт тулгах, бусад хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхээс ангид байх болон гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдоогүй байхад яллагдагчаар татахгүй байх эрх эрхүүд хамаарна. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын дагуу, хязгаарлаж үл болох эрхүүдэд дараах хамаарна\*/ИУТЭОУП 4.2/: амьд явах эрх (6-р зүйл), эрүү шүүлт тулгахаас хамгаалуулах эрх (7-р зүйл), боолчлол ба зарцлагдахыг хориглох эрх (8.1, 8.2-р зүйл), зээлийн өр төлбөрийн төлөө хорихыг хориглох (11-р зүйл), эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг хориглох (16-р зүйл), шашин шүтэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх (18-р зүйл) болно. Эдгээр эрхийн хязгаарлалт нь арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг буюу нийгмийн гарлаар алагчилах явдалд хүргэхгүй байх ёстой.

\* ИУТЭОУП 4.2

Европын конвенцид хязгаарлаж үл болох эрхүүдийг заасан бөгөөд, тэдгээрт эрүү шүүлт тулгахаас хамгаалуулах эрх, боолчлол ба боолчлогдохыг хориглох эрх, эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг хориглох, амьд явах эрх зэрэг болно.

\*\*ЕК 15-р зүйл

Америкийн конвенц нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 4.2-т заасан эрхүүдээс гадна төрийн эрхэд оролцох эрх, гэр бүл, хүүхэдтэй болох эрх, нэр, харьяалалтай байх эрх, шүүхээр хамгаалуулах эрх зэргийг хязгаарлаж үл болох эрхэд хамааруулжээ.\*\*\* /АК 27-р зүйл/

#### 31.3.1. Америк хоорондын тогтолцооны дагуух шүүхийн баталгаа

Хэдийгээр америкийн конвенц шударга шүүхийн бүх эрхийг хязгаарлаж үл болох эрхэд хамааруулаагүй ч конвенцийн 27.2-т амьдрах, хүнлэг харьцах, гэх мэт эрхүүдийн түдгэлзүүлж болохгүй, хамгаалалтыг хүчингүй болгохыг хориглосон байдаг. ^

^ Америкийн конвенцийн 27.2 дугаар зүйл

Америк хоорондын шүүхээр тодорхойлсон түдгэлзүүлж болохгүй шүүхийн баталгаанууд нь эрх, тэдгээрийн хэрэгжилтийг нотлох, батгай болгох, хамгаалахад чиглэдэг. Хүний эрхийн хамгаалалтад шүүхийн баталгаа

##### Холбогдох хэм хэмжээ

Америкийн конвенцийн 27.1, 27.2 дугаар зүйл

27.1 Зэвсэгт мөргөлдөөн, нийтэд аюултай эсвэл гэнэтийн тусгаар тогтнол болон үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн гэнэтийн нөхцөл байдал бий болсон үед тухайн улс нь зөвхөн зайлшгүй шаардлагатай нөхцөлд, тодорхой хугацаагаар олон улсын гэрээгээр хүлээсэн арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг болон нийгмийн гарлаар нь ялгаварлахгүй байхаас бусад конвенцоор хүлээсэн үүргээсээ татгалзах арга хэмжээг авч болно.

27.2 Энэхүү арга хэмжээгээр дор дурдсан эрхүүдийн аль нэгийг хязгаарлах эрх байхгүй. Үүнд: 3 дугаар зүйл /шүүхээр сонгогдсон хувь хүний эрх/, 4 дүгээр зүйл /амьд явах эрх/, 5 дугаар зүйл /хүнлэг харьцах/, 6 дугаар зүйл /боолчлолоос ангид байх/, 9 дүгээр зүйл /Ex Post Facto эрх зүйгээр олгогдсон эрх чөлөө/, 12 дугаар зүйл /итгэл үнэмшилтэй байх болон шашин шүтэх эрх чөлөө/, 17 дугаар зүйл /гэр бүлтэй байх эрх/, 18 дүгээр зүйл /нэртэй байх эрх/, 19 дүгээр зүйл /хүүхэдтэй байх эрхтэй/, 20 дугаар зүйл /үндэстний/, 23 дугаар зүйл /засгийн газрын ажиллагаанд оролцох эрх/ эдгээр эрхүүдийн шүүхийн баталгаа



зайлшгүй чухал бөгөөд түүнийг түдгэлзүүлж үл болно. Хамгаалалт заавал зайлшгүй биш бөгөөд харин шүүхийн хувьдбайх нь чухал. Энэхүү үзэл санаа онц байдлын үед хууль ёсны байдлыг хэрэгжүүлэх эрх мэдэл бүхий шүүхийн байгууллагын бие даасан, шударга, идэвхтэй оролцоог далдуур илэрхийлж байгаа юм.<sup>12</sup> Түүнчлэн шүүх ийнхүү шийдвэрлэсэн: “шүүхийн баталгаа нь Конвенцийн 8-р зүйлд илэрхийлсэн, эрх зүйн процессын зарчим хүрээ хязгаарын дотор хэрэгжих ёстой”<sup>13</sup>

Шүүхийн баталгаа нь халдашгүй дархан байх эрхүүдийг агуулдаг.

Америк хоорондын шүүх халдашгүй дархан байх эрх нь хоригдлын эрхийг хамгаалах онцгой арга хэрэгсэл болсон бөгөөд эрүү шүүлт, хэрцгий байдлаас хамгаалуулах болон амьд явах эрхийг огт хязгаарлаж болохгүй гэж үзсэн.<sup>14</sup> Түүнчлэн шүүх шүүхийн баталгаа н халдашгүй чөлөөтэй байх эрхийг Конвенцийн 27.2-т зааснаар хориглосон янз бүрийн эрхийн хамгаалалтын хувьд онц чухал гэж үзсэн.<sup>15</sup>

### 31.4. Шүүхээр шударгаар шүүлгэх эрхийг хязгаарлахыг хориглосон хэм хэмжээ

Шударгаар шүүлгэх эрхүүдтэй хамаарал бүхий олон улсын хэм хэмжээний нэг нь шүүхийн баталгааг түдгэлзүүлж болохгүй байдал юм.

#### 31.4.1. Хүний эрхийн Олон Улсын гэрээнүүд

Зарим хүний эрхийн олон улсын гэрээнүүд нь улсуудын тогтоосон эрхийн хязгаарлалтыг хүлээн зөвшөөрдөггүй. Жишээлбэл Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, Хүүхдийн эрхийн конвенц, Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг арилгах устгах тухай конвенц, Арьс өнгөөр алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, болон Африкийн Хартигаар шударгаар шүүлгэхтэй хамааралтай эрхүүдийг хязгаарлахыг хориглосон байдаг.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид “дайны онц байдал, дайны аюул, эсвэл дайн дотоодын улс төрийн тогтворгүй байдал буюу бусад аливаа онц байдал нь эрүүдэн шүүхийг зөвтгөх үндэслэл болохгүй”<sup>\*</sup> гэж заасан байдаг. Тэрчлэн энэ конвенцын дагуу яллагдсан этгээдийн хувьд эрүүгийн байцаан шийтгэх бүхий ажиллагаа, байцаалт, баривчилгаа, шүүх, ял оноох, шийдвэр гүйцэтгэх үе шатын туршид эрүү шүүлтээс ангид байх эрх нь хязгаарлагдах ёсгүй юм. Иймд эрүүдэн шүүх замаар гаргуулж авсан нотлох баримтыг зөвхөн эрүүдэн шүүснийг нь нотлохоос бусад тохиолдолд нотлох баримт гэж үзэхгүй. хэмээн заасан байдаг.<sup>16</sup> (10.4, 17 дэх зүйлийг үз)

Африкийн Хартигийн заалтууд нь ямар ч нөхцөл байдалд шударгаар шүүлгэх баталгааг хангах явдлыг хязгаарлахыг үл зөвшөөрдөг. Африкийн Комисс нь онц байдлын үед, засгийн газар иргэдийнхээ эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг үргэлжлүүлэн хангах үүрэгтэй гэж тодорхойлсон байдаг. Үндэсний онц байдал зарласан нь олон гэрээний дагуух үүргээсээ засгийн газар татгалзах үндэслэл болохгүй.<sup>\*\*17</sup>

#### 31.4.2. Гэрээний бус хэм хэмжээ

Шударгаар шүүлгэх эрх нь гэрээний бус зарим хэм хэмжээгээр хамгаалагдсан байдаг. Тухайлбал Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Үндсэн зарчмууд, Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмууд гэх зэрэг. Гэрээний бус хэм хэмжээ нь бүхий л нөхцөл байдал, цаг хугацаанд хэрэглэгддэг. Тэдгээр хэм хэмжээнүүд практик, зарчимд тулгуурласан олон улсын харилцааны нэгдмэл санааны төлөөлөл болдог. Түүнчлэн онц байдлын үед хүлээн зөвшөөрөх боломжтой наад захын хэм хэмжээ болдог.

\* Эрүү Шүүлтийн Эсрэг Конвенцийн 2(2) дугаар зүйл

\*\*Африкийн Дүрэм

#### Ишлэл

12. Америк Дундын Шүүх, Зөвлөх санал OG-8/87, 1987 оны 1 дүгээр сарын 30, “Habeas Corpus Онц Байдалд”, хуудас 25, 26
13. “Онц Байдал дах шүүхийн баталгаа”, Зөвлөмж санал OC-9/87 of 6 October 1987, Америк Дундын Шүүхийн жил бүрийн илтгэл, 1988, OAS/Ser.L/V/III.19 баримт бичиг 13, 1988
14. Америк Дундын Шүүх, Зөвлөх санал OG-8/87, 1987 оны 1 дүгээр сарын 30, “Habeas Corpus Онц Байдалд”, 1987, OAS/Ser.L/V/III.17 баримт бичиг 13, 1987;
15. “Онц Байдал дах шүүхийн баталгаа”, Зөвлөмж санал OC-9/87 of 6 October 1987, Америк Дундын Шүүхийн жил бүрийн илтгэл, 1988, OAS/Ser.L/V/III.19 баримт бичиг 13, 1988
16. The administration of justice and the Human Rights of Detainees, The right to a fair trial, С. Черниченко ба В.Триэ, НҮБ-ын баримт бичиг, Хүний эрхийн Комисс/Sub.2/1994/24 (1994 он), догол мөр128
17. Хүний болон улс түмний эрхийн тухай Африкийн Дүрмийн 9 дүгээр Илтгэл (74/92), 1995/96

### 31.4.3. Хүмүүнлэгийн эрх зүй

Женевийн конвенц болон түүний 2 нэмэлт протокол нь зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэгддэг бөгөөд эрхийг түдгэлзүүлэхийг хүлээн зөвшөөрдөггүй. Үүний үр дүнд олон улсын болон дотоодын зэвсэгт мөргөлдөөний үеэр ч хүмүүнлэгийн эрх зүйн дагуу шударгаар шүүлгэх эрх нь хүчин төгөлдөр байна.

1949 оны Женевийн дөрвөн конвенц болон 1-р нэмэлт протокол нь олон улсын зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэгдэхээр зохицуулагдсан. 1-р Нэмэлт протоколын 75-р зүйл нь олон улсын зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотойгоор хэн нэгнийг баривчилахад шударга шүүхийн суурь эрхүүдийг хангасан юм. Ердийн шүүхийн процессын зарчмын дагуу шүүхээс зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотой гэмт хэрэгтэнд хорих ял эдлүүлсэн этгээдийн гэм буруу тогтоогдоогүй байж болно. \*\*

Женевийн конвенцийн нийтлэг 3-р зүйл болон 2-р нэмэлт протокол нь олон улсын биш зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэгдэнэ. Женевийн конвенцийн нийтлэг 3-р зүйлээр дайны үеийн үйлдэлтэй холбогдуулан “зайлшгүй шаардлагаар тогтоосон шүүхийн бүхий л баталгааг зөвшөөрч байгаа” шүүхээс өмнө шүүхийн шийдвэргүйгээр түүнийг хэрэгжүүлэх, ял оноохыг хориглодог. \*\*\*Энэхүү заалтаар үл хязгаарлахыг хүлээн зөвшөөрөх хүртэл, олон улсын бус зэвсэгт мөргөлдөөний үе дэх шүүхийн баталгааны эрхүүд нь хүмүүнлэгийн эрх зүйн хувьд салшгүй эрх байна.

3-р зүйлийн дагуу заншлын эрх зүй нь олон улсын харилцааны гишүүн улсууд нь гэрээнд нэгдэж орсон эсэхээс үл хамааран хэрэгжих ёстой.

Женевийн конвенцын баталгаанууд нь онц байдлын үед, түүний ард орших энх тайван цагт тэгш хүчин чадалтай.<sup>18</sup> Бүслэлтэд буй улс болон онц байдлын үедэх улсын НҮБ-ын тусгай илтгэгч хүмүүнлэгийн эрх зүйн дагуу шударга шүүхийн эрхүүдийг хязгаарлаж үл болох ба бүх нөхцөл байдалд үл хязгаарлалтыг хангах ёстой гэж “хамгаалалт нь дайны үеэс илүү энх тайван цагт сул байдаг” гэдэгт үндэслэн маргасан байна.<sup>19</sup>

### 31.5. Олон улсын үүргээ биелүүлэх

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Америкийн Конвенц, Европын конвенцуудад заасан эрхийн хязгаарлалт олон улсын эрх зүйн үүргийн дагуу хүмүүнлэгийн эрх зүйг хангасан байх ёстой. Женевийн конвенц болон түүний нэмэлт протоколууд нь зэвсэгт мөргөлдөөний үед шударга шүүхийн эрх нь хүмүүнлэгийн эрх зүйн дагуу хүчин төгөлдөр байна гэсэн санааг агуулж байдаг. түүнчлэн энэхүү утга санаа нь эрхийн хязгаарлалтаас илүү өргөн хүрээнд хамгаалсан бусад хүний эрхийн гэрээнүүдэд тусгалаа олсон байдаг. Мөн заншлын эрх зүйн хэм хэмжээ нь үл хязгаарлах үүргийг бусад гэрээний дагуу хязгаарлаж буй улсуудад ногдуулдаг байна.

\*\*1 дүгээр Нэмэлт Протоколын 75 дугаар зүйл

\*\*\*Женевийн Конвенцийн нийтлэг 3(г) зүйл

#### Ишлэл

18. Seguridad del Estado, Derecho Humanitario y Derechos Humanos, Informe Final, Comité Internacional de la Cruz Roja, Instituto Interamericano de Derechos Humanos, San José, 1984 он, хуудас 61

19. НҮБ-ын баримт бичиг, Хүний эрхийн Комисс/ Sub.2/1982/15, хуудас 20

## 32 дугаар бүлэг

### Зэвсэгт мөргөлдөөний үед хэргийг шударгаар шийдвэрлүүлэх эрх

Зэвсэгт мөргөлдөөний үед баримтлах наад захын зарчмыг заасан олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн хэм хэмжээнд шударга шүүхийн талаар ч агуулагдсан байдаг. Эдгээрийг олон улсын дайн хийгээд зэвсэгт мөргөлдөөн, иргэний дайны үед ч хэрэглэнэ.

- 32.1 Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй
  - 32.1.1 Олон улсын зэвсэгт мөргөлдөөн
  - 32.1.2 Олон улсын бус зэвсэгт мөргөлдөөн
  - 32.1.3 Ялгварлан гадуурхагдахгүй байх
  - 32.1.4 Хамгаалалтанд байх хугацаа
  - 32.1.5 Шүүхээр хэргээ шударгаар шүүлгэх эрх
- 32.2 Шүүх хурлаас өмнө
  - 32.2.1 Мэдэгдэл хийх
  - 32.2.2 Гэм буруутай нь нотлоогүй тохиолдолд гэм буруугүйд тооцох
  - 32.2.3 Өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх
- 32.3 Урьдчилан хоригдох үед эдлэх эрх
  - 32.3.1 Эмэгтэйчүүдийг урьдчилан хорих
  - 32.3.2 Хүүхдийг урьдчилан хорих
- 32.4 Шүүхэд эдлэх эрх
  - 32.4.1 Шударга, хараат бус шүүх
  - 32.4.2 Боломжит хугацаанд хэргээ шийдвэрлүүлэх эрх
  - 32.4.3 Өмгөөлүүлэх эрх
  - 32.4.4 Нэг хэрэгт хоёр удаа ял шийтгүүлэхээс хамгаалах
  - 32.4.5 Хууль болон ялыг буцаан хэрэглэхээс хамгаалах
- 32.5 Цазаар авах ялгүй хэргүүдэд ял шийтгэх
  - 32.5.1 Хоморголон шийтгэхийг хориглох
- 32.6 Цазаар авах ял оногдуулах хэргүүд

#### 32.1 Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй

Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйгээр зэвсэгт мөргөлдөөний үе дэх зан үйлийг зохицуулдаг. 1949 оны Женевийн Конвенц болон түүний Хоёрдугаар нэмэлт Протоколын дагуу янз бүрийн хүмүүсийн эрхийг тодорхой нөхцөл байдалд хамгаалах асуудлыг зохицуулдаг. Тухайлбал гэмт хэрэгт ял тулгагдсан хүмүүсийн процессийн эрхийг хамгаалах талаар ч зохицуулсан.

Хэрэв зэвсэгт мөргөлдөөн нь олон улсын шинжтэй бол дайны олзлогдсдыг Женевийн 3 дугаар конвенц, энгийн иргэдийг 4 дүгээр конвенцийн дагуу хамгаалдаг. 1977 оны Нэгдүгээр нэмэлт протокол нь олон улсын зэвсэгт мөргөлдөөнд оролцож буй аль нэг талын иргэдийн хувьд ч үйлчилдэг, тухайлбал дайны олзлогдсон, дайтаж буй статусгүй хүмүүс болон хүн төрөлхтөний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэгт яллагдаж буй хүний хувьд ч үйлчилнэ.

Олон улсын бус зэвсэгт мөргөлдөөний хувьд Женевийн конвенцийн дөрвөн ч удаа давтагсан 3 дугаар зүйл болон Хоёрдугаар нэмэлт Протокол үйлчилдэг. 3 дугаар зүйлд заасан зарчим бүхий л үед үйлчилдэг.

Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн дагуу шүүхээр хэргээ шударгаар шийдвэрлүүлэх эрхийг ямар ч нөхцөлд хангах ёстой. Дайны үеэр шүүхээр хэргээ шударгаар шийдвэрлүүлэх эрхийг зөрчих нь олонтаа тохиолддог бөгөөд энэ нөхцөлд хариуцлага хүлээх этгээдийг холбогдох улсад шүүх аль эсвэл олон улсын эрүүгийн шүүхэд шилжүүлэх нь чухал.

Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн дагуу шүүхээр хэргээ шударгаар шийдвэрлүүлэх эрхийг дайны үеэр онцгой нөхцөлд тодорхой субъектийн хувьд хэрэгжүүлдэг учир холбогдох олон улсын гэрээний зохицуулалтыг тухайн нөхцөл бүрт тохируулан ойлгох хэрэгтэй. Хамгийн гол нь хэдий нөхцөл байдал бүр нь өөр өөр байдаг ч шүүхээр хэргээ шударгаар шийдвэрлүүлэх талаарх шаардлага нь олон улсын болон дотоодын зэвсэгт мөргөлдөөнд аль алинд нь хэрэгжих ёстой.

### 32.1.1 Олон улсын зэвсэгт мөргөлдөөн

Олон улсын зэвсэгт мөргөлдөөнд оролцож буй хүний эрхийг Нэгдүгээр нэмэлт протоколын 75 дугаар зүйлийн дагуу баталгаажуулсан байдаг. Мөн түүнчлэн дайнд олзлогсдын эрхийн талаар Женевийн 3 дугаар конвенцийн 82, 88 болон 108 дүгээр зүйлд заажээ.<sup>1</sup>

Энгийн иргэдийн шүүхээр хэргээ шударгаар шийдвэрлүүлэх эрхийг 4-р Конвенцийн 64 болон 78 дугаар зүйлд тусгажээ. Эзлэгдсэн нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрхийн талаар 79 болон 141 дүгээр зүйлд заасан.

### 32.1.2 Олон улсын бус зэвсэгт мөргөлдөөн

Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн дагуу шүүхээр хэргээ шударгаар шийдвэрлүүлэх эрхийн талаар дөрвөн Женевийн конвенцийн нийтлэг 3 дугаар зүйл болон Хоёрдугаар нэмэлт протоколын 6 дугаар зүйлд мөн заажээ.

Нийтлэг 3 дугаар зүйлд “олон улсын бус” зэвсэгт мөргөлдөөний үе дэх талуудын зан үйлийг зохицуулахаас гадна зэвсэгт мөргөлдөөнд оролцохгүй байгаа, мөн буу зэвсгээ буулгасан, байлдахаа больсон цэргийн хүмүүс, байлдагч нарын, тухайлбал өвчтэй, шархадсан цэргүүд, хоригдсон болон бусад армийн бүрэлдэхүүнд байсан хүмүүсийн эрхийг заажээ.

Харин Хоёрдугаар Протокол нь хязгаарлагдмал хүрээний асуудлыг зохицуулдаг. Энэхүү Протокол нь эсэргүүцлийн зэвсэгт хөдөлгөөн, зохион байгуулалттай зэвсэгт бүлэглэлд хамаардаг бөгөөд тэд нь цэргийн үйл ажиллагаа, хяналтаа тогтвортой хэрэгжүүлэх зорилгоор нутаг дэвсгэрт өөрийн хяналтаа тогтоосон байдаг. Хоёрдугаар Нэмэлт протоколоор дотоодын зэвсэгт мөргөлдөөн үүнд зэвсэгт жагсаал, төстэй үйл ажиллагаанд хамаардаг. **(Онц байдлын үеэр шүүхээр хэргээ шударгаар шийдвэрлүүлэх эрхийн талаар 31 дүгээр бүлгээс үзнэ үү.)**

### 32.1.3 Ялгаварлан гадуурхагдахгүй байх

Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн дагуу шүүхээр хэргээ шударгаар шийдвэрлүүлэх эрхтэй холбоотой ялгаварлан гадуурхахгүй байхтай холбоотой 2 зохицуулалтыг заасан байдаг. Тухайлбал зэвсэгт мөргөлдөөнд оролцож байгаа аль нэг талд олгож байгаа эрхийг нөгөө талд мөн адилаар олгох ёстой. Үүний дагуу дайны олзлогдогсдыг тухайн улсын цэргийн албан тушаалтнуудыг буруутгадаггүй гэмт хэргийн төлөө шүүхийг хориглосон байдаг<sup>2</sup> Дайны

#### Ишлэл

1. Женевийн 3 дугаар Конвенцийн 89-97 дугаар зүйлүүд

олзлогдогсдсг тухайн улсын цэргийн албан тушаалтныг шүүдэг ижил шүүхээр, адил журмын дагуу шүүх ёстой бөгөөд тэдэнд ялгаатай арай илүү хариуцлага ногдуулахыг хориглодог.\*

Мөн түүнчлэн арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, хөрөнгө чинээ болон бусад шалгуурыг үндэслэж, тухайн зэвсэгт мөргөлдөөн нь дотоодын болон олон улсын эсэхээс үл хамаарч ялгаварлан гадуурхахыг хориглоно.\*\*

### 32.1.4 Хамгаалалтанд байх хугацаа

Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн шүүхээр хэргээ шударгаар шийдвэрлүүлэх талаар зарчим нь зэвсэгт мөргөлдөөний үеэр төдийгүй түүний дараа нь ч үйлчилдэг. Шүүхээр хэргээ шударгаар шийдвэрлүүлэх эрх нь 1 дүгээр нэмэлт протоколд заасны дагуу дайны олзлогсод, баривчлагдсан хүмүүсийн хувьд суллагдах хүртэл нь дайн, мөргөлдөөн дууссаны дараа ч үйлчилсээр байдаг.\*\*\*

Энэхүү эрх нь мөн цэргийн үйл ажиллагаа дуусгавар болсны дараа болон зэвсэгт мөргөлдөөн дууссаны дараа хамгийн багаар 1 жилийн хугацаанд үйлчлэх ёстой. Эзлэгдсэн нутагт эзэлсэн тал нь шүүхээр хэргээ шударгаар шийдвэрлүүлэх эрхийг хангах үүргийг дээр заасан хугацаанд мөн хангах ёстой.

Мөн түүнчлэн конвенцийн хамгаалалтанд байгаа хүмүүсийг бүрэн суллагдтал хэдий хугацаа 1 жилээс илүү байсан ч шударга шүүхээр нөхцлийг бүрдүүлэх ёстой.\* 2 дугаар нэмэлт протоколын 6 дугаар зүйлийн дагуу шударга шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх эрх нь мөн дотоодын зэвсэгт мөргөлдөөн дууссаны дараа эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн хувьд ч үйлчилнэ.

\*Женевийн 3 дугаар Конвенцийн 102 дугаар зүйл

\*\* 1 дүгээр Нэмэлт Протоколын 75(1) дугаар зүйл, 2 дугаар Нэмэлт Протоколын 2(1) дугаар зүйл тус тус

\*\*\* 1 дүгээр Нэмэлт Протоколын 75(6) дугаар зүйл

#### Холбогдох хэм хэмжээ

##### Женевийн конвенцийн 3.1 дүгээр зүйл / дайны үед энгийн иргэдийг хамгаалах тухай/

Дайтах ажиллагаанд шууд оролцоогүй этгээд, түүний дотор байлдахаа зогсоосон болон өвчлөх, шархдах, саатуулагдах буюу аливаа бусад шалтгааны улмаас байлдаанд оролцоогүй зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний этгээдтэй арьс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэг, хүйс, гарал үүсэл, эд хөрөнгийн байдал буюу бусад төсөөтэй шалгуурт үндэслэн ялгаварлан гадуурхалгүйгээр бүх нөхцөл байдалд хүнлэг харьцана.

Энэ үүднээс дараахь үйлдлийг дээр дурдсан этгээдийн хувьд хийхийг хэзээ ч, хаана ч хориглоно:

- (a) амь нас, бие махбодид халдах, тухайлбал, бүхий л хэлбэрээр амийг нь хөнөөх, хүнд гэмтэл учруулах, харгис хэрцгийгээр харьцах, эрүүдэн шүүх;
- (b) барьцаанд авах;
- (c) хүний нэр төр, алдар хүндэд халдах, тухайлбал, доромжлон гутаах;
- (d) соёл иргэншилт ард түмний зайлшгүй гэж хүлээн зөвшөөрсөн шүүхийн бүх баталгаагаар хангаж байнгын ажиллагаатай шүүхээс урьдчилан гаргасан шийдвэргүйгээр ял шийтгэх болон ял эдлүүлэх.

##### Нэмэлт 1-р протоколын 75.4

Зэвсэгт мөргөлдөөнтэй холбогдох гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж үзэж байгаа хүнд таслан шийдвэрлэх тогтоол гаргаж болохгүй бөгөөд түүнийг зохих ёсоор байгуулагдсан, дор дурдсан шүүн таслах ажиллагааны нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудыг мөрдөж байгаа шударга шүүхийн ажиллагаанаас гадуур ямар ч ял ногдуулахгүй:

##### Нэмэлт 2-р протоколын 6.2

Гэм буруутай болохоо өөрөө хүлээн зөвшөөрсөн хэдий ч бие даасан хараат бус шударга байх баталгааг дор дурдсанаар хангасан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолгүйгээр шүүхийн ямар ч шийдвэр гаргаж болохгүй бөгөөд ямар ч ял ногдуулж болохгүй.

#### Ишлэл

2. Гэвч дараах хэргүүдэд сахилгын шийтгэл ногдуулж болох юм. Женевийн 3 дугаар Конвенцийн 82 дугаар зүйл

\*Женевийн 4 дүгээр  
Конвенцийн 6 дугаар зүйл

### 32.1.5 Шүүхээр хэргээ шударгаар шүүлгэх эрх

Хэдий олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн гэрээ конвенцид шүүхээр хэргээ шударгаар шийдвэрлүүлэх талаар шууд зохицуулалт байхгүй ч энэ нь хүний энэ эрхийг зөрчиж болно гэж ойлгож болохгүй. Шүүхээр хэргээ шударгаар шийдвэрлүүлэх эрх нь өөрөө өргөн утгатай бөгөөд энэ зарчмыг орчин үеийн эрх зүйн бүхий л салбарт хэрэглэж заншсан байдаг.

Нэгдүгээр нэмэлт Протоколын 75.4-т заасны дагуу олон улсын зэвсэгт мөргөлдөөний үеэр дайтаж буй талын аль нэг нь өөрийн эрх мэдэлд байгаа хүмүүсийг хараат бус шүүх ажиллагааны зарчмын хүндэтгэдэг эрх бүхий шүүхээр шүүхийг шаардсан байдаг. Өөрөөр хэлбэл уг Протоколд мөн шүүхээр хэргээ шударгаар шүүлгэх хүний салшгүй эрхийг баталгаажуулсан байна. Мөн түүнчлэн өргөн утгаар нь ойлговол яллагдагч нь шүүхийн өмнө болон шүүхийн үеэр өмгөөлөгч авах эрхтэй байна.\*\*

Олон улсын зэвсэгт мөргөлдөөний үеэр эзлэгдсэн нутаг дэвсгэрт амьдарч буй болон оршин байгаа энгийн иргэдийн хувьд ямарваа шийтгэх шийдвэрийг тогтмол үйл ажиллагаа явуулдаг шүүхгүйгээр гаргаж болохгүй.\*\*\*

\*\*1 дүгээр Нэмэлт Протоколын  
75(4) дугаар зүйл

Олон улсын бус зэвсэгт мөргөлдөөний үеэр мөн шүүхээр хэргээ шударгаар шийдвэрлүүлэх эрхийг хүлээн зөвшөөрсөн байдаг. Нийтлэг 3 дугаар зүйлд заасны дагуу шүүх ажиллагааг соёлт нийгэмд хүлээн зөвшөөрсөн шүүх ажиллагааны зарчмын дагуу хэрэгжүүлэх нь улсуудын үүрэг гэжээ. 2 дугаар нэмэлт протоколын 6.2-т заасны дагуу шүүх нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ хараат бус голч байх ёстой бөгөөд процессийн бүхий л эрхийг иргэдэд олгох ёстой гэсэн байдаг.^

\*\*\* Женевийн 4 дүгээр  
Конвенцийн 71 дүгээр зүйл

^ Женевийн Конвенцийн 3  
дугаар зүйл, 2 дугаар Нэмэлт  
Протоколын 6(2) дугаар зүйл

## 32.2 Шүүх хурлаас өмнө

### 32.2.1 Мэдэгдэх

Олон улсын зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотой гэмт хэрэг үйлдсэний төлөө эрх чөлөөгөө хасуулсан, аль эсвэл баривчлагдсан хэн бүр нь мэдээлэл авах эрхтэй.

#### *Эрхийнхээ талаар мэдэх*

Дайны олзлогдогсод нь шүүх хурлын өмнө өөрсдийн эдлэх эрхийн талаар мэдэх эрхтэй. Эдгээр эрх өөрийн армийн ахлах албан тушаалтнаас тусламж авах, өмгөөлөгчийн туслалцаа авах, тэдгээрийг сонгох, гэрчийг дуудуулах, шаардлагатай бол орчуулагч авах зэрэг эрхийг багтаадаг.^^

^^ Женевийн 3 дугаар  
Конвенцийн 1 дүгээр хэсэг,  
105 дугаар зүйл

#### *Баривчлах шалтгаан*

Олон улсын зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотойгоор баривчлагдсан, албадан саатуулагдсан хэн ч өөрт ойлгомжтой хэлээр баривчилсан шалтгааныг тайлбарлуулан авах эрхтэй.^^^

^^^1 дүгээр Нэмэлт Протоколын  
75(3) дугаар зүйл

#### *Ял*

Олон улсын зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотой ял тулгасан нөхцөлд тухай этгээд нь нэн даруй яг ямар гэмт хэргийн төлөө түүнд ял тулгаж байгаа талаар мэдэж авах эрхтэй.\*

Дайны олзлогсод болон тэдний өмгөөлөгч нь зохистой хугацаанд өөрт ойлгомжтой хэлээр яг ямар үйлдэлд яллагдаж байгаа талаар мэдэж авах эрхтэй байдаг.\*\*

Эзлэгдсэн нутаг дэвсгэрт байгаа энгийн иргэд мөн өөрт нь тулгасан ялын талаар нэн даруй өөрт ойлгомжтой хэлээр бичгээр мэдээлэл авах эрхийг эдлэнэ.\*\*\*

### **Өөрийн гэр бүл болон найз, ойр дотныхондоо мэдэгдэх эрх**

3 дугаар Женевийн Конвенцийн дагуу дайны олзлогдогсдыг баривчилж, олзолсны дараа эрх бүхий тал нь Хамгаалах тал, түүний гэр болон ойр дотныхонд нь энэ талаар мэдэгдэх үүрэгтэй. Хамгаалах тал гэдэг нь байлдагч талуудын аль алиных болон тэдний иргэдийн эрх ашгийг сахин хамгаалах үүрэг бүхий гуравдагч улсыг хэлдэг. 104 дүгээр зүйлд Хамгаалах талд хэрхэн мэдэгдэх талаар нарийвчилсан журмыг зааж өгсөн байдаг бөгөөд хэрэв холбогдох тал нь Хамгаалах талд мэдэгдээгүй нөхцөлд шүүх хурлыг хойшлуулах үүрэгтэй байдаг.

4-р Женевийн Конвенцийн дагуу Эзэлсэн талыг ноцтой хэргийн талаар Хамгаалах тал, гэр бүл болон найзуудад нь мэдэгдэх үүрэгтэй. Ийнхүү зохих ёсоор мэдэгдээгүй нөхцөлд Шүүх хурлыг эхлэхийг хориглодог.^ Уг 4-р Конвенцийн 76 дугаар зүйлд дайны олзлогсод нь гэр бүлийн гишүүд болон найзуудтайгаа уулзах эрхийн талаар зааж өгөөгүй ч Хамгаалах талын төлөөлөгчид болон Улаан загалмайн ажилчид тэдэн дээр очиж уулзах эрхтэй байдаг.^

### **32.2.2 Гэм буруутай нь нотлогдоогүй тохиолдолд гэм буруугүйд тооцогдох**

Олон улсын болон дотоодын зэвсэгт мөргөлдөөнд ч тэр хэн бүр нь гэм буруу нь шүүхээр тогтоогдтол гэм буруугүйд тооцогдох эрхтэй. Энэхүү эрх нь шүүхийн өмнөх болон шүүхийн явцад шүүхийн шийдвэр гаргал хадгалагдана. Олон улсын болон дотоодын зэвсэгт мөргөлдөөний үеэр гэмт хэрэгт яллагдаж байгаа хэн ч хуулийн дагуу гэм буруутай гэж тогтоогдтол гэм буруугүйд тооцогдох эрхтэй.^^

### **32.2.3 Өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх**

Олон улсын зэвсэгт мөргөлдөөний үеэр хэн ч өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх эрхгүй бөгөөд өөрийгөө гэм буруутай гэдгийг хүлээн зөвшөөрөх албагүй. +Гэм буруутайг нь хүлээн зөвшөөрүүлэх үүднээс тухайн иргэний хувьд бие махбодийн сэтгэлийн дарамт үзүүлэхийг хориглодог.++ Мөн түүнчлэн олон улсын бус зэвсэгт мөргөлдөөний үеэр ч хэн бүхэн нь өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх үүрэггүй.+++

### **32.3 Урьдчилан хорих үед эдлэх эрх**

Хэрэв баривчилж байгаа талын армийн бүрэлдэхүүний гишүүн нь ижил төрлийн гэмт хэргийн төлөө ийнхүү баривчилдаггүй бол Дайны олзлогдогсдыг шүүх хурлын өмнө баривчлахыг хориглосон байдаг.\*

### **Эрүү шүүлт болон хэргий хандахаас хамгаалах**

3-р Женевийн Конвенцид зааснаар дайны олзлогсдыг санаатайгаар алах, тэдэнд эрүү шүүлт тулгах, хүнлэг бусаар харьцах, биологийн туршилт хийх,

\*1дүгээр Нэмэлт Протоколын 75(4)(а) дугаар зүйл

\*\*Женевийн 3 дугаар Конвенцийн 105 дугаар зүйл

\*\*\* Женевийн 4 дүгээр Конвенцийн 71(2) дүгээр зүйл

^ Женевийн 4 дүгээр Конвенцийн 2 болон 3 дугаар хэсэг, 71 дүгээр зүйл

^^ Женевийн 4 дүгээр Конвенцийн 6 дугаар хэсэг, 76 дугаар зүйл

^^^1дүгээр Нэмэлт Протоколын 75(4)(г)дугаар зүйл, 2 дугаар Нэмэлт Протоколын 6(2)(г) дугаар зүйл

+1дүгээр Нэмэлт Протоколын 75(4)(е)дугаар зүйл

++ Женевийн 3 дугаар Конвенцийн 99 дүгээр зүйл

+++2 дугаар Нэмэлт Протоколын 6(2)(е) дугаар зүйл

\* Женевийн 3 дугаар Конвенцийн 1 дүгээр хэсэг, 105дугаар зүйл

\*\* Женевийн 3 дугаар Конвенцийн 130 дугаар зүйл

эрүүл мэнд болон сэтгэл санаанд нь ноцтой хохирол учруулах нь олон улсын эрх зүйг ноцтойгоор зөрчсөн хэрэг болно.\*\* Мөн түүнчлэн энгийн иргэдийн эсрэг дээрх үйлдлийг хийх нь 4-р Женевийн Конвенцийг зөрчсөн ноцтой үйлдэл болно.\*\*\*

\*\*\* Женевийн 4 дүгээр Конвенцийн 6 дугаар зүйл

Дайны олзлогсодод биед нь гэмтэл учруулах шийтгэл, харанхуй өрөөнд хорих, эрүү шүүлт тулгах, хэрцгий хандсан шийтгэл ногдуулж болохгүй.^

### *Эрүүл мэндийн тусламж, тусалцаа авах эрх*

Эзэлсэн талын эрх мэдэлд байгаа бөгөөд дайны олзлогсод нь тэдний эрүүл мэндийн байдалдаа нийцсэн эмнэлгийн тусламж авах эрхтэй.^^

^ Женевийн 3 дугаар Конвенцийн 3 дугаар хэсэг, 87 дугаар зүйл

### *Хорих газрын нөхцлийн талаар гомдол гаргах эрх*

Дайны олзлогсод нь сөрөг үр дагавар бий болно гэдгээс айхгүйгээр цэргийн эрх бүхий байгууллага, хорьж байгаа тал болон хамгаалах талд хорих газрын нөхцлийн талаар гомдол гаргах эрхтэй.^^^ Хэрэв хорих газрын нөхцөл нь олзлогсод эрүү шүүлт тулгах, хэрцгий хүнлэг бус хандах байдалтай бол тухайн хорих нь өөрөө хууль бус болно.

^^ Женевийн 4 дүгээр Конвенцийн 2 дугаар хэсэг, 76 дугаар зүйл

^^^ Женевийн 3 дугаар Конвенцийн 87 дугаар зүйл

### *Гэр бүл болон гадаад ертөнцтэй харьцах эрх*

Дайны олзлогсод нь гэр бол гадаад ертөнцтэй Хамгаалах талаар дамжуулан эсвэл шууд харьцах зарим нэгэн эрхийг эдэлдэг. 3-р Женевийн Конвенцийн 103 –р зүйлийн 3-т заасны дагуу захиа авах, явуулах эрх нь шүүх хурлаа хүлээж буй дайны олзлогсдийн эдлэх ёстой наад захын эрх гэжээ.+

+ Женевийн 3 дугаар Конвенцийн 3 дугаар хэсэг 103 дугаар зүйл

## **32.3.1 Эмэгтэйчүүдийг урьдчилан хорих**

Олон улсын зэвсэгт мөргөлдөөний үеэр хоригдож буй эмэгтэйчүүд онцгой хамгаалалтанд байна.++ Эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдээс тусад нь хорьж, тэдний харгалзагч нь эмэгтэй хүн байх ёстой. Гэвч боломжтой бол гэр бүлийг хамтад нь байлгаж болно.+++

++ 1 дүгээр Нэмэлт Протоколын 76(1) дугаар зүйл

+++ 1 дүгээр Нэмэлт Протоколын 75(5) дугаар зүйл

Сахилгын шийтгэл ногдуулсан эмэгтэй олзлогдогсдыг эрэгтэйчүүдээс тусад нь хорих бөгөөд мөн эмэгтэй харгалзагчийн хяналтанд байлгана.# Энэхүү заалт нь мөн шүүх хурлаа хүлээж буй эмэгтэй олзлогсод ч хамаарна.##

# Женевийн 3 дугаар Конвенцийн 97 дугаар зүйл

Эзэлсэн талаар баривчлуулсан энгийн эмэгтэй иргэдийг ч эрэгтэйчүүдээс тусад нь хорьж, харгалзагчаар нь эмэгтэй хүнийг томилно.\*

## **32.3.2 Хүүхдүүдийг урьдчилан хорих**

Олон улсын зэвсэгт мөргөлдөөний үед хүүхдүүдийг онцгой анхаарах хэрэгтэй.\*\*

## Женевийн 3 дугаар Конвенцийн 3 дугаар хэсэг 103 дугаар зүйл

### **Холбогдох хэм хэмжээ**

#### **Нэмэлт 1-р протоколын 75.5**

Зэвсэгт мөргөлдөөнтэй холбогдох шалтгаанаар эрх чөлөөг нь хязгаарласан эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдээс тусгай байранд байлгана. Тэднийг эмэгтэй харгалзагчийн шууд хараа хяналтанд байлгана. Гэхдээ албадан саатуулагдсан, тусгаарлагдан хоригдсон гэр бүлийг бололцоотой бол нэг газар, тус тусад нь гэр бүлийн байдлаар байршуулна.



Мөн Эзэлсэн тал хоригдсон түүнчлэн бага насны хүүхдийг анхаарах нь чухал.\*\*  
Хүүхдүүдийг гэр бүлтэй нь цуг байлгаагүй л бол хүүхдүүдийг насанд хүрсэн хүмүүсээс тусад нь байлгах хэрэгтэй.^

## 32.4 Шүүхэд эдлэх эрх

### 32.4.1 Хараат бус, шударга цэргийн шүүх

Олон улсын зэвсэгт мөргөлдөөний үеэр нөгөө талынхаа эрх мэдэлд байгаа хүн бүр нь шударга, хараат бус, шударга шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх эрхийг Нэгдүгээр нэмэлт Протоколд заасан байдаг.^ Уг Протоколд заасны дагуу шүүх нь голч бөгөөд байнгын үйл ажиллагаатай байх ёстой. Хэрэв холбогдох эзэлсэн аль эсвэл хорьж байгаа тал нь өөрийн цэргийн албан тушаалтнуудыг энгийн шүүхээр шүүгээгүй л бол Дайны олзлогсдыг цэргийн шүүхээр шүүх ёстой.^^

Ихэвчлэн энгийн иргэдийн хэргийг авч хэлэлцэх шүүхийн чадварлаг байдал, хараат бус болон голчийн байдал нь эзлэгдсэн нутаг дэвсгэрт хязгаарлагдмал байдаг. Ихэнх тохиолдолд эзлэгдсэн нутаг дэвсгэрт эрүүгийн хууль нь хүчин төгөлдөр хэвээр үйлчилдэг ч орон нутгийн шүүхүүд нь зарим нэгэн хязгаарлалттайгаар тус хуулийг хэрэглэх боломжтой байдаг . 4-р

Женевийн Конвенцийн дагуу хэрэв Эзэлсэн тал нь эрүүгийн хууль болон ял шийтгэлийн тухай орон нутгийн хуулийг хэрэглэх нь түүний аюулгүй байдал болон эл Конвенцийг хэрэглэхэд саад болохгүй л гэж үзэхгүй бол тухайн орон нутгийн эрүүгийн хууль, ял шийтгэлийн хууль, хэвээр үйлчилж шүүх нь хэвээрээ ажиллах болно гэжээ.+

Гэсэн хэдий ч шүүгчдийг ажлаас нь чөлөөлөхөөс хамгаалах зохицуулалт байдаг. Эзэлсэн тал нь албан үүргээсээ сайн дураараа үзэл бодлоын шалтгааны улмаас чөлөөлөгдөхийг хүссэн төрийн албан хаагчийг, эсвэл шүүгчийг шийтгэх, статусыг нь өөрчлөх эрхгүй. Гэвч энэ нь эзэлсэн талыг тухайн албан тушаалаас нь чөлөөлөхөд саад болох ёсгүй.++

Эзэлсэн тал нь тухайн нутаг дэвсгэрт удирдлагыг хангах болон өөрийн аюулгүй байдлыг хангах үүднээс эрүүгийн хууль шинээр баталж болно.+++ Энэ нөхцөлд тухайн улсын иргэдийг тус нутагт байгаа бөгөөд зохих ёсоор байгуулсан, улс төрийн бус цэргийн шүүхээр шүүж болно. Эдгээр шүүх нь эзэлсэн нутаг дэвсгэрт байрлах ёстой.#

### 32.4.2 Боломжит хугацаанд хэргээ шийдвэрлүүлэх эрх

Дайны олзлогсод нь хэргээ боломжит хугацаанд шийдвэрлүүлэх эрхтэй. Дайны олзлогсодтой холбоотой хэргийг нөхцөл байдал зөвшөөрч

\*Женевийн 4 дүгээр Конвенцийн 4 дүгээр хэсэг, 76 дугаар зүйл

\*\* 1 дүгээр Нэмэлт Протоколын 77(1), 77(2), 77(3) ба 77(5) дугаар зүйл

\*\*\*Женевийн 4 дүгээр Конвенцийн 5 дугаар хэсэг, 76 дугаар зүйл

^^ дүгээр Нэмэлт Протоколын 77(4) дугаар зүйл

^^1 дүгээр Нэмэлт Протоколын 77(4) дугаар зүйл

^^^ Женевийн 3 дугаар Конвенцийн 84 дүгээр зүйл

+Женевийн 4 дүгээр Конвенцийн 1 дүгээр хэсэг, 64 дүгээр зүйл

++Женевийн 4 дүгээр Конвенцийн 54 дүгээр зүйл

+++Женевийн 4 дүгээр Конвенцийн 2 дугаар хэсэг, 64 дүгээр зүйл

#Женевийн 4 дүгээр Конвенцийн 66 дугаар зүйл

#### Холбогдох хэм хэмжээ

##### 32.4.1 женевийн 3-р конвенцийн 84 дүгээр зүйл

Олзлогч гүрний хууль тогтоомжоор өөрийнхөө зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд хамаарах этгээдийг иргэний шүүхээр шийтгэх тусгай эрх олгогдоогүй тохиолдолд ижил төрлийн гэмт хэрэгт сэжиглэгдэж буй дайнд олзлогдогчийн хэргийг зөвхөн цэргийн шүүхээр шийдвэрлэнэ.

байвал аль болохоор хурдан шуурхай шийдвэрлэх хэрэгтэй.\*\* Мөн түүнчлэн эзэлсэн талын эрх мэдэлд байгаа иргэдийн хэргийг ч нэгэн адил шуурхай шийдвэрлэнэ.\*\*\*

\*\* Женевийн 3 дугаар Конвенцийн 1 дүгээр хэсэг 103 дугаар зүйл

### 32.4.3 Өмгөөлүүлэх эрх

#### Өөрийгөө өмгөөлөх эрх

Нэгдүгээр нэмэлт протоколд өөрийгөө өмгөөлөх эрхийг баталгаажуулсан байдаг бөгөөд үүнд заасны дагуу шүүхийн өмнөх ажиллагааны явцад болон шүүх хурлын явцад хэн бүр нь шаардлагатай эрхээ эдэлж, өмгөөлүүлэх эрхтэй.^

Дайны олзлогсод хэн бүрт өөрийгөө өмгөөлөх, эсвэл мэргэжлийн төлөөлөгчөөрөө дамжуулан төлөөлөх эрхийг олгохгүйгээр шийтгээ болохгүй.^

Дөрөвдүгээр Женевийн Конвенцийн дагуу мөн энгийн иргэдийн хувьд өөрийгөө хамгаалах хангалттай нотлох баримтыг бүрдүүлэх эрхийг, түүнчлэн гэрчийг дуудах эрхийг олгосон байдаг.^^

^ 1 дүгээр Нэмэлт Протоколын 75(4)(а) дугаар зүйл

^^ Женевийн 3 дугаар Конвенцийн 99 дүгээр зүйл

#### Яллагдагчийг байлцуулах

Олон улсын болон дотоодын зэвсэгт мөргөлдөөний үеэрх шүүх хурлыг яллагдагчийг байлцуулан явуулах хэрэгтэй.^^

^^ Женевийн 4 дүгээр Конвенцийн 72 дугаар зүйл

#### Өмгөөлөгч, Зөвлөх авах эрх

Гэмт хэрэгт яллагдаж буй дайны олзлогсод мэргэжлийн өмгөөлөгч болон зөвлөхийг сонгох олж авах эрхийг олгосон байдаг. Тухайн өмгөөлөгч, зөвлөх нь яллагдагчтай уулзах эрхтэй.^^^

^^ 1 дүгээр Нэмэлт Протоколын 75(4)(г) дугаар зүйл, 2 дугаар Нэмэлт Протоколын 6(2)(г) дугаар зүйл

#### Өмгөөлөлд бэлтгэх боломжит хугацаа болон нөхцлөөр хангагдах эрх

Дайны олзлогсдын өмгөөлөгчид нь шүүх хуралд бэлтгэх дор хаяж 2 долоо хоногийн хугацаа болон өмгөөлөлд бэлтгэх өрөөтэй байх эрхтэй. Мөн түүнчлэн дайны олзлогсодтой биечлэн дангаараа уулзах, гэрчтэй уулзах эрхтэй байж, тэрхүү өрөөг давж заалдах шатны шүүх хурал дуусах хүртэл ашиглах эрхтэй.\*

+++ Женевийн 3 дугаар Конвенцийн 105 дугаар зүйл

\* Женевийн 3 дугаар Конвенцийн 105 дугаар зүйл

#### Холбогдох хэм хэмжээ

##### Нэгдүгээр нэмэлт протоколын 75.4. а (Олон улсын зэвсэгт мөргөлдөөн)

“шүүхийн ажиллагааны явцад яллагдагч нь цаг алдалгүй ямар гэмт хэргийг түүнд тулгаж байгаа талаар мэдэх эрхтэй бөгөөд үндсэн эрхээ болон өмгөөлөгч авах эрхээ шүүхийн өмнөх болон явцад эдлэх эрхтэй.

##### 2-р Нэмэлт Протоколын 6.2. а (олон улсын бус зэвсэгт мөргөлдөөн)

“шүүхийн ажиллагааны явцад яллагдагч нь цаг алдалгүй ямар гэмт хэргийг түүнд тулгаж байгаа талаар мэдэх эрхтэй бөгөөд үндсэн эрхээ болон өмгөөлөгч авах эрхээ шүүхийн өмнөх болон явцад эдлэх эрхтэй.

Өөрийгөө хамгаалахад бэлтгэх хангалттай цагтай байх болон өрөө, тоног төхөөрөмжөө хангагдах эрх

### ***Гэрчийг олж илрүүлэх, гэрчтэй уулзах эрх***

Олон зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотой гэмт хэрэгт яллагдаж байгаа хэн ч өөрийн болон эсрэг талын гэрчийн мэдүүлгийг ашиглах, тэднийг шүүх хуралд оролцуулах эрхтэй.\*\*

Гэмт хэрэгт ял тулгуулсан дайны олзлогсод нь гэрчийг дуудуулан хуралд оролцуулах эрхтэй.\*\*\*

### ***Орчуулгатай байх эрх***

Дайны олзлогсод нь шаардлагатай бол орчуулагчийн үйлчилгээ авах эрхтэй.^

### ***Ил тод шүүх хурал болон шүүхийн шийдвэрийн талаар эдлэх эрх***

Олон улсын зэвсэгт мөргөлдөөний үеэр ял тулгуулсан хэн бүхэн нь шүүх хурлаа нээлттэй явуулах, шийдвэрээ нийтэд мэдээллэхийг шаардах эрхтэй.^

Хэдий Женевийн 3 дугаар Конвенцид дайны олзлогсдын хувьд шүүх хурлыг ил тод нээлттэй явуулах талаар шууд заагаагүй ч хэрэв үндэсний аюулгүй байдлын асуудлаас болж хаалттай л болоогүй бол Хамгаалах талын төлөөлөгчид хуралд оролцох, сонсох эрхтэй.^^ Шүүх хуралдааны шийдвэр болон давж заалдах эрхийн талаар нэн даруй Хамгаалах тал, дайны олзлогсдын төлөөлөгчид болон түүнд өөрт өөрийн ойлгож буй хэлээр мэдэгдэх ёстой.+

### ***Давж заалдах эрх***

Дайны олзлогсод нь олзолсон талын цэргийн бүрэлдэхүүний хүмүүстэй адил давж заалдах эрхтэй байх бөгөөд тэдэнд энэ талаар мэдэгдсэн байх ёстой.++

Хэдий 1 дүгээр нэмэлт протоколд давж заалдах эрхийн талаар заагаагүй ч дайны олзлогсодод шүүхийн шийдвэр, авах арга хэмжээ, цаг хугацааг нь хэлэх ёстой.+++ Олон улсын бус зэвсэгт мөргөлдөөний хувьд 2 дугаар нэмэлт протоколд төстэй заалт байдаг.#

## **32.4.4 Нэг хэрэгт хоёр удаа шийтгүүлэхээс хамгаалах**

Нэгдүгээр нэмэлт протоколд заасны дагуу хэнийг ч өмнө нь хэргийг авч шийдвэрлүүлсэн хууль, шүүхээр дахин мөрдөн мөшгөж, шүүж болохгүй.## Гуравдугаар Женевийн Конвенцийн дагуу хэнийг ч нэг үйлдлийн төлөө нэгээс дээш дахин шийтгэж болохгүй.###

## **32.4.5 Хуульд болон ялыг буцаан хэрэглэхээс хамгаалах**

Олон улсын зэвсэгт мөргөлдөөний аль нэг талын мэдэлд байгаа хэнийг ч тухайн үд нь үндэсний хийгээд олон улсын эрх зүйн дагуу гэмт хэрэгт тооцдоггүй байсан үйлдэл, эс үйлдлийн төлөө ял шийтгэж болохгүй.\*

Тухайн үеэд нь гэмт хэрэгт тооцогддоггүй байсан үйлдэл эс үйлдлийн төлөө мөн дайны олзлогсдыг шийтгэж болохгүй.\*\*

\*Женевийн 3 дугаар Конвенцийн 105 дугаар зүйл

\*\* 1 дүгээр Нэмэлт Протоколын 75(4)(е) дугаар зүйл

\*\*\* Женевийн 3 дугаар Конвенцийн 1 дүгээр хэсэг, 105 дугаар зүйл

^ Женевийн 3 дугаар Конвенцийн 1 дүгээр хэсэг, 105 дугаар зүйл

^^ 1 дүгээр Нэмэлт Протоколын 75(4)(з) дугаар зүйл

^^ Женевийн 3 дугаар Конвенцийн 105 дугаар зүйл

+ Женевийн 3 дугаар Конвенцийн 107 дугаар зүйл

++ Женевийн 3 дугаар Конвенцийн 106 дугаар зүйл

+++ 1 дүгээр Нэмэлт Протоколын 75(4)(з) дугаар зүйл

# 2 дугаар Нэмэлт Протоколын 6(3) дугаар зүйл

## 1 дүгээр Нэмэлт Протоколын 75(4)(ж) дугаар зүйл

### Женевийн 3 дугаар Конвенцийн 86 дугаар зүйл

\* 1 дүгээр Нэмэлт Протоколын 75(4)(в) дугаар зүйл

\*\* Женевийн 3 дугаар Конвенцийн 99 дүгээр зүйл

\*1 дүгээр Нэмэлт Протоколын  
75(4)(в) дугаар зүйл

\*\* Женевийн 3 дугаар  
Конвенцийн 99 дугаар зүйл

\*\*\* Женевийн 4 дүгээр  
Конвенцийн 65 дугаар зүйл

^ Женевийн 4 дүгээр  
Конвенцийн 67 дугаар зүйл

^^ 2 дугаар Нэмэлт Протоколын  
6(2)(в) дугаар зүйл

^^^ Женевийн 3 дугаар  
Конвенцийн 87 дугаар зүйл

+ Женевийн 3 дугаар  
Конвенцийн 87 дугаар зүйл

++ Женевийн 3 дугаар  
Конвенцийн 103 дугаар зүйл

+++ Женевийн 3 дугаар  
Конвенцийн 85 дугаар зүйл

# Женевийн 3 дугаар  
Конвенцийн 88 дугаар зүйл

## Женевийн 4 дүгээр  
Конвенцийн 76 дугаар зүйл

### 1 дүгээр Нэмэлт Протоколын  
75(4)(в) дугаар зүйл, 2 дугаар  
Нэмэлт Протоколын 6(2)(в)  
дугаар зүйл

\* 1 дүгээр Нэмэлт Протоколын  
75(4)(б) дугаар зүйл

\*\* Женевийн 3 дугаар  
Конвенцийн 87 дугаар зүйл

\*\*\* Женевийн 4 дүгээр  
Конвенцийн 33 дугаар зүйл

Мөн түүнчлэн Женевийн 4 дүгээр Конвенцид эзлэгдсэн нутаг дэвсгэрт энгийн иргэдийн эсрэг хуульд заагаагүй гэмт хэргийн төлөө шийтгэхээс хамгаалах зохицуулалт бий. Эзэлсэн талын эрүүгийн хууль болон хариуцлагын тухай хууль нь тухайн нутгийн иргэдийн хэлээр нийтэд мэдээлснээс хойш л хүчин төгөлдөр үйлчилнэ. Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэж болохгүй.\*\*\*

Эзэлсэн талын шүүх нь зөвхөн гэмт хэргээс өмнө үйлчилж эхэлсэн хуулийг л хэрэглэх ёстой.^

Хоёрдугаар нэмэлт протоколын дагуу мөн тухайн үеэдээ үндэсний хууль тогтоомж болон олон улсын эрх зүйн дагуу гэмт хэрэгт тооцогддоггүй байсан үйлдэл эс үйлдлийн төлөө хэнийг ч шийтгэж болохгүй гэж заасан байдаг.^

## 32.5 Цаазаар авах ялгүй хэрэгт ял шийтгэх

Дайны олзлогсодод тэднийг олзолсон улсын цэргийн бүрэлдэхүүний гишүүдийг ялладаг гэмт хэргээс өөр гэмт хэргийн төлөө шийтгэл ногдуулж болохгүй.^^

Олзолсон талын шүүх болон эрх бүхий байгууллага нь холбогдох хүний хэргийг шүүхдээ тухайн хүн нь тухайн олзолсон талын иргэн бус, ямарваа нэгэн холбоогүй, мөн зөвхөн зэвсэгт мөргөлдөөний улмаас олзлогдсон гэдгийг нь харгалзан үзэх ёстой. Тухайн шүүх болон эрх бүхий байгууллага нь дайны олзлогсодод тулгаж байгаа гэмт хэргийн төлөө ялыг хөнгөрүүлэх эрхтэй ч хамгийн бага ялыг ногдуулах албагүй.+

Дайнд олзлогдогсдын шүүх хурлаас өмнө баривчлагдсан хугацааг түүнийг хорих ялын хугацаанаас хасах бөгөөд энэ байдлыг мөн хариуцлага ногдуулахад нь харгалзана.^^

Дайнд олзлогсдыг баривчлагдахаасаа өмнө үйлдсэн гэмт хэрэгт ч 3-р Женевийн конвенцийн хамгаалалт үйлчлэх болно.+++ Ялаа эдэлсэн хэнийг ч дайны олзлогсодоос ялган харьцаж болохгүй.#

4-р Женевийн Конвенцид заасны дагуу энгийн иргэдийг шүүж байгаа шүүх нь эрх зүйн ерөнхий зарчимтай нийцэж буй хуулийг хэрэглэх ёстой бөгөөд шийтгэлийг тэдний гэмт хэрэгт нийцүүлэн ногдуулах үүрэгтэй гэжээ.##

Нэгдүгээр болон Хоёрдугаар нэмэлт Протоколд заасны дагуу гэмт хэргийг үйлдэх үед нь ногдуулж байсан шийтгэлээс илүү хүнд шийтгэл ногдуулж болохгүй талаар заасан байдаг. Хэрэв гэмт хэрэг үйлдсэнээс нь хойш үндэсний хуулиар нь тухайн гэмт хэргийн төлөө ялыг нь багасгасан тохиолдолд тухайн багасгасан ялыг нь хэрэглэвэл зүйтэй.

### 32.5.1 Хоморголон шийтгэхийг хориглох тухай

Олон улсын зэвсэгт мөргөлдөөний тухай Нэгдүгээр нэмэлт протоколд заасны дагуу хэнийг ч нийтэд ногдуулсан ялаар шийтгэж болохгүй.\* Өөрөөр хэлбэл хүн бүрт нь тусад шийтгэл ногдуулах ёстой.\*\*

Олон улсын бус зэвсэгт мөргөлдөөнд мөн энэ заалтыг оруулсан байдаг Эзэлсэн нутаг дэвсгэрт мөн энгийн иргэдийг зөвхөн үйлдсэн гэмт хэргийнх нь төлөө шийтгэх ёстой бөгөөд нийтийг хамруулан шийтгэх, терроризмыг хориглосон байдаг.\*\*\*

## 32.6 Цаазаар авах ялтай хэргүүд

Цаазаар авах ялтай хэргүүд

Цаазаар авах ялыг халаагүй улс орнуудад олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн дагуу цаазаар авч болох хэргүүдийг хатуу тогтоож өгсөх ёстой. Эдгээр хязгаарлалт нь шүүхээр хэргээ шударгаар шүүлгэх хүний эрхийн баталгаа, хүний эрх, олон улсын стандартын өндөр ач холбогдолтой. (Цаазаар авах ялтай хэргүүд, 28 дугаар бүлэг)

Югослав, Руандын аль алины Цэргийн шүүхийн дүрэмд төрлөөр устгах, хүн төрөлхтөний эсрэг гэмт хэрэг, хүмүүнлэгийн эрх зүйг ноцтойгоор зөрчсөний төлөө цаазаар авах ял ногдуулахыг заагаагүй. ОУЭШ-ийн Дүрэмд мөн цаазаар авах ялыг ногдуулахгүй гэж заасан байдаг.

### *Дайны олзлогсод*

Женевийн 3-р конвенцоор дайны олзлогсодод ногдуулж болох нөхцлийг хязгаарласан байдаг.

Үйлдсэн эрх зүйн зөрчил нь олзлогч гүрний хуулиар цаазаар авах ялтай болохыг олзлогсодод ба хамгаалагч гүрэнд нэн даруй мэдэгдвэл зохионо. Дайны олзлогсодод баривчлагдсаных нь дараа нэн даруй энэ талаар мэдэгдэх ёстой бөгөөд ийнхүү мэдэгдсэний дараа үйлдсэн гэмт хэрэгт цаазаар авах ял ногдуулж болно.

Олзлогч тал нь Хамгаалах талд мэдэгдэхгүйгээр цаазаар авах ялтай хэргийн тоог нэмэгдүүлж болохгүй. Энэ нь дайны олзлогсодыг эзэлсэн талын түр хугацааны (ad hoc) хуулиас хамгаалах зорилготой .

Өнөө үед цаазаар авах ялтай хэргийн тоог нэмэх нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн болон НҮБ-ын Хүний эрхийн комиссын цаазаар авах ялыг ирээдүйд халах бодлого болон ИУТЭОУП, Америкийн конвенцтой зөрчилдөх болно. (Цаазаар авах ялтай хэргүүд, 28 дугаар бүлэг)

3-р Женевийн Конвенцийн 100-р зүйлд Цаазаар авах ялыг ногдуулахын өмнө нь шүүх нь тухайн олзлогдогч нь өөр улсын эрх мэдэлд байсан бөгөөд сайн дураараа баривчлагдаагүй гэдгийг анхаарах ёстой. Даргалагч шүүгч нь уг нөхцлийг чухалчилж үзэх ёстой.

\*\*\* Женевийн 4 дүгээр  
Конвенцийн 65 дугаар зүйл





**ШУДАРГААР  
ШҮҮЛГЭХ ЭРХ**

---

# **ХАВСРАЛТ**

---

- ХАВСРАЛТ 1**      **Хүний эрхийн Хорооноос баталсан  
Ерөнхий Тайлбар**
- ХАВСРАЛТ 2**      **Хүний болон Ард түмний эрхийн Африкийн  
Комиссийн Шударга шүүх, Гомдол хэлэлцэх  
ажиллагааны эрхийн тухай Тогтоол**





## ХАВСРАЛТ 1

### Хүний эрхийн Хорооноос баталсан Ерөнхий Тайлбар

НҮБ-ын Хүний Эрхийн Хорооноос баталсан Иргэний болон улс төрийн эрхийн Олон улсын Пактыг тайлбарлахад удирдлага болгох тайлбараас сонгон авсан хэсгүүд (UN Doc. HRI/GEN/1/Rev.3, 15 August 1997)

#### Ерөнхий Тайлбар 6 (6 дугаар зүйл)

3. 6(1) дугаар зүйлийн гуравдахь өгүүлбэрт тодорхой шаардсаны дагуу шүүхийн шийдвэрээс гадуур хүний амь насыг хороох явдлаас хамгаалах асуудал нь нэн тэргүүний ач холбогдол бүхий асуудал болдог. Гишүүн Улсууд нь эрүүгийн шинжтэй үйлдлээр хүний амь насыг хороох явдлыг зогсоож шийтгэхээс гадна мөн өөрсдийн хүчний байгууллагын ажилтнууд дур зоргоор хүний амь насыг хороох явдлыг зогсоох арга хэмжээг авах ёстой гэж Хорооноос үзэж байна. Төрийн эрх мэдэл бүхий байгууллагын зүгээс хүний амь насыг хороох явдал нь маш ноцтой асуудал юм. Тиймээс, эрх бүхий байгууллагын зүгээс хүний амь насыг хороож болох нөхцөл байдлыг хуулиар хянаж хатуу хязгаарлах ёстой.

6. 6 дугаар зүйлийн 2-оос 6 дахь заалтуудад гишүүн Улсууд цаазаар авах ялаас бүрэн татгалзах үүрэггүй боловч түүнийг хязгаартай хэрэглэх үүрэгтэй, ялангуяа “онц хүнд гэмт хэргээс” бусад тохиолдолд түүнээс татгалзах үүрэгтэй. Үүний дагуу Улсууд өөрийн эрүүгийн хуулиа эргэн хянаж үзэх шаардлагатай бөгөөд ямар ч тохиолдолд цаазаар авах ялыг “онц хүнд гэмт хэрэгт” хэрэглэхийг хориглох үүрэг хүлээнэ. Энэхүү зүйл нь ийнхүү татгалзах явдлыг (2(2) болон (6) заалтууд) хүслийн дагуу хийнэ гэдгийг хатуу санал болгож байгаа юм. Татгалзах явдлын бүх арга хэмжээг 40 дүгээр зүйлийн санааны хүрээнд амьд явах эрхийг эдлэх асуудалд дэвшил болж байгаа хэмээн Хорооноос дүгнэж энэ талаар Хороонд илтгэх ёстой. Хорооноос мэдэгдсэнээр хэд хэдэн улс цаазаар авах ялаас татгалзсан эсвэл хэрэглэхийг зогсоосон байна. Хэдийгээр тийм боловч цаазаар авах ялыг хэрэглэх явдлыг зогсоох эсвэл хязгаарлах чиглэлд хийсэн алхмууд нь хангалтгүй байгаа гэдэг нь Улсуудын илгэл тайлангаас харагдаж байна.

7. Хорооноос “онц хүнд гэмт хэрэг” гэдэг нэр томъёог цаазаар авах ял бол маш онцгой арга хэмжээ гэсэн утгын хүрээнд ойлгож хэрэглэнэ гэсэн үзэл санааг баримталдаг. Мөн 6 дугаар зүйлд зааснаар уг ялыг гагцхүү гэмт хэрэг үйлдэх үед хүчин төгөлдөр үйлчилж байсан хуулийн дагуу боловч Пактад харшлахгүйгээр ногдуулна гэжээ. Ингэхдээ бае даасан шүүхээр хэргээ шударгаар хэлэлцүүлэх, гэм буруу нь тогтоогдохоос өмнө гэм буруутайд тооцогдохгүй байх, хамгаалалтын наад захын баталгаа, хэргээ дээд шатны шүүхээр хянуулах зэрэг асуудлыг хамарсан журамыг баримтлах баталгаагаар хангах ёстой. Эдгээр эрхийг уучлал хүсэх эсвэл ялыг хөнгөрүүлэх зэрэг тусгай эрхийн зэрэгцээ нэмж хэрэгжүүлэх боломжтой юм.

#### Ерөнхий Тайлбар 8 (9 дүгээр зүйл)

1. Хүний эрх чөлөө болон аюулгүй байдлын тухай заасан 9 дүгээр зүйлийг гишүүн Улсууд явцуу байдлаар тайландаа тусгадаг учир бүрэн мэдээллийг өгдөггүй юм. Хороо заасны дагуу 1 дэх заалтыг эрүүгийн болон бусад, тухайлбал сэтгэцийн өвчин, тэнүүчлэл, мансуурах бодисонд донтох, боловсролын асуудалтай, цагаач иргэдэд тавих хяналтын асуудлыг хөндсөн хэрэгт эрх чөлөөг хязгаарлах бүх явдалд хэрэглэнэ. 9 дүгээр зүйлийн зарим заалтыг /2 дахь заалтын хэсэг болон 3 дахь заалт бүхэлдээ/ зөвхөн эрүүгийн гэмт хэрэгт яллагдсан хүнд хэрэглэж болохоор байгаа нь үнэн юм. Гэвч

бусдыг нь, ялангуяа 4 дэх заалтад заасан чухал баталгааг, жишээлбэл, хуулийн үндэслэлтэй хоригдож байгааг шүүхээр хянаж шалгуулах эрх, баривчлагдаж эсвэл хоригдож эрх чөлөөгөө хязгаарлуулсан бүх хүмүүст хэрэглэх боломжтой юм. Цаашилбал, 2(3) дугаар зүйлийн дагуу гишүүн Улсууд Пактыг зөрчиж эрх чөлөөг нь хязгаарласан гэж гомдоллож буй хувь хүмүүсийн гомдлоос бусад тохиолдолд шүүхийн үр дүнтэй хамгаалалтыг баталгаатай болгох үүрэгтэй.

2. 9 дүгээр зүйлийн 3 дахь заалтын дагуу эрүүгийн хэрэгт холбогдож баривчлагдсан эсвэл хоригдсон хүнийг нэн даруй шүүхээр эсвэл шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх хуулиар эрх олгогдсон эрх бүхий байгууллагаар хэлэлцүүлэхийг шаарддаг. Ихэнх гишүүн Улсад цаг хугацааны нарийн хязгаарлалтыг хуулиар тогтоосон байдаг бөгөөд Хорооны зорилгод нийцүүлэн энэ нь цөөхөн хэдэн хоногоос хэтэрдэггүй. Олон улс энэ асуудалтай холбоотой бодит байдлын талаар хангалттай мэдээлэл өгдөггүй.

3. Шүүн таслах ажиллагааны өмнө хорих нийт хугацааны тухай асуудал нь анхаарал татаж буй бас нэг асуудал юм. Зарим улсад зарим тодорхой төрлийн гэмт хэрэгт тогтоосон хугацаа Хорооны анхаарлыг татаж байгаа учир гишүүн Улсуудаас тэдний үйл ажиллагаа нь 3 дахь заалтад заасан “зохих хугацаанд шүүн хэлэлцүүлэх эсвэл суллагдах” гэсэн эрхтэй ямар хэмжээнд нийцэж байгааг асуусан байдаг. Шүүхээс өмнө хоригдох хугацаа нь тодорхой бөгөөд аль болох богино байх ёстой. Шүүхээс өмнө хорих хугацааг багасгах зорилгоор авч буй арга хэмжээ мөн үйлчилж буй журамын талаархи мэдээллийг Хороонд нээлттэй хүлээж авдаг.

### **Ерөнхий Тайлбар 13 (14 дүгээр зүйл)**

4. 14 дүгээр зүйлийн заалт нь тухайн зүйлд заасан энгийн болон тусгай бүх төрлийн шүүхийг хамаарна. Хорооны тэмдэглэж буйгаар олон улс оронд энгийн иргэдийн хэргийг таслан шийдвэрлэдэг цэргийн буюу тусгай шүүх ажиллаж байна. Энэ байдал нь тэгш, хараат бус болон бие даасан шүүх ажиллагааны асуудлыг хөндөж байгаа учир ноцтой байдлыг бий болгох талтай юм. Ийм шүүх байгуулах шалтгаан нь ихэнхдээ шүүх ажиллагааны ердийн стандарттай нийцэхгүй онцгой ажиллагаа явуулж хэрэглэх боломжийг бүрдүүлэх гэсэн явдал байдаг. Хэдийгээр Пактад ийм төрлийн шүүхийг хориглоогүй ч энгийн иргэдийн хэргийг шүүн таслах ажиллагааны нөхцөл нь маш онцгой байж 14 дүгээр зүйлд заасан бүх баталгааг бодитоор олгосон байх ёстой гэж тодорхой заах ёстой. Энгийн иргэдийн хэргийг ийм шүүхээр хэлэлцдэг зарим гишүүн Улсууд энэ асуудалтай холбоотой мэдээллээр бүрэн хангадаггүй гэж Хорооноос тэмдэглэжээ. Зарим улсад иймэрхүү цэргийн болон тусгай шүүх нь шүүн таслах ажиллагааг 14 дүгээр зүйлд заасан хүний эрхийг үр дүнтэй хамгаалахад зайлшгүй хэрэгтэй шаардлагын дагуу зохистой байдлаар явуулдаггүй. Гишүүн Улс 4 дүгээр зүйлд дурдсан нийтийн онцгой байдлын нөхцөлд 14 дүгээр зүйлээр шаардсан энгийн шүүн таслах ажиллагааг хялбарчилж багасгах шийдвэр гаргасан тохиолдолд бодит нөхцлийн дагуу тулгарсан байдлыг хэтрүүлэхгүй байх баталгаа гаргах бөгөөд 14 дүгээр зүйлийн 1 дэх заалтад заасан бусад нөхцлийг хүндэтгэн үзнэ.

5. 14 дүгээр зүйлийн 1 дэх заалтын эхний өгүүлбэрт “хүн бүр шударга болон нийтэд нээлттэй шүүхэд хэргээ хэлэлцүүлэх эрхтэй” гэж заасан. Уг зүйлийн 3 дахь заалтад “шударга шүүхэд хэргээ хэлэлцүүлэх” шаардлагыг эрүүгийн хариуцлагыг тодорхойлоход нарийн тогтоож өгсөн. Гэвч 3 дахь заалтын шаардлагууд нь 1 дэх заалтын дагуу шаардсан шүүх ажиллагааны шударга байдлыг хангахад ямагт хангалттай байж чаддаггүй хамгийн бага баталгаа болдог юм.

6. Шүүн таслах ажиллагаа нийтэд нээлттэй байх шаардлага нь юуны өмнө

хувь хүний, цаашилбал нийгмийн, ашиг сонирхолын чухал хамгаалалт болдог. Үүний зэрэгцээ 14 дүгээр зүйлийн 1 дэх заалтад тухайн заалтад тусгасан үндэслэлээр шүүх нь олон нийтийг хэсэгчилэн эсвэл бүхэлд нь оролцуулахгүй байх эрх мэдэлтэй гэж тайлбарласан байдаг. Ийм онцгой нөхцөл байдлаас гадна Хорооны үзэж буйгаар шүүн таслах ажиллагаа нь ерөнхийдөө хэвлэл мэдээллийн хүмүүст нээлттэй байж зөвхөн тодорхой төрлийн хүмүүсийн оролцоогоор хязгаарлагдах ёсгүй юм. Хэргийг нийтэд нээлттэй хэлэлцэхгүй тохиолдолд ч шүүхийн шийдвэр нь зарим тодорхой заасан онцгой хэргээс бусад тохиолдолд нийтэд нээлттэй болох ёстой.

7. 14 дүгээр зүйлийн 2 дахь заалттай холбоотой мэдээлэл дутагдаж байгаа талаар Хорооноос мэдэгдэж байсан бөгөөд хүний эрхийг хамгаалах асуудлын үндэс болох шүүхийн шийдвэр гарахаас өмнө гэм буруугүйд тооцох тухай зарчмыг маш ойлгомжгүй утгаар илэрхийлэх эсвэл түүнийг үр дүнгүй болгох нөхцлийг бүрдүүлэх байдал ажиглагдаж байв. Уг зарчмын улмаас ялын нотолгооны асуудал яллагчид ногдож шүүгдэгч эргэлзэх байдалд хүрч байна. Үндэслэл бүхий эргэлзээг нотлохоос наана гэм буруутай гэсэн ялыг ногдуулж болохгүй. Түүнчилэн шүүхээс өмнө гэм буруугүй гэж үзнэ гэдэг нь уг зарчимд нийцүүлэн шүүгдэх эрхийг илэрхийлдэг. Тиймээс шүүх ажиллагааны үр дүнг урьдчилан шийдвэрлэх явдлаас татгалзах нь төрийн эрх бүхий байгууллагын үүрэг юм.

8. 3 дахь заалтад заасан эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагааны наад захын баталгааны эхнийх нь хүн бүрийн түүнд тулгаж буй ялын тухай өөрийнх нь ойлгодог хэлээр мэдэгдэх эрхийн асуудалтай холбоотой юм /(а) дэд заалт/. Тухайн эрхийг хэр зэрэг хүндэтгэн үзэж баталгаажуулдаг талаар Улсууд ихэнх тохиолдолд тайлбар өгдөггүй гэдгийг Хорооноос тэмдэглэж байна. 14 дүгээр зүйлийн (3) (а) заалтыг хоригдоогүй байгаа хүнийг оролцуулан эрүүгийн хэрэг үйлдсэн гэж ял тулгасан бүх тохиолдолд хэрэглэдэг. Хорооноос тэмдэглэснээр тулгаж буй ялын талаар “нэн даруй” мэдээлэл авах эрхийн дагуу эрх бүхий байгууллагаас анх ял тулгумагц тайлбарлах аргаар мэдээлэл өгөхийг шаарддаг. Хорооны үзэж буйгаар энэхүү эрх нь мөрдөн байцаалтын явцад шүүх эсвэл яллах эрх бүхий байгууллага гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа хүний эсрэг шүүн таслах ажиллагаа явуулах шийдвэр гаргах эсвэл түүнийг тийнхүү сэжиглэж байгаа гэдгийг олон нийтэд зарлах үед үүсдэг. Мэдээлэлд хууль тогтоомж болон түүний үндэслэл болох нотлогдсон баримтыг заасан нөхцөлд ялыг амаар эсвэл бичгээр илэрхийлснээр 3(а) дэд заалтын онцгой шаардлагыг хангах боломжтой юм.

9. 3(б) дэд заалтад зааснаар шүүгдэгчид өмгөөлөлд бэлтгэх мөн өөрийн сонгосон өмгөөлөгчтэй уулзах боломжит цаг хугацаа гаргаж зохих хэрэгслээр хангах ёстой. “Боломжит цаг хугацаа” гэдэг нь хэрэг бүрийн нөхцөл байдлаас хамаарах боловч хэрэгсэл гэдэгт шүүгдэгч хэргээ хэлэлцүүлэхэд бэлтгэх ажилд шаардлагатай баримт бичиг болон бусад нотлох баримтыг олж авах мөн түүнчилэн өмгөөлөгчтэй болж түүнтэй уулзах зэрэг асуудлыг хамруулж ойлгох ёстой. Шүүгдэгч өөрийгөө өөрийн биеэр хамгаалахыг хүсэхгүй байх эсвэл өөрийн сонгосон хэн нэгэн буюу байгууллагаар хамгаалуулах хүсэлт гаргах тохиолдолд түүнийг хуульчийн туслалцаа авах боломжоор хангах ёстой. Цаашилбал, уг дэд заалтын дагуу өмгөөлөгчөөс уулзалтын талаархи нууцлалыг хадгалах нөхцөлтөйгөөр шүүгдэгчтэй харилцахыг шаарддаг. Өмгөөлөгч нь тогтоосон мэргэжлийн стандарт болон шийдвэрийн дагуу ямар нэгэн байгууллагын зүгээс аливаа хориг, нөлөө, дарамт шахалт эсвэл хөндлөнгийн оролцоогүйгээр өөрийн үйлчлүүлэгчид зөвлөгөө өгч, төлөөлөх боломжтой байх ёстой.

10. 3(в) дэд заалтад зааснаар шүүгдэгчийг шаардлагагүйгээр сунжруулахгүйгээр шүүх ёстой. Энэхүү баталгаа нь зөвхөн шүүн таслах ажиллагаа эхлэх

хугацаатай холбоотой бус мөн шүүн таслах ажиллагаа дуусах, шийдвэр гарах хугацаатай холбоотой бөгөөд шүүн таслах ажиллагааны бүх үе шат “шаардлагагүй сааталгүйгээр” явагдах ёстой. Уг эрхийг хэрэгжүүлэхийн тулд анхан шатны болон давж заалдах шатны шүүн таслах ажиллагаа “шаардлагагүй сааталгүйгээр” явагдана гэдгийг баталгаажуулах үүднээс шүүн таслах ажиллагааг зохих журмаар явуулах боломжийг бий болгох ёстой.

11. 3(г) дэд заалтад тогтоосон өмгөөлөлийн эрхийн бүх асуудлыг тайлан бүрт тусгаагүй байна. Шүүгдэгчид тулгаж буй аливаа ялыг тодорхойлох үед өөрийн биеэр байлцах эрхийн асуудал мөн өөрөө өөрийгөө өмгөөлөх эсвэл өөрийн сонгосон өмгөөлөгчийн туслалцаа авах эрхтэй холбоотой хуулийн баталгаа, эсвэл тухайн хүн эрх зүйн туслалцааны төлбөрийг хийх хангалттай мөнгөгүй бол ямар зохицуулалт хийгдэх зэрэг асуудлаар Хороо төдийлөн хангалттай мэдээлэл авдаггүй. Шүүгдэгч болон түүний өмгөөлөгч бүхий л боломжийн хамгаалалтыг хэрэглэхдээ хичээл зүтгэл гаргаж айдасгүйгээр ажиллах эрхтэй байх бөгөөд хэргийг шударга бусаар шүүж байна гэсэн итгэлтэй байх тохиолдолд хэргийг авч хэлэлцэх явцад маргалдах эрхээр хангагдах ёстой. Аль нэг оролцогчийг байхгүй үед хуулийн үндэслэлтэйгээр шүүн таслах ажиллагааг явуулах онцгой тохиолдолд өмгөөллийн эрхийг хатуу баримтлах явдал хангалттай зүйл болдог.

12. 3(д) дэд заалтад зааснаар шүүгдэгч өөрийнх нь эсрэг мэдүүлэг өгч байгаа гэрчийг байцаах эсвэл байлцаалтад оруулах эрхтэй байх бөгөөд түүний эсрэг гэрчтэй адил нөхцөлтөйгөөр гэрчийн байцаалтад биеэрээ оролцож байцаах эрхтэй байна. Энэхүү заалт нь гэрчийг шүүн таслах ажиллагаанд албадан оролцуулах, яллах ажиллагаанд хэрэгтэй аливаа гэрчийг байцаах эсвэл зэрэгцэн байцаах хууль ёсны адил эрхээр шүүгдэгчийг хангах зорилготой юм.

13. 3(е) дэд заалтад зааснаар шүүгдэгч шүүхэд хэрэглэж буй хэлийг ойлгохгүй эсвэл ярьж чадахгүй тохиолдолд түүнд үнэ төлбөргүйгээр хэлмэрчийн туслалцаа авах эрх олгодог. Энэхүү эрх нь шүүн таслах ажиллагааны үр дүнгээс үл хамаарах бөгөөд гадаадын иргэн болон тухайн улсын иргэнийг шүүн таслах ажиллагаанд хэрэгждэг. Шүүн таслах ажиллагааг явуулж буй хэлийг үл тоож хэргийг хэлэлцэх эсвэл шүүн таслах ажиллагааг ойлгоход учруулж байгаа бэрхшээл нь өмгөөллийн эрхэд саад болж байгаа тохиолдолд хэлний асуудал ноцтой асуудал болдог.

14. 3(ё) дэд заалтад зааснаар шүүгдэгчийг өөрийн эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах эсвэл гэм буруу хүлээлгэж болохгүй. 7 болон 10 дугаар зүйлийн 1 дэх заалтад тусгасан хамгаалалтыг ямагт анхааран санах ёстой. Шүүгдэгчид өөрийнх нь эсрэг мэдүүлэг өгүүлэхээр албадах эсвэл гэм буруу хүлээлгэх зорилгоор дээрхи заалтуудыг зөрчих тохиолдол гардаг. Хуулийн дагуу ийм аргаар эсвэл шахалт дарамт үзүүлэн гаргаж авсан нотлох баримтыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй байхыг шаардана.

15. 14 дүгээр зүйлийн 1 болон 3 дахь заалтуудад заасан эрхийг хамгаалах үүднээс шүүн таслах ажиллагааны явцад шүүгдэгчийн эрхийг зөрчсөн аливаа гомдлыг шүүгч авч хэлэлцэх ёстой.

16. 14 дүгээр зүйлийн 4 дэх заалтад зааснаар насанд хүрээгүй хүний хэргийг шүүн таслах тохиолдолд шүүх ажиллагаанд тэдний нас болон цагаатгах боломжийг дэмжих санааг харгалзан үзнэ. Насанд хүрээгүй хүнд эрүүгийн ял тулгаж болох насны доод хязгаар, хүнийг насанд хүрээгүйд тооцох насны дээд хязгаар, тусгай шүүх болон шүүн таслах ажиллагааны журам байгаа эсэх, насанд хүрээгүй хүний хэргийг шүүн таслах тухай хууль тогтоомж байгаа эсэх мөн насанд хүрээгүй хүмүүсийг шүүн таслах эдгээр тусгай зохицуулалт “цагаатгах боломжийг дэмжих санаа”-г хэрхэн тусгаж байгаа талаархи тайлан төдийлөн их байдаггүй. Насан хүрээгүй хүмүүс нь 14 дүгээр зүйлд заасан

насанд хүрэгчдэд үзүүлдэг хамгаалалтын адил баталгаагаар хангагдах ёстой.

17. 14 дүгээр зүйлийн 5 дахь заалтад зааснаар гэмт хэрэгт буруутгагдсан хүн бүр түүний гэм буруу болон ялыг хуулийн дагуу дээд шатны шүүхээр хянан хэлэлцүүлэх эрхээр хангагдана. Үүнд “гэмт хэрэг” гэдэг нэр томъёог бусад хэл рүү орчуулсан хувилбаруудыг (“infractio”, “delito”, “prestuplenie”) онцгойлон анхаарах ёстой байдаг. Үүнтэй холбоотойгоор давж заалдах шатны шүүн таслах ажиллагаа, тухайлбал хянах шатны шүүх ажиллагаа, хүртээмжтэйбайх эрх, мөн шүүхийн шийдвэрийг давж заалдахад ямар шаардлагыг хангасан байх ёстой, түүнчилэн хяналтын шүүхийн өмнөх ажиллагаанд 14 дүгээр зүйлийн 1 дэх заалтад тусгасан шударга бөгөөд нийтэд нээлттэй байх шаардлагыг харгалзан үзэх арга зэрэг асуудлыг тусгасан мэдээлэлийг хангалттай гаргаж өгдөггүй практик байдаг.

18. 14 дүгээр зүйлийн 6 дахь заалтад зааснаар шүүн таслах ажиллагааг зохих ёсны дагуу явуулаагүй зарим тодорхой тохиолдолд хуулийн дагуу нөхөн олговор олгодог. Улсуудын тайлангаас харахад тухайн эрхийг дотоодын хууль тогтоомжид тусгаагүй эсвэл хангалттай баталгаажуулаагүй байдаг юм шиг санагддаг. Шаардлагатай тохиолдолд Улсууд Пактын заалтад уг асуудлыг нийцүүлэх зорилгоор дотоодын хууль тогтоомжид нэмэлт оруулах ёстой.

19. Улсуудын тайланг авч хэлэлцэхэд 14 дүгээр зүйлийн 7 дахь заалтын талаар ялгаатай үзэл санаа илэрхийлсэн байдаг. Зарим гишүүн Улс эрүүгийн хэргийг шүүн таслах ажиллагааг шинээр эхлүүлэх журамыг тодруулах шаардлагатай гэдгийг ойлгосон. Хорооны үзэж буйгаар ихэнх гишүүн Улс онцгой нөхцөл байдлын улмаас цагаатгах шийдвэр гарсан анхан шатны шүүн таслах ажиллагааг шинээр эхлүүлэх болон 7 дугаар заалтад заасан *ne bis in idem* зарчмын дагуу хориглосон дахин шүүн таслах ажиллагаа гэсэн хоёр ойлголтыг хооронд нь ялгаж тодорхой болгох шаардлагатай байна. *ne bis in idem* зарчмын утгыг ийнхүү ойлгосноор гишүүн Улсууд 14 дүгээр зүйлийн 7 дахь заалтын талаархи өөрийн тодруулгыг дахин авч хэлэлцэх болно.

### **Ерөнхий Тайлбар 16 (17 дугаар зүйл)**

8. Пактад тодорхойлсон хөндлөнгийн оролцооны хувьд ийм хөндлөнгийн оролцоог зөвшөөрөх нөхцлийг холбогдох хууль тогтоомжид нарийвчилан тогтоох шаардлагатай. Энэхүү зөвшөөрсөн хөндлөнгийн оролцооны тухай шийдвэрийг зөвхөн хуульд заасан эрх мэдэл бүхий этгээдийн зүгээс хэрэг тус бүрт тусгайлан гаргах ёстой байдаг. 17 дугаар зүйлд нийцүүлэн захидал харилцааны нэгдмэл байдал болон нууцлалыг *de jure* болон *de facto* байдлаар баталгаажуулахыг шаарддаг. Захидлыг ямар нэгэн саадгүйгээр бөгөөд задалж нээлгүйгээр эзэнд нь хүргэх ёстой. Цахим хэлбэрээр буюу өөр аргаар шалгах, телефон утас, туузан холбоо болон бусад хэлбэрийн харилцааг саатуулах, харилцан яриаг хуурцаганд буулгах, бичлэг хийх зэргийг хориглох ёстой. Хүний орон байранд нотлох баримт хайх зорилгоос бусад байдлаар нэгжлэг хийхийг хязгаарлах ёстой бөгөөд дур зоргоор авирлахыг зөвшөөрөхгүй. Хувь хүний биед нэгжлэг хийхтэй холбоотойгоор ажиллагааг нэгжлэгт өртөж буй хүний нэр хүндийг хөндөхгүй арга байдлаар хийх баталгааг гаргах ёстой байдаг. Хүний биед нэгжлэг хийж буй төрийн албан хаагч нь адил хүйсийн хүн байх ёстой.

### **Ерөнхий Тайлбар 20 (7 дугаар зүйл)**

3. 7 дугаар зүйлийн заалтаар хязгаарлалт хийхгүй байхыг зөвшөөрсөн байдаг. Пактын 4 дүгээр зүйлд заасан нийтийн онцгой байдлын нөхцөлд 7 дугаар зүйлийн заалтыг хүчингүй болгохыг зөвшөөрдөггүй бөгөөд заалтууд нь хүчин төгөлдөр байх ёстой гэдгийг Хорооны зүгээс дахин баталж байгаа. Үүний адил

Хорооны үзэл бодлоор дээд албан тушаалтан эсвэл төрийн эрх мэдэл бүхий байгууллагын тушаалд үндэслэсэн аливаа үндэслэлээр 7 дугаар зүйлийг зөрчсөн явдлыг уучилах боломжтой ямар нэгэн зөвтгөл эсвэл цагаатгасан нөхцөл байхгүй.

5. 7 дугаар зүйлд заасан хориг нь зөвхөн бие махбодид өвчин шаналал учруулах асуудлыг хамаарахгүй мөн хохирогчид сэтгэл санааны зовлон шаналал учруулах асуудлыг хөнддөг. Түүнчилэн Хорооны үзэж буйгаар энэхүү хоригт гэмт хэргийн нэг төрлийн шийтгэл болгон үздэг нэмэлт шүүмжлэн сануулга эсвэл сурган хүмүүжүүлэх буюу сахилга батын арга хэмжээ зэрэг биеэр эдлэх ял шийтгэл хамрагдах ёстой. Үүнтэй холбоотойгоор 7 дугаар зүйлд хүүхэд, сургуулийн сурагч болон сургалт, эмчилгээний байгууллагын өвчтөнг онцгойлон анхаарах ёстой юм.

6. Хорооны тэмдэглэснээр хоригдсон эсвэл шоронд удаан хугацаагаар ганцаарчилсан нөхцөлд ял эдэлж буй хүний асуудал 7 дугаар зүйлээр хориглосон үйлдэлд хүргэж болох юм. Хорооны Ерөнхий Тайлбар 6 (16)-д өгүүлснээр Пактын 6 дугаар зүйл нь цаазаар авах ялаас татгалзах нь зүйтэй гэсэн утгаар түүнээс татгалзахын хатуу санал болгож байгаа юм. Гишүүн улс цаазаар авах ялыг онц ноцтой эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн хүнд хэрэглэх тохиолдолд 6 дугаар зүйлийн дагуу үүнийг хатуу хязгаарлаад зогсохгүй сэтгэл санааны болон бие мах бодийн аль болох бага зовлон шаналал учруулах байдлаар хэрэгжүүлэх ёстой.

7. 7 дугаар зүйлд тухайн хүний зөвшөөрөлгүйгээр түүнд эмчилгээний болон шинжлэх ухааны туршилт хийхийг тодорхой байдлаар хориглосон. Хорооны тэмдэглэснээр гишүүн Улсуудын тайланд уг асуудлыг маш бага тусгасан байдаг. Тухайн заалтыг баримтлах асуудлыг баталгаажуулах шаардлага болон хэрэгсэлд илүү анхаарал хандуулах нь зүйтэй юм. Дээр дурдсан туршилтуудтай холбоотойгоор хүчин төгөлдөр зөвшөөрөл өгөх чадваргүй, ялангуяа ямар нэгэн хэлбэрээр хоригдож байгаа эсвэл ял эдэлж байгаа хүмүүс, байх тохиолдолд тусгай хамгаалалт зайлшгүй шаардлагатай болдог. Ийм хүмүүсийг эрүүл мэндэд нь хор хөнөөлтэй аливаа эмчилгээний болон шинжлэх ухааны туршилтад оруулж болохгүй.

11. Гишүүн улс нь эрх нь олгогдоогүй, 7 дугаар зүйлээр хориглосон, үйл ажиллагааны эсрэг ерөнхий хамгаалалтаар хангах алхамуудын тайлбарын зэрэгцээ нэн эмзэг хүмүүсийн тусгай хамгаалалтын талаархи тодорхой мэдээллийг гаргаж өгөх ёстой байдаг. Баривчлах, саатуулан хорих эсвэл шоронд хорих зэргийн аль нэг хэлбэрээр хяналтан дор байлгах зохицуулалтууд мөн байцаалт явуулах дүрэм, заавар болон үйл ажиллагааг тогтмол хянаж байх явдал нь эрүүдэн шүүх эсвэл өвчин шаналал учруулан харьцах тохиолдлоос урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэрэгсэл болдог. Хоригдож буй хүмүүсийг үр дүнтэй хамгаалахыг баталгаатай болгохын тулд зохицуулалтуудыг албан ёсоор хорих байгууллага гэж хүлээн зөвшөөрсөн газар, хорих газрын нэр болон байрлалд мөн түүнчлэн хоригдогсдыг хариуцаж буй хүмүүст зориулж төрөл төрөгсөд болон найз нөхөд зэрэг холбогдох хүмүүст хүртээмжтэй байх бүртгэлд хадгалах үүднээс боловсруулах шаардлагатай юм. Үүний адил байцаалт явуулсан цаг, газрыг болон оролцсон хүмүүсийн нэрсийн хамт тэмдэглэн бичлэг үйлдэх бөгөөд энэхүү мэдээллийг шүүхийн болон захиргааны үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн хүртээмжтэй болгоно. Мөн захидал харилцааны ба төрөл төрөгсөд буюу өмгөөлөгчтэй шууд харилцах эрхийг хасах явдлын эсрэг зохицуулалтыг боловсруулах шаардлагатай. Үүнтэй холбоотойгоор гишүүн Улсууд хорих газар нь эрүүдэн шүүлт эсвэл өвчин шаналал учруулан харьцах байдлыг бий болгох тоног төхөөрөмжгүй байх ёстой. Хоригдогсдын хамгаалалтын асуудлын дагуу эмч болон өмгөөлөгч нар, мөн мөрдөн байцаах ажиллагааны шаардлагаар зохих хяналтан дор гэр бүлийн

гишүүд сааталгүйгээр, тогтмол эргэж тойрох явдлыг боломжтой болгохыг шаарддаг.

12. 7 дугаар зүйлд заасан зөрчлийг зогсооход эрүүдэн шүүлт эсвэл бусад хориглосон арга замаар олж авсан мэдэгдэл эсвэл гэм бурууг хүлээн зөвшөөрсөн үгийг шүүн таслах ажиллагаанд хүлээн зөвшөөрөх явдлыг хориглох ёстой.

14. 7 дугаар зүйлийг Пактын 2 дугаар зүйлийн 3 дахь заалттай холбож ойлгох ёстой. Гишүүн Улсууд тайландаа 7 дугаар зүйлээр хориглосон үйл ажиллагааг нэн даруй зогсоох мөн засч залруулах баталгааг хууль тогтоомжиндоо хэрхэн суулгаж өгснийг тусгаж өгөх ёстой. 7 дугаар зүйлээр хориглосон зүй бус харьцааны эсрэг гомдлыг тодорхойлох эрхийг дотоодын хууль тогтоомжид хүлээн зөвшөөрөх шаардлагатай юм. Шүүхийн хамгаалалтыг үр дүнтэй болгох үүднээс гомдлыг эрх бүхий байгууллагаар хойшлуулалгүйгээр бөгөөд хараат бус байдлаар мөрдөн шалгуулах ёстой. Гишүүн Улсуудын тайланд зүй бус харьцааны хохирогчдын шүүхийн хамгаалалт болон гомдол гаргагчдын дагаж мөрдөх журам мөн ийм төрлийн гомдлын талаархи статистик мэдээлэл болон гомдлыг хэрхэн авч хэлэлцсэн талаархи мэдээллийг тусгах шаардлагатай байдаг.

### **Ерөнхий Тайлбар 21 (10 дугаар зүйл)**

3. 10 дугаар зүйлийн 1 дэх заалтын дагуу гишүүн Улсууд эрх чөлөө нь хязгаарлагдсаны улмаас нэн эмзэг байдалд байгаа хүмүүстэй холбоотой эерэг үүрэг хүлээдэг бөгөөд тэдгээр хүмүүст эрүүдэн шүүлт тулгах эсвэл хэрцгий хүний ёсноос гадуур буюу доромжилсон байдлаар харьцах эсвэл Пактын 7 дугаар зүйлд заасан шийтгэл хүлээлгэхийг хориглодог. Тиймээс эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүстэй 7 дугаар зүйлд харшилсан эмчилгээний болон шинжлэх ухааны туршилтад оруулах зэрэг байдлаар харьцаж болохгүй байгаад зогсохгүй тэд нарыг эрх чөлөөний хязгаарлалтаас үүдэлтэй бусад хатуу хэрцгий буюу хориотой байдлын зүйл болгож болохгүй. Эдгээр хүмүүсийн нэр төрийг эрх чөлөөтэй байгаа хүмүүсийн адил хүндэтгэх ёстой. Эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүс нь хаалттай орчинд зайлшгүй байх хориглолтын зэрэгцээ Пактад заасан бүх эрхийг эдлэнэ.

4. Эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүст хүнлэг ёсоор нэр хүндийг нь хүндэтгэн хандах нь суурь бөгөөд нийтээр хүлээн зөвшөөрсөн дүрэм юм. Тиймээс энэхүү дүрмийг хэрэглэх асуудал нь юуны өмнө гишүүн Улсын байдлаас хамаарах боломжгүй. Энэхүү дүрмийг үндэс угсаа, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний эсвэл нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн байдал эсвэл бусад байдлыг харгалзахгүйгээр хэрэглэх ёстой.

9. 10 дугаар зүйлийн 2(а) дахь заалтын дагуу онцгой нөхцөл байдалд шүүгдэгчийг яллагдагчаас тусгаарлах шаардлагатай гэж заасан. 14 дүгээр зүйлийн 2 дахь заалтад зааснаар шүүхийн шийдвэр гартал гэм буруугүй гэдэгт тооцогдох эрхийг эдэлж буй хүмүүсийн яллагдаагүй гэсэн байдлыг онцгойлон үзэх зорилгоор ийм тусгаарлалт хийх шаардлагатай байдаг. Гишүүн Улсуудын тайланд шүүгдэгчийг яллагдагчаас хэрхэн тусгаарлаж байгаа мөн эдгээр хүмүүстэй харьцах асуудал хэр ялгаатай байгаа талаар тусгах ёстой байдаг.

13. Хорооны тэмдэглэснээр зарим гишүүн Улсын тайланд насанд хүрээгүй шүүгдэгч болон насанд хүрээгүй гэмт хэрэгтэнтэй харьцах хандлагын талаар тусгаагүй байдаг. 10 дугаар зүйлийн 2 (б) дахь заалтын дагуу насанд хүрээгүй шүүгдэгчийг насанд хүрсэн хүмүүсээс тусгаарлах ёстой. Тайланд өгсөн мэдээллийн дагуу зарим гишүүн Улс үүнийг Пактын дагуу заавал биелүүлэх заалт гэдэгт төдийлөн анхаарал хандуулахгүй байгаа нь тодорхой харагдаж байна. Мөн насанд хүрээгүй хүмүүстэй холбоотой хэргийг аль болох хурдан таслан шийдвэрлэх шаардлагатай. Гишүүн Улсууд уг заалтыг хэрэгжүүлэх

арга хэмжээг тодорхойлсон байх ёстой. Сүүлийн үед 10 дугаар зүйлийн 3 дахь заалтад заасны дагуу насанд хүрээгүй хүмүүсийг насанд хурсэн хүмүүсээс тусгаарлаж богино цагаар ажиллах мөн цаашид өөрчлөгдөж, засан хүмүүжинэ гэсэн зорилгоор ар гэрийнхэнтэй нь уулзуулж байх зэрэг байдлаар тэдний нас болон эрх зүйн байдалд нийцүүлэн зохих хорих нөхцлийг бүрдүүлнэ. 10 дугаар зүйлд насанд хүрээгүй гэдэгт тооцох тодорхой насыг заагаагүй байдаг. Хэдийгээр уг асуудлыг гишүүн Улсууд өөрсдийн нийгэм, соёл болон бусад нөхцлийг харгалзан тодорхойлдог боловч Хороо 6 дугаар зүйлийн 5 дахь заалтад заасан юуны өмнө эрүүгийн гэмт хэрэгтэй холбоотой асуудалд 18 наснаас доош насны хүн бүрийг насанд хүрээгүй хүн гэж тооцох саналыг дэмжидэг. Улсууд насанд хүрээгүй хүн гэж тооцох насны хязгаарын талаар холбогдох мэдээллийг гаргаж өгөх ёстой байдаг. Үүнтэй холбоотойгоор гишүүн Улсуудаас Бээжингийн Дүрмүүд \1987\ хэмээн нэрлэдэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Насанд хүрээгүй хүмүүсийг талаар байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг Дүрмийг хэрэглэдэг эсэх талаар мэдэгдэхийг хүсдэг.



## ХАВСРАЛТ 2

### Хүний болон Ард түмний эрхийн Африкийн Комиссийн Шударга шүүх, Гомдол хэлэлцэх ажиллагааны эрхийн тухай Тогтоол

#### Хүний болон ард түмний эрхийн Африкийн Комисс

Африкийн Хүний болон ард түмний эрхийн Дүрэм нь Дүрэмд заасны дагуу хүний эрхийг хамгаалах, дэмжих зорилгыг агуулж хүний эрхийн олон улсын стандартыг хүлээн зөвшөөрч байгааг ухамсарлан ойлгож,

Хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалахад шударга шүүхээр шүүлгэх эрх зайлшгүй шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрөн,

Африкийн Хүний болон ард түмний эрхийн Дүрмийн 7 дугаар зүйлийг оюун санаандаа тунгааж,

1. Эрх эсвэл эрх чөлөө нь зөрчигдсөн хүн бүр үр нөлөөтэй шүүхийн хамгаалалтаар хангагдах эрхтэй гэж үзнэ.

2. Шударга шүүхээр шүүлгэх эрхэд бусад зүйлийн зэрэгцээ дараах зүйлс хамаарна гэдгийг ойлгоно. Үүнд:

А. Бүх хүмүүс хэргээ шүүхээр хэлэлцүүлэх мөн шүүхийн өмнө эрх болон үүргээ тогтоолгохдоо тэгш эрхтэй байна.

Б. Баривчлагдсан хүмүүс баривчлагдах үед өөрт нь ойлгогдох хэлээр баривчлагдах болсон шалтгаан болон өөрт нь тулгаж буй ялын талаар нэн даруй мэдээлэл авах эрхтэй.

В. Баривчлагдсан эсвэл хоригдсон хүмүүс нь сааталгүйгээр шүүгч болон хуулийн дагуу шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх эрх олгогдсон бусад албаны хүний өмнө хүргэгдэх ёстой бөгөөд зохих хугацаанд шүүхээр хэргээ хэлэлцүүлэх эсвэл суллагдах эрхийг эдлэнэ.

Г. Эрүүгийн гэмт хэрэгт яллагдаж буй хүн эрх бүхий шүүхээс гэм бурууг нь нотолтол гэм буруугүй хэмээн тооцогдоно.

Д. Хувь хүний гэм бурууг тогтоох ажиллагааны үед хувь хүн дараах эрхийг эдэлнэ. Тухайлбал:

1/ Өөрийгөө өмгөөлөхөд бэлдэх болон сонгосон өмгөөлөгчтэй биечлэн холбогдох хангалттай цаг хугацаа, орон байраар хангагдах

2/ Зохих хугацаанд шүүхээр хэргээ хэлэлцүүлэх

3/ Өөрийнх нь эсрэг гэрчийг шалгах эсвэл шалгуулах мөн өөрийнх талд байгаа гэрчийн байцаалтад эсрэг гэрчийн байцаалтын адил нөхцлөөр оролцох, шалгах

4/ Шүүхэд хэрэглэж буй хэлийг ойлгохгүй тохиолдолд хэлмэрчийн туслалцаа авах

3. Гэмт хэрэгт буруутай гэж тогтоогдсон хүмүүс дээд шатны шүүхэд давж заалдах эрхтэй.

4. Африкийн Хүний болон ард түмний эрхийн Дүрэмд нэгдсэн Улсад гомдол хэлэлцэх ажиллагаа явуулах мөн шаардлагатай хүнд эрх зүйн туслалцаа үзүүлэх боломжийн талаар мэдэгдэхийг санал болгодог.

5. Шударга шүүх болон Гомдол хэлэлцэх ажиллагаатай холбоотой зарчмыг улам боловсронгуй болгох зорилгоор уг ажиллагааг үргэлжлүүлэн явуулах асуудлыг шийдвэрлэдэг.





Цахим хуудас: [www.amnesty.org](http://www.amnesty.org)  
[www.amnesty.mn](http://www.amnesty.mn)

Цахим шуудан: [aimncc@magicnet.mn](mailto:aimncc@magicnet.mn)

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 6-р хороо,  
Бага тойруу-44, 10 тоот

Утас/Факс: 976-11-324705

Шуудангийн хаяг: Улаанбаатар 210648,

Шуудангийн хайрцаг-180

